Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

- Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэлийн онол, практикийн ач холбогдол
- Нээлттэй болон хаалттай компанид хяналтаа хадгалах компанийн эрх зүйн механизм
- Шилжих хөдөлгөөн ба Монгол Улс
- Монголд тангаргатны шүүх хэрэгтэй юу (АНУ, ОХУ-тай харьцуулсан аналитик тойм)
- Иргэний хэргийн шүүхийн зардал
- Ард нийтийн санал асуулга ба Монгол Улсын Үндсэн хууль
- Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах асуудал, тулгарч буй бэрхшээл, цаашид анхаарах зарим асуудал
- Хууль зүйн клиник сургалтын технологийн тулгамдсан асуудал
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг анхан шатны шүүхээс хэрэглэж буй практик
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.11. дүгээр зүйл болон Иргэний хуулийн холбогдох заалтуудын хэрэглээ
- Хараат бус, бие даасан байдлыг хамгаалах хариуцлагын тогтолцоо
- Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын эрх зүйн зохицуулалтын талаар
- Улс төрийн намуудын байгуулсан гэрээ ба эрх зүйн зохицуулалт, хяналт

2011
№3 (34)

СЭТГҮҮЛИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

Ц.Нямдорж	- Хууль зүй, дотоод хэргийн сайд
Ц.Зориг	- Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
Д.Дорлигжав	- Улсын Ерөнхий прокурор
Д.Одбаяр	- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга
Д.Лүндээжанцан	- Улсын Их Хурлын гишүүн
Ц.Мөнх-Оргил	- Улсын Их Хурлын гишүүн
С.Батдэлгэр	- Улсын Дээд шүүхийн шүүгч
Ц.Шаравдорж	- Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга
П.Цагаан	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх
Б.Долгор	- Монгол Улсын Ерөнхий сайдын хуулийн зөвлөх
Ж.Бямбадорж	- Хүний эрхийн үндэсний комиссын дарга
Г.Баясгалан	- ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
Б.Пүрэвням	- Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч
Ч.Отгонбаяр	- Монголын Нотарчатчдын Танхимын Ерөнхийлөгч
Д.Батжаргал	- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
Ж.Амарсанаа	- Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал
С.Нарангэрэл	- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга
Д.Сандаг-Очир	- Цагдаагийн ерөнхий газрын дарга
Д.Зүмбэрэллхам	- Төрийн албаны зөвлөлийн дарга
Д.Сүгар	- Төрийн өмчийн хорооны дарга

СЭТГҮҮЛИЙН ШИНЖЭЭЧ ЭРДЭМТДИЙН ЗӨВЛӨЛ

С.Жанцан	- Хууль зүйн шинжлэх ухааны доктор
Ч.Энхбаатар	- Хууль зүйн шинжлэх ухааны доктор
Ш.Чоймаа	- Хэл шинжлэлийн шинжлэх ухааны доктор
Б.Амарсанаа	- Хууль зүйн доктор
Б.Гүнбилэг	- Хууль зүйн доктор
Б.Тэмүүлэн	- Хууль зүйн доктор
Г.Банзрагч	- Хууль зүйн доктор
Д.Баярсайхан	- Хууль зүйн доктор
Т.Мэндсайхан	- Хууль зүйн доктор

ХЯНАН ТОХИОЛДУУЛАХ ЗӨВЛӨЛ

Хүндэт зөвлөх: **Монгол Улсын ходөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор Б.Чимид**

Ерөнхий эрхлэгч: Д.Батжаргал
Эрхлэгч: Б.Гүнбилэг
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: С.Алтантуяа
Эрхлэн гаргагч:
Хууль зүйн үндэсний хүрээлэн

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай-7
Утас: 315736, 99083007 Факс: 315736
Вэб сайт: www.legalinstitute.mn
И-мэйл хаяг: altantuya.s@legalinstitute.mn
Улсын бүртгэлийн дугаар: 279

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Цуврал 34 2011 он, Есдүгээр сар №3

АГУУЛГА

ХУУДАС

Цагдаагийн ерөнхий газрын дарга Д.Сандаг-Очирын "Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн"-ийг нээж хэлсэн үг 9

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн "Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн"-д хэлсэн үг 11

Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжавын "Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн"-д хэлсэн үг 14

Илтгэл

Мөрдөн байцаалтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашид анхаарах зарим асуудал 20
УМБГ-ын дарга, цагдаагийн хурандаа Ө.Энхтор

Гэмт хэрэг зүйлчлэх өрчин үеийн тулгамдсан асуудал 27
МУИС-ийн профессор, Академич С.Нарангэрэл

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны үед анхаарах зарим асуудал 34
Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимийн тэргүүн Б.Батцэрэн

Эрүүгийн процесс дахь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 54
Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, докторант Ч.Хосбаяр

Санал, зөвлөмж

"Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн"-өөс гарсан санал, зөвлөмж 61

хуулийн зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Эрдэм шинжилгээ, онол, арга зүй

ОХУ-ын холбооны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хангах зохион байгуулалт, эрх зүйн онцлог **90**
Хууль зүйн доктор Б.В.Сангаджиев

Татвар төлөхөөс санаатай зайлсхийх гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын асуудал **100**
ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, докторант Г.Оюунболд

Их сургуулийн эрдмийн эрх чөлөөт байдлын тухай **109**
МУБИС-ийн Түүх, нийгмийн ухааны сургуулийн Философи, дидактикийн тэнхимийн багш, магистр Э.Чулуунцэцэг

Судалгааны тайлан

Төрийн албаны эрх зүйн байдлын тойм, шинэтгэл түүний агуулга **116**
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэхэд анхаарах зарим асуудал **174**
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Үзэл бодол, эргэцүүлэл

Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд анхаарах зарим асуудал **186**
Хууль зүйн доктор, профессор Л.Батжав

Эвлэрүүлэн зуучлах ажиллаагааг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бий **191**
ХЗҮХ-ийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Мэнджаргал

Ураны салбар дахь төрийн оролцоо **196**
ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Халиунаа

Канад, Кипр Улсын мэдээллийн агентлагийн эрх зүйн байдлын тухай **202**
ХЗҮХ-ийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Л.Амаржаргал

Хууль зүйн албаны 100 жилийн ойд **206**

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.ikuz.mn

Vol.34 September 2011 NO.3

CONTENTS

PAGE

Inaugural Address by D.Sandag-Ochir, Chief of General Depertment Police, in the 5th State Conference of Police Investigators 9

Address by Ts.Nyamdorj, Minister of Justice and Internal Affairs, in the 5th State Conference of Police Investigators" 11

Address by D.Dorligjav, General Prosecutor of Mongolia, in the 5th State Conference of Police Investigators" 14

Speeches

Current Situation of Investigation Process and the Further Issue to Consider 20
Enkhtur.U, Colonel, Chief of State Investigation Department

Current Pressing Issues on Qualification of Crimes 27
Narangerel.S, Academician, Professor of School of Law, National University of Mongolia

Emphasizing Issues on Inquiry and Investigation Process 34
Battseren.B, Presiding Justice of Chamber of Criminal Case, Metropolitan Court of Mongolia

Simplified Procedure of Criminal Proceedings 54
Khosbayar.Ch, Ph.D candidate, Judge of Court of Sukhbaatar District

Recommendation

Recommendatin made by 5th State Conference of Police Investigators 61

Articles

Organization and Legal Distinctive to Provide Federal Court Jurisdiction in Russian Federation 90

www.shuspi.mn www.mn.gov.mn

Sangadjiev.B.V, Ph.D

Theoretical Issues of Composition of Tax Evasion 100
Oyunbold.G, Ph.D candidate, Researcher of Criminal Law and Criminology Sector, National Legal Institute

Academic Freedom 109
Chuluuntsetseg.E, LLM

Research Reports

Review and Reform of Legal Status of Public Service and its Content 116
Research Report by National Legal Institute

Emphasizing Issues on Transfering Prison Regime into the Open and Closed System 174
Research Report by National Legal Institute

Notes

Emphasizing Issues to Prevent Conflict of Interests in Public Service 186
Batjav.L, Ph.D

It is Need to Implement Alternative Dispute Resolution 191
Mendjargal.D, Researcher of Administration and Humanitanian Law Sector, National Legal Institute

State Participation in the Uranium Sector 196
Khaliunaa.G, Researcher of International Law Sector, National Legal Institute

Legal Status of the Information Agency of Canada and the Republic of Cyprus 202
Amarjargal.L, Researcher of Administration and Humanitanian Law Sector, National Legal Institute

The 100th Anniversary of the Justice Sector 206

www.nli.gov.mn

Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн болов

Улсын цагдан сэргийлэх газрын даргын 1940 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 41 тоот тушаалд "Цагдан сэргийлэх газар бол гэмт хэрэг үйлдэгчдийг дайчлан баривчлах, хорьж мөрдөх зэргээр байцаан нягтлах ажлыг явуулах мөрдөн байцаах газар" хэмээн дурьдаж үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж улмаар ДЯЯ-ны 1946 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 504 тоот тушаалаар Улсын Цагдан Сэргийлэх газрын гүйцэтгэх 1 дүгээр хэлтсийн харъяанд Мөрдөн байцаах группыг байгуулснаар Мөрдөн байцаах албаны үндэс суурь тавигдаж өдгөө 65 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөрдөн байцаах ажилтнууд түүхэндээ 4 удаа улсын зөвлөгөөн хийж, алдаа дутагдал, ололт амжилтаа дүгнэн хэлэлцэж, тодорхой шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж иржээ.

"Улсын анхдугаар зөвлөгөөн"-ийг 1969 оны 12 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж Улсын прокурор Ж.Авхиа "Мөрдөн байцаалтын ажлын одоогийн байдал, цаашид тавих зорилт" гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлжээ. Үүнээс хойш 1972, 1977, 1985 онуудад улсын 2, 3, 4 дүгээр зөвлөгөөнүүдийг зохион байгуулсан байдаг.

Эдгээр зөвлөгөөнөөр тухайн цаг үеүдэд эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль, холбогдох хуулийн заалтуудыг

нэг мөр хэрэгжүүлж, байцаан шийтгэх ажиллагааг цаг алдалгүй, шуурхай явуулахад мөрдөн байцаагчийн мэдлэг боловсрол, ажлын арга туршлагыг дээшлүүлэх, эрүүгийн хэргийг шуурхай илрүүлж, хуулийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг хэлэлцэж ирсэн.

Мөрдөн байцаах албаны түүхт 65 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулж байгаа мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн нь ардчилсан Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн явцад гарч б[illegible]аа хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, мөрдөн байцаах албаны ажлын үр өгөөжийг дээшлүүлэх үнэтэй санал, зөвлөмжийг боловсруулахад оршино.

Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн 2011 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Монгол Улсын Төрийн ордны Их танхимд нээлтийн ажиллагаа хийж, зөвлөгөөнийг ЦЕГ-ын дарга, хошууч генерал Д.Сандаг-Очир нээж ХЗДХ-ийн сайд Ц.Нямдорж, Монгол Улсын Ерөнхий прокурор, төрийн хууль паазын тэргүүн зөвлөх Д.Дорлигжав, Улсын мөрдөн байцаах газрын дарга, цагдаагийн хурандаа Ө.Энхтөр нар илтгэл тавьж, үг хэлжээ.

Зөвлөгөөнөөр Төрийн ордны Их танхимд "Эрүүгийн хуулийг

хэрэглэх явцад үүсч буй тулгамдсан асуудлууд", "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй тулгамдсан асуудлууд" сэдвүүдээр нэгдсэн хуралдаан, "Хүн амины болон шинэ төрлийн гэмт хэргийг мөрдөхөд анхаарах зарим асуудал", "Гомдол мэдээллийг

шийдвэрлэх, эрүүгийн хэргийг түдгэлзүүлэхэд анхаарах зүйл, цаашид авах арга хэмжээ", "Мөрдөн байцаалтын ажиллагаанд хүний эрхийг хангах нь" сэдвүүдээр салбар хуралдаануудаа А, Б, В

танхимуудад хуралдаж, МУИС-ийн ХЗС-ийн захирал, Академич С.Нарангэрэл, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн мэргэжилтэн Г.Оюунболд, Авилгатай тэмцэх газрын хэлтсийн дарга Н.Батзогсох, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн хэлтсийн дарга, доктор С.Ганболд, Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор Т.Жадамбаа, ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвийн дарга, цагдаагийн хурандаа Ж.Бумнанжид, Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн тэргүүн, элчин сайд Л.Эрдэнэчулуун, АНУ-ын Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Мелони Лендберг, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн П.Оюунчимэг, Нийслэлийн өмгөөлөгчдийн холбооны дарга Д.Энхдалай, "Иргэдийн Альянс" төрийн бус байгууллагын тэргүүн Ж.Занаа нарын төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцож илтгэл тавилаа.

Зөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчид, УЕП-ын дэргэдэх мөрдөн байцаах алба, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтэс, Авилгатай тэмцэх газрын мөрдөн байцаах хэлтсүүдийн мөрдөн байцаагчид, ХЗДХЯ, Хууль зүйн үндэсний хүрээлэн, прокурор, шүүх, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Шүүхийн шийдвэр гүйцэхгэх ерөнхий газар,

Монголын өмгөөлөгчдийн холбоо, Гаалийн ерөнхий газар, Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Татварын ерөнхий газар, "Эмнести интернешнл" олон улсын байгууллага, АНУ, ОХУ, БНХАУ, Япон, Солонгос улсуудын элчин сайдын яамдын хуулийн асуудал хариуцсан ажилтан нарын 800 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар салбар хуралдаануудыг хөтөлсөн Улсын мөрдөн байцаах газрын хэлтсийн дарга нар үр дүнг танилцуулж, салбаруудаас гарсан санал, зөвлөмжүүдийг нэгтгэжээ.

"Хууль дээдлэх ёс" сэтгүүл энэ дугаартаа зөвлөгөөнд хэлсэн үг, хэлэлцэгдсэн илтгэл болон гарсан санал, зөвлөмжүүдээс уншигч та бүхэндээ хүргэж байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга Д.Сандаг-Очирын "Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн"-ийг нээж хэлсэн үг

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,
Хүндэт мөрдөн байцаагчид аа,
Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Цагдаагийн ерөнхий газрын дарга Д.Сандаг-Очир

Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын V зөвлөгөөнийг хамтран зохион байгуулж, дэмжлэг үзүүлсэн Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Улсын Ерөнхий прокурорт зөвлөгөөнийг зохион байгуулагч, оролцогчдын өмнөөс болон хувиасаа гүн талархал илэрхийлж байна.

Энэ зөвлөгөөнд цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албаны үе үеийн ахмад ажилтнууд, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчид, шүүх, прокурор болон хууль сахиулах бусад байгууллагын удирдлага, алба хаагчид, мөрдөн байцаагчид, хуульчид оролцож байгааг тэмдэглэхэд таатай байна.

Мөрдөн байцаалтын ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлэх, ололтоо бататгах, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шинэлэг санал, санаачилга, анхаарах асуудлын талаар хэлэлцэх зорилгоор мөрдөн байцаагчдын зөвлөгөөнийг зохион байгуулж ирсэн уламжлалтай.

Энэ удаагийн зөвлөгөөн нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч байгууллагуудын хамтын ажиллагаа, мөрдөн байцаалтад хүний эрхийг хангах, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэх, онц хүнд, шинэ төрлийн гэмт хэргийг мөрдөх мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зэрэг олон чухал асуудлыг хамтран хэлэлцэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох юм.

Эрх зүйн шинэтгэлийн зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх, мөрдөн байцаагчдын үйл ажиллагааны болон сэтгэлгээний шинэчлэлд өөрчлөлт гаргахад энэхүү зөвлөгөөн бодитой үр дүн өгнө гэж үзэж байна.

Дээрх зорилтын хүрээнд төр, засаг болон Цагдаагийн ерөнхий газраас тодорхой арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. Тухайлбал: 2011 онд Монгол Улсын Засгийн газраас цагдаагийн байгууллагыг бэхжүүлэх талаар гаргасан шийдвэрийн хүрээнд төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын бүх мөрдөн байцаагчид компьютерээр хангагдлаа.

Цагдаагийн ерөнхий газраас Мөрдөн байцаах газрын бүтцэд "Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтэс", "Зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөх хэлтэс", "Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг мөрдөх тасаг"-ийг тус тус шинээр зохион байгууллаа.

Улс орны эрүүгийн нөхцөл байдал хүндхэн байна. Иймд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг улам бэхжүүлж, онол, практикийн нэгдсэн ойлгоцтой, ажлын нягт уялдаатай байх нь чухал байна.

Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг шуурхай эрэн сурвалжилж илрүүлэх, олж тогтоох, нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэхэд шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг өргөнөөр ашиглах нь мөрдөн байцаалтын ажиллагааны чанар, үр дүнд ач холбогдолтой байгааг тэмдэглэж байна.

Мөрдөн байцаалтын ажиллагааг олон улсын дэвшилтэд стандартад хүргэх талаар гадаад орнуудын туршлагыг харьцуулан судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж хэвшүүлэх нь эрх зүйн шинэтгэлийн нэг гол асуудал юм.

Мөрдөн байцаагчийн хөдөлмөр нь хүндтэй бөгөөд нэн хариуцлагатай.

Мөрдөн байцаагчид зөвхөн хуулийн хүрээнд мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллаж, иргэнтэй эгц харж, хүндэтгэлтэй харьцаж, тэдний хууль ёсны эрх ашгийг туушгай хамгаалж, шударга, ёс зүйтэй үйлчилгээ үзүүлж байвал зохино.

Иймд мөрдөн байцаагчид мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд эрин үед нийцэхүйц шинэчлэл хийж, хуулийн зорилт, зарчмыг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

Зөвлөгөөнд оролцогч та бүхний хэлэлцэх асуудлын талаар гаргасан оновчтой санал, зөвлөгөө нь хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, мөрдөн байцаах ажлын чанар, үр дүнг ахиулахад үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэл төгс байна.

Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын V зөвлөгөөний ажиллагаа нээснийг мэдэгдье.

Зөвлөгөөний үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн "Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн"-д хэлсэн үг[1]

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж

Мөрдөн байцаах ажилтны V зөвлөгөөнд хүрэлцэн ирсэн та бүхний амрыг айлтгая. Би бэлдсэн үг уншья гэж бодсон ч сэтгэлээсээ үг хэлэх нь илүү гэж бодлоо.

1981 онд сургууль төгсөж ирээд 1964 оны Эрүүгийн болон ЭБШХ-ийг хэрэглэх, 1987 онд Эрүүгийн шинэ хуулийг Академич С.Нарангэрэлийн оролцоотойгоор батлах үед хөдөө сургалтад явах, 1994 оны ЭБШХ-ийн том өөрчлөлтийг санаачлах, 2002 онд одоо мөрдөж байгаа хуулийг батлуулах зэрэг байдлаар миний бие та бүхний эрхэлж байсан ажилд оролцож байсан түүхтэй. Өөрөөр хэлбэл, би сүүлийн 30-аад жилийн хугацаанд Цагдаагийн байгууллага түүний дотор Мөрдөн байцаах албаны ажлын нэгэн амьд гэрч болсон түүхтэй.

Өнөөдөр Монгол Улсад шударга ёс тогтоох, шударга ёсны өлсгөлөн бий болчихсон нь нууц биш. Бий болсон нөхцөл байдалд янз янзын шалтгаан байдаг. Үүнээс би гурвыг хэлье.

1.Улс төрийн нөлөөлөл мөрдөн байцаах ажлын эцсийн үр дүнд шударга ёс тогтооход сайн нөлөө үзүүлэхгүй, зарим талаар хэтэрхий муу нөлөө үзүүлж байна. Үүнийг зөвлөгөөнд оролцож буй та бүхэн ярилцаж, цаашид улс төрийн нөлөөллөөс ангид ажиллах шаардлага урган гарч байна.

2. Мөрдөн байцаах алба, мөрддөг хүмүүс нь арай ядан байж хэрэг босгоод ирэхэд шүүх, прокурорын шатанд замхардаг явдал бараг 20 жил үргэлжиллээ. 17 чингэлэг спирт ус болдог, ордонгийн хажуу дахь байшингууд алга болчихсон байхад хэн ч хариуцлага хүлээдэггүй явдал гарсаар байна. Энэ нь олон түмний дургүйцлийг зүй ёсоор хүргэж байна. Энэ байдалд цаашдаа мөрдөн байцаах алба, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьдаг прокурорууд, ийм хэргийг шийдвэрлэдэг хуульчид нухацтай дүгнэлт хийж ажиллах

[1] Тус зөвлөгөөнд оролцсон мөрдөн байцаагчдад Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн ярьсныг бичлэгээс хуулбарлан авсан болно.

шаардлагатай байна. Төрийн хуулийг нүдэн дээр бараг хулгайлдаг ёс манай шүүхийн ажилд бий боллоо. Үзсээр байтал илэрхий заалттай, цагаан дээр хараар бичсэн хуулийг мушгин гуйвуулж шийдвэр гаргадаг, энэ нь олон түмний дургүйцлийг төрүүлдэг явдал тасрахгүй байна.

3. Танил талын муу нөлөөнөөс ангид байх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Улс төрийн нөлөөллөөр, танил талын сүлжээгээр хийж буй бүх ажлыг замхаруулж байна. Энэ байдалд мөрдөн байцаагчдын зөвлөгөөнд оролцож байгаа та бүхэн нухацтай дүгнэлт хийх ёстой гэж бодож байна.

Мөрдөн байцаах албаныхан, энэ албаны ажилд хяналт тавьдаг прокурорууд, шүүхийнхэн ажлын хуулийн дагуу хийж чадах юм бол Монголд хууль хэрэгжиж шударга ёс нэг мөр биелэнэ.

Мөрдөн байцаагчид төрийн хуулийг манах ажилдаа сэтгэлийн зориг гарган ажиллах шаардлагатай. Элдэв талаас нь шахаж шаардаад, сонин хэвлэлээр дарамтлаад ирэхээр хүч нь сулардаг, мөхдог явдал ажиглагдаад болохгүй байна. Төрийн хуулийг манах манаачийн үүргийг мөрдөн байцаах албаныхан туйлын чанд гүйцэтгэх шаардлага зүй ёсоор гарч байна. Дайралт, шахалт, муу нөлөө цаашдаа ч их иргэ. Ийм нийгэмд бид амьдарч байна. Үүнд буулт хийж болохгүй.

Шударга ёсыг тогтоох ажилдаа чин сэтгэлээсээ, үнэнч байх шаардлагатай байна. Наашаа харж нэг юм ярьчихаад, цаашаа өөр зүйл хийж, дутагдал нь илрэхээр хуульд бурууг нь түлхэж өөрөөсөө хариуцлагыг холдуулаад байх юм бол мөрдөн байцаагчдын ажил сайжрахгүй гэдгийг сануулахад гэмгүй.

Хөндлөнгийн нөлөөнд үл автах, түүнээс ангид байх шаардлага зөвхөн энэ нийгмийн үед ч биш социалист нийгэмд ч байсан.

Монгол төрд, Монгол Улсад шударга ёсыг тогтоон хууль хэрэгжүүлэх эцсийн хариуцлага та бүхнээс шалтгаална гэдгийг энэ ялдамд хэлье. Монгол Улс хөгжлийн шинэ гараанд босгон дээр ирчихээд байна. Энэ жил дотоодын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 14 хувиар, оны эцэст 20 хувиар нэмэгдэх байдал ажиглагдаж байна. Уул уурхайн салбарт гадаад, дотоодын асар их хөрөнгө оруулалт орж ирж байна. Үүнийг дагаж сайны зэрэгцээгээр саар зүйл гарахыг үгүйсгэх аргагүй. Зэвсгийн наймаа, хар тамхины наймаа, хүний наймаа, мөнгө угаах гэсэн дөрвөн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд Мөрдөн байцаах албаныхан цоо шинэ мэдээллээр хангагдаж, шинэ нөхцөлд сайн ажиллах хэрэгтэй. Хүний амь биед халдсан, хүч хэрэглэсэн, өмч хөрөнгө хулгайлсан хэргийг манай хуулийнхан мөрдөж, илрүүлж, шийдвэрлэж чаддаг. Төрийн өндөр дээд албан тушаалтануд, эрх мэдэл, нөлөө бүхий хүмүүсийн сонирхол нөлөөлөөд ирэхээр сөхөрч унадаг байдлаас бид хэзээ салах вэ. Цаашдаа энэ нөлөөлөл буурахгүй

улам нэмэгдэнэ. Мөнгөний хэмжээ, үйлдвэрлэл, үйлчилгээ өсөхийн хэрээр улсын хөгжлийг дагаж гардаг сөрөг үзэгдлүүд нэмэгдэх болно. Үүнийг энэхүү зөвлөгөөнд сууж буй хүн бүр дор бүрнээ бодож үзэн ажилдаа дүгнэлт хийх байх гэж бодож байна. Монголын ирээдүй өнгөлөг харагдаж байна. Амьдралыг өнгөтэй байлгахын тулд та бүхний хийх ажил их байна.

Цагдаагийн байгууллага, Мөрдөн байцаах байгууллагыг бэхжүүлэхэд үе шаттай арга хэмжээнүүд авч байгааг та бүхэн мэдэж байгаа, одоогийн энэ ажил бол хийж дуусгах ажлын эхлэл гэдгийг хэлэх хэрэгтэй байна. Ядаж л 327 сумдад сууж байгаа хэсгийн төлөөлөгчдийг орон байртай болгох хэрэгтэй байна. Цагдаагийн алба хаагчдыг орон сууцанд амьдардаг болгомоор байна. Сүүлийн үеийн техник хэрэгслээр хангах хэрэгтэй байна. Энэ жил 20 тэрбум төгрөгийн зардал гаргах шийдвэр гарч 3.5 тэрбум төгрөг нь шийдэгдэж байгаа. Үлдсэнийг нь дараагийн он жилүүдэд шийдэх болно. Гэхдээ асуудлыг материаллаг талаас нь шийдвэрлэх нэг асуудал, хамгийн гол асуудал сэтгэлийн ариусал гэж байна. Хиртэй бодолтой, хиртэй сэтгэлтэй, хувийн шуналтай хүмүүс мөрдөн байцаах албанд, цагдаа, прокурор, шүүхийн байгууллагад шургалж муу санаа бодолдоо хүрэхийн тулд терийн хуулийн боломжийг ашиглаж эхлэх юм бол энэ жинхэнэ аюул.

Мөрдөн байцаах албаны 65 жилийн ой тохиож байгаа энэ өдөр энэхүү зөвлөгөөний индэр дээрээс та бүхэнд сэтгэл тэнь ариун байхын ерөөлийг өргөж төрийн хуулийг чандлан биелүүлэх ажилдаа чин сэтгэлээсээ ажиллахыг хүсэж баяр хүргэж байна.

Монгол Улсын Ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүнзөвлөхД.Дорлигжавын"Цагдаагийнбайгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн"-д хэлсэн үг

Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжав

Цагдаагийн мөрдөн байцаах албаны ажилтнууд, цагдаагийн байгууллагын удирдлагууд, энэ зөвлөгөөнийг зохион байгуулсан та бүхэнд баяр хүргэж амжилт хүсье.

Та бүхэнд баяр хүргэхийн учир нь өнөөдөр Монгол оронд эрх зүйн шинэтлэл, хуулийн байгууллагын үйл ажиллагааны шинэчлэл эрчимтэй хийгдэж байгаа энэ үед гучаад жил тасарсан улсын мөрдөн байцаагчдын зөвлөгөөнийг зохион байгуулж байгаа явдалд талархаж байгаа юм.

Энэхүү зөвлөгөөнийг зөвхөн цагдаагийн мөрдөгчдийн биш улсын нийт мөрдөн байцаах байгууллагын ажилтнуудын улсын зөвлөгөөн болгосон бол илүү үр дүнтэй, илүү нэг мөр ойлголцсон ажил болох байсан байх. Гэхдээ цагдаагийн байгууллага санаачилсан нь бага хэрэг биш юм. Бүхэлдээ мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа дутагдал, иргэдийн хүлээж байгаа хүлээлт зөвхөн цагдаагаар хязгаарлагддаггүй гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Гэхдээ иргэд бүгдийг нь хуулийнхан гэдэг нэг үгээр хэлдэг, нэг нүдээр хардаг. Ийм учраас хуульчид нэг ойлголттой, зовлон жаргалаа нэг ярьдаг, асуудлаа нэг мөр шийддэг ийм байсан бол төрийн бодлого талаасаа ач холбогдолтой байх байсан бол уу гэх бодол төрж байна. Прокурор, мөрдөн байцаах байгууллага хамтарч, хэргийн хоёр талаас ажилладаг хүмүүсийн хувьд энэ зөвлөгөөнийг яаж үр дүнтэй болгох вэ, асуудлыг аль талаас яаж ярих вэ гэдгийг урьдчилж төлөвлөж ярилцсан зүйл бий. Өнөөдөр би энэ индэр дээрээс хэдэн зүйлийг та бүхэнд хэлье.

Ажил явуулахад тохиолдож буй гол бэрхшээлүүд дээр тогтож ярья.

1. Хууль. Бидний барьж ажиллаж байгаа хуулиудын заримд бэрхшээл учруулж байгаа хэд хэдэн зүйл байгаа. Энэ бэрхшээл учруулаад байгаа хуулийн заалтуудыг тодорхой болгуулах асуудлыг Улсын Их Хуралд тал талаас нь ярьж шийдвэрлүүлэх шаардлага байгаа. Товчхондоо Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх

хуулийг боловсронгуй болгох хэрэгтэй байна;

2. Бүхэлдээ субъектив шинж чанартай, хувь хүмүүс, мөрдөн байцаагчид, хуулийн байгууллагын ажилтнуудын хувийн шинж чанартай гаргаж байгаа алдаа дутагдал нь байгууллагын алдаа дутагдал байдлаар нийгэмд харагдаж байгаа тул нийтлэг гаргаж байгаа дутагдалуудыг нэгтгэж түүнийг засах талаар Мөрдөн байцаах үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргах зорилт болгож тавьбал зүйтэй байх гэж бодож байна;

3. Удирдлага, зохион байгуулалт, ажил үүргийн шинж чанартай алдаа дутагдал, энэ бол прокурорын байгууллагад ч анзаарагддаг.

4. Орчин үеийн нийгэм маш хурдтай өөрчлөгдөж байгаа энэ цаг үед нөхцөл байдлыг хуулийн байгууллагын ажилтнууд бид бүхэн зөв мэдэрч цаг тухайд нь зөв дүгнэж нийгмийн үзэгдлийнх нь хувьд ялгаж салгаж, дүгнэлт хийж ажилдаа тусгаж чадаж байна уу гэдэг асуудал байна.

Жишээлбэл, Эдийн засгийн шинжтэй томоохон гэмт хэргүүд, банк, санхүүгийн байгууллагуудын хооронд явагдаж байгаа санхүүгийн олон талт үйл ажиллагаануд, дотоод, гадаад санхүүгийн үйлчилгээ гэх мэт. Бидний урьд нь нүүр тулж байгаагүй хүн худалдаалах, хүн хулгайлах, хар тамхи хэрэглэх, зөөх гэх мэт шинэ төрлийн гэмт хэргүүд гарч ирсэн. Иймд учраас хуулийн байгууллагын ажилтнууд цаг тухайд нь мэдэрч шаардлагатай бол хуулиа, зохион байгуулалтаа, арга барилаа өөрчилж, хурдаа нэмж, хасаж ажиллах шаардлага та бидэнд байгаа.

Улсын Ерөнхий прокурорын хувьд та бүхэнд сануулж хэлэх нэг зүйл байгаа. Энэ зөвлөгөөний дараа та бүхэн ажилдаа мэдрэгдэхүйц ахиц дэвшил гаргах хэрэгтэй. Мөрдөн байцаалтын ажиллагааг зөвхөн хүнийг дуудаж байцаадагаар хязгаарлахгүй, олон талтай болгох, ур чадвараа нэмэгдүүлэх шаардлагатай. Дээр нь орчин үеийн техник хэрэгсэл нэвтрүүлэх ажлыг бодлогын чанартай, дэс дараатай явуулах хэрэгтэй байна.

Шаардлагатай орчин үеийн техник хэрэгслээр бүрэн хангах, улсын хэмжээнд биш гэхэд төвдөө нэг иж бүрэн хэмжээний шинжилгээний лабораториттой болох тэнд ажиллах ажиллагсад нь техник хэрэгсэлээ бүрэн эзэмшсэн байх шаардлага гарцаагүй гарч байна. Зөвхөн дуудаж байцаах замаар гэмт хэрэг илрүүлнэ гэдэг хуучин арга барилаа өөрчлөх хэрэгтэй. Товчхондоо мөрдөн байцаах цоо шинэ арга барил нэвтрүүлэх хэрэгтэй байна.

Мөн хувь хүний ааш араншингаас хамаарч ихэнх тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хуулийн хугацаанд нь хийдэггүй, цаг алддаг, хууль зөрчдөг үүнээс болж нотлох баримт бүдгэрдэг, ач холбогдолоо алддаг үзэгдэл ялангуяа орон нутагт

нийтлэг байна. Хурааж авсан нотлох баримт ор сураггүй алга болдог, зарим нь түүнийгээ баяраар шагнал болгоод хуваж байна. Энэ нь огт байж болохгүй зүйл бөгөөд жирийн үзэгдэл болтлоо явж байгаа. Энэ бол завхарал шүү.

Мөрдөн байцаах ажиллагааны явцад бусдыг эрүүдэн шүүх хэлбэр, тухайлбал, хуурч мэдүүлэг авах, хорьж цагдна гэж айлган сүрдүүлэх зэрэг явдал тасрахгүй байна. Энэ бол XXI зууны ардчилсан Монгол Улсын мөрдөгчдийн амнаас гарч болохгүй үг бөгөөд ийм арга барилтай мөрдөн байцаагчид байх ёсгүй, ийм орон зай байх цаг өнгөрсөн гэдгийг анхааралдаа авч арга барил, ур чадвараа өөрчилж ажиллах шаардлагатай байгаа юм.

Саяхан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал гарсан. Үүнийг жирийн л байдаг заавар, журам, тушаал гэж битгий бодоорой. Ялангуяа Мөрдөн байцаах тасгийн дарга нар энэ тушаалыг хэрхэн хэрэгжүүлж ажиллах тал дээр бүхэл бүтэн бодлого болгож, хүмүүстээ нэг бүрчлэн тайлбарлаж ажиллаарай. Энэ бол хариуцлага, сахилгыг шат шатандаа чангатгах шийдвэр. Нөгөө талаас, хуулийн байгууллагууд бие биедээ буруулж чихэж манай байгууллагаас болоогүй цагдаагаас болсон, прокуроороос, шүүхээс болсон гэсэн байдлаар хэрэг төөрүүлэх, үг түүж суудаг нь гадна талдаа буруу харагдаг, хуулийнхан арчаагүй харагддаг. Энэхүү тушаал хариуцлагыг зааглан тогтоосон, прокурор, шүүх, мөрдөн байцаагчид нь ямар тохиолдолд хэн нь ямар хариуцлага хүлээх вэ гэдгийг тодорхой болгосон маш чухал тушаал байгаа юм.

Прокурор хэрэг мөрдөх ажиллагааг удирдах, хяналт тавих үүрэгтэй байдаг, прокурорын ур чадвар зарим тохиолдолд энэ хэмжээд хүрэхгүй байгааг бид ойлгож байгаа. Иймд хэд хэдэн чиглэлийн сургалт төлөвлөгдөж, явж эхлээд байгаа. Нөгөө талаас, прокурорын орон тоо ч хүрэхгүй байгаа бэрхшээл бий. Ийм учраас прокурорын байгууллагын орон тоог нэмэгдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн Улсын Ерөнхий прокурорын газраас "Хэрэг мөрдөх аргачлал, заавар"-ыг зүйл, ангиар нь боловсруулж баталж байгаа. Зарим ижил хэргийн хувьд бүлэг бүлгээр нь хэрэг шалгах заавартайгаар боловсруулж байна. Учир нь хэрэг хянаж байгаа прокурор хоёр адилхан хэрэгт хоёр өөр янзаар хандаж байгаа. Энэ бол хуулийг нэг мөр ойлгох, нэг мөр сахиулах үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна. Тиймээс шинэ зааврын дагуу прокуроруудтайгаа нягт хамтран ажиллах шаардлагатай болж байгааг анхааралдаа аваарай.

Гүйцэтгэх ажилтай холбоотой ганц хоёр зүйлийг энд хэлье.

Гүйцэтгэх ажил бол зөв хэрэглэж чадвал гэмт хэргийг илрүүлэхэд

маш ур дүнтэй арга хэрэгсэл мөн. Үүнийг хяналтгүйгээр хэрэглэх юм бол хууль болон хүний эрхийг зөрчдөг, байгууллагын хувьд ноцтой байдалд оруулдаг иймд ажиллагаа байдаг. Өнөөдөр гүйцэтгэх ажилд прокуророос тавих хяналт ёс төдий байгаа. Иймд учраас гүйцэтгэх ажилд тавих хяналтыг чангатгах тухай Улсын Ерөнхий прокурорын тушаал гарч байгаа, 10 дугаар сараас эхэлж дагаж мөрдөнө. Энэ заавар, журамд ороогүй арга хэлбэрээр, хүлээн зөвшөөрөгдөөгүй хэм хэмжээний дагуу гүйцэтгэх ажил явуулж, нотлох баримт цуглуулсан байвал үүнийг нотлох баримтын хэмжээнд үнэлэхгүй гэдгийг та бүхэн маш сайн ойлгох хэрэгтэй. Ялангуяа гүйцэтгэх ажил эрхэлж байгаа нөхдүүд онцгой анхаарах шаардлагатай.

Гүйцэтгэх ажил нэрээр хийгдэж байгаа хууль бус үйлдэл газар авсан байгаа шүү. Үүнд гүйцэтгэх ажил эрхэлдэг бүх байгууллага хамаатай. Тухайлбал, өнгөрсөн жил гарсан Авлигатай тэмцэх газрын дарга нарын хэрэг. Гүйцэтгэх ажил явуулж байгаа хүн мөрдөгдөж байгаа хүндээ баригдах түвшиндээ хүрч арга барил нь ядуурсан, эсвэл хэнэггүй болсон байхад хууль сахиулах, хүний эрх ярих ямар ч боломж байхгүй, иймд энэ чиглэлд онцгой анхаарч, шаардлага тавьж ажиллана.

Мөн зохион байгуулалтын шинж чанартай нэг зүйл байна. Хэрэг мөрдөх үйл ажиллагаанд цаг хугацаа алдах үүнээсээ болж хам хүм хэргээ боогоод прокурорт шилжүүлдэг. Хийж байгаа ажилдаа хайнга ханддаг, анзаардаггүй, тоодоггүй, прокурор нь ч олигтой хянахгүй, шүүхэд шилжүүлдэг. Энэ том дутагдал шүү.

Нөгөө талаас, мөрдөн байцаагчдаас шалтгаалахгүй нэг зүйл байна. Мөрдөн байцаагчид цагдаагийн үндсэн үүрэгт ажилд татагдан ордог, аж ахуйн ажил, элдэв мэдээлэлд дүгнэлт гаргах, харуул хамгаалалт болон бусад ажилд дайчлагддаг. Үүнээс болж тасралтгүй явагдаж байх ёстой мөрдөн байцаалтын үйл ажиллагаа тасалдаж байгаа нэг хүчин зүйл болж байна. Улсын Ерөнхий прокурорын хувьд Мөрдөн байцаах байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар гаргасан санал бий. Бүх мөрдөн байцаах албыг нийлүүлээд нэг статустай байгууллага болгох эсвэл мөрдөн байцаах байгууллагын ажилтнуудыг цагдаагийн үндсэн үүргээс чөлөөлөх хэрэгтэй байна. Элдэв ажилд дайчлагддаггүй болгох шаардлагатай байна. Өндөржүүлсэн бэлэн байдал нэрээр бүгдийг нь дайчилдаг, эсвэл ач холбогдол багатай мэдээ, мэдээлэл гаргаж ир гээд мөрдөн байцаах ажлын хажуугаар дарга нарын шаардсан элдэв бичиг, цаас гэсээр хамаг ажил нь явчихдаг. Мөн хог шороогоо цэвэрлэх гээд аж ахуй, санхүүгийн ажилд мөрдөн байцаагчид түүртэж явдаг, энэ асуудлыг таслан зогсоох шаардлагатай.

Өнөөдөр мөрдөн байцаах үйл ажиллагаа эрхэлж байгаа дервөн байгууллага өөр өөр санхүү, нөхцөл байдал, цалин ахуйтай ажиллаж

-8873-

Хууль зүйн
НОЛООН СЭН

байгаа. Авлигатай тэмцэх газрын мөрдөгчид санхүү, цалингийн хувьд цагдаагийн байгууллагатай адилтгахын аргагүй өндөр байна. Яагаад ингэж ялгаатай хандаж байгаа юм бэ. Прокурорын мөрдөн байцаах байгууллага байж байна. Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй. Гүйцэтгэх ажил явуулахгүй хэрэг илрүүлдэг агуу мөрдөн байцаагчид хаана байна. Мөн үнэн хэрэгтээ захиргааны нөлөөнд хамгийн их ордог байгууллага бол Тагнуулын мөрдөн байцаах алба юм. Эдгээр байгууллага харъяаллын онцлогоос болоод өөр өөр арга барил, өөр орчинд ажиллаж байна. Гэтэл мөрдөн шалгах ажиллагаа нэг л зарчмаар, нэг л орчинд явагдаж байх ёстой. Хэрвээ мөрдөн байцаагчдыг хэний ч нөлөөнд автуулахгүй байлгая гэвэл Мөрдөн байцаах байгууллагуудыг нэгтгээд Улсын Их Хурлаас удирдлагыг нь томилоод, бие даасан тусдаа статустай байгууллага болгох ёстой гэсэн зарчмын байр суурьтай байгаа.

Та бидний үйл ажиллагаанд бэрхшээл учруулж байгаа өөр нэг зүйл бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэд хэдэн зүйл ангиуд байгаа. Энэ чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулахгүй бол бидний үйл ажиллагаанд ихээхэн бэрхшээл учирч байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 151, 152, 153 дугаар зүйл ангиуд байна. Энэ зүйл ангиудад хохирлын хэмжээг зааж өгөөгүйгээс болоод бага бус хохирлын хэмжээнээс доош байсан ч эрүүгийн хэрэг үүсгэж шалгаж болохоор нөхцөл байдал үүссэн байгааг та бүхэн мэдэж байгаа. Тодорхойгүй хэрэг гэсэн үг. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 263, 264, 265, 266, 267 дугаар зүйл ангиуд байна. Үлэмж хэмжээний хохиролтой бол эрүүгийн хэрэг үүсгэхээр хуульчилсан байгаа. Тэгвэл бага бус хохирол учруулсан албан тушаалтны хэргүүдэд эрүүгийн харгуцлага хүлээлгэхгүй байхаар таарч байгаа. Энэ хэрэгт прокурорын зүгээс харахад бага бус хохирлоос эхэлж хохирлыг тооцож болмоор байгаа юм. Гэтэл хуульд тодорхой заагаагүй л байгаа. Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 202 дугаар зүйлд: "эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисоор хордуулсны улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан" гэж заасан бөгөөд байгальд учруулсан хохирлыг үлэмж хэмжээний гэдгийг яаж тодорхойлохыг заагаагүй. Бараг л өнөөдөр мөрдөн байцаагчид бусадтай нь адилтгаж, харьцуулаад явж байгаа байх. Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 205 дугаар зүйл байна. Энд аюултай болон бусад хог хаягдлаар байгаль орчин бохирдуулсаны улмаас их буюу онц их хэмжээний хохирол учруулсан бол гэсэн тодорхой бус заалт байдаг. Саяханы дуулиантай Эрдэнэбилэгийн гэх хэрэг байна, хэвлэл мэдээллээр шуугиад л байгаа. Үнэн хэрэгтээ хуулийн дагуу хорьж, мөрдөх хугацаа нь дуусан. Гэтэл хэрэг шалгаж дуусаагүй байх гэх мэт манай хуульд бэрхшээл учруулсан зүйл их байгаа. Ялангуяа тээврийн хөдөлгөөний аюулгүй

байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна. Энэ талаар гомдол их ирж байгаа.

Би энэхүү зөвлөгөөнийг ихээхэн ур дүнтэй болох байх гэж найдаж байна. Ялангуяа салбар хуралдаан дээр сайн ярилцах хэрэгтэй байна. Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байгаа хэд хэдэн зүйлийг нэн даруй өөрчлөх санал мөрдөн байцаагчдаас гарна байх.

Цааш цаашдаа прокурор, мөрдөн байцаах байгууллага урьдынхаасаа илүү нягт хамтран ажиллах, хуулийн байгууллагын ажилтнууд гэсэн нийтлэг уур амьсгалыг бүрдүүлэхийн төлөө прокурорын зүгээс санаачлага гаргаж ажиллаж байгаа.

Иймд бидний ажилд амжилт гарна гэдэгт найдаж байна.

Та бүхэнд амжилт хүсье, баярлалаа.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

"МӨРДӨН БАЙЦААЛТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ"

Эрхэм хүндэт зочид оо!
Эрхэм мөрдөн байцаагчид аа!
Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Мөрдөн байцаах ажилтнууд түүхэндээ 4 удаа улсын зөвлөгөөн хийж, алдаа дутагдал, олдолт амжилтаа дүгнэн хэлэлцэж, тодорхой шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж иржээ.

УМБГ-ын дарга, цагдаагийн хурандаа Ө.Энхтөр

"Улсын анхдугаар зөвлөгөөн"-ийг 1969 оны 12 дугаар сарын 15-нд зохион байгуулж Улсын прокурор Ж.Авхиа "Мөрдөн байцаалтын ажлын эдоогийн байдал, цаашид гавих зорилт" гэсэн илтгэл гавьж хэлэлцүүлжээ. Үүнээс хойш 1972, 1977, 1985 онуудад улсын 2, 3, 4 дүгээр зөвлөгөөнүүдийг зохион байгуулсан байдаг. Эдгээр зөвлөгөөнүүдээр тухайн цаг үеүүдэд эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль, холбогдох хуулийн заалтуудыг нэг мөр хэрэгжүүлж, байцаан шийтгэх ажиллагааг цаг алдалгүй шуурхай явуулахад мөрдөн байцаагчийн мэдлэг боловсрол, ажлын арга туршлагыг дээшлүүлэх, эрүүгийн хэргийг шуурхай илрүүлж, хуулийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг

хэлэлцэж ирсэн.

Өнөөдөр бидний Мөрдөн байцаах албаны түүхт 65 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулж байгаа мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн нь ардчилсан Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн явцад гарч байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлыг хэлэлцэж, мөрдөн байцаах албаны ажлын үр өгөөжийг дээшлүүлэх үнэтэй санал, зөвлөмжийг боловсруулахад оршино.

Ингэснээр улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, төр засгаас авч хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, эрх зүйн шинэчлэл, түүний дотор шүүхийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, түүнчлэн өнөөгийн нийгэмд гарч байгаа шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн үүргээ хэрэгжүүлэх, мөрдөн байцаалтын ажиллагааны шуурхай байдлыг хангах, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэхэд шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх зэрэг чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Мөрдөн байцаах алба үүсэн байгуулагдсан 65 жилийнхээ хугацаанд Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, байцаан шийтгэх ажиллагаа явуулах хуулиар хүлээсэн чиг үүргээ үе үеийн мөрдөн байцаагчид зохих түвшинд хэрэгжүүлж ирсэнийг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах алба сүүлийн 5 жилийн байдлаар эрүүгийн 53337 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 28203 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх, 16652 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, нийт 44855 хэргийг шийдвэрлүүлэхээр прокурорт шилжүүлсэн.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нийт хэргийн 90.2 хувийг нь хуулийн анхны хугацаанд, шалгасан нийт хэргийнхээ 84.1 хувийг эцэслэн шийдвэрлүүлэхээр прокурорт шилжүүлжээ.

Бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 22548 хэргээс 15657 бүюу 69.4 хувийг нь халуун мөрөөр нь илрүүлж, ЭБШХуулийн 205 дугаар зүйлийн 205.1.1-д заасан яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргээс 10679 хэргийг нөхөн илрүүлжээ.

Дээрх хугацаанд иргэд, байгууллагаас ирүүлсэн 124482 гомдол, мэдээллийг хүлээн авч шалган, 59506-д нь эрүүгийн хэрэг үүсгэх, 45977-г нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, 9437-г харьяаллын дагуу шилжүүлэх саналтай, 7737-г нь эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгажээ.

Мөрдөн байцаалтын явцад гэмт хэргийн улмаас бусдад учирсан нийт 276 тэрбум 840 сая төгрөгийн хохирлоос 78 тэрбум 121,8

сая төгрөгийг нь нөхөн төлүүлж, 152 тэрбум 354 сая төгрөгийн эд хөрөнгийг иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор битүүмжлэн хамгаалж, хохирлыг нөхөн төлүүлэх баталгааг хангасан байна. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн байдлыг авч үзвэл 2007 онд шалгасан гомдол, мэдээллийн 97,3 хувийг, 2008 онд 90,5 хувийг, 2009 онд 99,2 хувийг, 2010 онд 99,1 хувийг, 2011 оны эхний 8 сарын байдлаар 97,9 хувийг шийдвэрлүүлэхээр прокурорт шилжүүлээд байна.

Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албанд бүртгэгдсэн гэмт хэргийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл гэмт хэргийн гаралт буурсан боловч гэмт хэргийн бүтэц, шинж чанар өөрчлөгдөж, үйлдлийн арга нь нарийсч, бүлэг, зохион байгуулалттай хэлбэрт шилжиж байна. Энэ нь сүүлийн үед гарч байгаа гэр бүлээр нь болон олон хүнийг нэг дор санаатай алах, бага насны охидыг хүчирхийлж, амь насыг нь хохироох зэрэг онц ноцтой гэмт хэргээс иргэд, олон нийтэд мэдрэгдэж байгаа.

Мөн үндэстэн дамнасан гэмт хэрэг түүний дотор хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисын хууль бус худалдаа, хэрэглээ, тээвэрлэлттэй холбоотой хэргүүд дотоод, гадаадад гарч, бусдын бие махбодид гэмтэл учруулж танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих, хүн худалдаалах хэргүүд өсч цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Уул уурхай, ашигт малтмалын салбарын хөгжил нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах болсноор эдийн засаг, хөрөнгө оруулалтыг дагасан гадаад, дотоодын гэмт бүлэглэлийн зүгээс банк санхүү, хөрөнгийн зах зээл, татварын хууль бус ажиллагаа, мөнгө угаах гэмт хэргүүд үйлдэгдэж болзошгүйг анхааралдаа авч ажиллах шаардлага тулгарсан.

Өнөөгийн нийгэмд гарч байгаа шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаах ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор тус газрын бүтцэд Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх, Зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөх хэлтсүүдийг орон тоонд нь зохицуулан шинээр байгуулж, дүүргүүдийн ажлын ачаалалыг харгалзан мөрдөн байцаах 2 тасагтай болгон ажиллуулж байна.

Үүний зэрэгцээ мөрдөн байцаалтын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор албаны хэмжээнд хүрэх түвшингийн үзүүлэлтээ жил бүр тодорхойлж, нэг мөрдөн байцаагчийн шийдвэрлэх мөрдөн байцаалтын хэргийн тоо, гомдол, мэдээллийн түвшинг тодорхойлж, олныг хамарсан онц их хэмжээний хохиролтой, ээдрээ төвөгтэй, зохион байгуулалттай үйлдсэн хэргүүдийг шуурхай илрүүлж шалгахын тулд мөрдөн байцаалтын ажлын хэсгүүдийг томилж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ирлээ.

Эдгээр арга хэмжээний үр дүнд сүүлийн 5 жилийн байдлаар хуулийн хугацаа 4 хувиар, хэргийн шийдвэрлэлт 3 хувиар, хохирол нөхөн төлүүлэлт 12 хувиар өсч, мөрдөн байцаалтын шатанд ээлж холбогдогч нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг 26.8 хувиар, сэжигтэн, яллагдагч нь оргон зайлсан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг 70.1 хувиар тус тус буурсан ажлын эрэг узүүлэлт нь манай хамт олны хичээл зүтгэлийн үр дүн гэдгийг тэмдэглэхэд таатай байна.

Мөрдөн байцаалтын ажиллагаа, иргэдэд үйлчилэх үйлчилгээг шуурхай болгох, гэмт хэрэг түүнийг үйлдсэн этгээдийг халуун мөрөөр нь илрүүлж, шалгахад дан ганц байцаалтын арга хэрэглэн мөрдөн байцаагчийн ур чадварт найдах нь нийгмийн хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцэхгүй байгааг анхаарч шинжлэх ухаан техникийн дэвшил, шинэ техник, технологийг цаг алдалгүй нэвтрүүлэх нь нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага болоод байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Бид мөрдөн байцаалтын ажиллагаанд сүүлийн үеийн техник хэрэгслүүдийг хэрэглэж эхлээд байна.

Үүний тод жишээ нь ОХУ-д үйлдвэрлэсэн "Крис" маркын полиграфын техник хэрэгсэл ашиглаж иргэдээс асуулга авах явдал юм. Манай улсад хамгийн анхны полиграфч мэргэжилтэнг 2004 оны 1 дүгээр сард Москва хотод сургалтад бэлтгэж байсан түүхтэй бөгөөд өдгөө бид 8 дахь жилдээ албан хэрэгцээндээ уг техник хэрэгслийг ашиглаж байна. Уг техник хэрэгслийг хүнд, онц хүнд гэмт хэрэгт тулхүү ашиглаж, гаргасан дүгнэлтүүд нь эрүүгийн хэргийн шийдвэрлэлтэд зохих хувь нэмэр узүүлж байна. БНХАУ-д үйлдвэрлэсэн хэргийн газраас биологийн гаралтай бичил ул мөр, гар хөлийн болон тоосон мөр илрүүлэгч, олон долгионт 9 төрлийн гэрэл үүсгэгч төхөөрөмжийг үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

Мөн Мөрдөн байцаах албаны Онц хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтэс нь GPS, хэргийн газрын үзлэг хийх бүрэн тоноглогдсон автомашинтай боллоо.

GPS нь гэмт хэрэг гарсан газрыг өргөрөг, уртрагийн солбицлоор нь тодорхойлдог багаж юм. Үүнийг ашигласнаар хэргийн газрын байршил, үзлэг хийх үл хөдлөх цэг, явсан зам зэргийг хөдөлбөргүй тогтоохоо ихээхэн ач холбогдолтой юм. Өдөр ирэх тусам өөрчлөгдөн хөгжиж байгаа хот суурин газруудад нэг өдөр байсан барилга байшин, объект, эд зүйл үгүй болох явдал байнга гарч байгаа, хэргийн газрын үзлэгээр сонгосон үл хөдлөх цэг ч үгүй болох явдал байдаг. Иймд дээрх техникийг ашигласнаар энэ асуудал үгүй болно. Хэргийн газрын үзлэгийн байршил, үл хөдлөх цэгийн талаар цөөнгүй маргаан гардагийг мөрдөн байцаагчид та бүхэн мэдэх билээ.

Тоноглогдсон машин, техник, хэрэгсэл ч бидний ажилд ихээхэн тус дэм болж, хэргийн газрын үзлэг хийх, мэдээ, мэдээлэл авах, дээж

шинжилгээ авах, нүдэнд үл үзэгдэх ул мөр илрүүлэх гэрэл ашиглан түүнийг бэхжүүлэх, улмаар гэмт хэргийн илрүүлэлтэд чухал ач холбогдолтой.

Төрөөс хэрэгжүүлж байгаа "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр", "Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр", "Хүн худалдаалах, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр", "Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг хэрэгжүүлэх хөтөлбөр", "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр", "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтуудыг ханган биелүүлж, хэрэгжүүлэхэд мөрдөн байцаах алба үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байгаа билээ.

Ер нь аль ч улс орны цагдаагийн байгууллага, тухайн улсынхаа ямар нийгэмд оршин тогтнож байгааг үл харгалзан төр, нийгэм, иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл байдлыг хангах чиг үүрэгтэй ажилладаг бөгөөд Цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах алба нь цаашид энэ үүргээ нэр төртэйгээр биелүүлэх болно.

Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн хөгжлийн хурд, нийгмийн шаардлагыг үндэслэн мөрдөн байцаалтын ажиллагаанд дараах зүйлд анхаарал хандуулах шаардлагатай байна.

1. Улсын хэмжээнд яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 8437 эрүүгийн хэрэг байна. Үүний ард иргэдийн эрх ашиг зөрчигдөж, гэмт этгээд ял завшиж яваа. Иймд хэрэг бүрийг шуурхай бүрэн илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэх нь бидний үүрэг гэдгийг ямагт санаж, хэрэг бүрийг илрүүлэхийн төлөө ажиллах;

2. Цагдаагийн байгууллагын мэдээллийн орчинг илүү боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна. Гэмт хэргийн илрүүлэлт нь цаг хугацаатай уралдаж явагддаг ажил. Гэмт хэргийн талаарх мэдээллийг дамжуулах хурдыг сайжруулах, нөгөө талаар Прокурор, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Татвар, Гааль, Хил хамгаалах, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монголбанк, Авто тээврийн газар зэрэг байгуулагатай нэгдсэн сүлжээнд холбогдон мэдээлэл авах техникийн нөхцөлийг бүрдүүлж, мэдээллийн нэгдсэн санг өргөн цар хүрээтэй ашиглах хэрэгтэй;

3. Иргэд, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаанд онцгой анхаарч, ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгах хугацаар хэтрүүлдэг, хууль бусаар эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг гэх мэт зөрчил дутагдлыг гаргахгүй байх, нэгэнт хүлээн авсан гомдол, мэдээллийг

хуулийн дагуу чанартай, шуурхай шалгаж, иргэдийг чирэгдүүлэлгүй ажиллах;

4. Мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай, хуулийн дагуу явуулах, хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй, хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг баримтлан, яллах, цагаатгах талын нотлох баримтыг цуглуулах үүргээ хуульд заасны дагуу биелүүлэх;

5. Мөрдөн байцаагчид нь эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хүрээнд мөрдөн байцаах ажиллагаагаа явуулахаас гадна хуульд нийцүүлэн гаргасан заавар, журамд зааснаар албан үүргээ гүйцэтгэдэг. Гэтэл зарим хууль тогтоомж, заавар, журмууд нь Монгол Улсад даган мөрдөж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэх, ямар харилцааг зохицуулах талаар ямар нэг бүртгэл тооцоогүй байдгаас алдаа, дутагдал гаргах явдал байсаар ирсэн. Иймд цаашид мөрдөн байцаах ажиллагаанд хэрэглэгдэх хууль тогтоомж, заавар, журмыг эргэн харж боловсронгүй боловронгүй болгох, системчлэх, тэдгээрт өөрчлөлт оруулах талаар эрх бүхий байгууллагад тодорхой санал дэвшүүлэх;

6. Мөрдөн байцаагчдаас гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд хуулийг хэрхэн дагаж мөрдөх, хууль зөрчихгүйгээр албан үүргээ нэр төртэйгээр биелүүлэх нь тухайн алба хаагчийн мэдлэг боловсрол, түүнчлэн байгууллагын дүрэм, журмаар зохицуулагдах учиртайг анхаарч ажиллах;

7. Мөрдөн байцаах албаны үйл ажиллагааны шинэчлэл нь алба хаагчдын мэдлэг ур чадвартай салшгүй холбоотой тул алба хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч, сургалтыг чанартай явуулах, алба хаагчдыг тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөх чиглэлээр мэргэшүүлэн сургах шаардлагатай байна;

8. Алба хаагчдаас гадны ямар нэгэн нөлөөнд автах, нэр төр, алдар хүнд нь гутаан доромжлогдох, амь нас, эрүүл мэндэд нь хохирол учрах явдал байсаар байна. Энэ байдлыг таслан зогсоох тал дээр доривтой арга хэмжээ авч тодорхой судалгаа, баримтад тулгуурлан алба хаагчдын эдийн засгийн болон эрх зүйн орчинг сайжруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгүй болгох чиглэлээр эрх бүхий байгууллагад санал дэвшүүлэх цаг нэгэнт болсон;

9. Манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн хурдацтай байдлыг даган нийгмийн сөрөг үзэгдэл, үр дагаврууд шинээр бий болсоор байна. Өнөөгийн мөрдөн байцаах албаны бүтцэд цаг үеийн хандлагыг дагасан зарим төрлийн нэмэлт, өөрчлөлт, зохион байгуулалтыг хийх шаардлагатай байгаа нь статистик тоо баримт болон нийгмийн хүчин зүйлээр тодорхойлогдож байгаад дүгнэлт хийх шаардлагатай. Тухайлбал, Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, Экологийн аюулгүй байдал, Хөрөнгийн зах зээл, санхүү биржийн

эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэн энэ чиглэлээр төрөлжүүлэн ажиллуулах шаардлага бидний өмнө тулгараад байна.

Ингээд та бүхнээс өнөөдөр энэ салбар зөвлөгөөнүүдэд нэлээн олон асуудал яригдан би ерөнхий илтгэл дээрээ ерөнхийд нь мөрдөн байцаах албаны хэмжээнд байгаа алдаа дутагдал, чиглэл, ажлын үр дүнг тодорхойлсон. Тухайн салбар зөвлөгөөнүүд дээр та бүхэн оролцож холбогдох хууль тогтоомжууд, мөрдөн байцаах ажиллагааны өнөөгийн түвшин яг ямар байх бэ талаар үнэтэй санал, шүүмжлэл гаргана гэдэгт найдаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

"Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын V зөвлөгөөн"-ий илтгэл

ГЭМТ ХЭРЭГ ЗҮЙЛЧЛЭХ ОРЧИН ҮЕИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ*

Ю уны өмнө Монгол Улсад орчин цагийн мөрдөн байцаах алба байгуулагдсаны түүхт 65 жилийн ойг тохиолдуулан өнөөдөр улс орныхоо нийслэлд хуран цугларсан Монголын нийт мөрдөн байцаагчдад чин сэтгэлийн тэгэхдээ багшийн, эрдэмтний мэндчилгээ дэвшүүлж, та бүхэнд эрүүл энх, сайн сайхан ерөөлийг дэвшүүлж байна.

Мөрдөн байцаагчийн мэргэжил бол хуульчдын мэргэжил дотроос хамгийн хүнд, хамгийн няхуур бас их эр зориг шаардаг мэргэжил. Ялангуяа энэ мэргэжил шүүн таслах ажилагааны түүхий эдийг маш их чанартай, шударгаар, зөв бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой. Би мөрдөн байцаагчийн мэргэжлийг заримдаа геологичийн мэргэжилтэй харьцуулж жишихдуртай. Геологич хүн алт эрдэнэсийг илрүүлэхийн тулд хэрхэн яаж цуцалтгүй, тэсвэр тэвчээртэй, гярхай, нягт нямбай, мэдлэгтэй хөдөлмөрлөдөг билээ, яг түүнтэй адил мөрдөн байцаагч та бүхэн эрүүгийн хэргийн нотлох баримтыг олж тогтоох,

МУИС-ийн профессор, Академич С.Нарангэрэл

* Тус зөвлөгөөнд оролцсон мөрдөн байцаагчдад Академич С.Нарангэрлийн ярьсныг бичлэгээс хуулбарлан авсан болно.

илрүүлэх, тэдгээрийг хууль ёсны болгоход асар их оюуны бөгөөд бие махбодын хүнд хүчир хөдөлмөр зарцуулдаг. Ялгаад хүнд хүчир гэхээр сэтгэлийн асар их дарамттай, барагтай аавын хүү, ээжийн охинд тохиолдоод байдаггүй тийм хүнд хэцүү халуун зүйл руу заримдаа ордог, аль аль талын дарамт, шахалт ирдэг хүнд мэргэжил. Тийм учраас багшийн хувьд, эрдэмтний хувьд та бүхний ажил мэргэжилд үргэлж хүндэтгэлтэй ханддаг.

Миний та бүхэнд өнөөдөр ярих гэж байгаа "Гэмт хэрэг зүйлчлэх орчин үеийн тулгамдсан асуудлууд" гэсэн энэ сэдэв бол олон жил багшлах, эрдмийн ажил хийсний үр дүнд нэг талаас, нөгөө талаас практик ажил үйлсэд нэлээн хэдэн жил зүтгэсэн, нийслэлийн прокурорын орлогч, УЕП-ын туслах, хэлтсийн дарга, өмгөөлөгчийн гэсэн олон практик ажил хийсний үр дүнд та бүхэнд цаашдын чинь ажил үйлсэд сургамжтай, хэрэгтэй зарим нэг зүйлийг ярьж хэлье гэж бодсон.

Ер нь мөрдөн байцаагчийн ажил мэргэжлийг онолын хувьд авч үзэхээр гурван үндсэн хэвшмэл үйлдлээс бүрддэг.

Нэгдүгээрт. Юуны өмнө болж өнгөрсөн тэр хэрэг явдлыг болж өнгөрсөн тэр чигээр нь сэргээн тогтоох үйл ажиллагаа. Үүнийг нотолгоожуулахтай холбоотой асуудал гэж хэлж болно. Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны хамгийн гол үндсэн нөхцөл нь юуны түрүүн бидний амьдралд болоод өнгөрсөн тэр хэрэг явдлыг болсон чигээр нь нотолгоожуулж сэргээх үйл ажиллагаа байгаа юм. Энд буруу зөрүү зүйлүүд гараад ирэх юм бол цаашдын бүх зүйл буруудчихна. Үүнд онцгой анхаарах хэрэгтэй.

Эрхэм хүндэт мөрдөн байцаагчид аа. Өнөөдөр өдөр тутам гарч байгаа, намайг ингээд та бүхэнтэй уулзаж байгаа энэ үед үйлдэгдэж байгаа тэр гэмт хэргүүд та бидний хүсэл зоригоос огт шалтгаалахгүй. Тэнд та бидний ямар нэгэн оролцоо байхгүй. Нэг бүрчилсэн шинжээрээ дахин давтагдахгүй. Жишээлбэл, Хүн амины хэрэг гэхэд субъектын онцлог шинж, хэрэглэсэн арга ч байдаг юм уу, сэжигтэн, хохирогчийн хоорондын харьцааны асуудал, цаг хугацаа, газар орон, сэдлэг, хэрэг болсон шалтгаан зэрэг нь дахин давтагддаггүй. Та бүхний ажил мэргэжлийн ур чадварын нэг нэг гол үзүүлэлт чухам үүнд оршиж байгаа юм. Энд нотлох баримтыг ямар нэгэн байдлаар хайхрахгүй орхих, ач холбогдолгүй гэж үзэх явдал нь цаашдаа нотолгоожуулах үйл ажиллагаанд их сөргөөр нөлөөлдөг юм.

Намайг хотын прокурорт ажиллаж байхад хүн амины ноцтой хэрэг гарсан, тэр нь нэг залуу эмэгтэйг алаад жорлонд булсан хэрэг. Нэлээн олон жилийн турш мөрдөн байцаалтын ажиллагаа үргэлжилсэн. Сэжиглэгдэж байгаа нөхөр хардалтаар алсан гэдэг нь тодорхой боловч гол, шууд нотлох баримтаа бид олж чадаагүй. Бүр сүүлд нь арга ядаад дахин эксгумац хийсэн, урьд өмнө нь бүх юмыг нь задалж үзсэн юм уу гэдэг асуудал тавьсан чинь гадна талын үзлэг хийгээд

орхисон. Эксгумацын үр дүнд хохирогчийн үтрээ рүү нь цаас хийгээд чихчихсэн, цаасыг шинжилгээнд өгсөн чинь хохирогчийг ална гэсэн бүх заналхийллээ бичээд үтрээнд нь хийгээд булчихсан байв. Үүний дараа л энэ гэмт хэрэг ямар ч хөдөлгөөнгүйгээр онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хүн амины санаатай хэрэг болох нь тогтоогдсон.

Ийм учраас аливаа мөрдөн байцаагчийн мэргэжлийн дахин давтан хэлэхэд нэг дэх үндсэн хэвшмэл үйлдэл бол ерөөсөө нотолгоожуулалтын асуудлыг хөдөлбөргүй тогтоох асуудал. Энэ дээр алдвал зүйлчлэл зөв болж чадахгүй. Сүүлийн үед энэ асуудалд төвөгтэй байдал үүсч байна. Яагаад гэхээр хэргийн сонирхогч талууд, ялангуяа сэжиглэгдэж байгаа тал хэргийн ул мөрийг үгүй болгох, нотолгоожуулалтыг саармагжуулах зорилгоор хэмжээ хязгааргүй асар их мөнгө шиддэг болсон. Тэрний төлөө хэнийг ч, юуг ч худалдаж авахаас сийхгүй ийм байдалд тэд хүрдэг. Тэр сонирхолдоо та биднийг худалдаж авах гэж оролдог. Түүнчлэн улс төрийн элдэв нөлөөлөл орох боллоо. Хэрвээ энэ байдалд онцгой анхаарахгүй бол Монгол Улсад мөрдөн байцаалтын үйл ажиллагаа хэвийн, шударга ёсоор явагдахад нэн төвөгтэй болно. Ялангуяа энэ бол зах зээлийн тогтолцооны их өвөрмөц шинж байгаа юм. Хуучин тогтолцооны үед ийм зүйл бараг байгаагүй. Одоо бол та бүхний ажиллаж байгаа нөхцөлийн хамгийн гол хүндрэл нь энд байгаа гэдгийг зориуд тэмдэглэж хэлье.

Хоёрдугаарт. Мөрдөн байцаагч Эрүүгийн хуль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудын жинхэнэ мэргэжилтэн байх ёстой. Яагаад гэхээр өнөө болж өнгөрсөн хэрэг явдал иргэний хэргийн зөрчил юм уу, гэрээ юм уу, эсвэл захиргааны эрх зүйн зөрчил юм уу, эсвэл сахилгын зөрчил юм уу, эсвэл ёс суртахууны гажуудал юм уу үүнийг мөрдөн байцаагч таньж, ялгаж ямар гэмт хэрэг гэдгийг тогтоох ёстой. Энэ дээр бид олон алдаа гаргаж байна. Юуны өмнө бид гэмт хэргийг иргэний эрх зүйн зөрчлөөс зааглан ялгаж чаддаггүй. Ялангуяа гэрээнүүдээс зээлийн гэрээ, бусад гэрээ. Хэрвээ зээлдүүлсэн тал хүчтэй байх юм бол өнөөдөр зээл авчихаад эрсдэлд орсон тэр хүн бол зээлийн хэмжээ ЭХ-д заасан их, онц их хэмжээнд хүрсэн л байх юм бол олон жилийн хугацаагаар нийгмээс тусгаарлагдаж, эрх чөлөөгүй, хамгийн хатуу цээрлэлийг амссан, Монголын шоронд суугаа олон аавын хүү, ээжийн охин байгаа. Тодорхой хэргүүдийн баримт жишээ ч бий. Захиргааны зөрчил юм уу, гэмт хэрэг юм уу. Иймэрхүү хэргүүд танхайн хэрэгт маш их хэмжээтэй гарна. Сүүлийн үед ёс суртахууны, харьцааны гажуудалтай хэргийг танхайн гэмт хэрэг гэж зүйлчлээд шоронд ял эдэлж байгаа хүмүүс маш их байна. Би орон нутагт гарсан нэг хэргийг та бүхэнд ярья.

Монгол эрчүүд бол ханьдаа, гэр бүлдээ эрүүлдээ, нүүрэн дээр нь юу ч хэлж чаддаггүй. За л гээд байдаг. Жаахан ууж идээд, зоригоо чангалсныхаа дараа бол ёстой хэлэх үгээ сайн хэлдэг. Нэгэн малчин нөхөр ууж идэж ирчихээд авгайдаа баахан агсам тавиад аяга, галын

хайч авгайруугаа авч шидээд эхнэрийнхээ нүүрэнд жаахан зулгаралт, хөнгөн гэмтэл учруулжээ. Авгай нь нөхрөө хашраагаад өгье, цагдаагийнхан хэд хоног баривчлаад, залхаачихаж магадгүй гээд аймаг руу ачуулаад явуулчихжээ, тэгсэн чинь зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн танхайн хэргээр нөхөр нь 5 жилийн хорих ял уншуулсан чинь эхнэр нь уйлж орилоод, одоо миний нүүрэн дээр ямар ч шарха сорви байхгүй, арилчихсан. Миний нөхөр ийм олон жилээр хоригдох ноцтой хэрэг үйлдээгүй гэжээ. Иймэрхүү гэмт хэргийн шинжтэй биш, айл гэрийн дотор болдог, эрчүүдийн гар зөрүүлэх амьдралын асуудал, хүмүүсийн хоорондын таагүй харьцааг гэмт хэрэгтэн болгоод явуулчихдаг явдал газар авч байна. Хор уршгийн хэр хэмжээгээр бус харин хэлбэрийн шинжээр шоронд сууж буй хүмүүс цөөнгүй байна. Монголын шоронд сууж байгаа хүмүүсийн тоо одоо 10 мянга дөхөж байна. Тухайн улс орон хэр зэрэг шоронжилтой улс орон гэдгийг тогтоодог дэлхий нийтийн стандарт нь 100,000 хүн амд хэдэн хоригдол оногдож байна гэдгээр тогтоогддог. Тэгэхдээ нийт хүн амаас бус харин гэмт хэргийн субъект хэдэн наснаас эхэлж байна, манайхаар бол 14 нас, бүрэн чадвар нь 16 нас. Ийм статистикаар үзвэл манайх дэлхийд их дээгүүр орчихсон.

Мөрдөн байцаагчийн өдөр тутмын үйл ажиллагаа бол бүх хуулиудаа мэддэг, хоорондын зааг ялгаа, ёс суртахуун, хуулийн биш нийгмийн хэм хэмжээний зөрчил, гажуудлуудыг зааглаж чаддаг ийм мэдлэг, ур чадварыг төгс эзэмших явдал юм.

Гуравдугаарт. Мөрдөн байцаагчийн мэргэжлийн нэг гол шалгуур бол гэмт хэргийг зөв зүйлчлэх явдал юм. Хэрэв үнэн зөв, хөдөлбөргүй тогтоогдсон өнгөрсөн хэрэг ба эрүүгийн хуулийн зүйл хэсэг хоорондоо яг тохирч байвал зүйлчлэл зөв болно. Эрхэм хүндэт мөрдөн байцаагчдаа Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид "гэмт хэргийн шинж тэмдгийг ялимгүй агуулсан хэргийг гэмт хэрэгт тооцохгүй" гэсэн заалт байгаа. Одоо энэ заалтыг хэрэглэж асуудлыг шийдэж байгаа мөрдөн байцаагч байна уу, үгүй юу. Бүгдийг нь хэрэг гэж боогоод, явуулчихаж байна уу. Сүүлийн үед олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлсөн 10 жил хоригдсон, 2 удаагийн үйлдэлтэй эмэгтэйн тухай шуугисан шүү дээ. Хүний эрхийн хуульч Ичинноров энэ талаар зөвлөгөө авах гэж над дээр орж ирсэн юм. Чи ялимгүй хэрэг гэвэл л хөөцөлдөлдөө. Наадах чинь өлмүүн, зэлмүүний улмаас жаахан идэх юм авсан 2 удаагийн жижигхэн үйлдэлтэй. Үүнийг мөрдөн байцаагч тэр үед нь тэгээд л шийдчих байсан байхгүй юу. Шүүгч ч анзааараагүй бас л тэгээд л явуулчихсан, тэгээд л 10 жилтэй гэсэн. Ийм учраас гэмт хэргийн зүйлчлэл гэдэг бол болж өнгөрсөн хэрэг явдал, дагаж мөрдөж буй эрүүгийн хууль хоёр хоорондоо нийцэж, тухайн тодорхой хэрэг ямар гэмт хэрэг вэ, ямар гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулсан хэрэг вэ гэдгийг тогтоох үйл ажиллагаа. Энэ үйл ажиллагаа бол маш олон талын эрх зүйн ач холбогдолтой. Гэмт хэрэг зүйлчлэхийн ач

холбогдолын тухай та бүхэнд хэлэхэд ЭБШийтгэх маш олон үйлдлийг зөв хийхэд зүйлчлэл шууд нөлөөлнө. Жишээлбэл, Зүйлчлэлээс шалтгаалаад хэргийн ангилал гараад ирнэ, хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд. Хүнд, онц хүнд болоод ирэхээр хорьж цагдах асуудал үүснэ. Эд хөрөнгө битүүмжлэх, албан тушаалаас нь түдгэлзүүлэх, ялангуяа мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн үйл ажиллагааны эхний шатанд гэмт хэргийн зүйлчлэл баримжаа төдий байна. Цаашдаа улам нарийсч гүнзгийрэх ийм логик нарийн үйл ажиллагаа явагддаг.

Гэмт хэргийн зүйлчлэлээс ялтай холбоотой бүх асуудал шалтгаалдаг. Шүүх ямар ял өгөх вэ, ЭХ-д заасан онц хүнд, хүнд хэргүүдийн дийлэнх нь доод санкцийг тогтоож, 5-аас дээш, 8-аас дээш гэх мэт байгаа. Дараа нь ял эдэлж байх үеийн асуудал нь зүйлчлэлээс бас шалтгаална. Хугацаанаас нь өмнө суллах, өршөөлд оруулах гэх мэт. Иймд гэмт хэрэг зүйлчлэлийн асуудал бол мөрдөн байцаагчдын мэргэжлийн ур чадвааруудын үндсэн үзүүлэлтийн нэг гэдгийг би та бүхэнтэй өнөөдөр уулзсаных онцлон тэмдэглэн хэлье гэж бодсон юм.

Гэмт хэрэг зүйлчлэх явцад өөр нэг анхаарах асуудал бол ойролцоо төрлийн гэмт хэргүүдийг хооронд нь зааглаж ялгах асуудал байгаа. Энэ нь мэргэжлийн ур чадвартай холбоотой асуудал, бас хууль тогтоомжийн боловсронгуй бус, хийдэлтэй холбоотой асуудал. Одоо энэ асуудлууд бол МУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүх бүлэгт хийдлийн асуудлууд үүссэн. Жишээ нь. Хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгтэй холбоотой нэгэн жишээ ярья. Мөрдөн байцаагчид хүн амины санаатай, болгоомжгүй хэрэг, хүнд гэмтэл учруулсан хэргийг хооронд нь зааглаж, ялгаж чадахаа больчихсон. Ер нь ч олон жилийн туршид элгээр хэргийг зааглаж, ялгах асуудал мөрдөн байцаагчийн мэргэжлийн ихээхэн төвөгтэй асуудал болж Монгол Улсад хуримтлагдсан юм. 2002 оны ЭХ-ийн төслийг боловсруулах явцад мөрдөн байцаагчдаас санал авсан. Тэр саналаар дийлэнх олон мөрдөн байцаагч ЭХ-д байгаа санаатай хүнд гэмтэл учруулах хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд "энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол" гэсэн хүндрүүлэх шинжийг хасаад өгчихвэл хүн амины гэмт хэрэг хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэргийг ялгаж салгаж, хэрэг буддаг, чирэгдүүлж байна гэдэг явдал багасна гэсэн асуудал тавьсан. Энэ үндсэн дээр төсөл боловсруулагчид хассан. УИХ-ын чуулганд Эрүүгийн хуулийн төслийг бэлтгэх хэсэгт эл хүндрүүлэх шинжийг хасаж огт болохгүй гэсэн санал тавьсан. Харамсалтай нь миний саналыг хүлээж аваагүй. Одоо нөхцөл байдал ямар байна гэхээр тухайн этгээд хүнд гэмтэл учруулсан тэр хор уршгийг бий болгосон үйлдлээс санаатай хандсан, хор уршигтаа болгоомж, хайхрамжгүй хандсан ийм хэрэг бол одоо хүн амины санаатай хэрэг болчихсон. Хэрэв жаахан хэлбэрийн төдий онцлон хүндрүүлэх шинж байх юм бол хүн амины санаатай хэрэг болчихоод байх юм. Ө.Энхтөр даргын тавьсан илтгэлийг сонсож байхад хүн амины санаатай гэмт хэрэг нэмэгдэх

хандлагатай болсон байна. Гэхдээ дэндүү ингэж өсөөд байгаагийн тодорхой шалтгаан нь зүйлчлэлд байж болох юм. Үүний улмаас маш олон хүн хэт их хүнд цээрлэлийг хүлээчихсэн. Тэгээд хуульд ийм өөрчлөлт орчихсоны улмаас мөрдөн байцаагчдын толгой ажиллахаа больсон. Хүн амины санаатай хэрэг, хүн амины биш хэргийг ялгадаг шинжлэх ухааны шалгуур нь юу байдаг вэ гэхээр алах гэсэн санаа заавал байгааг тогтоох ёстой. Яаж тогтоох вэ? гэвэл гэмт этгээд нь ямар зэвсэг хэрэглэсэн эсэх амин тус газар нь эхлээд чиглэсэн, сэжигтэн, хохирогч хоёрын хоорондын харьцаа, шалтгаан юу байсан, хэрэг болсон цаг үе, нөхцөл байдал энэ бүх объектив нөхцөл байдлууд алья гэсэн санааг тодруулаад гаргаад өгчихнө. Эдгээр нөхцөл байдлыг нотлох баримтуудаар мөрдөн байцаагч тодруулаад гаргаад тавьчихсан байх ёстой. Хэрвээ тэр гарч ирэхгүй бол хүн амины хэрэг биш болоод явчихна.

Одоо зөвхөн шинжээчийн дүгнэлт шууд үхэлд хүргэжээ гэсэн бол санаатай хэрэг гэж үздэг. Гэтэл цаана чинь хүнд гэмтэл санаатай учруулчих, алья гэсэн санаа байхгүй байдаг. Хохирогч хайхрамжгүй хандаад, тухайн үед эмнэлгийн тусламж авч чадаагүй, эмнэлэгт үзүүлээгүй, тэрнээс болоод хууч өвчин нь хүндрээд нас барсан, эсвэл эмнэлгийн ажилтнууд хариуцлагагүй хандсанаас нас барсан ийм хэргүүдэд олон арван хүн "хүн амины санаатай хэргээр" шоронд хатуу цээрлэл хүлээх ийм нөхцөл байдал манайд бүрдсэн байна.

Мөн эдийн засгийн хэрэг дээр өмчийн хэргүүдийг зааглаж ялгах асуудал маш төвөгтэй болсон. Албан тушаалынхаа байдлыг урвуулан ашиглаж ашиглан шамшигдуулсан хэрэг мөн үү, аль эсвэл албан тушаалаа урвуулчихсан албан тушаалын хэрэг үү. Үүнийг өнөөдөр Монголын хууль зүйн практикт ялгаж чадахгүй болсон. Үүнд мөрдөн байцаагчдын ур чадвар ч дутаж байна, дээр нь хуулийн хийдэл ч бас их нөлөөлж байна. 2002 оноос өмнөх хуульд эдгээр хэргүүдийг ялгадаг шалгуурыг заасан байсан. Тэр шалгуурыг аваад хаячихгүй юу. Тэр шалгуур нь хулгай, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, далайлган сүрдүүлэх гэсэн энэ 5 төрлийн гэмт хэргийг ашиглан шамшигдуулах шинжтэй гэмт хэрэг гэж үздэг. Энэ шинжээрээ бусад хэргээс ялгагдана. Жишээлбэл, залилан мэхлэх гэмт хэрэг энэ шинжээрээ эрсдэлтэй зээл буюу иргэний эрх зүйн зөрчлөөс ялгагдана. Зээлийн гэрээний гүйцэтгэл хангагдаагүй явцад тухайн зээл авсан хүнд ашиглан шамшигдуулах зорилго огт байдаггүй. Ашиглан шамшигдуулах бол 4 үндсэн шинжээр тодорхойлогдоно.

1.Шунахай, 2.Хууль бус, 3.Буцааж огт төлөхгүй, 4. Бодитой хохирол учруулсан гэх.

Эрүүгийн хуульд байгаа ойролцоо төрлийн гэмт хэргүүдийг хооронд нь зааглан ялгана гэдэг маш төвөгтэй бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлд төрөөс өгч буй эрх зүйн үнэлэлтийн асуудал. Энэ асуудлууд зөвхөн хууль зүйн асуудал биш. Цаанаа Монгол Улсын

язгуур эрх ашигтай холбоотой асуудал. Үүнийг буруу зүйлчилснээс болоод хэргийн холбогдогчид төдийгүй тэдний ойр дотны хүмүүс би Монгол Улсын иргэн мөн үү, би монголын төрөөр эрх ашгаа хамгаалуулдаг иргэн мөн үү гэх эргэлзээ төрөх явдал газар авч байна.

Манай хууль зүйн практикт болсон нэг жишээ ярья. 20-иод насны урьд нь ял шийтгэлгүй 5 залуугийн хэрэг. Хэргийн болсон үйл явдал нь 5 залуугийн гэрийн ойролцоо хятадын тоосгоны жижиг үйлдвэр ажилладаг байжээ. Үйлдвэрийн хятад ажилчид тэр 5 залуугийн 2-ынх нь нохойг нь идшиндээ хэрэглэчихсэн. 5 залуу жаахан айраг уучихаад үйлдвэр рүү орж хятадуул руу замаггүй буугаар айлган сүрдүүлж байхад цагдаа ирээд тэднийг аваад явсан. Шүүх энэ залуучуудад 5-аас дээш жилийн ял ногдуулсан. Энэ хэргийг мөрдсөн мөрдөн байцаагч, хянасан прокурор, анхан, давах болон хяналтын шатны шүүгчид юуны төлөө төрөлх нутагтаа байгаа монгол эх оронч залуус ийм хүнд ялаар цээрлүүлэх болов оо? Тийм учраас гэмт хэргийн зүйлчлэлийг хийх асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй зөв хандах хэрэгтэй байна. Хэрэг бүр давтагдашгүй, өөр хувь заяа, өөр амьдрал түүний цаана байгаа шүү гэдэг асуудалд мөрдөн байцаагчид их чадварлаг хандаж, мэргэжлийн хуульчийн ёс зүйн чадварыг ч чанд сахих ёстой. Манай зарим мөрдөн байцаагчид сэжигтэн, яллагдагч, хохирогч, гэрч, ЭБША-ны бусад оролцогчидтой харьцахдаа хувь хүнтэй харьцаж байгаа мэт авирлах юм. Гэтэл та бүхэн хувийн харилцаанд байгаа биш шүү дээ. Нэг талд төрийг төлөөлж та, нөгөө талд хар цагаанаа ялгуулах гэсэн байгаа. Тийм учраас чи би дээ хүргэлгүй болж өгвөл та, болохгүй бол өөрөө гэж харьцаж байгаарай.

Би хуульчийн ёс зүй төдийгүй ер нь монголчуудын ёс зүйн талаар сүүлийн 5 жилд судалгаа хийсэн. Тэр шударга ёс гэдэг чинь ёс суртахуундаа суурилдаг юм байна. Тийм учраас хэзээ монгол орны хууль зүйн бүхий л салбарын үйл ажиллагаа сайн болохов гэхээр ёс суртахууны эрхэм шинжүүдэд суурилсан цагт. Монголын нийгэм нийтдээ оюун санааныхаа асуудалд онцгой анхаарахгүй бол цаашдаа хөгжлийн зөв, баттай чиг хандлага ажиглагдахгүй байна.

Төгсгөлд нь, цаашдаа монголын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг боловсронгуй болгох, төгөлдөржүүлэхэд та бүхний практик, дадлага туршлага, оролцоо их хэрэг болно.

Төрийн их танхимд монголын нийт мөрдөн байцаагчдад хандаж жаахан эрдэм номны дуу сонсгох боломж олгосон ЦЕГ, Мөрдөн байцаах газрын удирдлагад баярлалаа, Эрхэм хүндэт мөрдөн байцаагч та бүхэнд дахин эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье.

Баярлалаа

ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНЫ ҮЕД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Эрүүгийн хэрэгт явуулах байцаан шийтгэх ажиллагааг улс орны хөгжлийн чиг хандлага, орчин цагийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох асуудал нь зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч зэрэг хууль хэрэгжүүлэгч нарын төлөө хийж байгаа ажил биш, энэ бол Монгол улсад эрх зүйн баталгаат орчныг бүрдүүлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, нийгэмд шударга ёсыг тогтоож, цаад утгаараа иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, тэдний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх найдвартай ажиллагаатай механизмыг бүрдүүлэх зорилготой үйл ажиллагаа бөгөөд энэ бүхэн иргэдийн хувьд амин чухал зүйл гэдгийг тэмдэглэн хэлэхийг хүсч байна.

Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Б.Батцэрэн*

Ингээд мөрдөн байцаагчийн улсын зөвлөлгөөнд илтгэл тавих завшааныг ашиглан дараахь багц асуудалд та бүхний анхаарлыг хандуулья. Үүнд:

---

* Хамтран зохиогчид: Нийслэлийн шүүхийн шүүгч Х.Эрдэнэсувд, Баянгол дүүргийн шүүхийн шүүгч Т.Өсөхбаяр

1.Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үед нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд анхаарах зарим асуудал;

2. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахад анхаарах асуудал;

3. Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал, тэдний сэтгэл зүйд учирсан хохирлыг үнэлэхүйц нотлох баримтыг цуглуулах, үнэлэх асуудал.

Нэг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үед нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд анхаарах зарим асуудал

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт "Энэ хуулиар тогтоосон журмыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч, бусад оролцогч дагаж биелүүлнэ" гэж заасан бөгөөд дээрх субъектүүд нь энэ хуулийн зааалтыг хэлбэрэлтгүй сахиж ажилласнаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны өмнө тавигдаж буй зорилтыг хангаж, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох боломж бүрдэнэ.

Эрүүгийн хэргийг шүүх хуралдааныг хянан хэлэлцэх үед өмгөөлөх талаас ихэвчлэн "хэргийг нэмэлт мөрдөн байцаалтанд буцаах" санал гаргаж, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарыг хэтэрхий нэг талыг буюу яллах талыг барьж, үүнтэй холбоотой нотлох баримтыг цуглуулдаг гэсэн шүүмжлэл гаргадаг нь нууц биш. Иймд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд яллах, цагаатгах талын нотлох баримтын аль алиныг цуглуулах, үүнтэй холбоотой өмгөөлөгч нарын гаргасан санал, хүсэлтэд анхаарал хандуулж, зохих журмын дагуу шийдвэрлэж байх нь зүйтэй.

Мөн шүүгдэгч нарын зүгээс мөрдөн байцаагч хуурч мэхэлсэн, дарамт, шахалт үзүүлж хэрэг хүлээлгэсэн гэж цөөнгүй мэдүүлж байгаа бөгөөд ийнхүү мэдүүлэг өгсөн шүүгдэгч нар нь мөрдөн байцаалтын үед ихэвчлэн өмгөөлөгчгүй мэдүүлэг өгсөн байдаг.

Хэдийгээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд өмгөөлөгч оролцуулахгүйгээр сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авч болох ч тэдний боловсрол, хууль зүйн мэдлэг дутмаг, төлбөрийн чадваргүй байдалд онцгой анхаарч, аль болох өмгөөлөгч оролцуулан байцаан шийтгэх ажиллагаа явуулах нь хүнийг хилс хэрэгт шийтгүүлэх, нөгөө талаас хуурч мэхлэх, дарамт, шахалт үзүүлэх замаар хэрэг хүлээлгэсэн гэх асуудалд цэг тавьж, цаашид ийм гомдол гарахгүй байх нөхцөл бүрдэх юм.

Шүүхээс нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд буцаасан хэргүүдийн алдаа, зөрчлийн дийлэнхийг дараах үндэслэлүүд эзэлж байна. Үүнд:

- Гэрч, хохирогч нарын мэдүүлэг зөрүүтэй байхад мэдүүлгийн зөрүүг арилгаагүй, бусад нотлох баримтаар хэргийн бодит байдлыг тогтоох ажиллагаа хангалттай хийгдээгүйгээс шүүх хэрэгт авагдсан нотлох баримтыг үндэслэн үйл баримтыг зөв тогтоож, хууль зүйн дүгнэлт хийх нөхцөл бүрдэхгүй байна. Иймд эрүүгийн хэргийг нотлох ажиллагаа нь хохирогч, гэрч нарын мэдүүлэг дээр түлхүү тулгуурлаж байгаа өнөөгийн практикийг эргэн харж, цаашид орчин үеийн техник хэрэгсэл, технологи ашиглах замаар мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахыг цаг үе шаардаж байна;

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж, чанар, хэр хэмжээг нарийвчлан тогтоох ажиллагаа хангалтгүй хийгдэж байна. Гэмт хэргийн халдлагын зүйл болсон эд зүйлст үнэлгээ хийж, хохирлын хэмжээг тогтоохдоо хохирогчийн гаргасан үнэлгээний саналыг үндэслэн гэмт хэргийг мөрдөн шалгаж байгаа дүүргийн санхүүгийн хэлтсийн ажилтнуудаар үнэлгээ тогтоолгож байгаа нь зарим тохиолдолд шаардлага хангахгүй байна. Хохирлын үнэлгээ бодитой, үндэслэл бүхий хийгдээгүйгээс материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн хувьд хэргийн зүйлчлэл дээр маргах явдал гарч байна. Иймд ЭБШХ-д заасны дагуу шинжээч томилж, үнэлгээг тогтоолгож байх нь зүйтэй;

- ЭБШХ-ийн 42, 43 дугаар зүйлд заасан хохирогч, иргэний нэхэмжлэгч гэсэн ойлголтууд нь биеэ даасан ойлголтууд гэдгийг анхаарч, мөрдөн байцаалтын үед хохирогч, иргэний нэхэмжлэгчийг зөв тогтоож, иргэний нэхэмжлэгч нь хэнд холбогдуулан ямар шаардлага гаргаж байгааг тодруулж, зохих этгээдийг иргэний хариуцагчаар татаж байх нь гэм хорын хохирлыг эрүүгийн хэрэгтэй хамтруулан нэг мөр шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой;

- Зарим эрүүгийн хэрэгт нотариатын олгосон итгэмжлэлийг үндэслэн жинхэнэ хохирогчоос өөр этгээдийг хохирогчоор тогтоож, улмаар байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулж байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийг зөрчиж байна. Иймд гэмт хэргийн улмаас хохирсон этгээд нь эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо өөрөө хамгаалж чадахгүй нөхцөлд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар хэнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болохыг заасан зохицуулалтын хүрээнд хохирогчийг тогтоож байх нь зүйтэй;

-Шинжээчийн дүгнэлт гаргуулах аар шинжээч томилсон тогтоолыг шинжээчид танилцуулж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254, 255 дугаар зүйлийг сануулж гарын үсэг зуруулаагүй, шинжээчийг татгалзан гаргах эрхийг бусад оролцогч нарт эдлүүлээгүй буюу шинжээчийн дүгнэлт гаргуулах ажиллагааг хуульд нийцүүлэн явуулаагүйгээс дахин шинжээчийн дүгнэлт гаргуулах, цаашлаад дахин дүгнэлт гарах үед шинжилгээ хийлгэх цогцос, эд зүйлс муудах, дахин дүгнэлт гаргах боломжгүй болох зэргээр хүндрэл учирч байгаад анхаарч, дээрх ажиллагаанд хариуцлагатай хандах шаардлагатай байна;

- Гэрч, хохирогч нар санаатай худал мэдүүлэг өгөх, шинжээч санаатай худал дүгнэлт гаргах зэргээр байцаан шийтгэх ажиллагаанд саад учруулах тохиолдол гарч байгааг анхаарч, тэднийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254, 255 дугаар зүйлийн зохих зүйл хэсэгт холбогдуулан шалгаж, эрүүгийн хариуцлага хүлээлгэж байх;

- Гэмт хэрэгт холбогдсон этгээдээс өөрөөс нь овог, нэрийг нь асууж, улмаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний баримтын архиваас лавлагаа авах төдийгөөр сэжигтэн, яллагдагчийн хувийн байдлыг нь тогтоох нь хангалтгүй бөгөөд өөр хүний нэрээр ял шийтгүүлэх явдал бус удаа гарчээ. Иймд гэмт хэрэгт холбогдсон этгээдийн хувийн байдлыг тодруулах асуудалд анхааралтай хандаж, төрийн эрх бүхий байгууллагаас лавлагаа авах, иргэний бүртгэлийн зөрчлийг арилгуулах, гэр бүлийн гишүүд болон бусад хүмүүсээс хувийн байдлынх нь талаар гэрчийн мэдүүлэг авах, ял шийтгүүлсэн тогтоол, бусад холбогдох баримтыг хэрэгт хавсаргах зэргээр ЭБШХ-ийн 80.1.4-т заасан шаардлагыг хангаж ажиллах шаардлагатай байна;

- Эд хөрөнгө хураах нэмэгдэл ялтай зүйл, хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдсон этгээдийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн байдал, банкинд хадгаламжтай эсэх, бусад этгээдэд мөнгө зээлсэн болон эд хөрөнгө худалдаад төлбөрийг нь авч чадаагүй байгаа зэрэг байдлыг нэг бүрчлэн шалгаж ирүүлэхгүй байгаагаас, мөн эд хөрөнгийг битүүмжлэн ирүүлээгүйгээс шүүх гэм буруутай этгээдэд дээрх нэмэгдэл ялыг хууль зүйн үндэслэлтэй зөв оногдуулах нөхцөл бүрдэхгүй байна;

- Зарим эрүүгийн хэрэгт гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн сэжигтэн, яллагдагч нарын мэдүүлгийг нэг ижил байдлаар буюу эхэлж мэдүүлэг өгсөн сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгийг хэвлэн гаргаж, бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн бусад этгээдээр нь гарын үсэг зуруулж, нэг хэргийн бүх сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгийг адилхан үйлдэж байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх журмыг зөрчиж, сэжигтэн, яллагдагч нарын мэдүүлгийг бусад нотлох баримттай уялдуулан үнэлэх боломжгүй болгож байна.

Энэ байдал нь мөрдөн байцаагч өөрийнхөө хийсэн ажлыг ямар ч үр дүнгүй болгох, цаашлаад гэм хэрэгт холбогдсон этгээдэд нотлох баримт ашигтай байдлаар нөлөөлөх эрх зүйн үр дагавар бий болгохыг анхаарах нь зүйтэй;

- Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан олон хавтаст хэргийг шүүгч нэг бүрчлэн уншиж танилцдаг. Иймд байцаалтын тэмдэглэл зэрэг гар бичмэл материалыг уншиж танилцахад гаргагдахуйц байхаар буюу орчин үеийн техник, хэрэгсэл ашиглан үйлдэж, хавтаст хэргийн материалыг логик, дэс дараалалтай үдэж байхыг анхааруулж байна.

Хоёр. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахад анхаарах асуудал

2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн ЭБШХ-ийн 62 дугаар зүйлийн 62.2-т: "... цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн шүүгч авна" гэж анх удаа хуульчлан тогтоож, Үндсэн хуулиар олгогдсон "иргэний халдашгүй чөлөөтэй байх" эрхийг хангах, хамгаалахад шүүхийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж өгсөн.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аливаа арга хэмжээг хууль бус болон үндэслэлгүй байхад хэрэглэх нь хүний халдашгүй чөлөөтэй байх, нэр төр алдар хүндээ хамгаалуулах эрхийг бүдүүлгээр зөрчиж, биеийн болон ёс суртахууны хохирол учруулдаг. Тийм ч учраас Эрүүгийн байцаан шийтгэх албадлагын арга хэмжээнүүд нь иргэдийн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг ямар нэг байдлаар хөндөх, хязгаарлахад хүргэдэг тул хуулиар тогтоосон баталгаа шаардах төдийгүй тэдгээр нь хууль ёсны хангалттай үндэслэлтэй байх учиртай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт: "Иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд ч болов эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ" гэж заасан нь хүний эрх, эрх чөлөө халдашгүй чөлөөтэй байхын тулгуур баталгаа мөн.

Үндсэн хуульд заасан дээрх үзэл санаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгалаа олж, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч нь өөрийн эрх, эрх чөлөөг зөрчигдсөн, үндэслэлгүйгээр эрхээ хязгаарлуулсан гэж үзсэн тохиолдолд мөн хуулийн 14 дүгээр бүлэгт заасан үндэслэл журмын дагуу гомдол, хүсэлт гаргаж хуулийн дагуу шийдвэрлүүлэх нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийн нэг баталгаа болдог.

2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн ЭБШХ-нар шүүх сэжигтнийг баривчлах, сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих, цагдан хорьж мөрдөх хугацааг сунгахдаа зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйлдэж, прокурорын танилцуулсан тогтоолыг батлах хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан нь хэтэрхий явцуу, өөрөөр хэлбэл шүүгч хуульд заагдсан эрхээ хэрэгжүүлэх боломж бага байсан бол нэмэлт өөрчлөлт орсон 2007 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар шүүгч цагдан хорихоос гадна цагдан хорих, цагдан хорих хугацааг сунгахаас татгалзах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эрх нь нээлттэй, тодорхой болсон юм. Мөн цагдан хоригдож буй яллагдагчийн насанд хүрээгүй этгээдийн нийт

хорьж мөрдөх хугацааг богиносгож, хэргийн ангиллаас нь шалтгаалж ялгавартай тогтоосон нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангахад чиглэгдсэн, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн бас нэг баталгаа болсон гэж үзэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад ямар нэгэн байдлаар саад учруулахад чиглэгдсэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтны хууль бус ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор тэдэнд таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа доорх нөхцөл байдлыг харгалзан үзвэл зохино.

а) гэмт хэргийн ангилал, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ (Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 63 дугаар зүйлийн 63.1);

б) нэг гэмт хэрэг, эсхүл хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн эсэх (Эрүүгийн хуулийн 18, 19 дүгээр зүйл);

в) онц аюултай гэмт хэрэгтэн, эсхүл ялтай байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн (Эрүүгийн хуулийн 24, 78 дугаар зүйл);

г) гэм буруугийн хэлбэр (Эрүүгийн хуулийн 25-27 дугаар зүйл);

д) гэмт хэргийг ердийн бүлэг, урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн (Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйл);

е) гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ (Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйл);

ё) ялыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдал (Эрүүгийн хуулийн 55, 55[1], 56 дугаар зүйл);

ж) таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч урьд нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргож байсан эсэх, урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчиж, итгэл алдсан эсэх, байнга оршин суух газаргүй, хувийн байдлын талаарх мэдээлэл хангалтгүй байгаа;

з) сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхэлж буй ажил, албан тушаал, нас, гэр бүлийн болон эрүүл мэндийн байдал, өрхийн сарын орлого, асрамжлах хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй, насанд хүрээгүй хүмүүс байгаа эсэх (Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 63 дугаар зүйлийн 63.1) талаар нягтлан тогтоох ёстой.

Цагдан хорих нь бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээтэй харьцуулахад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, эрх чөлөөг хамгийн их хэмжээгээр хязгаарладаг.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 9 дүгээр зүйлд "Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 9 дүгээр зүйлд "Хэнийг ч дур мэдэн баривчилж, цагдан хорьж болохгүй", Монгол Улсын Үндэсн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт "Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих,

баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэж тус тус заасан нь хүний эрхийн халдашгүй чөлөөтэй байх эрхийн баталгаа юм. Тийм ч учраас Эрүүгийн байцаан шийтгэх хуульд цагдан хорих үндэслэл, журмыг нарийвчлан хуульчилсан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан 2007 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуульд "Баривчлах, цагдан хорих, хорьж мөрдөх хугацааг сунгах, цагдан хорьсон таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох" асуудлыг шүүгч захирамж гаргаж шийдвэрлэж байхаар хуульчлан тогтоосонтой уялдан энэ ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд чанд нийцүүлэн явуулах, уг ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор 2008 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтран гаргасан 07, 26 дугаар захирамж, тушаалын хавсралтаар батлагдсан "Баривчлах цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам", мөн энэ асуудлыг нэг мөр ойлгож, зөв хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Дээд шүүхээс "Сэжигтнийг баривчлах, сэжигтэн, яллагдагчийг цагдан хориход анхаарах зарим асуудлын тухай" №178 дугаартай зөвлөмж, мөн өдөр "Насанд хүрээгүй сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хориход анхаарах зарим асуудал" №193 дугаартай зөвлөмжүүд гарсан билээ.

Хэдийгээр сэжигтнийг баривчлах, сэжигтэн яллагдагчийн цагдан хорих, цагдан хорьж мөрдөх хугацааг сунгах зөвшөөрлийг шүүгч өгч эхэлснээс хойш 10 жил, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт орсон шинэ хууль үйлчилж эхлээд 3 жил гаруй хугацаа өнгөрч байгаа ч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахдаа бид хуулийг буруу хэрэглэх, нэг мөр ойлгохгүй байх, хуульд заагдсан үг хэллэгийг оновчтой зөв хэрэглэхгүй байх зэрэг зөрчил өнөөдрийг хүртэл гаргасаар байгаа нь хүний эрхийг зөрчиж байгаатай агаар нэг билээ.

Сэжигтнийг баривчлах, сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих, цагдан хорих хугацааг сунгахад анхаарах зүйлийн талаар

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлийг хэрэглэж байгаа талаар:

Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хуульд заасан үндэслэлээр хязгаарладаг эрх бүхий ажилтан та бид зөвхөн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа анхаарах төдийгүй, сэжигтнийг баривчлахдаа хуулийн заалтыг нэг мөр, зөв ойлгон, хэрэгжүүлж байх хэрэгтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5-д заасан "Хойшлуулшгүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтнийг шууд баривчилж, 24 цагийн дотор тогтоолыг прокурорт болон шүүхэд хүргүүлнэ" гэсэн заалт тэр бүр хэрэгжихгүй байна.

Хойшлуулшгүй тохиолдол гэдгийг Улсын Дээд шүүхийн 2004 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тогтоолын 2-т зааснаар ойлгох ба энэ нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн дээрх тохиолдолд прокурорт танилцуулж, шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй, богино хугацаанд авч буй арга хэмжээ байхад ихэнх тохиолдолд сэжигтнийг ажлын өдөр, нэн ялангуяа үдээс өмнө сэжигтнээр тооцож байцаасан атлаа ажлын цаг дуусаны дараа буюу 18 цагаас хойш баривчлах тогтоолыг прокурорт танилцуулж, гарын үсэг зуруулж, хойшлуулшгүй үндэслэлээр баривчилж байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон тус хуулиар хамгаалуулсан сэжигтний эрхийг бүдүүлгээр зөрчиж байгаагийн нэг гэж үзэх үндэстэй. Иймд хойшлуулшгүй тохиолдолд сэжигтнийг баривчлах албадлагын арга хэмжээг хэрэглэсэн үед прокурорын хяналтыг сайжруулах, хуулийг зөрчихгүй байхад анхаарах нь зүйтэй.

Ер нь хойшлуулшгүй тохиолдолд сэжигтнийг баривчлах ажиллагаа жинхэнэ утгаараа огт хэрэгжихгүй байгаа ба хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч өөрийн хууль бус, хууль зөрчсөн ажиллагаагаа л халхавчилж хойшлуулшгүй үндэслэлээр сэжигтнийг баривчилж байгааг цаашид таслан зогсоох хэрэгтэй.

2.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийг хэрэглэж байгаа талаар:

- Хууль тогтоогч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-д зааснаар : "Эрүүгийн хуульд заасан

хүнд,

онц хүнд хэргийн сэжигтэн яллагдагч, шүүгдэгч,

удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд

онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол..." тэднийг дараах үндэслэлээр буюу

- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлахаас сэрэмжлэх,
- хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулахаас сэрэмжлэх,
- гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно гэсэн.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.2-т

- хүндэвтэр гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийг,

мөн хуулийн 68 дугаар зүйлийн 68.9.-д,
хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг цагдан хорих үндэслэлийг зааж өгсөн байхад хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчаас тэр бүр хэргийн холбогдогч буюу субъект хэн болох, ямар хэрэгт сэрдэгдэж байгаа, цагдан хорих үндэслэл нь юу болохыг тодорхой тогтоолгүйгээр зөвхөн хүнд эсхүл онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэх буюу оргон зайлж болзошгүй, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэх мэт жижүүрийн хэдэн үндэслэл зааж, түүнийгээ нотлох баримтаар баталгаажуулаагүй тогтоол бичиж ирүүлснийг прокурор хүлээн авч, шүүх захирамж гаргаж байгааг анхаарах нь зүйтэй.

3.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийг хэрэглэж байгаа талаар:

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлд цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах журмын талаар хуульчлан тогтоож өгсөн. Хэдийгээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д зааснаар сэжигтнийг цагдан хорьж мөрдөх хугацаа 14 хүртэл хоног байна гэсэн боловч энэ нь заавал 14 хоног байна гэсэн үг биш юм . Өөрөөр хэлбэл нэг талаас тухайн хэргийн сэжигтнийг (баривчлагдсан хугацааг оруулан тооцоод) цагдан хорьж мөрдөх хугацаа 14 хоногоос хэтэрч болохгүй, нөгөө талаас энэ хугацаанд яллагдагчаар татагдсан бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд заагдсан үндэслэл байвал яллагдагчийг цагдан хорих тухай шүүгчийн захирамжаар цааш цагдан хорино гэсэн үг.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ихэнх тохиолдолд сэжигтнийг цагдан хорьсноос хойш 14 дэх хоногтоо яллагдагчаар татаж, байцаасан байдаг боловч зарим тохиолдолд яллагдагчаар татсан хугацаандаа яллагдагчийг цагдан хорих тухай шүүгчийн захирамжгүйгээр сэжигтнээр цагдан хорьсон 14 хоног дууссаны дараа яллагдагчийг цагдан хориулахаар шүүхэд хандаж байна. Жишээлбэл: тухайн этгээдийг сэжигтнээр цагдан хоригдсоноос нь хойш 7 дахь хоногт нь яллагдагчаар татаж, байцаасан атлаа яллагдагчийг цагдан хорих тогтоол, саналаа шүүхэд ирүүлэхгүй байсаар сэжигтнээр цагдан хоригдсон 14 хоног дуусах үед яллагдагчийг цагдан хорих тогтоол, саналаа шүүхэд ирүүлж байгаа нь (яллагдагчаар татагдсан, сэжигтэн биш) яллагдагчийг 7 хоног тогтоолгүй цагдан хорьж байна гэж үзэх үндэстэй. Иймд тохиолдол цөөнгүй гарч байгаа тул энэ байдалд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар анхааралтай хандаж ажиллах нь зүйтэй.

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 7-д

зааснаар "цагдан хорих шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч мөн хуулийн 61 дүгээр зүйлд заасан хугацааны дотор цагдан хоригдсон этгээдийн гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн, эсхүл өмгөөлөгчид мэдэгдэх" үүрэгтэй тул сэжигтэн яллагдагчийг цагдан хорих тухай шүүгчийн захирамжид цагдан хорьсон цаг хугацааг тодорхой бичих шаардлагатай.

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 70 дугаар зүйлийг хэрэглэж байгаа талаар:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг өмгөөлөгчийн хүсэлт, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг харгалзан хяналт тавьж байгаа прокурор санал гаргах ба шүүгч түүнийг үндэслэн захирамж гаргаж шийдвэрлэнэ. Уг хэрэг шүүхэд шилжсэн бол шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ" гэж заасан. Энэ нь хэрэг шүүхэд шилжиж ирээгүй бол шүүх прокурорын саналыг үндэслэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгохоор захирамж гаргах л үүрэгтэй болохоос прокурорын гаргасан саналыг хүлээн авахаас татгалзах үндэслэлгүй байна.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох нь хоёр өөр утгатай, өөр ойлголт.

Гэмт хэргийн ангилал болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг харгалзан урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг чангатгах болон хөнгөрүүлэх нь таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж байгаа ажиллагаа ба харин урьд үндэслэлгүйгээр цагдан хорих болон бусад таслан сэргийлэх арга хэмжээ авсан, ер нь цаашид ямар ч таслан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагагүй болсон, тухайн этгээд гэмт хэрэгт холбогдолгүй болох нь тогтоогдсон гм нөхцөлд сая урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай ойлголт хамаарна. Гэтэл хуулийн энэ заалтыг нэг мөр ойлгоогүйгээс янз бүрээр хэрэгжүүлж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д: "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болох буюу эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болох, эсхүл гэмт хэрэг үйлдэж болох үндэслэлтэй бол түүнд 62.1.1-62.1.5-д заагдсан таслан сэргийлэх арга хэмжээний аль нэгийг авч болно." гэж заасан байгаа. Гэтэл урьд бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байсан, эсхүл өөр бусад таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байсан этгээдийг цагдан хорихдоо урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг

өөрчлөлгүйгээр нэг хүнд 2 таслан сэргийлэх арга хэмжээ зөрөг авч байгаа тохиолдол байна. Энэ ажиллагаа ихэвчлэн урьд эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан этгээдэд, эсхүл прокуророос шүүхэд шилжиж ирсэн хэрэгт шүүх таслан сэргийлэх арга хэмжээг авахдаа урьд авагдсан таслан сэргийлэх арга хэмжээг анхааралгүй байдагтай холбоотой гарч байна.

Гурав. Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал, тэдний сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт

Эрх зүйт төр, иргэний ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрх эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцдаг бол эрх нь зөрчигдсөн иргэн өөрийн эрх, эрх чөлөөг хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр хамгаалах, түүний дотор учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

Гэмт хэргийн улмаас хохирогчид эд хөрөнгө, бие эрхтэнээс гадна сэтгэл зүйд хохирол учирдаг нь хэнд ч нотлох шаардлагагүй үнэн бөгөөд хохирлыг үнэн зөв бодитой тогтоож, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлснээр хохирогчийн эрхийг жинхэнэ утгаар хамгаалж, шударга ёс хэрэгжих болно.

Гэвч Баянгол дүүргийн шүүхийн 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 72А дугаартай шийтгэх тогтоол, Улсын Дээд шүүхийн 2011 оны 2 дугаар сарын 23-ны 77 тоот тогтоолоор хүний санаатай алсан гэмт хэрэгт сэтгэл санааны хохиролд 100 сая төгрөг гаргуулж шийдвэрлэсэн жишээг эс тооцвол эрүүгийн гэмт хэргийн улмаас сэтгэл зүйд учирсан хохирлыг үнэлж гэм буруутай этгээдээс гаргуулж шийдвэрлэсэн жишээ өнөөгийн шүүхийн практикт өдрийн од шиг ховор байна.

Хүний эрхийн асуудал, түүний дотор гэмт хэргийн хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх явдал төрийн болон иргэний нийгмийн байгууллага, хуульч, эрдэмтэд, судлаачдын байнгын анхаралд байж, судалгааны нэг объект болж байдаг хэдий ч эдийн бус хохирлын талаар хуульчид нэг мөр ойлголтгүй, энэ талаар шүүхийн нэгдсэн практик тогтоогүй байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42.1-д "Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ" гэж тодорхойлсон боловч хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

ЭБШХ-ийн 17.1-д "Шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий

яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана" гэж заасан хэдий ч байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогчийн эрх, тэдний санал хүсэлт тэр бүр хангагдахгүйгээс хохирогч давхар хохирох явдал гарсаар байна.

ЭБШХ-ийн 43.1-д "Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон *эд хөрөнгийн бус хохирол* хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ", мөн хуулийн 115.1-д "Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ" гэж *2007 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн хуулаар нэмэлт орсон* заасан атлаа эдийн бус хохирлыг үнэлэх аргачлалыг хууль тогтоогч хуульчлаагүй орхигдуулсан нь хохирогч нарт давхар хүндрэл учруулж байна.

Иймд гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал, тэдэнд учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг эргэн харж, дэлхийн жишигт нийцсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх явдал эрүүгийн эрх зүйн салбарт та бидний өмнө тулгамдсан асуудлын нэг болсон гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Нөгөө талаар өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээдийн сэтгэл зүйн буюу эдийн бус хохирлыг эдийн хохирол руу шилжүүлэн нотлох баримт бүрдүүлэх замаар хохирол нөхөн төлүүлэх боломжийг сайтар судалж, энэ талаар хуульчид нэгдсэн ойлголттой байх нь чухал.

Эдийн бус хохирлыг аль болох бага зардлаар, богино хугацаанд найдвартай нөхөн төлүүлэх арга замыг авч үзэхдээ дараахь асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байна. Үүнд:

1. Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал, хохирогчийн эрх хэмжээ;
2. Иргэний нэхэмжлэл, түүнтэй холбоотой нотлох баримт бүрдүүлэх;
3. Эдийн бус хохирлын төрөл, түүнийг гаргуулах эрх зүйн зохицуулалт;
4. Сэтгэл зүйн хохирол тооцоход анхаарах зүйлс.

Сэтгэл заслын эмчилгээний баримт, тооцоо нь хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тодорхойлж болох тул энэ талаар өмгөөлөх тал нотолгоо гаргаж ирвэл шүүх эдийн бус хохирлыг эдийн хохиролд шилжүүлэн тооцох замаар гэм хорын хохирлыг шийдвэрлэх,

түүнээс гадна сэтгэл зүйн хохирлын нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч хүлээн зөвшөөрсөн, эсхүл талууд эвлэрсэн тохиолдолд прокурор, эсхүл шүүгч нь зөвшөөрөл, эвлэрлийг батлах замаар сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Шүүгдэгч нь Эрүүгийн хуулийн 55[1], 61 дүгээр зүйлд заасан хөнгөлөлт, боломжийг эдлэхийн тулд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан байх шаардлагатай, мөн Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлд "Гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо сайн дураараа нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол", мөн хуулийн 74 дүгээр зүйлд "Хорих ял шийтгүүлсэн ялтан засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг шүүх ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болно." гэж заасныг мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн, яллагдагчид сайтар тайлбарлаж өгөх хэрэгтэй.

Хохирогчийн эрх зүйн байдлыг ЭБШХ-д хэрхэн тусгасан бэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцна гэж заасан, Энэ заалт ямар түвшинд хэрэгжиж байгааг ЭБШХ болон Иргэний, Хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтаас харж дүгнэж болохоор байна.

ЭБШХ-ийн 42, 43 дугаар зүйлийн агуулгаас харахад гэмт хэргийн улмаас эд хөрөнгө, бие эрхтэндээ хохирол хүлээснээс гадна сэтгэл санааны хохирол хүлээсэн "*этгээд*"-ийг хохирогч гэж ойлгож байна. Үүнийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч хүлээн зөвшөөрч, хохирол хүлээсэн этгээдийг хохирогчоор тогтоосноор тэдэнд иргэний нэхэмжлэл гаргах эрх нээгдэг.

Энд "*этгээд*" гэдэгт *хувь хүн болон хуулийн этгээдийг* хамааруулан ойлгодог. Хуулийн этгээдийн хувьд хувь хүнээс ялгаатай нь эд хөрөнгийн хохирлоос гадна ажил хэргийн нэр хүндэд нь хохирол учирдаг. Ажил хэргийн нэр хүндэл учирсан хохирол гэдэгт гэмт хэргийн улмаас мөнгөн илэрхийллээр тооцож болох, өөрөөр хэлбэл санхүүгийн тайлан балансад тусгагдсан алдагдал, тухайлбал бараа үйлчилгээний чанар доголдсоноос орлого багасах, үнэ буурах, харилцагч цөөрөх, ажиллах хүчнээр дутагдах зэрэг сөрөг өөрчлөлтүүдийг хамааруулан ойлгож болно.

Хохирогчид дээр дурьдсан эд хөрөнгө, бие эрхтэн, сэтгэл зүйд

хохирол учирсан байж болох хангалттай үндэслэл тогтоогдсон явдал нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болдог бөгөөд байцаан шийтгэх ажиллагааны явцад ЭБШХ-ийн 80.1.5-д заасаар гэмт хэргийн улмаас *учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээг* нарийвчлан тогтоох нь эрүүгийн хэрэгт заавал нотолбол зохих зүйлийн нэг гэж үздэг.

Хохирогчид эрх үүргийг нь сайтар тайлбарлан өгч, байцаан шийтгэх ажиллагаанд эрх хэмжээг нь бүрэн эдлүүлэх явдал тэдний зөрчигдсөн эрхийг сэргээх, хэргийн бодит үнэн, хохирлын шинж чанар, хэр хэмжээг зөв тогтооход чухал ач холбогдолтой.

Гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд бодит хохирол учраагүй, тухайлбал гэмт хэрэг нь бэлтгэх, завдах цс шатанд таслан зогсоогдсон бол тэднийг хохирогчоор тогтоох үндэслэлтэй юу.

Эрх зүйт төрд зайлшгүй шаардлагаанд нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд хүний эрхэд халдаж болно. Гэвч энэ зарчим дангаараа хангалтгүй. Ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ гэдгээс гадна ямар үр дүнд хүрэх, ямар зорилгоор хүрэх вэ гэдэг асуулт тавигдана. Америкийн хуульчид энэ асуултад хариулахын тулд Harm Principle буюу Хор уршгийн зарчмын дагуу иргэдэд хохирол учруулахуйц үйлдэл хийгдсэн тохиолдолд хүний эрхэд халдаж болно гэж үзсэн. Энэ зарчмыг үндэслэгч нь 19 зуны Английн философич John Steward Mill. Энэ зарчмын нэг дутагдалтай тал нь тодорхой иргэнд хохирол учирсан байхыг шаардаг.

Гэмт халдлагад өртөж бодит хохирол хүлээж болох байсан этгээдийг хохирогчоор тогтоох нь ЭБШХ-ийн 42 дугаар зүйлийн агуулгатай зөрчилдөж байгаа мэт боловч түүнийг хохирогчоор тогтоож, ЭБША-нд оролцуулж хохирогчийн эрх хэмжээг эдлүүлснээр гэмт хэргийг бүрэн бодитой шалгаж тогтоох, гэм буруутай этгээдэд зохих хариуцлагыг гарцаагүй оногдуулах эрх зүйт төрийн зарчим хангагдана. Хохирогчид эд хөрөнгө, бие эрхтэнд бодит хохирол учраагүй ч гэсэн гэмт халдлагад өртөж болох байсныг ойлгож мэдсэнээр түүний сэтгэл санаанд хохирол учрах нь тодорхой. Нөгөө талаар зөрчигдсөн эрхээ ямар хэмжээнд хамгаалах нь хохирогчийн эрхийн асуудал юм.

Амь хохирогчийн ар гэр, төрөл садны хүмүүс хохирогч мөн үү. Эсхүл тэднийг хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, иргэний нэхэмжлэгчийн хэмжээнд авч үзэх үү. Бодит хохирол нь хүний амь нас гэж үзвэл оршуулгын зардал хохиролд хамаарах уу, ойр дотны хүнээ алдсанаас сэтгэл санаанд учирсан хохирлыг хангах үндэслэл бий юу.

ЭБШХ-ийн 5.1.11-д заасан "гэр бүлийн гишүүн" буюу амь

хохирогчийн хамгийн ойрын төрөл садны хүнийг эмь хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоодог. Гэвч байцаан шийтгэх ажиллагааны явцад тэдгээрийн хооронд маргаан гарах, иргэний нэхэмжлэлтэй холбоотой сонирхлын зөрчил гарсан тохиолдолд нэг хэрэгт 2 бүюу түүнээс дээш хүн хохирогчоор тогтоогдох явдал гарч байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрөө хохирол хүлээсэн бол түүнийг хохирогчоор тогтоох нь зөв үү

ЭБШХ-ийн 42 дугаар зүйлийн 42.5.2-т зааснаар хохирогчоор тогтоогдсон этгээд нь хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх, мөн хуулийн 83.1-д зааснаар хохирогч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн дуудсанаар ирж, хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлж, тавьсан асуултад хариулт өгөх үүрэгтэй хэдий ч яллагдагчийн хувьд ЭБШХ-ийн 36.4-т зааснаар өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, түүнчлэн өөрийн гэм буруугүйг болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээдэггүй.

Нөгөө талаар ЭБШХ-ийн 13.1-д зааснаар шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй тул сэжигтэн, яллагдагчид хохирол учирсан байж болох хангалттай нөхцөл тогтоогдсон тохиолдолд тэдний давхар хохирогчоор тогтоож, хуульд заасан хохирогчийн эрх хэмжээг эдлүүлэх нь хэргийн бодит үнэнийг тогтооход ач холбогдолтой. Цаашид ЭБШХ-нд хохирогчийн эрх зүйн байдлыг улам боловсронгуй болгох шаардлагатай.

ЭБША дахь хохирогчийн эрх хэмжээ: ЭБШХ-ийн 42 дугаар зүйлд заасан хохирогчийн эрх үүргийг сайтар тайлбарлан ойлгуулах нь тэдний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд чухал ач холбогдолтой. Тухайлбал хохирогчоор тогтоосон тогтоолтой танилцаж, тогтоолын хувийг авах, хэргийн материалтай танилцах, өмгөөлөгч авах, сэжигтэн яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээ өөрчлөгдсөн талаар мэдэх, байцаан шийтгэх ажиллагааны зардлыг нөхөн төлүүлэх, сэтгэл санаанд учирсан хохирол нэхэмжлэх ... гэх мэт.

ЭБШХ-ийн 17.1-д заасан "Шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана", мөн хуулийн 13.2-т заасан "Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль[1] болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч,

[1] Монгол Улсын Эрүүгийн хууль – Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ" гэсэн заалтууд хоорондоо зөрчилдөг.

ЭБШХ-ийн 42 дугаар зүйлийн 42.3.9-д: хохирогч, түүний төлөөлөгч нь гэмт хэргийн улмаас өөрг учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх эдэлнэ, мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д "Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч" гэнэ, мөн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1-д "Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ" гэснээс үзэхэд гэмт хэргийн хохирогчид эдийн бус хохирлоо мөнгөн илэрхийллээр нэхэмжлэх эрх нээлттэй байна.

Эрх зүй өндөр хөгжсөн дэлхийн олон улс оронд гэм буруутай этгээдээс сэтгэл санааны хохирол гаргуулах, гэм буруутай этгээд тогтоогдоогүй бол эд хөрөнгө бие эрхтэнд учирсан хохирлоос гадна сэтгэл санаанд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлж барагдуулдаг тогтолцоо хэдий нь бий болжээ.

Монгол Улсад 2002 онд ЭБШХ-д Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хуульзөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай 44 дүгээр бүлэг шинээр нэмэгдсэн бөгөөд уг хуулийн 391 дүгээр зүйлд "Эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хэрэг шүүхэд аасан журмын дагуу нөхөн төлнө", "Эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно", "Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана" гэжээ.

Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт

Сэтгэл зүйн хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх асуудал нь Эдийн болон бие эрхтэнд учирсан хохиролтой харьцуулбал эрүүгийн эрх зүйн салбарт хамгийн бага судлагдсан гэж хэлж болно. Мөн чанарын хувьд сэтгэл зүйн хохирол нь хэзээ ч нөхөн төлөгдөж, арилж үгүй болдоггүй, өөрөөр хэлбэл түүнийг мөнгөөр худалдан авч болохгүй. Харин түүнийг шүүхийн шийдвэрээр мөнгөн дүнгээр дүйцүүлэн нөхөн төлөх зохицуулалт байж болох юм. Ийм практик Англи гэх

мэтийн олон улс оронд бий. Тэнд хохирогч иргэний журмаар хохирол нэхэмжлээгүй ч гэсэн хуульд заасан аргачлалын дагуу сэтгэл санааны хохирлыг тооцох боломжтой байдаг. Гэм буруутай этгээд тогтоогдоогүй тохиолдолд хохирогч энэ хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх эрхтэй. ХБНГУ-д гэмт хэргийн улмаас учирсан (бие эрхтэний гэмтэл, хүчин, эдийн бус эрх зөрчигдөн гэх мэт) сэтгэл санааны хохирлын хэр хэмжээг шүүхээс тогтоодог.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2.27 дахь заалтад "Хүн бүр эдийн болон сэтгэл зүйн хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй", Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт: Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй гэж заасныг үзэхэд сэтгэл санаанд учирсан болит хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэр гаргахаас татгалзах нь үндэслэлгүй бөгөөд энэ нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим хэм хэмжээнд нийцэхгүй байна.

Эрүүгийн гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх зорилгуулалт нь иргэний эрх зүйн хууль тогтоомжид үндэслэгддэг. Сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэхэд дараахь 4 нөхцөл хангагдсан байх ёстой. Үүнд:

1.Сэтгэл санааны хохирол бодитой учирсан байх;

2.Хохирол учруулсан хууль бус үйлдэл, эс үйлдэхүй;

3.Үйлдэл, эс үйлдэхүй болон хор уршгийн хоорондох шалтгаант холбоо;

4.Гэм буруу.

Сэтгэл зүйд хохирол бодитой учирсан байх шинж нь гэмт хэргийн улмаас сэтгэлийн зовиур, шаналалаас болж бие организмд сөрөг өөрчлөлт явагдсан байх, тухайлбал уй гашууд автаж уйлах... бусад шинжүүд.

Гэвч хохирогчийн нас, хүйс, төлөвшил, үндэсний онцлог, хувийн байдал зэргээс шалтгаалан гаднах шинж янз бүрээр илэрч болно. Тийм учраас уй гашууд автаж уйлах нь сэтгэл санаанд хохирол учирсныг шууд биш, харин шууд бусаар нотлох баримт юм.

ОХУ-ын эрдэмтэн А.М.Эрделевскийн үзэж байгаагаар гэм буруутай этгээд үгүйсгэж чадаагүй тохиолдолд гэмт хэргийн хохирогч бүрд сэтгэл санааны хохирол учирдаг байна. Үүнийг сэтгэл санааны хохирлын презумци гэдэг. Энэ тохиолдолд гэмт хэргийн хохирогчид сэтгэл санааны хохирол учирсан эсэхийг нотлох шаардлагагүй юм. Гэвч дээрх онол нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд баримталдаг гол зарчим болох гэм буруугүйн презумцийн зарчимд харшилдаг. Нөгөө талаар ЭБШХ-ийн 82, 13 дугаар зүйлд заасныг анхаарах хэрэгтэй.

Харин иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагч гэм буруугүй гэдгээ өөрөө нотлох шаардлагатай болдог.

Гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй хохирогчид учирсан сэтгэл санаяны хохирлын үндсэн шалтгаан болсон байх ёстойг нотлох нь тийм ч хялбар биш. Үүний тулд шүүх сэтгэц гэм судлалын шинжээч эмчийн дүгнэлтийг гаргуулах шаардлага гарч болно.

Сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэхэд гэм буруугийн хэлбэр нь нөхөн төлүүлэх хохирлын хэмжээг тогтооход харгалзах үзүүлэлт болохоос гадна гэм буруугүй боловч орчин тойронд аюул учруулж болох эд зүйлсийн улмаас, мөн эрүүгийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, таслан сэргийлэх арга хэмжээг буруу хэрэглэсэн, мөн нэр төр алдах хүндийг гутаасан мэдээ баримт тараах болон хуулиар тусгайлан авч үзсэн бусад тохиолдолд сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх үндэслэл бий болно. Гэм буруу бол гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг үндсэн шинж. Гэм буруу байхгүй ч гэсэн хохирлыг хууль ёсны төлөөлөгч буюу иргэний хариуцагч нөхөн төлөх асуудал гардаг.

Сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлөх толбөрийн хэмжээг тодорхойлох шалгуур

Сэтгэл санааны хохирол нь эдийн бус хохиролд хамаарах тул түүнийг эд хөрөнгөөр нөхөн төлөх боломжгүй гэж зарим судлаач үздэг. ЭБШХ-д сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх журмыг нарийвчлан зохицуулаагүй. Энэ талаар шүүхийн нэгдсэн практик тогтоогүй талаар дээр дурьдсан.

Сэтгэл санааны хохирлын хэр хэмжээг тогтоох нь шүүхээс өлнөх шатанд ЭБШХ-ийн 80.1.5-д заасан "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээ" шалгаж тогтоох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн чиг үүрэгт хамаарах уу.

Зарим судлаачид зөвхөн сэтгэл санаанд хохирол учирсан фактыг тогтоох нь хангалттай, харин нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох нь шүүхийн асуудал гэж үзэх нь бий. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход дараахь нөхцөл байдлыг харгалзан үзэх нь зүйтэй. Үүнд:

1.Гэм буруутай этгээдийн гэм буруугийн хэр хэмжээ;
2.Хохирогчид учирсан сэтгэл зүйн хохирлын шинж байдал;
3.Хохирол учирсан нөхцөл байдал;
4.Шударга ёсны шаардлага;
5.Хохирогчийн гэм буруугийн хэр хэмжээ;
6.Гэм буруутай этгээдийн төлбөрийн чадвар;
7.Хохирогч хэдий хэмжээнд хохирлыг үнэлж байгаа.

Монгол Улсын ИХШХШТХ-д эд хөрөнгөнд учирсан хохирлоос гадна эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг тооцож үнэлэх талаар тус хуулийн 63 дугаар зүйлд "Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан гэм хорын хохирлыг нэхэмжлэлд заасан үнийн дүнгээр тооцно" хэмээн нарийвчлан заасан хэдий ч энэ нь эд хөрөнгийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлоос зөвхөн "нэр төр, алдар хүнд, ажил хэргийн хүнд"-эд учирсан хохирлыг л тооцож үнэлж болно хэмээн хязгаар тавьсан байна.

Гэвч зарим төрлийн эрүүгийн хэрэгт, тухайлбал хүчингийн гэмт хэргийн хохирогчийн хохирлыг дан ганц тухайн үед учирсан бие махбодь, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирлоор төлөөлөн тооцох нь учир дутагдалтай юм. Хүчингийн гэмт хэрэг нь хохирогчийн сэтгэл санаа, нэр төр, хүрээлэх орчны харицааанд нь нөхөж болшгүй хохирлыг учруулдаг учраас гэмт хэргээс улбаатай эдгээр хохирол цаг хугацааг үл харгалзан улам өссөөр байдаг. Хүчингийн гэмт хэргийн хохирогчийн талаар ойр орчныхон нь мэдсэн тохиолдолд элдвээр чичлэн, ажил сургуулиас гарахад хүргэдэг бөгөөд гэр орны байршлаа өөрчлөн нүүхээс эхлээд эр хүнийг үзэн ядах, өөртөө итгэлгүй болох зэргээр сэтгэл санаанд учирсан сөрөг үр дагавар нь тэднийг цаашдын амьдралаа зохиох, ажиллаж хөдөлмөрлөхөд нь саад учруулдаг байна.

ЭБШХуулийн 42 дугаар зүйлд: "*Хохирогч нь* ...гэмт хэргийн улмаас өөрт учирсан *хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй*" хэмээн, мөн "Иргэний нэхэмжлэл гаргасан бол хохирлын хэмжээ, түүнийг арилгах арга, үндэслэл, нөхцлийг Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хуулиар тодорхойлно", тус хуулийн 123 дугаар зүйлд "Шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь ИХШХШТХ-д заасан журмын дагуу нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авч болно." хэмээн хохирлын хэмжээг тодорхойлох, түүнийг нөхөн төлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авахдаа Иргэний хууль болон ИХШХШТХ-ийн хэм хэмжээг хэрэглэхийг тусгайлан зааж өгсөн байна.

Харин Иргэний хуулийн хуулийн 52 дугаар бүлгийн "Гэм хор учруулснаас үүсэх үүрэг" гэсэн хэсэгт эмь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгө хэмээн гэм хорын төрлийг тодорхой зааж, гэм хорыг хариуцан арилгах үүргийг хуульчлж өгчээ. Мөн хохирлыг арилгах талаар тус хуулийн 18 дугаар бүлгийн "Гэм хорыг арилгах" гэсэн хэсгийн 228 дугаар зүйлд хохирогчийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлыг барагдуулах хэлбэрүүдийг:

- Зөрчигдсөн эрхийн нь нөхөн сэргээх буюу хохирол учрахаас өмнө ямар байсан яг тэр байдлыг нь буцаан сэргээх;
- Эсхүл боломжгүй бол учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр

нөхөн төлүүлэх;

· Эрүүл мэндэд учирсан хохиролд сар тутам мөнгөн тэтгэлэг буюу тэжээн тэтгэлэг тогтоолгох;

· Эсхүл сар тутмын мөнгөн төлбөрийн оронд нэг удаагийн нөхөн төлбөр гаргуулах хэмээн зааж өгсөн нь хохирогчийн хувьд учирсан хохирлоо арилгуулах боломж хуулиар олгогдсон гэж үзэж болохоор байна.

Гэвч энэ нь эрүүгийн гэмт хэргийн улмаас хохирогчийн хувьд дээрх боломжийг эдлэх эрх нь хуулийн зөрөөтэй зааалт, зөрчилдөөний улмаас хязгаарлагдсан байна. Иргэний хуулийн 230 дугаар зүйлд хохирогчийн эдийн бус гэм хорыг арилгах эрхийг баталгаажуулж өгсөн хэдий ч тус зүйлийн 2 дахь хэсэгт 229 дүгээр зүйлд Гэм хорыг арилгах хэмжээг зөвхөн "... эд хөрөнгөд учруулсан бодит хохирол болон олох ёстой байсан орлогыг нөхөн төлөх үүрэгтэй" хэмээн заасан нь гэмт хэргийн хохирогчийн хувьд сэтгэл санаа, эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээг тодорхойлох боломжгүй болж байгаа бөгөөд энэ нь 228 дугаар зүйлтэй зөрчилдөж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛЛЭГ
www.nli.gov.mn

ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхийн ач холбогдол

Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, докторант Ч.Хосбаяр

Эрүүгийн хэргийг илрүүлэн мөрдөж гэмт этгээдийг олж тогтоон гэм буруу нотлох хангалттай баримтыг цуглуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, энэ үйл ажиллагаанд гэм буруугүй хэнийг ч хэлмэгдүүлэхгүй байх нь аливаа улсын Эрүүгийн процессын зорилго бөгөөд энэ нь хүн хүч, хөрөнгө зардал, оюун ухаан, цаг хугацаа шаардсан ажиллагаа болохыг хуульчдаар тогтохгүй бүгд мэдэх билээ. Байцаан шийтгэх ажиллагааны зорилт, зарчмыг алдагдуулахгүйгээр хэмнэлт гаргах боломж бий эсэх нь хууль тогтоох, хэрэглэх, хамгаалах болон судлаачид эрдэмтдийн анхааралыг татаж ирсэн. Байцаан шийтгэх ажиллгааны оролцогчдын ур чадварыг дээшлүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг шахах, хязгаарлах зэрэг аргууд нь шууд нөлөөтэй боловч хүссэн үр дүнг авч ирж байсангүй. Харин зарим шат дамжлагыг товчлох, алгасах нь шийдвэрлэх нөлөө үзүүлэх нь тодорхой боловч энэ нь зарим сөрөг үр дагавар авчрах цаашилбал эрүүгийн процессын мөн чанарыг үгүйсгэх аюултай байв. Иргэний процессд талууд эвлэрч маргаангүй болмогц

хэргийг дуусгавар болгодог хялбаршуулсан журмыг эрүүгийн процесс хэрэглэх боломжтой эсэх нь одоо ч маргаантай байдаг болов ч тодорхой хязгаартай хэрэгжүүлвэл их хэмнэлт бий болох нь одоо нэгэнт хүлээн зөвшөөрөгдөөд байна. Гол асуудал байцаан шийтгэх ажиллагааны чухам аль хэсгийг алгасах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг нураахгүй, зарчмыг алдагдуулахгүй вэ?

Ямар ч улсын эрүүгийн процесс нь гэмт этгээдийг олж тогтоон баривчлах, нотлох баримт цуглуулах, гэм буруутай эсэхийг шүүхээр хэлэлцэх, шүүхийн шийдвэрт гомдол гаргах ажиллагааналс бүрдэг бөгөөд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эдлэх эрхийг шат бүрт тогтоож Үндсэн хууль болон эрүүгийн хууль, эрүүгийн процессын хуулиудаар цаашилбал олон улсын эрх зүйн хэм хэмжээ, гэрээ, конвенцор хамгаалагджээ. Хэргийн холбогдогч буюу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийн гэм буруугийн асуудлаар маргаж буй тохиолдолд хууль тогтоомжоор баталгаажсан дээрх ажиллагаануудыг бүрэн гүйцэд явуулах нь гарцаагүй болох бөгөөд харин шүүгдэгч гэм буруугаа хүлээж байцаан шийтгэх ажиллагаанд эдлэх зарим эрхээсээ татгалзваас нотлох ажиллагаа хөнгөрөн шүүхийн хэлэлцүүлгийг товч явуулж болохоос гадна гомдол хэлэлцэх ч шаардлагагүй болдог ажээ.[1]

Энэ нь ялын тохироо гэсэн ойлголтыг бий болгож нийтийн эрх зүйт орнууд эрүүгийн процессгоо XIX дүгээр зуны хоёрдугаар хагасаас хэрэглэж эхэлснээс хойш ял тохироноос гардаг олон талын хэмнэлт, талуудад ашигтай байдлаасаа ихэд тархаж одоо эдгээр улс орнуудын шүүн таслах ажиллагааны нэг чухал стандарт болжээ. АНУ, Англи, Австралийн хуульчид, эрдэмтэн судлаачдын дунд ял тохирох нь ихээр шүүмжлэгддэг боловч хэрэв хоригловол эрүүгийн журмаар хэрэг хянах ажиллагааны ачаалал даруй арав дахин нэмэгдэж хямралд орно гэсэн судалгаа гарсан юм байна. Тиймээс энэ институтыг хасах, болих тухай биш харин эрх зүйн орчинг сайжруулж шүүхийн хяналтыг боловсронгуй болгох асуудал л яригддаг.

Шүүгдэгчид гэм буруугаа хүлээх сонирхлыг төрүүлэх гол хөшүүрэг нь мэдээж гэмээ хүлээсний хариуд ялын тал дээр төрөөс зохих хөнгөлөлт үзүүлэх явдал. Талууд энэ талаар тохиролцоонд хүрч маргаангүй болох нь хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх үндсэн нөхцөл юм. Энэ бол амьдралд байдаг, бодит байдлаас бий болсон зүйл билээ. Хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэснээр шүүх, прокурор, цагдаа болон өмгөөллийн байгууллагын ажилтан албан хаагчдын хэргийн ачаалал буурч нөгөө талаар шүүхийн шийдвэр талуудын хувьд ямар нэгэн эрсдэлийг агуулдаггүй, мөн байцаан шийтгэх ажиллагааны зардлыг эрс бууруулж яллах талын хувьд ч хэрэг цагаадах эрсдэлгүй, өмгөөлөх талын хувьд ч хатуу

[1] Albert W. Alschuler (1979) *Plea Bargaining and It's History*, 13 Law & Soc'y rev. p.211

ял шийтгэлээс зайлсхийх, хэргийн хохирогчид гэрчүүдийг шүүх хуралдаанд мэдүүлэг өгөх амаргүй давлаанаас чөлөөлж ерөнхийдөө шүүн таслах ажиллгааны чанарт эерэгээр нөлөөлдөг байна.

• *Зарим улсын эрүүгийн процесс дахь ял тохирох ажиллагаа*

АНУ-ын эрүүгийн процесс дахь шүүхийн ажиллагаа нь шүүхэд шилжиж буй яллагдагч холбогдсон хэрэгтээ гэм буруутайгаа хүлээн зөвшөөрч байгаа эсэхээс хамааран "хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" эсвэл "шүүх хуралдаанаар шүүн таслах ажиллагаа" гэсэн хоёр хэлбэрээр үргэлжилдэг. Шүүгдэгч тухайн гэмт хэргийг үйлдээгүй болохоо илэрхийлсэн тохиолдолд шүүх хуралдаан хийж шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоодог, харин гэм буруугаа хүлээн зөвшөөрч буй тохиолдолд ял тохиролцох байдлаар буюу хялбаршуулсан журмын хүрээнд хэргийг шийдвэрлэдэг.[2] Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан хэлэлцэх ажиллагааны үндсэн хэлбэрийг ял тохиролцох буюу *Plea bargaining* гэж АНУ-д ойлгодог аж. Ялын тохиролцоо бол үндсэндээ мэтгэлцээнт тогтолцооны үндсэн элементүүдийн нэг юм. Прокуророос үйлдсэн яллах дүгнэлттэй танилцсан яллагдагчаас шүүх түүнийг шүүхэд шилжүүлэхээс өмнө прокурорын яллах дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг асуудаг. Бух муж улсад яллагдагч энэ талаар гэм буруутай (Guilty Pleas), эсвэл гэм буруугүй (Not Guilty Pleas) гэсэн мэдэгдэл хийхийг зарим муж улсад тодорхой бус мэдэгдэл (Nolo Contendere Pleas)хийхийг зөвшөөрдөг. Шүүгдэгчийн өмгөөлөгч, улсын яллагч хоёрын тухайн гэмт хэрэгт шүүгдэгчийн гэм буруугийн асуудлаар нэг шийдэлд хүрэхээр хэлэлцээр хийхийг гэм буруугийн тохиролцоо гэдэг. Талууд шүүгдэгчийн үйлдлийн тоо, хэргийн зүйлчлэл буюу ангилал, ялын хэмжээн дээр тохиролцож болно. Шүүгдэгч хэд хэдэн гэмт хэрэгт холбогдсон үед тэдгээрийн аль нэгд гэм буруутайгаа хүлээсэн тохиолдолд бусад гэмт хэрэгт яллахгүй байхаар тохирохыг хэвтээ буюу горизонталь, гэмт хэргийн ангилал дээр, тухайлбал шүүгдэгч тодорхой гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрвөл уг гэмт хэрэгт хамаарч болох илүү хүнд зүйл эсвэл хэсгээр яллахгүй байхаар тохирохыг босоо буюу вертикаль тохироо, мөн зөвхөн оногдуулах ялын хэмжээг багасгаж тохиролцохыг ял тохирох гэж нэрлэдэг. Хэд хэдэн ноцтой үйлдэл бүхий гэмт хэрэгт холбогдсон шүүгдэгчийн хувьд дээрх гурван төрлийн тохироо зэрэг явагдах боломжтой.

ХБНГУ-ын Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд ял тохиролцохыг (Urteilsabsprachen) байцаан шийтгэх ажиллагааны үндсэн зарчим болон Үндсэн хуульд харш гэж үзэж олон жилийн

[2] Chemerensky Levenson (2005) *Plea bargaining and guilty pleas. Cnminal Procedure* p.659

туршид хүлээн зөвшөөрөгдөөгүй байжээ. 1970-аад оноос Германы эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд талууд ялын тохироо хийх нь зөвхөн төвөгтэй, олон хоногоор сунжиран үргэлжлэх процессуудын хувьд зайлшгүй шаардлагаар практик хэлбэрээр хэрэглэгдэх болсон. Албан ёсоор хууль тогтоомжид тусгахгүй байснаас хэрэг эцэслэн шийдвэрлэх үед зөрчил бүхий нөхцөл байдал үүсэх нь олонтаа. Энэ зөрчлийг арилгах талаар эрдэмтэн судлаачид, улс торчид санал бодлоо илэрхийлж санал гаргаж байсан боловч хүлээн авах нийгмийн уур амьсгал, улс төрийн нөхцөл байдал бүрдээгүй байжээ. Харин 2005 оны 3 дугаар сард Германы Дээд шүүх нэгэн шийдвэртээ тус улсын хууль тогтоогчдод ялын тохирооны талаар хууль, эрх зүйн хэм хэмжээ тогтоохыг урианаар 2009 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Германы парламентаас Эрүүгийн процесс дахь тохиролцооны тухай хуулийг батлан гаргаж мөн оны 09 дүгээр сараас мөрдөн болсон.

Итали улс нь хэдийгээр уламжлалаараа эх газрын эрх зүйтэй боловч Германыг бодоход өөрийн процессын хуулиудаа мэтгэлцээнт системийн элементүүдийг эртнээс нэвтрүүлсэн улс. Герман, Италийн эрүүгийн процесст ял тохиролцох (patteggiamento) ажиллагаа үндсэндээ төстэй боловч шүүгчийн оролцоогоороо ялгаатай. Германд шүүгч талуудын тохиролцоонд биечлэн оролцож зарим тохиолдолд манлайлдаг, удирддаг байхад Италд шүүгч идэвхгүй, хөндлөнгийн байр сууринаас хандаг байна.

• *Манай улсын ЭБШХ-д буй зохицуулалт*

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 48 дугаар бүлэгт тодорхой төрлийн хөнгөн гэмт хэрэгт хялбаршуулсан журмаар байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар заажээ. Эдгээр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, хохирогч харилцан зөвшөөрч, хүсэлт гаргасан бөгөөд сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн, хохирогч хохирлын талаар маргаангүй бол хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ гэжээ. Цаашилбал прокурор яллагдагчид оногдуулах ялын төрөл, хэмжээний талаар санал бичиж яллагдагч, хохирогчид танилцуулах зохицуулалт байгаа учир үүнийг мэтгэлцээнт тогтолцоот эрх зүйн системийн ялын тохирооны институттэй адилтган үзэх боломжтой.

2008 оны сүүлийн хагаст Нийслэлийн шүүхээс явуулсан судалгаагаар шүүхээр шийдвэрлүүлсэн нийт хэргийн 90 орчим хувьд шүүгдэгч өөрийн гэм буруу хүлээж шүүхээс хөнгөн ял шийтгэл хүссэн байна. Гэтэл ЭБШХ-ийн 48 дугаар бүлэгт заасан журмаар хянан шийдвэрлэгдсэн хэрэг Нийслэлийн хэмжээнд бараг байхгүй, харин улсын хэмжээнд Сүхбаатар аймагт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 151 дүгээр зүйлд заасан буюу алдуул мал завшсан цөөн тооны

хэргийг мөн журмаар хянан шийдвэрлэсэн мэдээ гарчээ. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх үндсэн нөхцөл шаардлага нийт хөнгөн хэргийн дийлэнх хувьд хангагдсаар байхад энэ журмыг хэрэглэхгүй байгаа гол шалтгааныг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 25 дугаар зүйлийг баримталж хохирогч нь яллагдагч шүүгдэгчтэй эвлэрсэн тохиолдолд эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох боломж хуульд байгаа явдал гэж хууль хэрэглэгчид үздэг. Хэдийгээр амьдрал дээр хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх нөхцөл, эрүүгийн хэргийг оролцогчид эвлэрснээр хэрэгсэхгүй болгох нөхцөл ихэнхи тохиолдолд давхацдаг ч энд дараах үндсэн ялгаа буйг анхаарах нь зүйтэй. Үүнд хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхдээ гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байхыг шаардахгүй харин хохирлын хэмжээн дээр талууд маргаангүй байх учиртай. Мөн шүүгдэгчид ашигтай бас нэг давуу тал нь шүүгдэгчийг заавал анх удаа гэмт хэрэг үйлдсэн байхыг шаардахгүй болно. Хөнгөн хэргийн хувьд ял тохироо, эвлэрэл хоёрын хооронд бага ялгаа гарч буй боловч эвлэрэх боломжгүй бусад онгиллын хэргийн хувьд ялын тохирооны ач холбогдол асар нэмэгдэх нь тодорхой. Хүндэвтэр хэргүүдийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх тухай монголын хуульчдын хүрээнд нэлээд яригддаг боловч хүнд, онц хүнд хэрэгт хэрэглэх талаар хөндөхгүйг хичээдэг.

• ***Ял тохиролцох асуудал болон Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллгааны үндсэн зарчмуудын нийцтэй байдал, шүүмж***

Ялын тохироо хийх замаар хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх нь дээр дурдсан олон давуу талыг бий болгох боловч ялын тохироог хэрэглэдэг улсуудын олон нийт болон хуульч судлаачдын зүгээс багагүй шүүмжлэлд өртдөг. Үүнээс хамгийн ноцтой нь хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхийн эрсдлээс эмээж гэмт хэрэг үйлдээгүй гэм буруугүй хүмүүс ч заримдаа прокурорын шахалтад автан хилс хэрэг хүлээж ял тохиролцох тохиолдол гардаг байдал. Энэ нь мэдээж эрүүгийн процессд яллах болон өмгөөлөх талуудын эзлэх байр суурийн тэнцвэргүй байдалтай, тухайлбал цагдаа, тагнуул, тусгай албадыг нотлох баримт цуглуулахад ашиглах боломж, хэргийн аль ч нотлох баримт прокурорын өмнө нээлттэй байдаг зэргээрээ өмгөөлөгчөөс илт давуу байдагтай холбоотой бөгөөд прокуроroос ялын саналыг эхэлж тавих, улмаар тулгах шахах, санал эс нийлвээс эрүүгийн хуулийн илүү хүнд зүйл, хэсгээр яллах, илүү ноцтой нотлгоо гаргаж ирнэ гэх мэтээр сүрдүүлэх нь олонтаа байдаг байна. [3]

Өөр нэгэн шүүмжлэлд өртдөг зүйл бол ялын тохироо зөвхөн талуудын

[3] Chemerensky Levenson (2005) *Plea bargaining and guilty pleas, Criminal Procedure* p.649

хооронд явцуу хүрээнд явагддаг тул хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхтэй харьцуулвал олон нийтийн хараа хяналтаас гадуур, далд шийдвэрлээд байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг. Энэ нь шүүн таслах ажиллагаа ил тод нээлттэй байх зарчимд харшлах нь ойлгомжтой бөгөөд олон нийтийн дунд шийдвэрийн талаар эргэлзэхэд төрүүлэхэд хүргэдэг. Дараачийн шүүмжлэлт үзэл бодол бол шүүгдэгч үйлдсэн хэргийнхээ төлөө бүрэн гүйцэт шударга шийтгэлийг хүлээхгүй байгаа, ял завшаад байна гэж үздэг явдал. Бас нэг шүүмжлэл бол шүүгдэгч, улсын яллагч тохиргоор хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол анхаарлаас гадуур хоцрох, үл тооцогдох асуудал ажээ. Дээр дурдсан шүүмжүүд бүгд манай улсын Эрүүгийн хууль тусгагдсан "ял, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг зөвхөн хуулиар тогтоох", "гэм буруутай нь зөвхөн шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх", өргөн утгаараа эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмуудтай холбоотой юм. Мөн сүүлчийн аргумент бол хуулийн өмнө бүгд тэгш байх зарчим алдагдах өөрөөр хэлбэл хэн сайн өмгөөлөгчийг өндөр үнээр хөлслөн авч ялын тохироо сайн хийж байна тэр хүн илүү хөнгөн ял шийтгэл авч байхад зарим шүүгдэгч ийм боломжгүй байх явдал юм. Мөн Эрүүгийн байцаан шийтэх хуулийн "гэм буруугүй хэнд ч эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх", "гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт үйлдэл бүрийнх нь төлөө зохих ялыг шударгаар оногдуулах" зарчмууд ч энд хөндөгдөж байна. Түүнчлэн ялын тохироог эрүүгийн процессын "хуулийн хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох", "шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндэсэн дээр явуулах", "шүүгдэгчид сонгосон ялыг нотлох үүргийг прокурор хүлээх", "гэм буруугүйд тооцох", "шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх" зарчмуудад тийм ч нийцтэй бус гэж судлаачид үздэгээс гадна шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдан шүүн таслах ажилалгааг явуулах тухай үндсэн хуулийн заалт ч прокурор, өмгөөлөгч хоёрын хэргийн талаар хийсэн тохироог шүүгч дагах албатай болж байгаагаараа бас биелэгдэхгүй болж байгаа юм.

Эрүүгийн хэргийн мэтгэлцээн хэрэгтэн, хохирогч хоёрын хооронд гэхээсээ төрийн хууль зөрчсөн этгээд, төрийн хуулийн манаа прокурор хоёрын хооронд үүсдэг нь талуудын эвлэрэлд эрх зүйн үнэлэлт, дүгнэлт өгөхөд бэрхшээлтэй байдлыг бий болгодог. Иргэний хэрэгт талуud эвлэрснээр хэрэг шийдвэрлэгдэж өөрийн нутаг дэвсгэрт үүсэн маргаан бүрийг заавал таслаж байх төрийн ашиг сонирхол амжилттай биелж байхад эрүүгийн хэрэгт явагдах эвлэрэл нь хэргийг эцэслэн шийдвэрлэж байгаагаараа төрийн нэг сонирхол хангагдах боловч төрийн хууль халдашгүй дархан байх нөгөө ашиг сонирхолд нь харш байх боломжтой. Заримдаа эрүүгийн хэрэг дэх эвлэрэл буюу ялын тохиролцоо нь хэргийн холбогдогчид хохиролтой байх нь ч бий. Нотлох баримтын илт давуу байдлаар улсын яллагч сүрдүүлж

сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид тийм ч таатай бус, харьцангуй шудага бус нөхцлийг тулган зөвшөөрүүлэх нь ч бий. Энэ утгаараа ялын тохироо нь хэрэгт холбогдсон этгээдийн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө болон төрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын тэнцвэр дээр оршиж аль алинд нь үйлчилж чадаж байвал түүнийг эрүүгийн процессын нэгэн дэвшилтэт институтэд тооцож авч хэрэглэхэд болохгүй зүйлгүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

"ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨН БАЙЦААГЧДЫН УЛСЫН У ЗӨВЛӨГӨӨН"-ӨӨС ГАРСАН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

"Эрүүгийн хуулийг хэрэглэх явцад гарч буй бэрхшээл, түүнийг арилгах арга замууд" сэдэвт хэлэлцүүлгээс гарсан нэгдсэн санал, зөвлөмж

1. Эрүүгийн хэргийг зөв зүйлчлэх асуудлыг анхаарах шаардлагатай. Зүйлчлэлээс шалтгаалж ялын бодлого хэрэгждэг, зүйлчлэхдээ нотлох баримтыг маш сайн цуглуулж болсон асуудлыг болсон чигээр нь сэргээн гаргасан байх шаардлагатайг анхаарах.

2. Мөрдөн байцаагчид Монгол Улсын нутаг дэвсгэрт дагаж мөрдөгдөж байгаа хуулиудыг маш сайн судалж ижил төстэй хууль, түүний заалт нэг бүрийг хооронд нь ялган ойлгох хэрэгтэй. Тухайлбал, иргэний болон захиргааны хэрэг зөрчлөөс эрүүгийн хэргийг ялгах шаардлагатай, мөн ёс суртахууны болон зан заншлын шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцож байгаад анхаарал хандуулах.

3. Тухайн гэмт хэрэг ямар гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулж байгааг маш сайн судалж үзээд зөв зүйлчлэх хэрэгтэй. Мэргэжлийн ур чадвар, хууль тогтоомжийн боловсронгуй бус хийдэлтэй холбоотой асуудлаас шалтгаалж эрүүгийн хэрэг буруу зүйлчлэгдэх явдал байгааг анхаарч, цаашид энэ тал дээр тодорхой арга хэмжээ авах. Зүйлчлэхдээ шинжлэх ухааны ололт, дэвшилтийг ашиглах, практик туршлага зэргийг хэрэглэх хэрэгтэй.

4. Захиргааны зөрчлүүд Эрүүгийн хууль тогтоомжтой давхардаж байгааг өөрчлөх, ижил төрлийн харилцааг зохицуулж байгаа захиргааны зөрчил нь хохирлын хэмжээнээс хамааарч гэмт хэрэг болж байгааг өөрчлөх. Аль нь гэмт хэрэг, аль нь зөрчил болохыг анхаарах.

5. Шинжээчийн дүгнэлт шууд бус нотлох баримт бөгөөд зөвхөн тусгай мэдлэг бүхий мэргэжилтний гаргаж байгаа үнэлэлт, дүгнэлт гэдгийг анхаарч, зөвхөн шинжээчийн дүгнэлтийг барьж хэргийг шийдвэрлэдэг явдлыг таслан зогсоох.

6. Иш татсан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж нь хууль өөрчлөгдөхөөр өөрчлөгдөж байгаа нь учир дутагдалтай байна.

7. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үндэслэл болгон эрүүгийн хэрэг үүсгэж байгаа нь учир дутагдалтай байгаа, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь ялын бодлогод нөлөөлж байгааг анхаарч эрх бүхий байгууллагад энэ талаар санал хүргүүлэх.

8. Зарим төрлийн гэмт хэрэгт хууль тогтоогчоос гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжийг тодорхой тусгаж өгөх.

9. Одоогийн Эрүүгийн хуульд нийгэмд байхгүй гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцож байгааг анхаарах. Эрүүгийн хуулийн ийм зүйл, ангиудыг хүчингүй болгуулахаар санал боловсруулах.

10. Гэмт хэргийн шинжийг ялимгүй агуулах үйлдэл гэж юуг ойлгох талаар тодорхой тусгах.

11. Зарим төрлийн эрүүгийн гэмт хэрэгт хувь хүнд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх биш, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тогтолцоог бий болгох.

12. Ялын бодлогод албадан хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг оруулах.

13. Албан тушаалын гэмт хэргүүд нь хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарагдаж байгаад анхаарч хүнд, онц хүнд гэмт хэргүүдэд хамааруулах, хохирлын хэмжээг анхаарах.

14. Хээл хахууль өгсөн хүн, гуравдагч этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байхад анхаарах.

15. Хийсэн ажлын төлөө шан, харамж авч байгаа гэмт хэргийг хээл хахууль авах гэмт хэргээр шалгаж шийдвэрлэхэд хүндрэлтэй байна.

16. Эрх бүхий албан тушаалтнуудын бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудалд анхаарах.

17. Гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч байгаа этгээдийг хамгаалах талаар анхаарах.

18. Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлд заасан хөнгөрүүлэх нөхцөл байдал гэсэн заалт нь тэр бүр хэрэгжихгүй байгааг анхаарч, цаашид хэрэгжүүлэхэд анхаарах.

19. Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг өнөөгийн нийгэмтэй нийцүүлэх шаардлагатай байна.

20. Тодорхой төрлийн тухайлбал: Байгаль орчны эсрэг гэмт хэрэгт хохирлын асуудлыг анхаарч үзэх шаардлагатай.

"Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй тулгамдсан асуудлууд" сэдэвт хэлэлцүүлгээс гарсан нэгдсэн санал, зөвлөмж

1. Байцаан шийтгэх хууль нэг хэргийг нэг л удаа шийднэ гэсэн хандлагыг хууль тогтоогчид шийдэж өгөх ёстой.

2. Хэргийн бодит үнэнийг тогтоож хэргийг бүх талаас нь нотлох, цагаатгах, яллах, хүндрүүлэх, хөнгөрүүлэх бүх ажиллагааг "төр хариуцна" гэж заасан байгаагаас хамааран ЭБШХ-ийн хүрээнд өмгөөлөгчийн эрх зүйн орчин хязгаалагдмал байдгаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах үйл ажиллагааны үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгчдийн хооронд хаалттай ойлгомжгүй байдал үүсч байгаад анхаарч, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага гарч байна.

3. Тодорхой төрлийн гэмт хэрэгт нотлох ажиллагааг тэр болгон хийж чадахгүй байгааг анхаарч, энэ чиглэлээр судалгаа, нотолгооны ажил хийдэг мэргэжилтнүүдийг татаж оролцуулах, сургалтын шинэлэг арга барилыг хэрэглэх хэрэгтэй болоод байна.

4. Шинжилгээний байгууллагын үүрэг, шинжээчийн дүгнэлтийг чухалчлан үзэж байна. Шинжилгээг хийлгэхгүйгээр хэрэг шийдэгдэхгүй байгаад анхаарах. Шинжээчийн дүгнэлт бол шууд бус нотлох баримт гэдгийг мөрдөн байцаагчид анхаарах.

5. Гэмт хэргийн халуун мөрөөр нь илрүүлэх ажиллагааг сайжруулах, дэвшилтэд хүрэхийн тулд хэргийн газрын үзлэг хийх ажилтнуудын мэдлэг боловсрол, техник хангалтыг сайжруулах хэрэгтэй. Иймд хэргийн газрын үзлэг, шинжилгээ хийх ажиллагаанд барууны орны туршлагыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

6. Гэмт хэрэгт хамтран оролцсон байж болох этгээдүүдийн үйлдлийг бүрэн шалгадаггүй, шаардлагатай гэрч, хохирогчдыг олж байцаах талаар ажилладаггүй, мэдүүлгүүдийн хоорондын зөрүүг арилгаж үнэн байдлыг тогтоохын тулд хэргийн нотлох баримтаа дахин шалгадаггүй гэсэн асуудлууд байгааг анхаарах.

7. Эд зүйлийн үнэлгээ дахин хийлгэх, хохирлын хэмжээг бүрэн гаргуулах, хохирлын тооцоог зөв хийх, бусдыг залилан мэхлэж авсан эд зүйл, мөнгийг юунд зарцуулсныг хөдөлбөргүй, зөрүүгүй тогтооход анхаарч, хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох хэрэгтэй.

8. Шүүхээс өмнө нь нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан захирамж, тогтоол, магадлал эдгээрийн заалтыг нэг бүрчлэн биелүүлж байж шүүхэд шилжүүлэх арга хэмжээ авч байх.

9. Баривчлагдах, цагдан хоригдож байгаа зэргээр ямар нэгэн байдлаар эрх нь хязгаарлагдаж байгаа тохиолдол бүрийг тухайн ар

"Гомдол мэдээллийг шийдвэрлэх, эрүүгийн хэргийг түдгэлзүүлэхэд анхаарах зүйл, цаашид авах арга хэмжээ" сэдэвт хэлэлцүүлгээс гарсан нэгдсэн санал, зөвлөмж

1. Гэмт хэргийн талаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг давхардуулан шалгах, нэг өргөдлийг олон газар зэрэг шалгах, гаргах асуудал гарч байгаа, түдгэлзүүлсэн хэргийн эрэн сурвалжлалтыг хүртээмжтэй болгох шаардлагатай байгаа тул төрийн байгууллагууд, ялангуяа хууль хяналтын байгууллагууд нэгдсэн сүлжээнд холбогдох.

2. Түдгэлзүүлсэн хэрэгтэй ажиллах ажиллагааны талаар нэгдсэн бодлого боловсруулж албадын үүрэг, оролцоог тодорхой болгосон эрх зүйн акттай болох.

3. Үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 70 хувь, нийт түдгэлзүүлсэн хэргийн 60 орчим хувийг ээлж байгаа бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох, бүтэц, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх.

4. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогчид нь гадаадад байдаг тул энэ төрлийн гэмт хэргийн гомдол, мэдээллийг хохирогч байхгүй үндэслэлээр татгалзан хаах, эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд шаардлагатай хохирогч байхгүй үндэслэлээр түдгэлзүүлдэг тул ЭБШХ-ийн 42 дугаар зүйлд өөрчлөлт оруулж, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоон байцаах болох заалтыг оруулах.

5. Шинжээчийн дүгнэлт гараагүйгээс хэргийг шийдвэрлэх хугацаа удааширдаг. Түдгэлзүүлэх өөр үндэслэл байхгүй учир зайлшгүй шаардлагтай гэрч, хохирогч байхгүй үндэслэлээр хэргийг түдгэлзүүлж байгааг анхааран үзэж ЭБШХ-ийн 205 дугаар зүйлд шинжээчийн дүгнэлт гараагүй үндэслэлээр хэргийг түдгэлзүүлэх заалтыг оруулах.

6. Эд зүйлийн үнэлгээ янз бүрээр гардаг ба нэг эд зүйлийг төв, орон нутгуудад өөр өөрөөр үнэлдэг, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хүрэхгүй үндэслэлээр гомдол, мэдээллийг татгалзан хаадаг, хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж байгаа нь иргэдийг хохироож байгаа тул эд зүйлийн үнэлгээг хийдэг нэгдсэн нэг байгууллагатай болох.

7. ЭБШХ болон ЭХ-д өөрчлөлт оруулах, хэрэв өөрчлөх шаардлагатай бол ямар зүйл, хэсэгт өөрчлөлт оруулах талаар хуулийн байгууллагын ажилтнуудаас санал авах.

"Мөрдөн байцаалтын ажиллагаанд хүний эрхийг хангах нь" сэдэвт хэлэлцүүлгээс гарсан нэгдсэн санал, зөвлөмж

1. Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл, эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг нэг мөр шийдвэрлэхгүйгээс тэдгээр нь өмгөөлүүлэх, эрх зүйн туслалцаа авах боломж нөхцөлөөр хязгаарлагдмал байна. Иймд:

- Эрүүдэн шүүлттэй тэмцэх, түүнээс ангид байхад чиглэсэн сургалтуудыг хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр бүсчилсэн бүхий хэсэгчилсэн байдлаар шинэ арга, хэлбэрээр хамтран зохион байгуулж байх;
- Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулагдсан эрх зүйн туслалцааны төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэхийн зэрэгцээ, үзүүлж буй үйлчилгээний талаар нийтэд сурталчлах, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулах ажлыг идэвхитэй зохион байгуулах;
- Мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагаа, онц хүнд гэмт хэргийн "хэргийн газрын үзлэг" хийх сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих асуудлыг шүүхээр шийдвэрлэхэд өмгөөлөгчийг заавал байлцуулах талаар ЭБШХ-ийн 40 дүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах, үүнтэй холбоотойгоор Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлөөс жижүүрийн өмгөөлөгч ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

2. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх зөрчигдөхөөс сэргийлэх, оролцогчдын эрхийг хангах үүднээс мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчдийн өрөө тасалгаа, байцаалт, мэдүүлэг авах өрөөнүүдэд хяналтын камер суурилуулах, байцаан шийтгэх ажиллагааны явцыг дүрсжүүлэх, соронзон хальсанд буулгаж баримтжуулах ажлыг бололцоотой бүх арга замаар хэрэгжүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны зардлын хүрэлцээг нэмэгдүүлж, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэх.

3. Хүний эрхийг хангах, мөрдөн байцаагчдийн ажлын ачааллыг багасгах чиглэлээр мөрдөн байцаагчийн ажлын байрны стандартыг шинээр бий болгох, төсөл хэрэгжүүлэх.

4. Байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх зөрчсөн талаарх мэдээ, мэдээллийг харилцан шуурхай солилцох ажиллагаанд өмгөөллийн болон хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүний эрхийн талаарх сургалт, хуулийн байгууллагын ажилтнуудын сэтгэхүйн өөрчлөлтийг шинэчлэх ажлыг зохион байгуулах.

5. НҮБ-аас дэмжигдсэн Дэлхийн хөгжиж буй орнуудын 2008

оны Эрүүгийн процессын загвар хуулийн зарчим, хүний эрхийн чиглэлээр стандартад нийцүүлж ЭБШ хуулийг өөрчлөн, шинэчлэх санал боловсруулах, шүүхээс өмнөх ЭБША-н дахь Хүний Эрхийн талаарх ОУ конвенцийн заалт, зарчмуудтай ЭБШ хууль тогтоомжийг нийцүүлэх.

6. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих болон суллах, өөрчлөх арга хэмжээний журмыг хүний эрхийн асуудалтай уялдуулж өөрчлөх, боловсронгуй болгох, өмгөөллийн үйл ажиллагааг тэгш эрхийн зарчимд нийцүүлэн чадавхижуулах эрх зүйн орчныг сайжруулах, гэм буруу тогтоохын тулд цагдан хорих бус, гэм буруу нотолсны дараа баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч байхыг хуульчлах.

7. ЭБШХ-ийн 68 дугаар зүйл"...Оргон зайлж болзошгүй..." гэсэн заалтыг нэг мөр ойлгох, цаашид хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар хууль боловсруулах түвшинд санал хүргүүлэх, шүүхээр гэм буруугүй нь тогтоогдоогүй байхад сэжигтэн, яллагдагчдын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхгүй байх талаар холбогдох хууль, дүрэмд санал оруулах.

8. ОУ-ийн конвенц ба түүнийг хэрэглэх арга зүйн талаар мэдээлэл, гарын авлагыг шинэчлэн тараах, НҮБ-ын 1984 оны конвенцийн нэмэлт протоколд нэгдэн орох.

9. Иргэдийн гомдол, мэдээллийг хүлээн авдаг журмыг боловсронгуй болгох, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг барагдуулах асуудлыг бүрэн төгс шийдэх боломж шийдлийг олж хуульчлах, бусдад учруулсан сэтгэл санааны хохирлыг бодитой үнэлэх үнэлэмжийг тогтоох, хохпрогч, гэрчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох.

10. Манай иргэд "эуучлал"-ын шугамаар гэр бүл болох, гадаадын иргэд хүүхэд үрчлэн авахтай холбоотойгоор хүүхэд, эмэгтэйчүүд гэмт хэргийн золиос болох явдал гарсаар байгаа тул Монгол Улс нэгдэн орсон "Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг Палермогийн протокол"-д үндэслэн энэ төрлийн харилцааг зохицуулж буй "Гэр бүлийн тухай", "Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль"-ийн зарим зүйл, заалтуудад өөрчлөлт оруулах.

11. ЭБШХ-ийн 28.2.2-т заасан "эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох саналаа прокурорт гаргах гэсэн" заалтыг боловсронгуй болгох чиглэлээр төрийн бус байгууллагуудаас санал оруулсныг тус тус хүргүүлж байна.

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР ҮЛСЫН МӨРДӨН БАЙЦААХ ГАЗРЫН САНАЛ

Санал	Тайлбар
12 дугаар зүйл. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууцыг хамгаалах 12.1. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууцыг хуулиархамгаалахбаэнэхүүэрхийг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно.	Захидал харилцаа гэдэгт шуудан, холбоо мэдээллийн бүх хэрэгслийн харилцааг ойлгох, эрүүгийн хэрэг үүссэн хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагчийн харилцааг хянах, хохирогч, гэрчийг ...згаалах.
28 дугаар зүйл. Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч 28.2.3 хэргийн газарт үзлэг хийх, зураглал үйлдэх, дууны болон дүрс бичлэг хийх, хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчийн утсан харилцаанд хяналт тавих, бичлэг хийх. (нэмэх) 28.2.15. Гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр бүюу өөр орон нутагт байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэнийг эрэн сурвалжлах, түүнчлэн гүйцэтгэх тодорхой ажиллагаа явуулах шаардлагатай бол энэ тухай даалгаврыг бичгээр гаргах ба түүнийг хүлээн авсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага заасан хугацаанд заавал биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар хүргүүлэх.	...ан харилцаанд хяналт тавих ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр 28.2.14-д заасны дагуу мөрдөн байцаагч даалгавар бичиж Гүйцэтгэх тагнуулын алба хяналт тавина. Хэсгийн төлөөлөгчид бичсэн мөрдөн байцаагчийн даалгавар зарим тохиолдолд нотлох баримт болохгүй байгаа тул оорчлөн найруулах шаардлагатай байна. 172.3. Гомдол мэдээллийг шалгах явцад гэмт хэрэг үйлдэж байгаа болон гэмт хэрэг үйлдсэн үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, АТГ, цагдаагийн байгууллагын ажилтан /хэсгийн төлөөлөгч/ эрүүгийн хэрэг үүссэн шийдвэрлэхийн тулд дараах хойшлуулшгүй ажиллагааг хийж болно. –гэж оруулах.

35 дугаар зүйл. Сэжигтэн 35.5. Сэжигтэн дараах үүрэг хүлээнэ: (Шинээр нэмж тусгах) 35.5.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын дуудсан цагт хүрэлцэн ирэх; 35.5.2. Биед үзлэг, шинжилгээ хийхээр эмнэлгийн байгууллагад шилжүүлэх тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын тогтоол болон байцаан шийтгэх ажиллагааны явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан бусад шийдвэрийг биелүүлэхэд саад хийхгүй байх;	Сэжигтнээс бусад оролцогчид луудсан цагт ирэх үүрэг хуулиар хүлээсэн байдаг учраас түүнд ч бас энэ үүргийг хүлээлгэх талаар шинээр нэмж тусгах шаардлагатай. Сэжигтнийг дуудсан цагт ирэх үүргийг хуулиар хүлээлгээгүй боловч албадан ирүүлэхийг зөвшөөрсөн заалттай зөрчилдөг. 74 дүгээр зүйл. Албадан ирүүлэх 74.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн гэрч, хохирогч, шинжээч нь дуудсан үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гарган албадан ирүүлнэ.
36 дугаар зүйл. Яллагдагч 36.3.8. Өөрт холбогдсон хэргийн материалтай танилцах; (хасах) 36.3.12. шинжээч томилсон тогтоол болон шинжээчийн дүгнэлттэй танилцах;	Яллагдагч хэргийн материалтай танилцсаар мөрдөн байцаах ажиллагаа удаашрах, хохирогч, гэрчүүд хамгаалалтгүй, нууцлал задарсан учраас мэдүүлгээсээ буцах, хэрэгт хохирогч, гэрчээр оролцох нь шийтгэл мэт ойлголт иргэдийн дунд байна.
41 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн эрх, үүрэг 41.3.3. хохирогч, гэрч, (хасах) шинжээчийг байцаахад байлцаж, тэдгээрт асуулт тавих; 41.3.4. Өмгөөлж байгаа этгээдийнхээ болон өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байлцаж тухайн ажиллагаанд оролцож байгаа гэрч, (хасах) шинжээч, бусад этгээдэд аль ч үед асуулт тавих; 41.3.8. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дуусаны дараа хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах; (хасах)	Хохирогч, гэрчийн хамгаалалт байхгүй, эрхэнд халдах боломжийг шүүгдэгчийн өмгөөлөгчид олгож байгаа учраас энэ заалтыг хасах саналтай. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрхийг хамгаалах талаар ЭБШХ бүхэлдээ чиглэсэн боловч хохирогч, гэрчийн эрхийг хамгаалах талаар нэг ч заалт байхгүй байгаад анхаарах. "Гэрч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн дуудсанаар ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй" гэж ЭБШХ 45 дугаар зүйлийн 45.4-т хуульчилсан байдаг. Гэтэл гэрчийн эрхийг хамгаалсан хуулийн зохицуулалт байхгүйгээс тэрээр мэдүүлгээсээ буцаж хэрэг, хэрэг биш болох тохиолдол цөөнгүй байна. Иймд гэрчийн эрхийг хамгаалах талаарх зохицуулалтыг ЭБШХуулинд оруулах шаардлагатай.

42 дугаар зүйл. Хохирогч 42.4 Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, эсхүл эрх зүйн чадамжгүй болсон бол энэ зүйлд заасан эрхийг түүний гэр бүлийн гишүүн болон төрөл садангийн хүн эдлэнэ гэсэн дээр Гэмт хэргийн улмаас хохирч гадаад байгаа гэснийг нэмэх	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогч нар нь гадаадад байгаа тул энэ төрлийн гэмт хэргийн гөмдөл мэдээллийг хохирогч байхгүй үндэслэлээр татгалзан хаадаг. Эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд шаардлагатай хохирогч байхгүй үндэслэлээр тулгэлэүүлдэг.
58 дугаар зүйл. Сэжигтнийг баривчлах үндэслэл 58.1. Сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд (хасах) гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол түүнийг баривчилж болно.	Сэжигтнийг баривчлах үндэслэлийг оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэг сэрдэгдэх х[illegible]ттай баримт байгаа бол гэснийг [illegible]х, ЭБШХ-ийн 35 дугаар зүйлд [illegible] сэжигтнээр тооцох үндэслэл нь [illegible]үүнийг баривчлах үндэслэл болдог байх. Гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт нь сэжигтнийг баривчлах үндэслэл болох бөгөөд шалтгааныг шаардах ёсгүй. Хэрвээ хууль бусаар баривчилсан бол төрөөс хохирлыг нөхөн төлөх заалт байгаа сэжигтэн, яллагдагчийн эрх бүрэн хамгаалагдсан.
59 дүгээр зүйл. Сэжигтнийг баривчлах журам 59.2. Тогтоолд баривчилсан үндэслэл, шалтгаан, (хасах) газар, хугацаа (цаг, минут заасан), биед нь хийсэн үзлэгийн үр дүн, түүнчлэн тэмдэглэл хөтөлсөн хугацааг тусгана.	
62 дугаар зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл (шинээр өөрчлөн найруулах) 62.1. Гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагч, шүүгдэгчид уг хэргийг шийдвэрлэх хүртэл хугацаанд дараах таслан сэргийлэх арга хэмжээний аль нэгийг нь авч болно: 62.1.1. оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа эвах; 62.1.2. батлан даалтад өгөх; 62.1.3. эд хөрөнгө барьцаалах; 62.1.4.цэргийн албан хаагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх; 62.1.5. цагдан хорих. 62.2. Таслан сэргийлэх арга хэмжээ авах талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргах бөгөөд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн шүүгч авна.	Ирээдүй цагийн субъектив шинжтэй оргон зайлж болох, буюу эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж болох, эсхүл гэмт хэрэг үйлдэж болох үндэслэлтэй бол гэснийг өөрчлөх энэ үндэслэлүүдийг нотлох баримтаар тогтоох боломжгүй, хүний эрхийг зөрчих боломжийг олгосон заалт учраас Гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, шүүгдэгчийн хэргийг шийдвэрлэх хугацаанд тэдгээрийг дуудсан цагт ирүүлж байхад ТСАХ чиглэгдэг учраас өөрчлөн найруулах саналтай.

68 дугаар зүйл. Цагдан хорих 68.1. Эрүүгийн хуульд заасан хүндэвтэр (гэж нэмэх), хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор (хасах) мөрдөн байцаагчийн саналыг үндэслэн цагдан хорьж болно. 68.2. Дараах нөхцөл байдал байвал хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорьж болно: 68.2.1. өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн; 68.2.2. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан; 68.2.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн. (бүхэлд нь хасах) 68.3. Энэ хуулийн 68.1, 68.2-т (хасах) заасан үндэслэл, шаардлага байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих газар, үндэслэлийг тодорхой заасан тогтоол үйлдэж прокурорт танилцуулах бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулна. Шүүгч шаардлагатай гэж үзсэн, эсхүл өмгөөлөгч хүсэлт гаргасан бол өмгөөлөгч, прокурорыг байлцуулан сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих эсэх асуудлыг шийдвэрлэж нэн даруй захирамж гаргана. 68.5. Шүүгч цагдан хорихоос татгалзсан бол сэжигтэн, яллагдагчийг дахин цагдан хорих саналыг зөвхөн цагдан хорих шинэ үндэслэл, шалтгаан бий болсон тохиолдолд шүүхэд ирүүлнэ. (хасах)	Хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг мөрдөн байцаагчийн саналыг үндэслэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авч байх шаардлагатай байна. Мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн урд нь эрүүгийн болон захиргааны зөрчилд шалгагдаж байсан эсэх, ял шийтгүүлж байсан эсэхийг тодруулсан байх. 68.2.-ыг бүхэлд нь хасах саналтай.

69 дүгээр зүйл. Цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах журам 69.3.Хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид хорьж мөрдөх зайлшгүй шаардлагатай бол шүүх хорьж мөрдөх хугацааг тухай бүр 30 хүртэл хоногоор сунгах бөгөөд яллагдагчийг хорьж мөрдөх нийт хугацаа хүндэвтэр гэмт хэрэгт 4 (12) гэж өөрчлөх сараас, хүнд.гэмт хэрэгт 12 сараас, (хасах) онц хүнд гэмт хэрэгт 24 сараас хэтэрч болохгүй.	Хүндэвтэр гэмт хэргийн яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа бага байгаа, яллагдагч хуульд заасан хугацааг өнгөрүүлэхийн тулд зориуд удаашруулах хандалгатай байдаг. Хүндэвтэр гэмт хэрэгт 12 сар, хүнд, онц хүнд гэмт хэрэгт 24 сараас хэтэрч болохгүй. Гэж өөрчлөх.
69 дүгээрзүйл. Цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах журам 69.4..... 69.3-т зааснаас илүү хугацаагаар хорьж мөрдөх шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно гэсэн дээр: Нийт хорьж мөрдөх хугацаа дуусан яллагдагч нь дахин гэмт хэрэг үйлдсэн, мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс зориуд зайлсхийсэн бол түүнийг хэргийг шийдвэрлэтэл цагдан хорьж болно гэж нэмэх.	; төвөгтэй хэрэгт яллагдагчийн хорьж мөрдөх хугацаа дуусч батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авахад зарим яллагдагч мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс зориуд зайлс хийх, дахин гэмт хэрэг хэд хэдэн удаа үйлдэх тохиолдол байна. Иймд яллагдагчийг цагдан дахин гэмт хэрэг үйлдэх, дахин мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс зориуд зайлсхийхээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдан хорьж баймаар байна.

ХУУЛЬ ЗҮЙН ТОЙМ ХЭЛЭЛЦЭХ www.parliament.mn

70 дугаар зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох, өөрчлөх 70.3. Баривчлах, цагдан хорихоос бусад. Прокурорын шийдвэрээр авсан таслан сэргийлэх арга хэмжээг гагцхүү тухайн прокурор буюу дээд шатны прокурор хүчингүй болгож, өөрчилж болно. (Хасах) 71 дүгээр зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээ хууль ёсны эсэхэдтавих хяналт 71.2.Сэжигтэн, яллагдагчид цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээ авах, нэгэнт авсан арга хэмжээг хүчингүй болгох, өөрчлөх шаардлагатай бол уг хэргийн ажиллагаанд хяналт тавьж байгаа, эсхүл дээд шатны прокурор тогтоол гаргаж, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид мэдэгдэнэ.	Таслан сэргийлэх арга хэмжээг хэргийг эцэслэн шийдвэрлэхэд чиглэгдсэн арга хэмжээ учраас хэрэгсэхгүй болгохоос бусад тохиолдолд хүчингүй болгох шаардлагагүй, мөрдөн байцаагч, прокурорын эрх хэмжээнд халдсан заалт учраас хасах.
72 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээ авах үндэслэл 72.1.1. дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг авахуулах; (Хасах) 73 дугаар зүйл. Дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг авахуулах 73.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ аваагүй нөхцөлд, түүнчлэн гэрч, хохирогч байцаан шийтгэх ажиллагаа явуулах, хэрэг шийдвэрлэхэд хүрэлцэн ирэхгүй гэх хангалттай үндэслэл байгаа буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дуудахад хүрэлцэн ирээгүй бол уг этгээдээр дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг бичгээр авахуулах ба тухайн этгээд оршин суугаа газрын хаягаа өөрчилсөн тохиолдолд нэн даруй мэдэгдэх үүрэг хүлээнэ. (Хасах)	Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид заавал таслан сэргийлэх арга хэмжээ авдаг байх ёстой. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхээр хэргийг шийдвэрлэх хүртэл хугацаанд дуудсан цагт хүрэлцэн ирэх үүрэг авахуулах гэсэн заалт байх шаардлагагүй. Биелэгдэх боломжгүй болсон заалт юм.

www.mnli.gov.mn

92 дугаар зүйл. Нотлох баримтыг цуглуулах 92.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад байцаах, нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах, хураан авах, үзлэг, нэгжлэг хийх, туршилт, шинжилгээ, полиграф, утсан харилцааг хянах болон энэ хуульд заасан бусад байцаан шийтгэх ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулна.	Полиграф нь шинжилгээний нэг төрөл бөгөөд түүнийг нотлох баримт цуглуулах аргад оруулан тооцох нь зүйтэй, хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчийн утсан харилцааг хянах нь гэмт хэргийг нотлох, хохирогч, гэрчийг хамгаалахад чиглэгдсэн ажиллагаа байна.
99 дүгээр зүйл. Байцаан шийтгэх ажиллагааны зардал 99.1.1.Хохирогч, түүний төлөөлөгч, гэр, хөндлийн гэрч, мэргжилтэн, шинжээч, орчуулагч, хэлмэрчид төлсөн зардал-ыг мөрдөн байцаалтын шатанд төлүүлэх.	Дээрх оролцогч нарт гаргаж байгаа байцаан шийтгэх ажиллагааны зардлыг тухайн байгууллагын төсөв суулгаж өгөх.
125 дугаар зүйл Эрүүгийн хэргийг тусгаарлах 125.1. Зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь хэргийг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор шинжлэх, зөв шийдвэрлэхэд саад болохгүй бол уг хэргийг тусгаарлаж болно. 125.2. Хэргийг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед тусгаарлаж болох бөгөөд энэ тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн үйлдсэн хэргийг шийдвэрлэхэд нотлох баримт хангалттай, гэмт хэрэгт хамтран оролцсон этгээдийг байгаа газар нь мэдэгдэхгүй бол уг хэргийг тусгаарлан шийдвэрлэж болно.
173 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг үүсгэх журам 173.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэсэн бол 72 цагийн дотор танилцуулж, эрүүгийн хэргийн дугаар авна.	Цагдаагийн байгууллага гомдол мэдээллийн бүртгэлийг өөрсдөө хүлээн авч бүртгэж байгаа тул эрүүгийн хэргийн дугаар олгодог эрхийг буцаан авч, прокурор зөвхөн хяналтаа тавьдаг болгох. (Эрүүгийн хэргийн дугаар авна) гэдгийг ЭБШХ-иас хасах.
174 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг үүссэний дараа явуулах ажиллагаа 174.1.1. Прокурор хэргийг бүртгэн, эрүүгийн хэргийн дугаар олгож, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагыг аль нэг мөрдүүлэхээр харьяаллын дагуу шилжүүлэх. –гэдгийг хасах.	Гарсан гэмт хэрэгт хойшлуулшгүй ажиллагаа хийх тохиолдолд цаг хугацаа алдах асуудал их гарч байна.

197 дугаар зүйл. Яллагдагчийг дуудах 197.4. Яллагдагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргон зайлсан, оршин суух тодорхой хаяггүй бол түүнийг урьдчилан дуудахгүйгээр албадан ирүүлж болно.	Байнгын болон түр оршин суух хаяг гэж хуулиар тодорхойлсон. Тодорхой оршин суух хаяггүй байна гэсэн ойлголт байдаггүй. Иргэний хуулийн 22 дугаар зүйл. Иргэний оршин суугаа газар 22.1.Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно. 22.2.Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн эгтгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно. 22.3.Бусдын асран хамгаалалтад байгаа этгээдийн оршин суугаа газрыг төлгөөрийн эцэг, эх, асран хамгаалагчийн оршин суугаа газраар тодорхойлно.
205 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлэүүлэх үндэслэл, хугацаа 205.1.2. сэжигтэн, яллагдагч оргон зайлсан, эсхүл байгаа газар нь мэдэгдэхгүй байвал (хасах)	Сэжигтэн, яллагдагчид заавал таслан сэргийлэх арга хэмжээ авах бөгөөд энэ арга хэмжээгээ зөрчсөн, дуудсан цагт ирэхгүй, оршин суух газраасаа мэдэгдэлгүйгээр алга болсныг зориуд зайлсхийсэн буюу оргон зайлсан гэж үзэх. байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа үндэслэлээр хэргийг түдгэлзүүлсэн тохиолдолд сэжигтэн, яллагдагчийн хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусан үед хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх боломжтой болж ял завшуулах боломж олгож байна.
212 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дуусаныг мэдэгдэх, хэргийн материал танилцуулах 212.2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дуусаныг мэдэгдсэний дараа яллагдагч, хохирогч, тэдний өмгөөлөгчид хэргийн бүх материалыг, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгчид хэргийн зөвхөн иргэний нэхэмжлэлд холбогдох хэсгийг танилцуулна.	Яллагдагчид хэргийн материалыг танилцуулах шаардлагагүй. Энэ нь хохирогч, гэрчийг хамгаалах, шүүхэд хэргийг хэлэлцэхэд мэтгэлцэх зарчмаар шийдвэрлэгдэх эрх нь яллагдагчид байгаа.

214 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос хянавал зохих асуудлууд 214.1.6. гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдийг яллагдагчаар татсан эсэх;	214.1.4. сонгосон ял нь хэрэгт байгаа нотлох баримтад үндэслэгдсэн эсэх нь заалтаар зохицуулагдсан учир хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгээр бүх этгээд яллагдагчаар татагдаагүй гэсэн шалтгаанаар хэрэг удааширах боломж олгодог, хэрвээ бусад этгээдийн байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа бол хэргийг түгаарлах боломжтой байх.
229 дүгээр зүйл. Хэргийг түдгэлзүүлэх 229.1. Шүүгч дараахь тохиолдолд хэргийг түдгэлзүүлнэ: 229.1.1. яллагдагчийн хаана байгаа нь мэдэгдэхгүй байгаа бол; (хасах)	Яллагдагч нь дуудсан цагт ирэх үүрэгтэй бөгөөд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан оршин суугаа хаяг нь тодорхой нөхцөлд оргон зайлах боломж олгож, улмаар хэрэг хэрэгсэхгүй болох ял завших боломж олгосон заалт учраас хасах. Оргон зайлсан гэж үзэж хэргийг нэмэлт мөрдөн байцаалтанд буцаах

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ГАЗАР www.nli.gov.mn

247 дугаар зүйл. Шүүх хэргийг түдгэлзүүлэх 247.1.Шүүгдэгчийн байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа (хасах), түүнчлэн сэтгэцийн болон өөр хүнд өвчний улмаас шүүхэд ирэх боломжгүй болсон нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлоогоор нотлогдсон бол шүүх тэр шүүгдэгчийн хувьд түүнийг эдгэртэл хэргийг түдгэлзүүлж, бусад шүүгдэгчийн хувьд шүүх хуралдааныг үргэлжлүүлнэ.	Шүүгдэгч ирэх үүрэгтэй бөгөөд түүнд ирэхгүй байх боломж олгож, хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусан үндэслэлээр хэрэгсэхгүй болгох боломж олгож ял завшуулах сорог үр дагавартай заалт юм. Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх 72.1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй: 72.1.1. хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн; 72.1.2. хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн; 72.1.3. хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн; 72.1.4. онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин таван жил өнгөрсөн. 72.3. Шүүхийн өмнөх шат болон шүүхийн шатнаас гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс зогсоож уг этгээд баригдсан бүюу хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно. гэсэн заалт хэрэгжихгүй байгаа нь энэ зааltаас үүдэлтэй.
414 дүгээр зүйл. Хялбаршуулсан журмаар байцаан шийтгэх ажиллагаа явуулах хэргийн харьяалал 99.2, 111.2, 135.2, 136.1,136.2, 137.2, 139.2, 144, 146.1, 147.1, 148.1, 149.1, 150.1, 153.1, 153*.1, 175.1, 216.2, 223.1, 230.2, 234.2, 237.1, 237.2, 240.1, 245.2, 277.2, 278.2, дүгээр зүйлд заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт хялбаршуулсан журмаар байцаан шийтгэх ажиллагаа явуулна.	Хялбаршуулсан журмаар хэрэгхянан шийдвэрлэх ажиллагаа нь байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулах, иргэдийг чирэгдүүлэхгүй байх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гэсэн нүсэр ажиллагааг хөнгөвчлөх чухал ач холбогдолтой.

415 дугаар зүйл. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл 415.2.Энэ хуулийн 414.1-т заасан гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, хохирогч харилцан зөвшөөрч, хүсэлт гаргасан бөгөөд сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн, хохирогч хохирлын талаар маргаангүй бол хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх бөгөөд хэрэг бүртгэх, мөрдөнбайцаах(нэмэх)ажиллагааг эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш нэн даруй гүйцэтгэнэ.	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаа нь үндсэндээ байцаан шийтгэх ажиллагаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч учраас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гэж ялгахгүйгээр байцаан шийтгэх ажиллагаа явуулах гэж өөрчлөх.
416 дугаар зүйл. Хялбаршуулсан хэрэг бүртгэх ажиллагаа	Хялбаршуулсан байцаан шийтгэх ажиллагаа гэж оорчлох

414 дүгээр зүйл. Хялбаршуулсан журмаар байцаан шийтгэх ажиллагаа явуулах хэргийн харьяалал

414.1. Эрүүгийн хуулийн 99.1 Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах ,103.1 Бэлгийн замын халдварт өвчнөө эмчлүүлэхээс зайлсхийх, халдаах , 110 Доромжлох/, 111.1/Гүтгэх/, 118 Асран хамгаалах үүргээ урвуулах , 123.1 Садар самууныг сурталчлах , 130.1 Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх , 132 /Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих , 135.1 Иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих , 137.1/Иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчих , 139.1/Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх , 142/Хуний шашин шүтэх, эс шүтэх эрхийг зөрчих/, 143 Шүтэж байгаа шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгих/, 145.1/Бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 151/Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших/, 152 Хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших/, 155.1/Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах/, 187.1/Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг хамгаалах үүрэгт ажилдаа хайнга хандах/, 197.1/Хууль бусаар эмчлэх/, 201.1/Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах/, 215.1/Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих/, 216.1/Зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхих/, 220.1/Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй

хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах/, 222.1/Жолоогоо бусдад шилжүүлэх/, 223.1/Авто тээврийн хэрэгслийг авч зуртаах/, 230.1/Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх/, 231.1/Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох/, 233.1/Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах/, 234.1/Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягтыг хулгайлах, устгах, гэмтээх, нуух/, 236/Дураараа аашлах/, 239/Төрийн дайчилгаанаас зайлсхийх/, 243.1/Мөрийтэй тоглох/, 244/Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах/, 245.1/Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд саад учруулах/, 255/Гэрч, хохирогч, мэдүүлэг өгөхөөс, шинжээч дүгнэлт гаргахаас татгалзах, зайлсхийх/, 259/Шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гутгэх/, 275.1/Захирагчийн тушаал биелүүлэхгүй байх/, 277.1/Захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх/, 278.1/Бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих/, 284.1 Байлдааны машин жолоодох болон ашиглалтын журам зөрчих/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт хялбаршуулсан журмаар байцаан шийтгэх ажиллагаа явуулна.

Тайлбар: Энэ зүйлд заагдаагүй бусад хөнгөн гэмт хэрэг ердийн журмаар шийдвэрлэгдэнэ.

Хавсралт:

д/д	*Эрүүгийн хуульд оруулах санал*	*Тайлбар*
1.	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 16 дугаар зүйлийн 16.2-т "Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй" гэж заасныг нарийвчлан хуульчилж өгөх.	Гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан, ялимгүйн учир нийгэмт аюулгүй үйлдэл, эс үйлдэхүй гэдэг ойлголтыг нэг мөр хуульчилж өгөөгүйгээс энэ ойлголт нь практикт хэрэгжихгүй байгааг анхаарч хуульчилж нэг мөр ойлголтыг бий болгох. Энэ нь гэр бүлийн маргаан нь гэмт хэрэг болон шалгагдах явдлаар ихэнх тохиолдолд илэрдэг.

2.	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 17 дугаар зүйлд гэмт хэргийн ангилалыг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилаад ЭБШХ-ийн 24, 25 дугаар зүйлд эрүүгийн хэргийн харьяалал тогтоосон, мөн түүнчлэн тусгай харьяаллын хэргүүд гэж харьяалал тогтоосон нь хэрэг шалгах хугацааны асуудал дээр удаашралтай байдал гарахад нөлөөлж байгааг анхаарч гэмт хэргийн ангилалыг өөрчлөн тогтоох.	Ихэнх тохиолдолд тусгай харьяаллалын хүндэвтэр гэмт хэргийг шалгах хугацааг 2 сараар тогтоосноос иргэдийн эрх ашиг зөрчигдөж, хэрэг шалгах хугацаа удааширч байгаатай холбоотой.
3.	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлд зааснаар хохирлын хэмжээг тодорхойлохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харгалзан үзэж байгааг "бага бус" хохирлын хувьд өөрчлөн хуульчлах. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн хохирлын хэмжээг хэрхэн тогтоох талаар хуульчлах.	"Бага бус" хохиролын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулснаар өмчийн эсрэг гэмт хэрэг, түүний дотор бусдын эд хөрөнгийг хулгайлах, залилан мэхлэх гэмт хэргийн хохирогч нарын эрх ашгийг нөхтойгоор зөрчиж байна. 1 хонь, 1 тугал гэх мэтээр түүж хулгай хийхэд захиргааны хариуцлагын тухай хуулиар зөрчилд тооцогдон 20.000 хүртэлх төгрөгөөр торгуулиад цаашид дахин гэмт хэрэг үйлдэх боломж нөхцөл бий болгож байна. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн хохиролын хэмжээг тогтооход бэрхшээлтэй байдгийг анхаарч шинээр хуульчлах.

www.ikh.mn

4.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 94 дүгээр зүйлд "...бусдыг болгоомжгүй алсан бол...", 97 дугаар зүйлд "...бусдын бие махбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулсан бол..." гэж хуульчилан 27 дугаар зүйлд гэмт хэрэг болгоомжгүй үйлдэхийг тайлбарласан боловч дээрх 2 гэмт хэргийн хувьд ямар тохиолдлыг болгоомжгүй гэж үзэж практикт хэрэглэх талаар хуульчлаагүй тул нарийвчлан хуульчлах.	Тусгай ангийн дурьдсан 2 гэмт хэргийн хувьд хөнгөмсгөөр найдсан, хайхрамжгүй хандсан гэдэг ойлголтыг хуульчлаагүйгээс практикт иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдсөөр байна. Жишээ нь: Бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулсаны улмаас хохирогч нас барах, энэ тохиолдолд болгоомжгүй гэж үзэх үү, эсвэл тухайн хохирогч эмчлэгдэх боломжтой байсныг эмчүүлэлгүй явсаар нас барсныг тогтоох уу, эмнэлгийн байгуулллагын ажилтан буруу оношлосноос болсон гэж үзэх үү гэх мэт.
5.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 "Хүн худалдаалах", 124 "Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" зүйлүүдэд заасан гэмт хэргийг тус тусад нь ойлгомжтой хуульчлах. Мөн тус хэрэгт хамтран оролцогчдыг тусгайлан хуульчлах шаардлагатай байна.	ЭХТА-ийн 113 дугаар зүйлд "мөлжих" гэдэгт Биенийг нь үнэлүүлэх..... гэсэн утгаал ойлгоно гэсэн нь ЭХТА-ийн 124 дүгээр зүйлд заасантай адил байгаа бөгөөд тус зүйл ангиудын тайлбарт ч хуурч мэхлэх, тухайн хүнд итгэл үнэмшил төрүүлэх, оюун ухааныг нь угаах гэдгийг нарийвчлан заагаагүй, мөн ямар тохиолдлыг бусдын эрхшээлд байгаа гэсэн ойлголтод хамруулахыг нарийвчлан заагаагүй байна. Жишээ нь өнөөгийн практикт хүч хэрэглэж буюу айлган сүрдүүлж, эд материалын эрхшээлд оруулсан, өөрөөр хэлбэл яг цоожтой байсан тохиолдлыг л ойлгож байгаа бөгөөд сэтгэл санаанд нь итгэл үнэмшил төрүүлэх, оюун ухааныг нь угааж менгө олох гэсэн хохирогчийн вективность буюу хялбар аргаар менгө олох гэсэн дур хүслийг нь өдөөж өгсөн тохиолдлыг оруулахгүй байна.

6.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 156.1 дүгээр зүйлд "...Хоршооны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас ...", 158.1 дугаар зүйлд "...Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомжоор тогтоосон журмыг зөрчсөний улмаас...", 160 дугаар зүйлийн 160.1-д "...Төрийн эрдэнэсийн сангийн тухай хууль тогтоомжоор тогтоосон журмыг зөрчсөний улмаас...", 161 дүгээр зүйлд "... хууль тогтоомжоор хориглосон...", 175 дугаар зүйлд "...хориглосон буюу хязгаарласан эд зүйлийг...", 204 дүгээр зүйлд "...газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчсөний улмаас ..." гэх мэт иш татсан хэм хэмжээнүүдийг өөрчилөн хуульчлах.	Хоршооны тухай хууль, захиргааны хариуцлагын тухай хууль зэргээс иш татсан, эсвэл тодорхой нэг байгуулллагын (газар агентлагийн) тогтоосон журмыг баримталсан хэм хэмжээг хуульчлсныг эрүүгийн хуулийн зорилт, бодлого алдагдаж байна. Жишээ нь Мэргэжлийн хяналтын газрын даргын тогтоосон журмаар зарим гэмт хэргийг шийдвэрлэж байна.
7.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 192 дугаар зүйлд "...хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан...." гэж заасан боловч хэрэглэсэн этгээдэд ял оногдуулахаар хуульчлаагүй байгаа тул хуульчлах.	Учир нь тухайн гэмт хэргийг үйлдэгч нар нь улам шинээр олон хэрэглэгчийг бий болгож байж өөрийн зах зээлээ олж авдаг, хэрэглэсэн этгээдүүд улмаар хар тамхи, мансууруулах бодисны хамаарал орж бусад төрлийн гэмт хэрэг үйлдэх магадлалтай байдаг.

www.mnli.gov.mn

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

70 дугаар зүйл. Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

70.1.Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдэж, сайн дураараа хэргээ илчилж ирсэн этгээд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

71 дүгээр зүйл. Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

71.1. Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураараа эвлэрсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

Энэ хэсгийг 2004 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-нээс өмнөх хуулиар өөрчлөлт орсон

145 дугаар зүйл.Бусдын эд хөрөнгийг хулгайлах

145.1.Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан, урьд захиргааны шийтгэл хүлээсэн этгээд энэ төрлийн зөрчил давтан гаргасан бол /нэмэх/ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавдаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.1 дэх хэсэгт "урьд захиргааны шийтгэл хүлээсэн этгээд энэ төрлийн зөрчил давтан гаргасан бол" гэсэн заалтыг нэмж найруулах

208 дугаар зүйл. Усны тухай хууль тогтоомж зөрчих

208.1.Усны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас ан амьтан, шувуу, загас олноор үхсэн болон бусад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ялшийтгэнэ.

Олноор үхсэн гэснийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй, бусад их хэмжээний хохирол гэсэн нь тодорхойгүй байгаа учраас бага бус хэмжээний хохирол учирсан бол гэж өөрчлөх

210 дугаар зүйл. Байгалийн обьектыг санаатай устгах гэмтээх

210 дугаар зүйл. Соёлын өвийн тухай хууль тогтоомж зөрчих

210.1 Түүхсоёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтанд орсон байгалийн обьектыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол:

хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтанд орсон байгалийн обьектыг гэснийг

о **Хөнгөрүүлэх бүрэлдэхүүнд:**

Ороо нутгийн хамгаалалтанд авсан түүх соёлын ердийн болон үнэт зүйлийг гэж

о **Хүндрүүлэх бүрэлдэхүүнд:**

Улсын болон орон нутгийн хамгаалалтанд авсан хосгүй үнэт дурсгалт зүйлийг гэж

о санаатай эвдсэн, гэмтээсэн,

устгасан гэсэн дээр хууль бусаар хайгуул, малтлага хийсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, бусдад шилжүүлсэн зэргийг нэмэх.

Тайлбар:

о Түүх соёлын эд өлгийн зүйлийн хууль бус эргэлтийг өнөөгийн эрүүгийн хуулинд харшуцлага хүлээлгэхээр зохицуулан өгөөгүй учир энэ төрлийн хууль бус үйлдэл сүүлийн жилүүдэд ихээхэн өссөн ба илэрсэн үйлдэлд захиргааны л арга хэмжээ авах төдий байна

о Жил ирэх тутам хил гааль хураагдах түүх соёлын эд зүйлийн тоо ихэссэн.

о 2006-2010 оны хооронд Улсын хэмжээнд 300 гаруй түүх соёлын дурсгалт биологийн үлдэц, хиргэсүүр, бунхан ухан тоногдсон тоо баримт шалшалтаар илэрсэн ба хууль бус худалдан авалт, захиалгаар хиргэсүүр, бунхан ухуулах явдал нэмэгдсэн.

о Мөн гадаад гарсан үзмэр, үзүүлэн, сэргээн засварлагдах эд зүйл эргэн ирэхгүй зарим тохиолдол устан үгүй болсон.

о Нотлох баримтанд ЭХ СУРВАЛЖ тодорхой байхыг шаарддагын адил бидэнд өв соёл, түүхийн дурсгал маань байж гэмээн бид тусгаар улс байж чадна.

Барилга, Ашигт малтмалын тухай хуульд:

Барилга барих, уул, уурхайн хайгуул эхлэхээс өмнө нь тухайн байгууллага өөрийн зардлаар археологи, палеонтологийн судалгаа хийлгэх гэсэн заалтыг нэмэх:

Энэ судалгааг урьдчилан хийлгэсэнээр түүх, соёлын мэдэгдээгүй байсан өвийг урьдчилан хамгаалах арга хэмжээ авна.

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

Хуулийн төсөлд гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын тусгай нэгж хариуцахаар заасан бөгөөд тус нэгжийн зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны чиглэл, эрх, үүргийг төсөлд нарийвчлан тусгах шаардлагатай байна гэжээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны 244 дүгээр журмын дагуу Цагдаагийн төв байгууллагын дотоод аюулгүй байдал хариуцсан нэгж хариуцахаар заасан байна.

Гэрч, хохирогчийг мэдээлэл авах, мэдээллээр хангагдах эрхийг баталгаажуулахдаа: Хуулийн байгууллагуудаас авч хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээнүүдийн тухай, яллагдагчийг баривчилсан, сэжигтнийг саатуулсан тухай; түүнийг шүүхээс хэргийг хянан хэлэлцэхээс өмнө суллах тухай; яллагдагчийн тухай, түүний талаар гаргасан шийдвэрүүдийн тухай, ялтан ял шийтгэлээ эдэлж байгаа тухай, мөн хорих газраас суллагдсан тухай мэдээлэлтэй байх эрхүүдийг заавал тайлбарлаж өгдөг журам тогтоох.

Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах эрхийг баталгаажуулахдаа: гэрч, хохирогчид учруулсан чирэгдлийг багасгах шаардлагатай үед нуущлалыг хангах, дарамтлагч ба өс хонзон хайгчдаас хохирогч, түүний гэр бүлийн гишүүд болон холбогдох гэрч нарыг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах арга хэмжээг авах зарчмыг баримтлах.

Манай улсад хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар Цагдаагийн байгууллагын хуулийн хүрээнд "..хүнийэрх, эрх чөлөөг хүндэтгэх..", Гүйцэтгэх ажлын хуульд "..иргэний аюулгүй байдлыг хангах.." зарчмыг тунхагласан төдий, мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд "байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчоос гаргасан гомдол хүсэлтийг шийдвэрлэх" хүрээнд л хохирогчийн зүгээс өөрийн болон өөрт хамаатай бусдын аюулгүй байдлыг хамгаалуулах талаар хүсэлт гаргах ганцхан "эрх"-ээр хязгаарлагдаж байгааг эс тооцвол гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах болон тэдгээрийг хамгаалах механизмын талаар ямар ч заалт үгүй байна.

Иймд эрүүгийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа улам нарийн төвөгтэй болж байгаа өнөө үед эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид аюулгүй байдлыг хангах талаар гэрч, хохирогчийн эрх зүйн байдлыг нэмэгдүүлэх талаар заалт тусгах ялангуяа хүнд, онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах хууль тогтоомж үгүйлэгдэж байна.

Тухайлбал: Эрүүгийн байцаан шийтгэх хуульд дараах өөрчлөлт

оруулах шаардлагатай. Шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, бусад холбогдох албан тушаалтан нь:

-Хамгаалагдаж байгаа гэрч, хохирогчийн талаархи мэдээлэл өгөхийг хязгаарлах; **ЭБШХ-ийн 144 дүгээр зүйл. Байцаалт явуулах нийтлэг журам-ын 144.1.** Байцаалтын эхэнд байцаагдах этгээдийн биеийн байцаалтыг авна.**147.3** заалтуудад өөрчлөлт оруулж гэрч, хохирогчийн биеийн байцаалтын мэдээллийг эрүүгийн хэргийн материалаас авах, эдгээр мэдээллүүдийг үндсэн хэргээс тусгаарлан хадгалах, гэрч, хохирогчид нууц нэр хэрэглэж болно гэсэн заалт оруулах

-Хохирогч, гэрчийн хувийн болон ойр дотны хүмүүс, эд хөрөнгийн аюулгүй байдлыгхангах;

-Эрүүгийн процесст оролцож байгаа хохирогч, гэрчийн эсрэг хүч хэрэглэх буюу бусад гэмт халдлага үйлдэх, зохион байгуулах боломжийг таслан зогсоох зорилгоор сэжигтэн, яллагдагчийн хувьд цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ сонгон авах

-Аюулгүй байдлын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс үл хамааран эрүүгийн хэргийг мөрдөх байцаах байгууллага нь эрүүгийн процесст оролцож байгаа хохирогч, гэрч, яллагдагч, сэжигтэн болон бусад этгээдийн эсрэг эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл үйлдэхээр заналхийлж байгаатай холбоотой хангалттай үндэслэл байвал эрүүгийн хэрэг үүсгэдэг болох.

-Хорих газраас суллагдсан, тэнсэгдсэн, ял хойшилсон, хөнгөрсөн, өршөөж уучлагдсан зэргээр хорих газраас төр болон бүр чөлөөлөгдсөн этгээдүүдийн хувьд хамгаалуулж байгаа этгээдтэй уулзах, амьдрах, ажиллах, зорчихыг хязгаарлах.

-Хохирогч болон бусад гэрчийн нэр, хаягийг хэвлэл мэдээллээр болон нээлттэй шүүх хуралдааны үеэр бусдад дэлгэдэг практикийг зогсоох, шүүх хуралдааны тусгай танхимыг байгуулах, хохирогч-гэрчийг асуух үед хоолойнх нь өнгийг өөрчлөх систем болон шүүх хуралдааны бүхий л үйл ажиллагааг хянах, бэхжүүлэх аудио-видео техник байрлуулах ажлыг зохион байгуулах, гэрч нь шүүх хуралдаанд биечлэн оролцохгүйгээр аюулгүй өөр байрнаас радио, холбоо, видео-камерын тусламжтайгаар мэдүүлэг өгөх талаар хуульд тусгайлан заах шаардлагатай байна.

ЭБШХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1. Хохирогч нас барсан буюу насанд хүрээгүй, эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэл зоригоо илэрхийлж чадахгүй тохиолдолд түүний насанд хүрсэн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь энэ хуульд заасан журмын дагуу байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхтэй. Мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.4. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, эсхүл эрх зүйн чадамжгүй болсон бол энэ зүйлд заасан эрхийг

түүний гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнэдэлнэ. гэсэн нь хүн худалдаалах гэмт хэргийн гадаалад байгаа хохирогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн энэ эрхийг эдлэх боломжгүй байгааг өөрчлөх ЭБШХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.3.3. хохирогч, гэрч, шинжээчийг байцаахад байлцаж, тэдгээрт асуулт тавих; 41.3.4. өмгөөлж байгаа этгээдийнхээ болон өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байлцаж тухайн ажиллагаанд оролцож байгаа гэрч, шинжээч, бусад этгээдэд аль ч үед асуулт тавих; эрхийг хязгаарлах шаардлагатай байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨН БАЙЦААГЧДЫН УЛСЫН V ЗӨВЛӨГӨӨНӨӨС ГАРСАН САНАЛЫГ ҮНДЭСЛЭН МӨРДӨН БАЙЦААХ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЗӨВЛӨМЖ

1.Мөрдөн байцаагч, мөрдөн байцаалтын ажиллагааг шударга, шуурхай явуулж, хэргийг хуульд заасан анхны хугацаанд дуусгах, зайлшгүй шаардлагаар хугацаа сунгасан тохиолдолд албаны дарга биечлэн хяналт тавьж бичгээр даалгавар өгч биелэлтийг нь тооцох.

2.Мөрдөн байцаах ажиллагааг явуулахдаа хэт нэг талыг барьж туйлшрахгүйгээр оролцогчдыг олон дахин дуудаж чирэгдүүлэхээс зайлсхийж хохирогч, гэрчийг тухайн хэрэгт нь нэг л удаа байцаадаг чадварыг мөрдөн байцаагч бүр эзэмших, иргэдийг чирэгдүүлэх, хүнлэг бус харьцах, эрх чөлөө, эд хөрөнгөд нь хууль бусаар халдах, танил талаа харах, бусдын нөлөөнд автахгүйгээр ажиллах.

3.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл үйлдэгдсэн хэрэгт хийгдвэл зохих хойшлуулшгүй ажиллагааг бүрэн хийхгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэргийг түдгэлэүүлэх санал гаргахгүй байх.

4.Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод хайхрамжгүй хандах, гаргасан санал, хүсэлтийг нь үндэслэн холбогдох ажиллагааг хийхгүй орхигдуулах, хохирогчид учирсан хохирлын дүнг үндэслэлгүй гаргах, шинжээчийн дүгнэлтийг байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод танилцуулдаггүй дутагдлуудыг гаргахгүй ажиллах.

5.Эрүүгийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалж, өмгөөлүүлэх болон хууль зүйн туслалцаа авах эрхээр нь хангах хувь хүний болон албаны нууцыг чанд хадгалах.

6.Мөрдөн байцаах албаны шинэчлэл нь алба хаагчдын мэдлэг ур чадвараас шалтгаалах тул сургалтыг алба хаагчдын ур чадвар, харилцааг дээшлүүлэхэд чиглүүлж, тодорхой төрлийн хэргийг мөрдөхөд мэргэшүүлэх.

Энэхүү зөвлөмжийг албаны хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг нийт алба хаагч, удирдах бүрэлдэхүүнд даалгаж байна.

УМБГ-ЫН ЗӨВЛӨГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС, ДАРГЫН ЗӨВЛӨЛ
2011.09.19

ОХУ-ЫН ХОЛБООНЫ ШҮҮХИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН ОНЦЛОГ

Хууль зүйн доктор Б.В. Сангаджиев*

Захиргааны шинэтгэл хийх явцад хүчтэй, бие даасан шүүх эрх мэдэл нь эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд чухал баталгаа болдогоос гадна төрийн бусад салаа эрх мэдлийг хязгаарлан тэнцвэржүүлдэг, тэдгээрийн зүгээс иргэний болон хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, төр иргэний хооронд үүсэх эрх зүй маргаанд хувь хүмүүсийн эрх чөлөөг хамгаалах баталгаа болдог.

Түлхүүр үг: бие даасан шүүх эрх мэдэл, хүний эрхийг хамгаалах, гүйцэтгэх эрх мэдэлтэй үүсэх зөрчил, шүүгчийн хараат бус байдал.

Шүүх эрх мэдлийн шинэтгэл хийх шаардлага шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагууд өөрсдийн хүчээр хэв журам, хууль ёсыг хамгаалах чадваргүй болсон явдал юм. Үзэл баримтлалд тусгагдсанаар улс оронд гэмт хэргийн тоо өсч, хууль хамгаалах байгууллага тэр дундаа шүүхийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны үр нөлөө суларч доройтсон нь нотлогдсон байна.[1]

Үзэл баримтлалд онцгойлон анхаарал татсан асуудал бол шүүхэд итгэх итгэл юм. Үзэл баримтлал боловсруулагчдын нэг болох профессор И.Л.Петрухины[2] тэмдэглэснээр шүүх ихэвчлэн хэрэг маргаан хянан шийдвэрлэх хугацааг зөрчдөг, энэ зөрчил нь ялангуяа тойргийн болон мужийн шүүхэд түгээмэл байдаг байна. Шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэргийн дөрөвний нэгнээс илүү нь хуулиар тогтоосон хугацааг хэтрүүлэх, багагүй тохиолдолд шүүх хурал цагаасаа хоцорч эхлэх, шүүх хурал хойшлогдох зэрэг зөрчлүүд гардаг таалаар бичжээ. Түүнчлэн шүүгчдийн зүгээс шүүн таслах ажиллагаанд оролцогчтой зүй бус харьцах явдал хүртэл гардаг байна.

Харамсалтай нь өнөөдөр ч иргэдийн шүүхэд итгэх итгэл муу

---

* ОХУ-ын Улс түмний найрамдлын их сургуулийн Үндсэн хууль ба төрийн захиргааны эрх зүйн тэнхимийн доцент

[1] См.: *Лебедев В.* Судебная реформа: итоги и перспективы // Российская юстиция. 2000. № 11.

[2] См.: *Петрухин И.Л.* (2000) Проблемы судебной власти в современной России // Государство и право. № 8. С. 10.

хэвээрээ байна. "Олон нийтийн санал" сангаас 2007 оны 09-р сард оросын шүүхүүдийн үйл ажиллагаанд судалгаа хийсэн. Судалгааны дүнд оросын иргэдийн дийлэнх нь шүүхэд итгэдэггүй гэжээ. Эерэг санал өгсөн иргэдээс сөрөг санал өгсөн иргэд бараг 2 дахин их байна. (42% ба 23% харьцаатай) Санал асуулгад оролцогчдын дийлэнх буюу 71% нь оросын шүүгчид авлига авдаг. Харин зөвхөн 13% нь шүүгчид шударга, худалдагдаггүй гэж үзсэн байна. Манай иргэдийн тал орчим хувь нь шүүх үргэлж шударга бус шийдвэр гаргадаг гэдэгт итгэлтэй байсан бол таван хүн тутмын нэг нь ийм шийдвэр цөөн гардаг гэжээ.[3]

Шүүхэд иргэдийн үл итгэх байдал нь тэдний гаргаж буй гомдлын үндсэн шалтгаан болдог. Иргэдийн зүгээс Шүүгчийн Мэргэжлийн Дээд коллегид шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол (өргөдөл) 2000 онд 5 463; 2001 онд 5 850; 2002 онд 6 993; 2003 онд 7 870; 2004 онд 9 123; 2005 онд 9 876; 2006 онд 9 109; 2007 онд 8 341 гарсан байна. (2007 оны 09-р сарын 01-ний байдлаар).[4]

Европын хүний эрхийн шүүхэд ОХУ-ын иргэдийн гаргаж байгаа гомдлын тоо нэмэгдэж байгаа нь үндэсний шүүхийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байгааг харуулж байна. 2004 онд Европын хүний эрхийн шүүхийн дэргэдэх ОХУ-ын бүрэн эрхт төлөөлөгчөөс дээрх шүүхэд хаягласан 49 иргэний гомдлын хуулбарыг дүгнэлт гаргуулахаар Оросын Ерөнхий Прокурорын газарт шилжүүлсэн байна.

Эдгээр гомдлын ихэнх нь ОХУ-ын шүүхийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл дундуур байгаа, давж заалдах гомдол гаргахад учирч буй хүндрэл, хугацаа зөрчдөг, хүнд суртал, чирэгдэл болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажил хангалтгүй байгаа талаар байжээ.

Түүнчлэн ОХУ-ын прокурор, цагдаагийн байгууллагад иргэдийн итгэх итгэл нь харьцангуй доогуур байна. Бидний үзэж байгаагаар энэ мэт шүүхийн шинэчлэлд саад хотгор болж буй шалтгаан Оросын шүүхийн шинэчлэлийн үзэл баримтлалд тусгагдсан. Үзэл баримтлал паг үеэ олсон, өндөр ач холбогдолтой хэдий ч зарим санал, дүгнэлт нь үнэхээр үндэслэлтэй эсэхэд онцгой анхаарах нь зүйтэй. Үзэл баримтлалыг боловсруулагчдын үзэж буйгаар "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилго нь гэмт хэрэгтэй тэмцэх бус харин эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх замаар нийгмийг гэмт явдлаас болон байцаан шийтгэх ажиллагаанд оролцож буй иргэдийн эрх, хууль ёсны сонирхолыг хамгаалах юм".

"Гэмт хэрэгтэй тэмцэх" гэсэн нэр томъёо ОХУ-ын Үндсэн хуулийн 114-р зүйлд: "ОХУ-ын Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ", ОХУ-ын Прокурорын байгууллагын тухай

[3] Результаты Фонда общественного мнения, опубликованные на сайте www.fom.ru/009/11.
[4] См. Данные сайта Московского городского суда www.mos-gorsud.ru.

Холбооны хуулийн 2-р зүйлд: "Оросын Прокурорын байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулна" гэж зааснаас гадна олон улсын эрх зүйн баримт бичигт тусгагдсан.

Үзэл баримтлал боловсруулагчид хууль сахиулах үйл ажиллагаанд шүүхийг дээдлэх, шүүгчийн хараат бус байдлыг хангах, ахуйн хангамжийг нэмэгдүүлэх саналыг дэвшүүлсэн боловч шүүгчийн хууль, хэв журам хамгаалах үүргийг хязгаарлаж гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой зарчмыг үндэслэлгүйгээр үгүйсгэж байна. Тэдний үзэж байгаагаар шүүх залхаан цээрлүүлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад бүх чиг үүргээс чөлөөлөгдөх ёстой гэжээ.

Энэхүү саналыг хүлээж авах боломжгүй юм. Учир нь энэ нь олон улсын хууль зүйн баримт бичиг, ОХУ-ын Үндсэн хуулийн заалттай нийцэхгүй байна. ОХУ-ын Үндсэн хуулийн 2-р зүйлд: "Иргэний болон хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, хангах, хамгаалах нь төрийн үүрэг" гэж заасан байдаг. Харин ОХУ-ын шүүхүүд Үндсэн хуулийн 10,11-р зүйлд зааснаар "Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй төрийн эрх мэдлийн нэг салаа мөчир". Мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 11-р зүйл, ОХУ-ын Үндсэн хуулийн 49-р зүйлд: Гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийн гэм буруг хуулийн дагуу хүчин төгөлдөр шийдвэрээр гагцхүү шүүх тогтооно гэж заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу гагцхүү шүүх үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулдаг, өөрөөр хэлбэл гэмт этгээдийг шийтгэдэг.

Үнэн хэрэгтээ шүүхүүд ОХУ-ын Ерөнхийлөгч, Холбооны хурал болон ОХУ-ын Засгийн газрын хамт төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг тул дэг журам бэхжүүлэх талаар төр, нийгмийн зүгээс шийдвэрлээгүй асуудлын төлөө хариуцлагаас чөлөөлөгдөх боломжгүй. Үзэл баримтлалын агуулгаас харвал шүүх эрүүтийн ял ногдуулж, гэмт этгээдийг үйлдсэн хэргийх нь төлөө цээрлүүлдэггүй, бусад хууль сахиулах байгууллагуудтай хамтран хууль ёсны манааанд гарч гэмт хэргийн нөхцөл байдлын төлөө хариуцлага хүлээхгүй тохиолдолд юу болох байсан талаар хариулт өгөөгүй байна.

Эдийн засаг, улс төр, захиргааны шинэчлэлийг нэгэн зэрэг явуулах хүндрэлтэй нөхцөлд улс орныхоо хувь заяаны төлөө шүүхүүд онцгой хариуцлага хүлээх нь тодорхой юм. Шүүхийн үр бүтээлтэй ажлын үр дүнгээс

Оросын нийгмийн үндсэн хуульт ёс, түүний тогтвортой байдал хамаарна. Өнөөдөр даярчлалтай хамт ирж буй боломж, заналхийлэлтээ зэрэгцэн маш олон хууль тогтоомж, зарчмыг дахин эргэн харж үнэлгээ өгөх шаардлага тулгараад байна. Тиймд шүүхүүд иргэн, нийгэм-эдийн засаг, улс төрийн эрхийн хамгаалалтыг сайжруулж нийгэмд

хуулийн хүрээнд хөгжих боломжийг бий болгох хэрэгтэй. Шүүхийн төлөв байдлыг тухайн асуудлыг шийдвэрлэж буй түүний чадвараас хамаарч үнэлэх шаардлагатай.[5]

Үзэл баримтлал боловсруулагчдын үзэж байгаагаар шүүгч нар өөрсдийн гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх зарчим нь идэвхгүй байна. (санаатай болон болгоомжгүйгээс бусад тохиолдолыг эс тооцвол).

Гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй байх зарчмыг Үзэл баримтлал боловсруулагч нар хамгийн хэцүү бөгөөд чухал асуудал болох гэм буруутай эсэхийг шийдвэрлэдэг тангарагтны шүүхтэй холбон танилцуулж байна. "Тангарагтнууд гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээдэггүй, түүнийгээ тайлбарлах үүрэггүй, үндэслэлгүйгээр цагаатгах эрхтэй" гэж Үзэл баримтлалд тэмдэглэжээ. Иймд байдлаар Үзэл баримтлал боловсруулагч нар шүүх эрх мэдлийн хараат бус байх зарчмыг шүүгчийн хувийн хараат бус, хариуцлага үл хүлээх зарчим болгон хувиргаж албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэх, хайхрамжгүй байдлыг бий болох боломжийг нээж өгч байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор шүүхийн үйл ажиллагаан дахь бүхий л зөрчлийг анхааралдаа авах нь чухал. Түүнчлэн шударга ёсыг тогтоох ажилд шүүх манлайлж буй цагт зөрчил гарах ёсгүй.[6]

Үзэл баримтлал боловсруулагчид гадаад орнуудын хэргийн 3-7 хувь нь тангарагтны шүүхээр шийдвэрлэгддэг туршлагыг дурдсан хэрнээ ОХУ-ад гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлдэг өөрөөр хэлбэл нэг жилээс дээш хорих ялаар шийтгүүлэх гэмт этгээдийн хэргийг тангарагтны шүүхээр шийдвэрлүүлэх саналыг дэвшүүлээд байна. Чухам яагаад гэдэгт ямар нэгэн үндэслэл тайлбар гаргаагүй юм.

ОХУ-д тангарагтны шүүх байгуулах асуудлыг шийдвэрлэхдээ Үзэл баримтлал боловсруулагчид Хаант засагт орос улс болон бусад улсын тангарагтны шүүхийн туршлагыг судлаж, түүний мөн чанар, давуу тал болон сул тал, шударга бус шийдвэр гаргахгүй байх баталгаа зэргийг нарийн гаргаж үзэх ёстой байсан юм шиг санагдана.[7]

Орос улсад тангарагтны шүүх 1964 оны шүүхийн шинэчлэлийн үр дүнд байгуулагдсан бөгөөд бий болсон цагаас нь эхлэн тэдний гаргасан цагаатгах тогтоол тоогоо алдсан талаар тэмдэглэж байсан. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гол шалтгааныг тангарагтнуудын боловсролын түвшин доогуур, тангарагтнуудыг сонгохдоо хариуцлагагүй ханддаг,

---

[5] См. *Жуйков В.М.* (2006) Судебная реформа: проблемы доступа к правосудию. М.: Статут. С. 12.

[6] См. *Шатовкина Р.В.* (2002) Организация и деятельность мировых судей в Российской Федерации. Дисс. ... канд. юрид. наук. М.: С. 8.

[7] См. *Ржевский В.А.* (1997) Судебная власть в Российской Федерации: конституционные основы организации и деятельности / В.А. Ржевский, Н.М. Чепурнова. М., С. 182.

олон нийт хуулийн нэр томьёо, хэм хэмжээг ойлгох ухамсаргүй, тангарагтнууд олон нийтийн санал, үзэл бодолд нийцүүлэх хандлага гаргадаг гэж бичдэг байжээ. Үүний хор уршиг нь дараах жишээ дээр харагдаж байна. 1873 онд Санкт-Петербург тойргийн шүүх тангарагтны төлөөлөгчийн оролцоотойгоор хотын дарга Ф.Треповыг алахаар завдсан Вера Засуличид холбогдох хэрэг нотлох баримтаар хөдөлбөргүй нотлогдсоор байхад түүнийг цагаатгасан байна. Гэмт этгээд гэм буруутайгаа өөрөө үгүйсгээгүй байхад шүү.

Тангарагтны шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэргийн тоо ямар ч үед буурсаар ирсэн. Октябрийн хувьсгалын дараа тангарагтны шүүхийг Орос улсад татан буулгасан бөгөөд 1993 онд дахин сэргээсэн юм.

Тангарагтны шүүхээр хэрэг шийдвэрлэж байгаа тохиолдолд яллагдагчийн гэм буруу, түүний үйлдлийг зүйлчлэх ажлыг мэргэжилтэн буюу мэргэжлийн шүүгч хийх ёстой. Харин ногдуулах ял шийтгэлийн хэмжээг тангарагтнууд өгвөл зохимжтой. Учир нь шүүгчийг бодвол хэрэг бүр тэдний хувьд шинэ байх бөгөөд ялын хэлбэр, хэмжээг тогтоохдоо олон талаас нь харж гэмт хэргийн сэдэлт, гэмт этгээдийн хувийн байдлыг харгалцан үзнэ. Хөнгөрүүлэх болон бусад нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хуульд заасан хэмжээнээс доогуур ял ногдуулах, тэнсэн харгалзах буюу ял эдлүүлэхийг хойшлуулах, бүр ялаас чөлөөлөх өөрөөр хэлбэл гэм буруутайг нь мэдсээр байж өрөвдсөн, гэмшиж буй этгээдийг хамгаалах сэтгэл зүрхэл өөр ямар нэгэн шалтгааны улмаас хэн нэгнийг гэм буруугүйд тооцох боломжтой юм.

Үзэл баримтлал боловсруулагчид өөрсдийн дүгнэлтээ бататгах үүднээс хуулийн заалтуудаас ишлэл авсан хэдий ч тэдгээрийн агуулгыг гажуудуулсан. Жишээ нь: Үзэл баримтлалд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт хэргийг түргэн, бүрэн дүүрэн илрүүлэх, гэм буруутай этгээдийг илчлэх, шүүх харин гэмт этгээдийг илчлэх, байцаан шийтгэх тогтолцоог хөдөлгөөнд оруулснаараа хөндлөнгийн чанараа алдаж прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагуудтай "нэг дугуйны хоёр" болно гэжээ.[4]

Гэтэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилго нь гэмт хэргийг түргэн шуурхай, бүрэн дүүрэн илрүүлэх, гэмт хэрэгтнийг илчлэхээс гадна хуулийг зөв хэрэглэх нөхцөлөөр хангаж, гэмт хэрэг үйлдсэн хэнийг ч эрүүгийн хариуцлагад татах, гэм буруугүй хэнийг ч эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөд оршино.

Үзэл баримтлал боловсруулагчид өөрсдийн дүгнэлтийг бататгах үүднээс өөр зохиогчдын хэлснээс ишлэл авч байгаа хэдий ч тэдгээр нь зөвхөн Үзэл баримтлалд тусгасан үндэслэлийг дэмжсэн өгүүлбэр,

[4] См.: Судоустройство и правоохранительные органы в Российской Федерации / Под ред. В.И. Швецова. М., 1997. С. 96.

зохиогч нар байна. Тэдгээртэй эсрэг байр суурьтай хүмүүсийн санал, дүгнэлтийн талаар тэд дуугүй байна.

Үзэл баримтлал боловсруулагчид прокурорын газрын хяналтын чиг үүргийг зайлшгүй багасгах саналаа хууль зөрчсөн захиргааны болон хэм хэмжээ тогтоосон актуудын мянганы хэсэгт ч хяналт тавих боломжгүй гэдгээр үндэслэжээ. Яагаад иймд дүгнэлтэнд хүрсэн, хэн* иймд судалгаа хийсэн нь тодорхойгүй юм. Зөвхөн 2006 онд гэхэд прокурорын газрууд 1 689 781 хуулийн зөрчлийг илрүүлсэн. Үүнээс хууль бус эрх зүйн актууд 195 152, эдгээрийн 4 зөрчил тутмын нэг нь иргэдийн эрх, эрх чөлөөг хангах асуудлын хүрээнд үйлдэгдсэн бөгөөд 179 030 нь эсэргүүцэл бичигдсэнээс гадна прокурорын шалгалтын үндсэн дээр 295 977 шаардлага хүргүүлж, 357 293 хэрэгт пргэний эрх болон төрийн ашиг сонирхолыг хамгаалахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Прокурорууудын мэдээлснээр ёс зүйн хариуцлага 83 028, захиргааны хариуцлагын арга хэмжээг 107 535 хүнд тус тус авч 11 703 хүнд эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Эдгээр баримтууд Үзэл баримтлал боловсруулагчдын прокурорын хяналтыг хязгаарлах тухай санал, дүгнэлтүүд бодит үндэнд нийцэхгүй байгааг нотолж байна.

Хэрвээ прокурорын байгууллагын ерөнхий хяналтын чиг үүргийг үгүй болгох юм бол хяналтын өөр байгууллага шинээр байгуулах хүртэл ОХУ-д хуулийн біелэлт үндсэндээ хяналтгүй болно." Шинээр байгууллага байгуулахад их хэмжээний зардал гарахаас гадна цаг хугацаа шаардах тул төрийг бэхжүүлэх, улс оронд хууль сахиулах ажилд сөргөөр нөлөөлнө.

Үзэл баримтлал зохиогчид прокуроруудын гүйцэтгэж байгаа үүрэг буюу пргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх ба эрх чөлөөг мөрдөн байцаалтын үед хязгаарладаг таслах сэргийлэх арга хэмжээг шүүхээр гүйцэтгүүлэхээр санал болгосон нь гайхал төрүүлж байна. Үзэл баримтлалд прокурорыг яллах хандлагатай гэж шүүмжилсэн хэрнээ иймэрхүү үзэл бодлын өөрчлөлтийг ойлгоход бэрх юм. Хэрвээ шүүх баривчлах, цагдан хорих, хамгаалалтанд авах шийдвэр гаргаад эхлэх

* См., например: *Бойков А.Д.* Третья власть в России. 2-е изд. Курск, 1999; Проблемы реформы уголовно-процессуального законодательства в проектах УПК РФ (материалы научно-практической конференции 15–16 декабря 1994 года). М., 1995. Выступления Ромазина С.Б., Бойкова А.Д., Пашина С.А., Шейфера С.А., Кашепова В.П., Томина В.Т., Михайлова А.И., Темушкина О.П., Коблякова А.С., Гуляева А.П. и многих других; *Кокорев Л.Д.* Судебная реформа: идеи и реальность // Проблемы судебной реформы (юридические записки). Вып. 1. Воронеж: ВГУ, 1994. *Ефимичев С.П.* Реформирование уголовно-процессуального законодательства // Актуальные проблемы досудебного производства по уголовным делам. М.: Изд-во Академии управления МВД РФ, 1999. С. 3–14; *Ефимичев С.П.* Уголовно-процессуальное законодательство и проблемы борьбы с организованной преступностью // Коррупция в России: состояние и проблемы. М., 1996; *Сухарев А.Я.* Правосудие и преступность // Прокуратура и правосудие в условиях судебно-правовой реформы. М., 1997. С. 22, 33; *Сухарев А.Я.* Криминализация общества. Пути противодействия // Научная информация по вопросам борьбы с преступностью. М., 1995. № 155.

юм бол өөрийн эрхгүй яллах хандлагатай болно.

ОХУ-ын шүүхийн шинэчлэлийн Үзэл баримтлалд тусгагдсан болон бусад дутагдлууд энэхүү баримт бичгийн дүгнэлт ба саналуудын үндэслэлгүйг харуулж байна.

Харамсалтай нь ЗСБНХОУ-ын Дээд зөвлөл 1991 оны 10 сарын 24-ний өдрийн тогтоолоор энэхүү хэсэг хуульчдын үзэл бодол, саналыг агуулсан Үзэл баримтлалыг хуулийн хэмжээнд баталсан.

Дээд зөвлөл энэ Үзэл баримтлалын зарим хэсгүүдийг Үндсэн хуулийн хэмжээнд хүлээн зөвшөөрч шүүхийн шинэчлэлтэй холбоотой шинэ хууль боловсруулахад хэрэглэж байхаар зөвлөсөн бөгөөд зарим хууль тогтоомжид тэр дундаа 1993 оны 12-р сарын 12-ны өдөр батлагдсан ОХУ-ын Үндсэн хуульд энэ үзэл баримтлалын зарим агуулга нөлөөлсөн. Өнөөдөр зарим яруу шинэчлэгчид нэгэнт хуулиар батлагдсан энэ үзэл баримтлалын заалтуудыг яаралтай хэрэгжүүлэхийг уриалж байна. Хэрвээ энэ үзэл баримтлалын зарим заалтууд алдаатай батлагдсан бол ийм алдаануудыг олшруулах шаардлага байна уу гэж асуумаар байна. Харамсалтай нь, бидний үзэж буйгаар Үзэл баримтлалын үндэслэлгүй заалтууд нь голдуу хэрэгждэг. Жишээ нь ЗСБНХОУ-д 2002 оны 7-р сарын 1-ний өдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байсан эрүүгийн байцаан шийтгэх хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хууль ёс, дэг журам бэхжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэнэ, (ЗСБНХОУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 2-р зүйл), хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх гэмт хэргийн учир шалтгаан, нөхцлийг илрүүлж, гэмт хэргийг арилгах арга хэмжээ авах үүрэгтэй гэж тус тус заасан байжээ. (ЗСБНХОУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 21, 212-р зүйл.)

Одоогийн мөрдөгдөж буй ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүхийн урьдчилан сэргийлэх үүргийг хязгаарлаж, харин гэмт хэрэгтэй тэмцэх талаар огт дурьдаагүй байна.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2000 оны 1-р сарын 10-ны өдрийн зарлигаар ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд орсон өөрчлөлт нь гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хүрээнд нийгмийн урьдчилан сэргийлэх болон хуулиа дээдэлдэг иргэдийг төлөвшүүлэх үр дүнтэй тогтолцоог бүрэлдүүлэхэд өндөр ач холбогдол өгчээ. Харин гэмт этгээдтэй тэмцэх ажлын хүрээнд тэргүүн байранд "гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй нөхцөл шалтгааныг илрүүлэх, арилгах, урьдчилан сэргийлэх" зэргийг оруулсан байна. 2000 онд Вена хотод болсон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэнтэй харьцах нөхцлийн тухай НҮБ-ийн 10-р чуулганы баримт бичгүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго нь үндэсний болон дэлхий хэмжээнд хамгийн түрүүнд тавигдах ёстойг онцолжээ. Харамсалтай

нь энэ тогтоол шүүхийн шинэчлэлийг зохиогчид болон гүйцэтгэгч нарын анхааралд өртөөгүй, хэрэгжихгүй хэвээр байна.

Шүүгч нарын халдашгүй дархан байдал болон эрх мэдлийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан шүүн таслах ажилд тавих гадны хяналтыг гуйвуулж байгаад санаа зовниж байна. Энэ нь ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас шүүхийн хяналтыг хассан явдал юм. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьдаг прокурорын хяналтыг мөн л Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиас хассан байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын тавих хяналтыг хуулиар хязгаарлах нь хуулийн биелэлтийг хангах ажлыг удаашруулж гэмт хэрэг болон бусад хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс авдаг таслан сэргийлэх арга хэмжээг бууруулаар ашиглах боломжийг олгон хууль ёсыг бэхжүүлэхэд саад болсоноор иргэдийг хүний эрхийн Европын шүүхэд гомдол гаргахад хүргэдэг.[10]

Дээрхийг үндэслэн шүүхийн хяналтын механизмыг хангах боломжтой шүүх эрх мэдэл дотор бие даасан бүтэц бий болгох шаардлага гарч байна. Давж заалдах шатны шүүхэд шүүх-хяналтын коллеги-мөрдөн байцаалтын шүүгч, тогтоол гүйцэтгэх коллеги-шүүхийн шийдвэр биелүүлэх шүүгч. Харин эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дээд шатны шүүхүүд шүүхийн хяналтыг уламжлалт шат, дамжлагыг дуусгаагүй байсан ч хэрэгжүүлэх боломжтой юм. Энэ бүхэн эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх явцад иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах шүүхийн ажлыг төгөлдөржүүлэхэд чиглэх болно.

Шүүхийн шинэчлэлийн үзэл баримтлалыг хуулийн хүчин төгөлдөр болгосон ОХУ-ын 1991 оны 10-р сарын 24-ний өдөр Дээд зөвлөлийн тогтоол өөрөө үндэслэлийн хувьд ч тэр, үндсэн хуульт ёсны хувьд ч тэр ноцтой эргэлзээ төрүүлж байна.

Нэгдүгээрт, Үзэл баримтлалын төслийг боловсруулахад Прокурорын ерөнхий газар, Дотоод явдлын яам, Холбооны Аюулгүй байдлын алба болон бусад зохих байгууллагуудын онол, практикийн төлөөлөгчид оролцуулаагүй. Үзэл баримтлалд дурьдсан арга хэмжээнүүдийн хэрэгжүүлэхэд шаардагдах материал болон санхүүгийн тооцоог гаргаагүй. Энэ асуудлаар ОХУ-ын Засгийн газрын шийдвэр гараагүй. 1991 оны 10-р сарын 21-ний өдөр 100 нүүр хуудас бүхий энэ баримт бичгийг ЗСБНХОУ-ын Ерөнхийлөгч Дээд зөвлөлд хүргүүлж мөн оны 10-р сарын 24-ний өдөр Дээд зөвлөл баталсан юм. Хэдхэн хоногийн дотор энэхүү баримт бичиг нь ЗСБНХОУ-ын Дээд зөвлөлийн бүх

[10] См.: *Бандуровский Р.В.* Особенности правового статуса Федерального арбитражного суда округа (на примере Федерального арбитражного суда Московского округа). Дисс. ...

хороо, комиссуудаар зохих журмын дагуу дорвитой судлагдаагүй, маш богино хугацаанд батлагдсан.

Хоёрдугаарт, Дээд зөвлөл нь энэхүү "ЗСБНХОУ-ын Шүүхийн шинэчлэлийн үзэл баримтлал"-ын заалтуудад үндсэн хуулийн хүчин чадал өгсөнөөрөө өөрийн эрх мэдлээ хэтрүүлсэн.

Гуравдугаарт, Дээд зөвлөл тогтоолоороо тэр үеийн Орос улсын Үндсэн хуульд харшилсан Үзэл баримтлалын зарим заалтыг хүлээн зөвшөөрсөн. Үндсэн хуулийн журмын дагуу үүнийг зөвхөн ОХУ-ын Ардын депутатуудын их хурал л ОХУ-ын Үндсэн хуульд зохих өөрчлөлт оруулах замаар хийх боломжтой юм. Энд "хуулийн биелэлтэнд хяналт тавих" гэсэн Үндсэн хуулийн ойлголтын агуулгыг өөрчлөх, прокурорын хяналттай холбоотой "дээд" гэсэн Үндсэн хуулийн нэр томъёоноос татгалзах, тангарагтны төлөөлөгч, эвлэрлийн шүүх байгуулах, шүүгчийг бүх насаар нь сонгох, шүүгчдийг огцруулах тогтолцоог халах тухай асуудал яригдаж байгаа гэдгийг санах хэрэгтэй.

ОХУ-ын шүүхийн шинэчлэлийн Үзэл баримтлалыг шүүмжлэлтэй судалж үзсэний үндсэн дээр дараах зүйлүүдийг тэмдэглэж байна. Орос улсын шүүхийн шинэчлэл илүү их идэвхи, зориллттой хэрэгжих ёстой. Шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажил иргэдийн эрх, эрх чөлөө, төр, нийгмийн хууль ёсны сонирхолыг хамгаалах, хуульт ёсны сонирхолыг хамгаалах үүрэг бүхий прокурор, цагдаа болон бусад хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох ажилтай зэрэг хийгдэх ёстой.

"Шинэчлэгдийн" дэвшүүлсэн прокурорын хяналтыг хязгаарлах, гэмт хэрэгтэй тэмцэхээс татгалзах зэрэг ойлгомжгүй санал дүгнэлт нь бодит амьдралаас тасарсан үзэл баримтлал болох нь өнөөдрийн манай улсын нөхцөл байдлаар нотлогдож байна. Харин эсрэгээрээ прокурорын хууль хамгаалах чиг үүргийг өргөжүүлэх, Үндсэн хууль болон бусад ОХУ-ын нутаг дэвсгэр дээр хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаа, гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий хуулийн байгууллагуудын чиг үүргийг идэвхжүүлэх шаардлагатай.

Ардчиллын үйл явцыг гүнзгийрүүлэх, шүүх эрх мэдлийн хөгжил ба шинэчлэл, төр ба иргэний нийгмийн зүгээс тавих хяналт зэрэг нь цаашид прокурорын байгууллагыг шинэчлэх, чиг үүргийг өөрчлөхийг шаардаж байна. Гэсэн хэдий ч улс оронд урт хугацааны тогтвортой байдал бий болж, өдөр тутмын эдийн засгийн амьдралд хуулиар баталгаажсан орчин үеийн зах зээлийн механизм нэвтэрч, одоогийн прокурорын байгууллагын чиг үүргийг биелүүлж чадах байгууллага ба алба гарч ирсэн тохиолдолд прокурорын хяналтыг хязгаарлаж болох юм.

Захиргааны шинэчлэлийн хөгжил, үйл явцад дүн шинжилгээ хийхэд гүйцэтгэх засаглалын зохион байгуулалт бат бэх болж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь хууль ёс болон дэг журам төдийгүй эдийн засаг, нийгмийн амьдралын салбарт эерэг өөрчлөлтийг авчирна.

Холбооны түвшинд гүйцэтгэх эрх мэдэл шинээр 3 шатны үйл ажиллагааг явуулах болсныг тэмдэглэх хэрэгтэй. Яам төрийн захиргааны бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, хууль боловсруулах зэрэг ажил гүйцэтгэдэг; Холбооны албад хяналтын чиг үүргийг гүйцэтгэж, харин холбооны агентлагууд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Улс төр, захиргааны тогтолцоонд гүйцэтгэх эрх мэдлийн хууль сахиулах байгууллагуудын дунд ихээхэн хэмжээний өөрчлөлт хийгдсэн. Үүнд: Холбооны алба (шүүхийн шийдвэр биелүүлэх алба, бүртгэлийн алба, цагаачлалын алба г.м.) шинээр байгуулагдаж, бусад хуучин албад шинэчлэгдэж байна. ОХУ-ын гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний Төрийн албадын шинэчлэл эхлэжээ байна.

Холбооны хүрлэн Төрийн думад "Холбооны захиргааны шүүхийн тухай" хуулийн төсөл хэлэлцэгдэж байна. Тус хууль батлагдахаар тохиолдолд захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндэс бий болох юм.

Иргэдийг гадна, дотны аюулаас хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, эрх бүхий этгээдүүдийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулсан нь хувь хүний аюулгүй байдлыг хангасан захиргааны эрх зүйн зохистой тогтолцоог бий болгоход эерэг алхамууд болжээ.[11] Захиргааны удирдлагын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлж байна.

Эцэст нь шүүхийн болон захиргааны шинэчлэл хууль тогтоомж, онол ба практикт тулгуурлан үндсэндээ өөрийн биелэлээ олж байгаа хэдий ч цаашид улам боловсронгүй болгох, хууль тогтоомж гаргах, хангалттай материал-техникийн баазыг бий болгох шаардлагатай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Харин шүүхийн шинэчлэлийн Үзэл баримтлалд илүү шүүмжлэлтэй хандах хэрэгтэй.

---

[11] См.: *Праскова С.В.* (2004) Теоретические основы гласности правосудия. Дисс. ... канд. юрид. наук. М., С.28.

ТАТВАР ТӨЛӨХӨӨС САНААТАЙ ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ОНОЛЫН АСУУДАЛ

ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, докторант Г.Оюунболд

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын иргэн шударга хүнлэг ёсыг эрхэмлэн хуулиар нөгдуулсан албан татвар төлөх үүргийг ёсчлон биелүүлнэ" гэж татвар төлөх үүргийг хуульчлан баталгаажуулжээ.

Монгол Улсад "татвар төлөхөөс зайлсхийх" зөрчил, гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхдээ:

1. Татварын Ерөнхий хуулийн 74.1-д Татварын тухай хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүйгээр татвар нөгдөх орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;

2. Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд татвар ногдох их хэмжээний орлого төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн бол эд хөрөнгө хураах эсвэл хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсвэл хоёроос зургаан сар баривчлах ял шийтгэхээр заажээ.

Судлаачид, практик ажилтнуудаас гарч байгаа саналаар бол татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг илүү тодорхой болгох, татварын хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх явдал[1] гэж үзэж байна. Цаашид татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн бүрэлдхүүнийг өөрчлөн найруулж татварын тухай хууль тогтоомжтой цогц байдлаар уялдуулан нийцүүлэх ажлыг нэн даруй эхлүүлэх шаардлагатай хэмээн яаран дүгнэхийн өмнө энэ гэмт хэргийг тодорхойлж байгаа эрх зүйн онолын асуудалд анхаарал хандуулахыг хүсье.

Нэг. Онолын асуудал

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн онолын ойлголтыг авч

[1] Оюунбаатар Ц. (2010) "Хуулийн этгээдийн татварын зөрчил, хүлээлгэх... " эрдэм шинжилгээний өгүүлэл. *Хуулийн этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага: харьцуулсан эрх зүйн асуудал* илтгэлийн эмхтгэл Уб: 16.

үзэхийн өмнө дараах хоёр ойлголтыг зөв ялган авч үзэх хэрэгтэй юм.

- **Tax avoidance** The lawful arrangement or planning one's affairs so as to reduce liability to tax. *Compare* tax evasian. - Хуулийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас татварыг багасгаж байгаа ойлголтыг хэлдэг;
- **Tax evasion** Any illegal action taken to avoid the lawful assesment of taxes; for example, by concealing or failing to declare income.[2] Татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн үйлдэл үгний улмаас улсад (татварын байгууллагад) хохирол учирсан, төлөгдөх ёстой татвар төлөгдөөгүй тохиолдол.

Гадаад орнуудад татварыг хууль бусаар багасгах үйлдэлд хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээг янз бүрээр тогтоосон байдаг. Судлаач нь асуудлыг гаргаж ирэхэд ойлгомжтойг бодож эрх зүйн тогтолцоогоор нь:

а) Англи, Саксоны эрх зүйн системтэй орнууд (Их британи, АНУ, Австрали г.м);

б) Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнууд (Итали, Испани, Франц, Герман) гэсэн 2 тогтолцоогоор авч үзлээ.

Нэг. Англи, Саксоны эрх зүйн тогтолцоотой орнууд дахь татварын хууран мэхлэх болон татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг

Тухайн орнуудын нийтлэг эрх зүйн олон зуун жилийн уламжлал[3] нь татварын эрх зүйд тусгалаа олсон байдаг. Тухайлбал:

1. Татварын зөрчилд хариуцлага хүлээлгэх онцлог хэм хэмжээг санхүүгийн (татварын) эрх зүйн хүрээнд зохицуулдаг;

2. Эрүүгийн хууль, Захиргааны зөрчлийн тухай хууль гэх мэт хэлбэрээр төрөлжсөн хууль гаргадаггүй, хуульдаа ялган зааглаагүй, үүнтэй уялдаж татварын талаар эрүүгийн болон захиргааны хариуцлагын төрлийг хэрхэн ялган салгах тухай асуудлыг авч үзвэл:

- Гадны судлаачид эрх зүйн зөрчилд ямар хариуцлага ногдуулахаар заасныг харгалзан зааглаж болно гэж үзжээ. Тухайлбал, Татварын тухай хуульд зөрчил гаргагчид торгох арга хэмжээ нь эрүүгийн хуульд заасан торгох болон баривчлах шийтгэлийн доод хэмжээнээс багаар шийтгэж болохоор байвал татварын зөрчил гэж үзэж болохоор байдаг.
- Түүнчлэн ямар байгууллагаас шийтгэл ногдуулж буйг харгалзан дээрх асуудлыг шийдвэрлэж болно гэж үздэг. (захиргааны эрх зүйн хариуцлага болох үйл ажиллагааг нь зогсоох, торгох, харин эрүүгийн хариуцлагын торгох, баривчлах ялыг зөвхөн шүүхээс хэрэглэнэ.)

[2] Oxford dictionary of law, 2001 E.A.M. 491p

[3] Энэ гэмт хэргийн бүрэлдхүүнийг анх 1780-аад оны үед АНУ-д тодорхойлсон гэж үздэг.

Их Британи Улс[4] нь ноцтойгоор хууран мэхлэх явдалтай тэмцэх хэлтсийн эрх хэмжээнд татварын дараах хэргийг хамааруулсан байна.

1. Хохирлын хэмжээ нь нэг сая фунтээс давсан бол;
2. Татварын хэрэг нь олон улсын шинжтэй эсвэл олон нийтийг хамарсан бол;
3. Тухайн хэргийг мөрдөн шалгахад тусгай мэдлэг (санхүүгийн зээлийн үйл ажиллагааны талаар) шаардлагатай бол.

Бусад онцлог:

- Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулдаг;
- Гэмт халдлагын обьектыг төрөлд хуваажаж ангилдаггүй, халдлагын обьектыг хамгийн өргөн утгаар ойлгодог.

Үйлчилж буй хуулиуд:

1. Мөнгөн төлбөрийн тухай (1935);
2. Татварын удирлагын тухай (1970);
3. Магистратын шүүхийн тухай (1980);
4. Санхүүгийн тухай (1956);
5. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тухай (1986,1987).

Эдгээр хуульд татвар төлөлтийн хүрээн дэх эрх зүйн зөрчилд ногдуулах хариуцлагын хэм хэмжээг тогтоожээ. Эдгээрийг хэд хэдэн хэсгээс авч үзэх бөгөөд:

а) Санаатай үйлдэл (эс үйлдэхгүй), татварын байгууллагыг төөрөгдөхөд хүргэсэн болгоомжгүй үйлдэл;

б) Татварын хөнгөлөлт эдлэхийн тулд худал тайлан, мэдээ гаргаж залилан мэхэлсэн үйлдэл;

в) Гаалийн татвар хураамж төлөхөөс зайлсхийсэн үйлдэл;

г) Эрх бүхий албан тушаалтанд үүргээ биелүүлэхэд саад хийх үйлдэл;

д) Татварын байгууллагын хэрэглэдэг сүлдэт тэмдэгтүүдийг хуурамчаар үйлдэх, борлуулах.

Хоёр. Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудын татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн талаар хуульчилсан онцлог

Дээрх тогтолцоотой улсын зарим нь системчилсэн эрүүгийн хуульгүй байдаг. Тэгвэл Ром, Германы эрх зүйн тогтолцоонд 2 хандлага байдаг.

А. Татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн үүний улмаас улсад (татварын байгууллагад) хохирол учирсан, төлөгдөх ёстой татвар

[4] Елинский А.В. (2008) Монография. *Уголовно-правовые меры борьбы с уклонением от уплаты налогов* С.77.

төлөгдөөгүй тохиолдолд зөрчил, гэмт хэрэг гэж зааглан ялгамжтай хуульчлах хандлага;

Б. Зөвхөн татварын хууль тогтоомжоор хариуцлага хүлээлгэх хандлага.

Герман: тус улсад татвар төлөхтэй холбогдсон 300 гаран хууль байдаг. Эдгээрээс татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгтэй холбоотойгоор:

1. Татварын Ерөнхий хууль (1977 он);
2. Эрүүгийн хууль (1871 он) гэсэн хоёр хууль үйлчилдэг.

Германы Эрүүгийн хуульд дараахь байдлаар татвартай холбоотой хууль бус үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилжээ. Үүнд:

Ст. 148 Төлбөрийн тэмдэгтийг дууриалган хийх (хуурамчаар үйлдэх);

Ст. 149 Мөнгө болон төлбөрийн тэмдэгтийг дууриалган хийхээр бэлтгэх;

Ст. 353 Төлбөрийг багасгах, эсвэл хууль бусаар татвар цуглуулах;

Ст. 355 Татварын нуугыг зөрчих;

Ст. 283б Нягтлан бодох бүртгэл хөтлөх үүргийг зөрчих.

Харин Герман улсын Татварын Ерөнхий хууль нь найман хэсгээс бүрдэх бөгөөд наймдахь хэсэгт татварын эрүүгийн хэргийн бүрэлдэхүүн, хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой заажээ.[6]

Германы Татварын Ерөнхий хуулийн 369-376 дугаар зүйлүүдэд татварын гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тухай хуульчилсан. Харин татварын эрүүгийн гэмт хэрэг болон тус хуулийн 377 дугаар зүйлээс 384 дүгээр зүйлүүдэд заасан "татварын талаарх тогтоосон журмын зөрчил" гэсэн ойлголтыг ялгаатай зохицуулжээ.

Энэ хуульд "Татвар төлөхөөс зайлсхийх" гэмт хэргийг Татварын Ерөнхий дүрмийн (положение о налогах) 370 дугаар зүйлд зохицуулжээ.

Татвараас зайлсхийх гэмт хэрэг нь дараах нөхцөлийг хангахын тулд:

- Санхүүгийн болон эрх бүхий байгууллагад татвар төлөхтэй холбоотой үйл явдал (факт)-ыг бууруу мэдээлэх, татвар ногдох нөхцөл байдлын бүрэн бус мэдээлэл өгөх замаар татварын хэмжээг бууруулах үйлдлийг;
- Санхүүгийн байгууллагад татвар ногдох нөхцөл байдлын тухай ач холбогдол бүхий үйл явдал, баримт сэлтийн талаар мэдээ гаргаж өгөх үүргээ зөрчих (эс үйлдэхгүй);
- Татварын төлбөр, хураамжийн тэмдэгт буюу онцгой албан тамга, тэмдэгийг хэрэглэх ёстой байтал үүргээ зөрчин хэрэглэхгүй байх, эсвэл татварын хөнгөлөлтийг үндэслэлгүйгээр эдлэх.

[6] Creifelds. RECHTS-WERTER-BUCH.18.Auflage.. ***Steuerstrafrecht***.1245

Дээр дурдсан үйлдлүүдийн улмаас гэмт хэргийг хийсэн этгээд татварын хэмжээг багасгасан эсвэл өөртөө, бусад этгээдэд үндэслэлгүйгээр татвар төлөлтийн хувьд давуу байдал бий болгосон байх үйлдэл гэмт хэрэгт хамаардаг. Германы дээрх хуулийн хэм хэмжээгээр хамгаалагдаж байгаа зүйл нь татварыг цаг хугацаанд нь бүрэн бүтэн, зөв байдлаар тогтоох, төлүүлэх эрх зүйн ашиг сонирхол юм. Энэ тодорхойлолтоос үзвэл цаг хугацааг хожимдуулан татварын мэдээг өгч байгаа явдалд хүртэл эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байна.

Татвараас зайлсхийх гэмт хэргийн хувьд 5 жил хүртэл хорих ял эсвэл торгууль ногдуулдаг. Онц их хэмжээний татвараас зайлсхийх гэмт хэргийн хувьд 10 жил хүртэл хорих ялтай байдаг.

Татварын дүрмийн 370.2 дахь хэсэгт заасны дагуу татвараас зайлсхийхийг завдах болон 369.1.4 дүгээр зүйлд заасанчлан зохион байгууллалтайгаар бүлэглэн үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлж хүлээлгэдэг байна.

Бүрэн бус мэдээ гаргах

Хариуцлага хүлээх этгээд (субьект) нь өөрөө эсхүл бусад этгээдээр дамжуулан санхүүгийн байгууллагад татварын хуудсаа өгсөн этгээд байна. Дамжуулагч нь зориуд санаатай дамжуулсан бол хамтран оролцогч болно.

Санхүүгийн байгууллагууд гэдэгт ямар байгууллага хамаарахыг заасан байдаг. (дүрмийн 6, санхүү удирдлагын тухай хуулийн 1)

Үүнд:

- Орон нутгийн байгууллагууд (жишээ нь: гаалийн, санхүү-татварын алба г.м);
- Дунд түвшний байгууллагууд (санхүүгийн дээд захиргаа г.м);
- Дээд байгууллагууд (холбооны сайд, яам г.м).

Дүрэмд (ст.370) хууль зүйн факт буюу үйл явдал. нөхцөл байдал зэрэг нь татвар ногдуулахад ач холбогдолтой мэдээлэлд хамаарна гэж заажээ. Харин мэдээлэлд юу юу хамаарахыг нэлттэй орхижээ. Энэ хууль хэрэглэгчийн мэдэх асуудал бөгөөд (татварын байгууллагын) үнэнд үл нийцэх мэдээллийг бүрэн бус мэдээнээс хэрхэн ялгах нь төвөгтэй байж болох юм.

Мэдээлэл гаргаж өгөхгүй байх

Энэ нь татвар төлөхөөс зайлсхийх хамгийн түгээмэл арга юм. Өөрийнхөө санхүү, аж ахуйн байдлын талаар өгөх мэдээллийн дэлгэрэнгүй жагсаалтыг татварын хуулиудад дурдсан байдаг. Гэхдээ

татварын байгууллага явуулж болно.

Татварын хөнгөлөлт, давуу байдлыг үндэслэлгүй олж авах

Татварын хөнгөлөлт, давуу байдал (tax avoidance) гэдэг нь:

- Татварыг багасгах;
- Татвараас чөлөөлөх;
- Татварын эцсийн тооцооны хуудсаар урьдчилан төлсөн татварыг буцааж олгох;
- Төлбөрийн хугацааг хойшлуулах, өөрчлөх;
- Татварын декларацн (хуудас)-ийн хугацааг уртасгах;
- Орлогын татварын үл ногдуулах доод хэмжээг орлогын албан татварын картанд шилжүүлэх;
- Бусад.

Татварын давуу байдал үндэслэлгүйгээр олж авах үйлдлийг залилангийн хэргээс ялгах шаардлагатай. Энэ талаар татварын дүрэмд маш дэлгэрэнгүй заасан байгаа гэх. Түүнчлэн тус дүрмийн Ст.370-д гэмт хэрэг үйлдэхээр завдсан бол ял шийтгэж болохыг зориуд тусгасан байдаг.

Тус зүйлд татвараа төлөхөөс зайлсхийсэн ноцтой тохиолдолд 6 сараас 10 жил хүртэл хорих ял оногдуулахаар заагаад онц хүнд тохиолдолд:

А. Шунахай зорилгоор их хэмжээгээр татварын хэмжээг дарагдуулсан эсвэл татварын хөнгөлөлт эдэлсэн, өөрийн эрх мэдэл, бодит байдлыг албан тушаалтан урвуулан ашиглах (бусдад давуу байдал олгох);

В. Хуурамч баримт бичиг ашиглан татварын хэмжээг бууруулах эсвэл хөнгөлөлт эдлэх.

Татвар нуун дарагдуулсан барааг худалдан борлуулах үйлдлийг Герман гэмт хэрэг гэж үздэг. Энэхүү гэмт хэргийг үйлдэх субъектив тал нь хувьдаа болон гуравдагч этгээдэд ашиг олох зорилгоор үйлдвэл торгох ял шийтгэхээр заажээ.

Харин төлбөр, хураамжийг төлсөн тухай тэмдэгтүүдийг хуурамчаар үйлдэх эсвэл үйлдэхээр бэлтгэх нь татварын гэмт хэргийн бие даасан төрөл болдог.

Герман Улсын Эрүүгийн хуулийн 148, 149, Татварын дүрмийн 369.1 түүнчлэн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үүргийг зөрчих нь тус улсын Эрүүгийн хуулийн 283.б-д заасан гэмт хэрэг болдог.

Герман Улсад "*хөрөнгө цгцй болох явдлыг зарлах*" бас нэг арга зам нь татвар юм гэж үздэг. Татварын эрх зүйд (хуулийн дагуу) иргэн хүн эд хөрөнгийнхөө талаар төрд тайлагнах зарчим үйлчилдэг. Үүнээс улбаалан ойлговол хүн өөрийнхөө эд хөрөнгийн гарал үүслийг (эх үүсвэр) төрд тайлбарлах, тайлагнах үүрэгтэй байдаг. Хэрэв эд хөрөнгийнхөө гарал үүслийг тайлбарлахаас татгалзвал түүний тухайн

эд хөрөнгө, орлогод маш өндөр татвар, тухайлбал, 90%-100%-ийн татвар ногдуулж болдог байна.

Гэтэл *АНУ-д* нуун дарагдуулсан эд хөрөнгийн талыг төр хурааж авах эрхтэй байдаг.[6] Герман Улсад татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн тохиолдолд хорих ялаар шийтгэх, тавар нөхөн төлүүлэх гэх мэт эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Германы Үндсэн хуулийн шүүх тамхимд ногдуулах тусгай албан татварын асуудлаар гаргасан шийдвэртээ хэрэгтэнг өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардаж болохгүй боловч энэ зарчим нь татварын мэдүүлэг өгөх асуудалд үл хамаарах ба тамхины импортын татвар төлөөгүй нөхцөлд оруулж ирсэн тамхийг хурааж авах нь зүйд нийцнэ гэж үздэг. (2009 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэр).[7]

Тиймээс татварын эрх зүйд тусгасан эд хөрөнгийнхөө эх үүсвэрийг тайлбарлах үүрэг болон нуун дарагдуулсан эд хөрөнгийг төр хурааж авах тухай зарчмыг эрх чөлөөг эрхэмлэсэн аль ч оронд хэрэгжүүлэхэд ямар ч саад бэрхшээл учрах ёсгүй юм. Энэ тохиолдолд зөрчил гаргагч нуун дарагдуулсан эд зүйл, орлоготой дүйцэх мөнгийг төлсөн бэйх ёстой.

БНСУ-д татвар төлөхөөс зайлсхийх үйлдэлд эрүүгийн хуулиар бус татварын хуулиар хариуцлага хүлээлгэдэг. Зарим төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг төрөлжсөн хуулиар зохицуулдаг нь энэ улсын онцлог юм. Тус улсын Татварын тухай хуулийн заалтыг үзвэл энэ зөрчлийг гаргасан этгээдэд зайлсхийсэн татварыг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгодог байна. Үүнд:

1. Тусгай хэрэглээний татвар болон согтууруулах ундааны татвараас зайлсхийсэн тохиолдолд мөн замын татвараас зайлсхийсэн нөхцөлд;
2. Тэмдэгтийн үнийн татвараас зайлсхийсэн тохиолдолд;
3. Бусад үндэсний татвараас зайлсхийсэн тохиолдолд.

Дүгнэлт

Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь[8] тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгал орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршдог.

Харин татвар төлөхөөс санаатай зайлсхийх үйлдэлд хүлээлгэх

[6] Чулуунцэцэг О. (2003) *Олон улсын татварын эрх зүйн зохицуулалт* УБ: 48.

[7] Германы эрдэмтэн. Доктор Бернд Шньюманны 2011 оны 3 дугаар сарын 15-нд ХЗДХЯ-ны Эрүү. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ирүүлсэн материал, уялзалт ярилцлагын тэмдэглэл.

[8] Эрүүгийн хуулийн - 1.

хариуцлага нь зарим талаар төрийн албадлага, цээрлэлийн шинжийг агуулдаг боловч татвар төлөгчдөд хуульд заасан үүргээ биелүүлэхийг ухамсарлуулах "хөшүүрэгдэх" зорилготой билээ. Дээрх судалгаанаас дүгнэн үзэхэд:

Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой улсууд төдийгүй эх газрын эрх зүйн системтэй зарим улсад (Герман, Солонгос г.м) бүрэн кодексжсон эрүүгийн хууль тогтоомж байхгүй байна.

- Эрүүгийн эрх зүйн шинжтэй бус атлаа өөртөө эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ агуулсан хуулиудын онцлог нь нийгмийн амьдралын янз бүрийн хүрээнд (эдийн засгийн, улс төрийн, эд хөрөнгийн, экологийн г.м) нааштай, эерэг харилцааны үйлчлэлийг хангах үндсэн зорилготой авч ямар нэг хэмжээнд дээрх харилцааныхаа эрүүгийн эрх зүйн хамгаалалтын чиг үүргийг мөн биелүүлдэг.
- Татварын эрх зүйн харилцаа өөрийн өвөрмөц онцлогуудтай, гүйцэтгэж буй үүрэг нь нэн чухал тул татварын гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж тэмдгүүд нь татварынхаа хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлогдсон байдаг ажээ.
- Эрүүгийн хууль тогтоомжийг бүрэн системчлэх нь тийм ч чухал бус. Тус хууль тогтоомжийг бодвол татварын харилцааг зохицуулсан хууль тогтоомж нь нийгмийн хөгжлөө даган илүү түргэн өөрчлөгдөж байдаг, динамик хөдөлгөөн ихтэй тул ийм байж болох юм.
- Татварын тухай хууль тогтоомжид нэр томъёоны зөрчилдөөнийг арилгаж байхад анхаарч эрүүгийн хуульдаа их хэмжээ, онц их хэмжээ, хамтран оролцогчдын хүлээх хариуцлага гэх зэрэг асуудлаа шийдвэрлэж, татварын тухай хууль тогтоомжид орлого, ашиг, зарлага, мэдүүлэх хуудас зэрэг ойлгодтын тайлбарыг сайн хийж өгдөг байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2004, 2009 онуудад давтамжтайгаар хийсэн "Монгол Улсын Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгааны тайлангаас үзэхэд торгох ялын хэрэгжилт тааруу байгаа тухай дурджээ. Энэ нь ч аргагүй юм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2002 оны Эрүүгийн хууль батлагдан гарсанаас хойш нийт 11 удаа өөрчлөгдөж тэр хэрээр торгох ялын хэмжээ шууд нэмэгдэж байв. Одоогийн байдлаар гэхэд Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд заасан торгох ялын заалтаас тооцоолж үзэхэд 28, 080, 000 төгрөгөөс 35, 100, 000 төгрөг, дээрээс их хэмжээний орлого болох 17, 550, 000 төгрөгөөс дээш улсад учруулсан хохирол төлөгдөх үү, үгүй юу гэсэн асуултын хариу тодорхой харагдаж байна. Гэтэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэх хөдөлмөрийн харилцааны ойлголт Эрүүгийн ялын бодлого болон гэмт хэргийн ангилалтад шууд нөлөөлж байна.

Тэгвэл татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг онолын үүднээс авч

үзэх шаардлага та бидний өмнө тулгарч байна. Монгол Улсад 2012 он хүртэл хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, Шүүх эрх мэдлийг шинэтгэх дунд хугацааны хөтөлбөр зэрэг эрх зүйн шинэтгэлийн эрчимтэй үйл явцаас харахад Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт хийх нь цаг хугацааны шинжтэй асуудал болоод байна. Энэ эгзэгтэй мөчид татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн бүрэлдхүүнийг зөв томъёолон, хууль боловсруулагч, шийдвэр гаргачдад санал хүргүүлж тусгуулах нь гол зорилго гэж үзэж болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЭРХ ЧӨЛӨӨТ БАЙДЛЫН ТУХАЙ

МУБИС-ийн Түүх, нийгмийн ухааны сургуулийн Философи, дидактикийн тэнхимийн багш, магистр Э.Чулуунцэцэг

Америкийн анхны коллежууд байгуулагдаж байсан үед эрдмийн эрх чөлөөний (Academic Freedom) тухай ухагдахуун бий болсон. Эрдмийн эрх чөлөө нь шинжлэх ухааны үр дагаварт чухал зүйл төдийгүй ардчилсан нийгмийн бодит илрэл болж байдаг. Гол асуудал нь эрдэмтэн судлаачид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, судалгаа, шинжилгээний үр дүнгээ нээлттэй дэлгэн тавих явдал юм.

Эрдэмтдийг төрийн бодлого, улс төрийн хүчний эсрэг үзэл бодлоо илэрхийлэхэд ажлаас халдаг, ял, шийтгэл хүлээлгэдэг, олон нийтийн нэр төрийг гутаасан гэж гутгэдэг, бүр амь насанд нь халддаг байсан түүх бий. Тухайлбал, хойд Африкд олон нийтийн эрүүл мэндийн мэргэжилтэн профессор өөрийн орны нялхасын эндэгдлийн үзүүлэлтийг засгийн газрын үзүүлэлтээс өндөр байсныг гарган харуулжээ. Үүний төлөө ажлаас нь халж, ял шийтгэл хүлээлгэж байсан удаатай.[1] Манай улсын тухайд социалист нийгмийн үзэл суртлын эсрэг үзэл бодлоо илэрхийлэхэд энэ мэт үзэгдэл олон байсныг үгүйсгэх аргагүй юм. Өнөөдөр ч эрх зүйн зохицуулалт, боловсролын удирдлагын тогтолцоо, эрдэм шинжилгээний байгууллагын санхүүжилт зэрэг зүйлээс үүдээд энэ асуудал байсаар байгаа гэдэгтээ олон хүн санал нийлэх биззээ.

Шинжлэх ухааны үнэн бодит мэдлэг бүтээх нь аливаа улс орны нийгмийн хөгжлийн нэг чухал хүчин зүйл юм. Иймээс судалгаа шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих тал дээр дэлхий нийтээрээ ихээхэн анхаарал хандуулж байна. Үүний нэг урьдач нөхцөл нь эрдмийн эрх чөлөөт байдлыг хангах юм. Их сургууль эрдэм шинжилгээ, судалгааны чиг үүрэг бүхий, эрдэм шинжилгээний байгууллага байдаг тул эрдмийн эрх чөлөөт байдлыг эрх зүйн зохицуулалтын хүрээнд баталгаажуулах шаардлагатай байна.

Эрдмийн чөлөөт байдлыг хангах гэдэг нь ямар нэг шахалт хавчилтгүй, айх эмээх зүйлгүй зарим хүнд таалагдахгүй байж ч болох зүйлийг ярих судлах эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх,

[1] Wikipedia. the free encyclopedi

эрх чөлөөг баталгаажуулах явдал юм. Өөрөөр хэлбэл эрдмийн чөлөөт байдал гэдэг нь эрдэмтэн судлаачид өөрсдийн сонирхлын дагуу чөлөөтэй сурч судлах, чөлөөтэй ярилцах, хэлэлцэх хэвлэн нийтлэх, чөлөөтэй шинжлэх ухааны үнэний мэдлэгийг эрэлхийлэх эрхийг нь төр, түүний эрх бүхий байгууллага, нийгмийн бүлгүүлийн шахалт хавчилтаас хамгаалахыг хэлнэ.

Эрдмийн эрх чөлөөт байдал нь зөвхөн мэргэжлийн чөлөөт байдлаас гадна сургуулийн чөлөөт байдал, оюутны чөлөөт байдал, судлаачдын чөлөөт байдлыг хамаарна.[2]

Энэхүү эрдмийн эрх чөлөөг хангахад дараах зүйлүүд чухал нөлөөтэй.

1. Эрх зүйн зохицуулалтанд тусгах;
2. Удирдлагын хувьд хараат бус байх;
3. Санхүүгийн хараат бус байдал;
4. Их сургуулийн профессор, багш нарын нийгэм, эдийн засгийн баталгаа зэрэг хамаарна.

Эдгээрийг тус бүрт нь авч үзвэл:

Нэг. Эдгээрийг улс орнууд болоод манай эрх зүйн зохицуулалтаар хэрхэн зохицуулсан талаар эрдмийн эрх чөлөөг хангах нэгдүгээр хүчин зүйлийг авч үзье.

Academic Freedom буюу Эрдмийн эрх чөлөөг хуульчлан баталгаажуулж, хамгаалсан эрх зүйн зохицуулалтын талаар авч үзвэл дэлхийн ихэнх улс орны хувьд үндсэн хуулиндаа энэ талаар тусгасан байна. Тухайлбал:

Франц улсын үндсэн хуулинд "...их сургуулийн профессор, дэд профессор судлаач багш нар бүрэн бие даасан судалгаа шинжилгээ хийх, үг хэлэх эрх чөлөөтэй, түүнд хүндэтгэл үзүүлэх, дараа дараагийн их сургуулиудад уламжлал болгоно."

Герман улсын үндсэн хуульд "..."Соёл урлаг, шинжлэх ухаан заах эрх чөлөөтэй, эрдмийн энэ эрх чөлөө нь үндсэн хуулийн үзэл баримтлалыг зөрчихгүй".

1987 оны филиппины үндсэн хуулинд "...эрдмийн эрх чөлөөг дээд боловсролын бүх институтад эдлүүлэнэ"[3]

Америкийн нэгдсэн улсын хувьд эрдмийн эрх чөлөөг хамгаалж тодорхойлдог нэг чухал баримт бичиг нь 1940 оны эрдмийн эрх чөлөөний тухай тунхаглал юм. Энэ баримт бичиг нь их сургууль, коллежид мөрдөх дүрэм журамд баталгаа болж байсан төлийгүй дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Мөн үнэн бодитой судалгаа хийж үзүүлэх нийлэг эрх чөлөөтэй. Эрдэм шинжилгээ судалгаа, үнэний

[2] Imporving Academic Management. Paul Jedamus, Marvin W.Peterson 1998. Jossey-Bass Publishers. Page 78

[3] http://www.ericdigests.org/1994/academic.htm

дэвшилтэт зорилготой.

Энэ тунхаглалын гол зарчим нь:

- Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг ил тод нээлттэй явуулах,
- Шинжлэх ухааны үнэн мэдлэгийг нээж, мэдээлснийхээ төлөө аливаа шийтгэл, хариуцлага, дарамт шахалт эдлэхгүй,
- Эдийн засгийн хувьд элбэг хангалуун байх, санхүүгийн тайланг мөн ил тод гаргах юм. [4]

Мөн АНУ-ын дээд шүүхээс эрдмийн эрх чөлөө гэдэг нь их сургууль" өөрсдөө сурах орчноо бүрдүүлнэ" гэсэн үг гэж тодорхойлоод:

1. Хэн хичээл заах;
2. Юуг заах болох;
3. Хэрхэн шалгах;
4. Хэрхэн заах хэрэгтэй;
5. Хэн сурч болох гэх мэт асуудал нь сургуулийн өөрийн эрх мэдэл болох талаар тогтоож өгсөн байна.[5]

Эндээс үзвэл манай дээд боловсролын тухай хуулиар "...дээд боловсролын байгууллагад элсэгчдийн тоог Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас тогтооно...[6] гэж заасан, мөн яамнаас эрх зүйн хэм хэмжээний акт гаргаж их сургуулийн тодорхой мэргэжлийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож байгаа зэрэг нь их сургуулийн эрдмийн эрх чөлөөг төрийн эрх бүхий байгууллагын зүгээс зөрчиж байгаа хэрэг болж байна.

Зарим улс орны хувьд эрдмийн эрх чөлөөг үндсэн хуулиараа заагаад түүнээс улбаалан дээд боловсролын харилцааг зохицуулдаг хууль, сургуулийн дотоод дүрэм журамд тусгаж хамгаалдаг эрх зүйн зохицуулалттай. Манай улсын хувьд үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.8 дугаар зүйлд "Соёл урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туувиах, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогчын шинэ бүтээл нээлтийн эрхийг хуулиар хамгаална" гэж заасан. Мөн боловсролын тухай хууль болоод дээд боловсролын тухай хуульд багш, оюутан нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн явуулах эрхтэй болохыг заасан байна. Гэхдээ энэ эрхээ хэрэгжүүлэх, хамгаалах эрх зүйн зохицуулалт дутагдалтай байна гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл эрдмийн эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд хэрхэх талаар зохицуулалт, хамгаалалт байхгүй. Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зөрчигдсөн гэж үзэх л болж таарч байна. Гэтэл шинжлэх ухааны бодит үнэн мэдлэгт тулгуурлан нээлт хийх, судалгаа шинжилгээний үр дүнг үндэслэн

[4] "1940 Statement on Academic Freedom and Tenure"

[5] http://www.rbs2.com/afree.htm

[6] Дээд боловсролын тухай хууль - 7.2

талаар төдийлөн оруулаагүй бөгөөд 10 дахь нэмэлт өөрчлөлтөөр боловсрол бол муж улсын түсгай эрх болохыг хүлээн зөвшөөрсөн. Боловсрол бол үндэстний хамгийн чухал салбар тул дэлхийн дийлэх улс орны хувьд төвлөрсөн удирдлагатай байдаг. Харин АНУ-ын үндсэн хуулийн зохицуулалтаас хамаараад 1950-иад он хүртэл холбооны улсаас боловсролд оролцох оролцоо маш бага байсан. 1950-аад оноос Орос улс шинжлэх ухаан, технik, сансарын салбарт онцгой амжилт гаргаж эхлэсэн нь холбооны улсаас боловсролд оролцох үүргийг шинээр авч үзэн холбооны улсаас боловсролыг дэмжих хөрөнгө оруулалт хийхэд ихээхэн түлхэц болжээ. Ийнхүү далаад оны үеэс боловсролд холбооны улсаас дэмжлэг үзүүлэх зарчмыг нийтээр хүлээн зөвшөөрөх болсон байна.[10]

Манай их сургуулийн төсөвийг оюутнуудын сургалтын төлбөрөөс бүрдүүлж байна гэж дүгнэж болох бодит жишээ дурьдвал . Манай ууган их сургууль болох Монгол улсын их сургуулийн тухайд авч үзвэл 2005-2006 оны хичээлийн жилийн тайлангаас үзвэл, их сургуулийн төсвийн орлого 5 754.1 сая төгрөг бөгөөд үүний 90.6 хувийг нь сургалтын төлбөр, есөн хувийг туслах үйл ажиллагааны орлого (туслах нэгж, курс дамжаа, түрээс гэх мэт.) бүрдүүлдэг ажээ, Үлдсэн 0.4 хувийг улсын төсвөөс олгосон нь МУИС-ийн харьяа лицей (үндсэндээ ерөнхий боловсролын сургууль) сургуулийн санхүүжилт байсан хэдий ч улс уг сургуулийн санхүүжилтийг даруй 11.5 сая төгрөгөөр тасалдуулсан аж.[11] Ийнхүү санхүүгийн хувьд оюутнаасаа хараат байх нь эрдмийн эрх чөлөөт байдалд харшилж байна. Мөн сургуулийн төлбөрөө нэмэх эсэх асуудалд бие даан шийдвэр гаргах эрхгүй байгаа нь санхүүгийн гол эх үүсвэрээ бүрдүүлэхэд хүндрэл учрах болсон байна.

Гэтэл 2000-2001 оны байдлаар АНУ-д бакалавраас дээш зэрэг олгодог улсын их сургуулиудын нийт орлогын 50.77 хувийг холбооны, мужийн болон орон нутгийн төсвийн санхүүжилт бүрдүүлсэн бол 18.06 хувийг сургалтын төлбөр, 25.32 хувийг эмнэлэг, туслах үйлдвэрлэл, боловсролын үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагааны орлого, үлдсэн 5.83 хувийг хандив, өргөл бүрдүүлж байна. Харин хувийн ашгийн бус их дээд сургуулиудын орлогын хувьд холбооны, мужийн болон орон нутгийн төсвийн хуваарилалт, тэтгэлэг болон гэрээт үйл ажиллагааны санхүүжилт 17.62 хувийг, сургалтын төлбөр 34.08 хувийг, хөрөнгө оруулалтын ашиг, эмнэлэг, туслах үйлдвэрлэл, боловсролын үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагааны орлого нь 34.68 хувийг, хувийн өргөл, хандив үлдсэн 13.60 хувийг бүрдүүлж байна. Үүнээс үзвэл, их сургуулийн чанар, хөгжилд төрийн дэмжлэг асар чухал үүрэгтэй болох нь ойлгомжтой юм.

---

[10] Бадарч.Б (1999) *Америкийн дээд боловсрол* УБ. 25.

[11] Монгол Улсын Их сургуулийн 2005-2006 он хичээлийн жилийн тайлангаас.

үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх нь арай өөр ойлголт юм.

Хоёр. Удирдлагын хараат бус байдлын талаар авч үзье.

Их сургууль нь удирдлагын хувьд төр, түүний эрх бүхий байгууллага, өөр бусад субъектээс хараат бус байх нь эрдмийн эрх чөлөөг хангах нэг урьдач нөхцөл болно. Их сургуулийн удирдлагын тогтолцоо нь:

- Захирлыг төрийн захиргааны тов байгууллага томилно;
- Эрдмийн зөвлөлийн дарга нь томилогдсон захирал байна.

Энд нэг ч "сонгоно" гэсэн үг, үйлдэл байхгүй цэвэр босоо удирдлагатай тогтолцоо болжээ.[7]

Мөн их сургуулийн захиргааны зөвлөл, эрдмийн зөвлөлийн эрх мэдэл тодорхойгүй, нэгдмэл байдал үүссэн, эрдмийн зөвлөл бэлэгдлийн шинжтэй байгууллага болж хувирсан төдийгүй удирдлах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл дангаар шийдвэр гаргах боломжоотой нөхцөл байдлыг боловсролын тухай хуульд тусгасан.

Бусад улс орны хувьд бол удирдлагын ямар загвар сонгосноос нь хамааraад хамтын удирдлагын тогтолцоо, өөрийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байдаг. Манайх хамтын удирдлагын буюу Америк маягийн удирдлагын загварыг сонгосон хэрнээ зарим алдаа дутагдлаас үйдээд дээрхи үр дагавар бий болсон байна. Удирдлагын тогтолцооны энэ гажилтаас үйдээд эрдмийн эрх чөлөө хязгаарлагдах болсон.

Гурав. Санхүүгийн чөлөөт байдлыг бүрдүүлсэн эсэх талаар авч үзье.

Их сургуулийн эрдмийн эрх чөлөөг хангахад эдийн засгийн тусгай баталгаа шаардлагатай байдаг. 1940 оны АНУ-ын тунхаглалд ч эдийн засгийн хувьд элбэг хангалуун байх, санхүүгийн тайланг мөн ил тод гаргах нь эрдмийн эрх чөлөөт байдлыг хангах чухал зарчим гэж тусгагдсан. Манай боловсролын тухай хуульд "Боловсролын санхүүжилтэнд улсын төсөвийн жилийн орлогын 20-иос доошгүй хувийг зарцуулна"[8] гэж заасан. Мөн дээд боловсролын тухай хуульд зааснаар улсын төсөвийн хөрөнгө" нь дээд боловсролын байгууллагын санхүүгийн эх үүсвэр болдог. Гэтэл их сургуулийн хувьд авч үзвэл улсын төсөвөөс дээд боловсролын байгууллагад тэр дундаа эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор мөнгө хуваарилагддах нь ховор нохцолтэй сургалтын төлбөрөөр санхүүгээ бүрдүүлж байна.

АНУ-ын хувьд авч үзвэл 1787 оны үндсэн хуулиар анх боловсролын

[7] Лүндэндож Н. Одгэрэл П. *Нийтийн өмчит их сургуулийн эрх зүйн байдлыг бүрдүүлэх зарим асуудал* судалгааны илтгэлээс

[8] Боловсролын тухай хууль - 39.1

[9] Дээд боловсролын тухай хууль - 18.1.1

талаар тодийлсон оруулаагүй бөгөөд 10 дахь нэмэлт өөрчлөлтөөр боловсрол бол муж улсын суугай эрх болохыг хүлээн зөвшөөрсөн. Боловсрол бол үндэстний хамгийн чухал салбар тул дэлхийн дийлэх улс орны хувьд төвлөрсөн удирдлагатай байдаг. Харин АНУ-ын үндсэн хуулийн зохицуулалтаас хамааралд 1950-иад он хүртэл холбооны улсаас боловсролд оролцох оролцоо маш бага байсан. 1950-аад оноос Орос улс шинжлэх ухаан, технік, сансарын салбарт онцгой амжилт гаргаж эхлэсэн нь холбооны улсаас боловсролд оролцох үүргийг шинээр авч үзэн холбооны улсаас боловсролыг дэмжих хөрөнгө оруулалт хийхэд ихээхэн түлхэц болжээ. Иймхүү далаад оны үеэс боловсролд холбооны улсаас дэмжлэг үзүүлэх зарчмыг нийтээр хүлээн зөвшөөрөх болсон байна.[10]

Манай их сургуулийн төсөвийг оюутнуудын сургалтын төлбөрөөс бүрдүүлж байна гэж дүгнэж болох бодит жишээ дурьдвал . Манай ууган их сургууль болох Монгол улсын их сургуулийн тухайд авч үзвэл 2005-2006 оны хичээлийн жилийн тайлангаас үзвэл, их сургуулийн төсвийн орлого 5 754.1 сая төгрөг бөгөөд үүний 90.6 хувийг нь сургалтын төлбөр, есөн хувийг туслах үйл ажиллагааны орлого (туслах нэгж, курс дамжаа, түрээс гэх мэт.) бүрдүүлдэг ажээ. Үлдсэн 0.4 хувийг улсын төсвөөс олгосон нь МУИС-ийн харьяа лицей (үндсэндээ ерөнхий боловсролын сургууль) сургуулийн санхүүжилт байсан хэдий ч улс уг сургуулийн санхүүжилтийг даруй 11.5 сая төгрөгөөр тасалдуулсан аж.[11] Иймхүү санхүүгийн хувьд оюутнаасаа хараат байх нь эрдмийн эрх чөлөөт байдалд харшилж байна. Мөн сургуулийн төлбөрөө нэмэх эсэх асуудалд бие даан шийдвэр гаргах эрхгүй байгаа нь санхүүгийн гол эх үүсвэрээ бүрдүүлэхэд хүндрэл учрах болсон байна.

Гэтэл 2000-2001 оны байдлаар АНУ-д бакалавраас дээш зэрэг олгодог улсын их сургуулиудын нийт орлогын 50.77 хувийг холбооны, мужийн болон орон нутгийн төсвийн санхүүжилт бүрдүүлсэн бол 18.06 хувийг сургалтын төлбөр, 25.32 хувийг эмнэлэг, туслах үйлдвэрлэл, боловсролын үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагааны орлого, үлдсэн 5.83 хувийг хандив, өргөл бүрдүүлж байна. Харин хувийн ашгийн бус их дээд сургуулиудын орлогын хувьд холбооны, мужийн болон орон нутгийн төсвийн хуваарилалт, тэтгэлэг болон гэрээт үйл ажиллагааны санхүүжилт 17.62 хувийг, сургалтын төлбөр 34.08 хувийг, хөрөнгө оруулалтын ашиг, эмнэлэг, туслах үйлдвэрлэл, боловсролын үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагааны орлого нь 34.68 хувийг, хувийн өргөл, хандив үлдсэн 13.60 хувийг бүрдүүлж байна. Үүнээс үзвэл, их сургуулийн чанар, хөгжилд төрийн дэмжлэг асар чухал үүрэгтэй болох нь ойлгомжтой юм.

---

[10] Бадарч.Б (1999) *Америкийн дээд боловсрол* УБ. 25.

[11] Монгол Улсын Их сургуулийн 2005-2006 он хичээлийн жилийн тайлангаас.

Доров. Их сургуулийн профессор, багш нарын нийгэм, эдийн засгийн баталгааны талаар авч үзье.

Их сургуулийн профессор багш нийгэм эдийн засгийн баталгааг хангаагүйгээс шалгаалж, мөн их сургууль нь төрөөс хараат түүний хяналтанд үйл ажиллагаагаа явуулдагаас хамаарч эрдмийн эрх чөлөө зөрчигдөх явдал цөөнгүй байдаг. Манайд боловсролын тухай хууль болоод дээд боловсролын тухай хуулиар их сургуулийн профессор, багш нарын нийгэм, эдийн засгийн баталгаа, халдашгүй байдал зэргийн тогтоож өгч чадаагүй гэж дүгнэж болохоор байна.

АНУ-ын хувьд багшид хууль болоод сургуулийн дотоод дүрэм заасны дагуу тусгай эрх олгодог байна. Энэ нь өөрийн албан тушаалын ажлыг тэтгэвэрт гартлаа, эсвэл хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдолд болон онцгой тохиолдол гарах хүртэл баталгаатай халгалж, сургалт судалгааны ажлаа сэтгэл тайван хийх боломж олгож байгаа онцгой эрх юм. Ихэнх сургуулиуд нь багшийн тусгай эрхийг хуулиар хамт олны санлаар, эсвэл онцгой тохиолдолд буюу шинжлэх ухааны агуу нээлт хийсэн бол олгодог байна. Профессорын орон тоонд ажиллаж байгаа хүнд тусгай эрхийг бараг автоматаар олгоно. Тухайлбал, АНУ-ын Роде арлын их сургуулийн дүрмийг авч үзвэл:

6.4. Багшийн тусгай эрх

6.4.1. Багшлах тусгай эрх олгох зорилго нь нэгд багшаа хамгаалах, хоёрт их сургуулиа хамгаалахад оршино.

6.4.2. Тусгай эрх авах нөхцөл

А. Багш түүнтэй дүйцэх зэрэглэлийн хүнд олгохгүй

Б. Ассистант профессор 7 жил багш, түүнээс дээших орон тоонд ажилласан бол 8 дахь жилээсээ тусгай эрх авна.

В. Дэд профессор 3 жил энэ орон тоонд ажилласан бол 4 дэх жилээсээ тусгай эрх авна.

Г. Чөлөөтэй хугацааг ажилласан хугацаанд тооцохгүй

6.1.7. тусгай эрх автоматаар олгогдохгүй. Улирлах зөвлөлийн гишүүдийн санлаар олгоно.

Ийнхүү их сургуулийн профессор багш нарын нийгэм, эдийн засгийн баталгааг хангах эрх зүйн орчин бурдүүлэх нь эрдмийн эрх чөлөөг хамгаалаад зогсохгүй их сургуулийн бие даасан байдалд нөлөөлөх чухал хүчин зүйл юм. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд их сургуулийн профессор, багш нарт онцгой эрх олгогдоогүй байгаа нь судалгаа, шинжилгээний ажилдаа өөрийгөө бүрэн зориулах нөхцөл боломж байхгүй гэж үзэж болох талтай.

Энэ бүхнээс дүгнэвэл манай их сургуулиудын эрдмийн эрх чөлөөг баталгаажуулахын тулд их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль батлан гаргах, их сургуульд бие даасан байдал олгохын зэрэгцээ тус

хуульд:

1. Их сургуулийн эрдмийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг тодорхой тусгах,

2. Их сургуулийн удирдлагын эрх зүйн зохицуулалтыг эргэн харж, хамтын удирдлагын тогтолцоо буюу америк маягийн удирдлагын загварыг зарчмын дагуу бүрдүүлэх,

3. Санхүүгийн хувьд хараат бус байхын тулд төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх,

4. Багшийн тусгай эрх олгох зэрэг асуудалд анхааралаа хандуулах шаардлагатай байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ТӨРИЙН АЛБАНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТОЙМ, ШИНЭТГЭЛ, ТҮҮНИЙ АГУУЛГА

*Хууль зүйн цидэсний хүрээлэнгийн судалгаа**

Удиртгал хэсэг

Нэг. Судалгааны зорилго, зорилт. Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны хууль болон төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын талаархи бусад хуулийг харьцуулан судалж, тэдгээрийн нийтлэг болон ялгаатай тал, бүлэг, зүйл хоорондын хийдэл, давхардал, зөрчлийг илрүүлэх үнэлгээ хийх явдалд оршино.

Үүний тулд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Монгол Улсын төрийн албанд холбогдох эрх зүйн актыг 1911-1921 он хүртэл түүвэрлэн гаргах;
- 1921-1940-1960 он хүртэлх үеийн Төрийн албаны хууль тогтоомж дахь төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, залгамж холбоог гаргах, шинжлэн судлах;
- 1960-1990, 1992-1994, 1994-2002 оны үеийн төрийн албаны хууль тогтоомж дахь төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, залгамж холбоог гаргах, шинжлэн судлах;
- 1990-1992 (завсрын үеийн) болон 1994 оны Төрийн албаны тухай хууль (1992-1994 оны Үндсэн хууль-Төрийн албаны тухай хууль)-ийн шинэтгэл, ялгагдах онцлогийг тухайлан судлах;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, 2002 оны шинэчилсэн найруулгын агуулга, ялгагдах байдал;
- Төрийн албан тухай хуульд 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн гол утга агуулгад дүн шинжилгээ хийх;
- Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын талаархи (1994 оноос хойшхи) тусгайлсан судалгаа гаргах;
- АНУ, ХБНГУ, Япон, ОХУ-ын төрийн албаны эрх зүйн зохицуулалт.

Хоёр. Судалгаа хийсэн байдал. Судалгааг Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн үндэслэл зааалт ба ШУ-ны арга зүйг ашиглан хийсэн ба дүгнэлтийг судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн гаргаж саналаа онолын үндэслэлтэй боловсруулна.

---

* Судалгааны зөвлөх хууль зүйн шинжлэх ухааны доктор Ж.Долгорсүрэн, хийж гүйцэтгэсэн Х.Наранцацралт.

- **Түүврийн аргыг онол, судалгааны бусад ном, эх сурвалж, сонин, тайлан, интернэтийн цахим хуудас дахь мэдээлэл болон гадаад хэл дээрх ном зэргээс судалгааны сэдэвтэй холбоотой асуудлыг түүвэрлэн судалгаанд ашигласан.**
- **Харьцуулалтын аргаар АНУ, ХБНГУ, Япон, ОХУ-ын төрийн албаны эрх зүйн зохицуулалтын тойм.**
- **Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг судалгааны хэсэг тус бүрт ашигласан.**

НЭГ. Түүхэн байдлын тойм (1911-1992 он хүртэл)

1.1. 1911-1921 оны үеийн төрийн албаны хөгжлийн тойм

Монголчууд 2200 гаруй жилийн төр, эрх зүйн хөгжлийн түүхтэй ард түмэн билээ. Монгол Улсын эрх зүйн хөгжлийн үечлэлийг, өөрөөр хэлбэл эрх зүйн тогтолцооны бүрдэлт, хөгжилтийг монголын нэгдсэн улс байгуулснаас хойш үзвэл:

1.Монголын тулгар төр байгуулагдаж, нийт үндэстний эрх зүйн тогтолцоо бүрэлдэн төлөвшин тогтсон үе (1206-1634 он);

2. Эрх зүйн 2 дахь төрөлжүүлэлт хийгдсэн үе (1640-1921 он);

3.Орчин үеийн эрх зүйн тогтолцооны үүсэл, хөгжлийн үе (1921 оноос өнөөг хүртэл) гэсэн үндсэн 3 үе шатанд авч үзэж болох юм[1].

Бид судалгаагаа Монгол оронд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хувьсгал, түүнээс хойшхи үеийг хамруулан тоймлон судалж байгаа болно.

Төрийн алба одоогийн бидний хэлж байгаагаар засаглалын хэлбэр буюу удирдлагын хэлбэртэй холбоотой юм. Тухайн улсад улс төрийн ямар дэглэм ноёрхож байгаагаас шалтгаалж төрийн алба өөр өөр утга чанартай байдаг. Хаант засагтай оронд хааны төлөө алба, бүгд найрамдах засагтайд нь нийтийн алба буюу нэг хүний төлөө бус алба гэсд мөн чанарын хувьд өөрчлөгдсөн түүхтэй.

Манай улсын хувьд төрийн алба нь эртнээсээ хаант засагтай байсан учир эзний алба болж үүссэн түүхтэй. Өөрөөр хэлбэл эзэн хаан хийгээд түүний шадруудын төлөө, түүний бие төлөөлөгч болох аймаг, хошуудын засаг ноёдын төлөө байжээ[2]. 1924 оноос л төгсгөл болсон. Энэ хүртэл манай төрийн алба хааны төлөө, засаг ноёдын төлөө алба гувчуур татахаас өгсүүлээд тэдний ноёрхлыг хамгаалж хангахад чиглэсэн байв. Мэдээж улс орны тусгаар тогтнол, хил хязгаар, аюулгүй байдлаа хамгаалах гэсэн ард түмний тэмцэл байсныг <u>үгүйсгэж болох</u>гүй. Энд төрийн алба залгуулж байсан олон үеийн

[1] Амарсанаа Ж. (2010) *Ардчилсан эрх зүйт ес* Уб., 4.

[2] Чимид Б. (2010) *Хуулийн биелэлтийг зохион байгуулах үүрэг бол төрийн албаны үйл ажиллагааны амин сүнс юм даа* // Төрийн захиргаа сэтгүүл. Тусгай дугаар. Уб., . 6.

баатарлаг хүмүүсийг мартаж болохгүй. **Гэхлээ л эцсийн эцэст төрийн алба гэдэг нэг хүний төлөө л байсан**[3].

1911 онд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хувьсгал нь Монголын эрх зүйн хүрээнд үндэсний шинжтэй өөрчлөлт шинэчлэлт хийх нөхцлийг бүрдүүлсэн юм. Монголд шинэ тулгар тогтсон **төр нь хэлбэрийн хувьд шашин-төрийг хослон барьсан хамжлагат ёсны-хэмжээгүй эрхэт хаант төр** байв. Шинэ тулгар Монгол Улсын хэмжээгүй эрхэт хаан бол VIII Богд Жибзумдамба хутагт байв. Тэрээр Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд нарын үүсгэн санаачилсан их хэргийг идэвхтэй дэмжиж, 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалд тэргүүлэх үүрэгтэй оролцсон юм.[4]

Энэ үеийн **хууль зүйн гол эх сурвалж нь 65 дэвтэрээр эмхтгэсэн "Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг" (ЗТМУХЗБ)** байсан. ЗТМУХЗБ-ийг 1913 оноос боловсруулж дагаж шийтгүүлж байсан[5] гэсэн бол зарим судлаач нар 1915-1918 онд зохион эмхтгэн бэлтгэж, Улсын Дээд, Доод хурлаар хэлэлцүүлж, Богд хааны зарлигаар батлуулсан[6] гэжээ. Энэ хууль цаазад анх удаа төрийн байгууллагуудын бүтэц, эрх хэмжээ, засаг захиргаа, нуташ дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, тушмэлийн зэрэг дэв, цалин пүнлүү зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулсан юм.[7]

ЗТМУХЗБ-т орсон хуулиудыг нийгмийн харилцааны олон тал, эрх зүйн харилцааны объектоор төрөлжүүлбэл, Хаант Монгол Улсын төрийн байгуулалд хамаарах 6 дэвтэр, төрийн захиргааны асуудлыг хөндсөн 9 дэвтэр, ..., ..., цэргийн харилцааг зохицуулсан 3 дэвтэр, ..., ... гэх зэрэг байна.

Энэ үеийн **төрийн алба нь тухайн үеийн дорно дахины**[8] хэв шинжийг агуулсан гэж үзэж болно. Төрийн бодлогдоо хоёр ёсны онцлыг тусган илэрхийлж байсан ба Богд Жибзумдамба шашин төрийг хослон барьсан Улсын хаан болгон өргөмжилсөн учир түүний нөлөө их байжээ. Энэ үеийн төрийн байгууллагын бүтцийг схем зургаар үзүүлбэл[9]:

---

[3] Чимид Б. (2010) *Хуулийн биелэлтийг зохион байгуулах үүрэг бол төрийн албаны үүл ажиллагааны амин сүнс юм даа* // Төрийн захиргаа сэтгүүл. Тусгай дугаар. Уб., 5.

[4] Болдбаатар Ж, Лундэзжанцан Д. (1997) *Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал*. Уб., 175.

[5] *Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/*. V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан нар. Уб., (2010). 6 дахь тал.

[6] Болдбаатар Ж, Лундэзжанцан Д. (1998) *Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал* Уб.,

[7] Баярсайхан Б. (2003) *Хууль зүйн тайлбар толь /Монголын төр, эрх зүйн түүх/*. Уб., 83.

[8] Лундэндорж Н. (1995) *Төрийн онол* Уб., 93; Мөн Сарантуяа (1998) Ц. *Төрийн ерөнхий онол* Уб., 84. "Дорно дахины төр ёсны ... нэг онцлог бол "шашин, төр хоёр хослох явдал юм" гэж төр судлаачид үздэг.

[9] Болдбаатар Ж, Лундэзжанцан Д. (1998) *Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал* Уб., 179 дэх тал; *Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/* V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан нар. Уб., 2010 он. 32-38 дахь тал; ЗТМУХЗБ-ийн Тэргүүн дэвтэр. Бүгдийн хууль дээд. 2-32 дахь тал.

гэсэн бүтэцтэй байв.

ЗТМУХЗБ-ийн Хоёрдугаар дэвтэр, Бүгдийн хууль Дундад: Бүх яамны сайд (дотоод, гадаад, цэргийн хэргийн, сангийн, шүүн таслах, улсын хурлын яамны, Улиастайн, Ховдын, Хиагтын сайдын), түшмэл, бичээч, олон харьяат ардын тооны ор.[10] Жишээ нь Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны айлтгаж тавих тэргүүн сайд 1 ор, дэд сайд 2 ор, дэс түшмэлийн зэрэг ёслолыг удирдагч түшмэл 1 ор, харьяат яамнаас эрхэлж тохоох эх бичиг зохиогч түшмэл 6 ор, эх зохиогч түшмэлийн зэрэг ёслолыг удирдагч түшмэл 1 ор, жинхэнэ бичээч 12 ор, яамны сав хэрэглэлийг эрхэлж сахих нярав 1 ор, хаалганы дарга 1 ор, зарлага 5 ор, хаалга сахигч 4 ор, галч 4 ор байгуулагтун гэх мэтээр 9 яамны орон тоог зааж өгсөн байна.

ХЗБ-ийн Гуравдугаар дэвтэр, Бүгдийн хууль Доодод: Богд хаанаар толгойлуулсан автономит засгийн газар Бүгд ерөнхийлөн захирах яам (засгийн газар), олон яам, хэлтсийн эрхлэн шийтгэх хэргийг тусгасан.[11] Үүнд: Дотоод хэргийн сайд, дэд сайд аливаа

[10] *Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/* V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан нар. Уб., 2010 он. 39-40.

*Хэргийг бүгд эрхлэн шийтгэх

** Бүгд захиран шийтгэх

[11] *Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/* V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан

дотоод застийн үндсэнд холбогдох хэргийг эрхлэн шийтгэнэ. Түшмэл, ёслол, төв 3 хэлтэс бий. Эрхэлсэн, дэс түшмэл 3 хэлтсийн хэрэг зүйлийг нэгэн адил хянан үзэж шийтгэнэ. Төвийн түшмэлийн, тоо бүртгэлийн, өртөөний зэрэг хэлтсүүдтэй байсан ба албан тушаал, зэрэг хэргэм олгох, хүн ам, малын тоо бүртгэл, өртөө, ёслолын зэрэг ажил эрхэлдэг. Мөн монгол, орос хэл бичгийн сургууль, цахилгаан мэдээний сургууль, хэвлэлийн хороо, өртөө харуулын зэрэг газрууд захирагдаж байсан эрхийн талаар бусад яамдаас илүү байжээ.

ХЗБ-ийн Доров, тавдугаар дэвтэр, Зэрэг залгамжлах нь Дээд, доод: Таван яамны сайд нарыг хаан сонгож хэрэглэнэ. Дэд сайд, эрхэлсэн, дэс түшмэлийг тэргүүн сайдуд сонгож батлан айлтгаад зарлигаар тавина. Эх бичиг зохиогчоос доош түшмэлийг анх удаа сонгоход өөр өөрийн яамны бичээчээс дэвшүүлэн хэрэглэх, эсвэвс олон хошуу шавийн газраа албан хааж хэрэг өнгөрүүлсэн нэр гарсан, түшмэл буй бөгөөс жил хуучин эндэгдэлгүй төв чигч байдлыг үзэж ор хүлээлгэ. Тушаалыг чадваас жинхэнэ оронд тохоон тавигтун гэжээ.

Энэ байгууллагад ажиллах төрийн албан хаагчийн эрх хэмжээ, цалин пүнлүүг зохицуулсан. Гэхдээ тэдгээрийн хэргэм зэргээс хамааран цалинг ялгамжтай ногдуулдаг байсан нь нэг талаас албаны зиндааг тодорхойлж байгаагаас гадна, тэдгээртэй холбоотой аливаа гэмт үйлдэл гарахаас урьдчилан сэргийлсэн шинжтэй болов уу.

Монголчууд эртнээс төрийн өмсгөл хэрэглэлийн тухай хууль гарган зохицуулдаг байсан.[12] Энэхүү хуулиар тогтоосон цалин хүртэхээс гадна өөрийн зэрэг дэвийг ялгасан хувцас хэрэглэлтэй байж түүнийг жилийн 4 улирал, төрийн ёслолын арга хэмжээний зэрэглэлээс хамааран хэрэглэж байхаар зохицуулсан байна. Мөн тэдгээр өмсөн хувцасны өнгө, хэв, дэг маягаас хамааран бие биедээ хүндлэл үзүүлэхээс гадна төрийн эрхэмсэг байдлыг илтгэн харуулдаг эрх зүйн үндсийг тогтоож өгчээ.

Төрийн албан хаагчийн хэргэм зэрэг дэв дэс нь албан тушаалын хэлбэрээс шууд хамааран байсан бөгөөд түүнийг ЗТМУХЗБ-ийн хэм хэмжээний хүрээнд авч үзье. Зургадугаар дэвтэр (Түшмэл байгуулах тушаал хууль)-т: Төрийн албанд авах ерөнхий болзол болох эрдэм чадал, сахилга бат, ажил хэргийн байдал, төлөв, насыг тус тус зохицуулсан. Тэргүүн сайдууд харьяат түшмэдийнхээ ажилд байнгын хяналт тавьж байх үүрэгтэй бөгөөд шалгах ажилд тэргүүн сайдуд хамт нийлж шалгуулах түшмэдийн нэрсийг гарган, улс орны байдалд холбогдох чухал сэдвээр 1 хуудас зохион бичлэг хийлгэж шалгахыг хуульчилж өгчээ. Түшмэлийг шалгахдаа гол үнэлэлт өгөх "чухам шалгах" 4 гол зүйлийг анхаарч байжээ. **Манжийн ноёрхлын үед төрийн түшмэлийг сонгохдоо гол төлөв эзэн хаандаа үнэнч эсэхийг**

нар. Уб., 2010 он. 42-43.

[12] Баярсайхан Б. (2005) *Монгол цаазын бичиг"-т хийсэн эрх зүйн судалгаа* Уб., 91.

гол шалгуур болгодог байсан бол Богд хаант торийн хуулиар олон яам, нутгийн захиргааны түшмэдүүдийг эрдэм, сахилга, хэрэг (ажил), нас мэдлэг, авъяас чадвар, ноён нуруу гол болгон нягтлан шалгаж дэвшүүлэх ёстойг хуульчлан тогтоож өгсөн байна[13]. Тухайлбал, Долдугаар дэвтэр. Шалгаж байцаах нь. Угаас эрдэм илүү, сахилга ариун, хэрэгт хичээнгүй, нас идэр залуу, эсвэс тэнхлүүн, тушаалыг чадахыг нь тэргүүн зэрэг шалгарсанд болгоно. Эрдэмд зэрэг, хэрэг зэрэг тушаалд эндэгдэлгүй, хичээнгүйг болгоомжтойг дэд зэрэг шалгарсанд болгоно. Эрдэм сахилга, хэрэгт зэрэг, нас залуу тэнхлүүн тушаалд энгийн зэрэг явахыг нь гуравдугаарт зэрэгт болгож уг тушаалд хэвээр агуулна.

Мөн түшмэл хний үл тэвчих 8 зүйлээр буруутгаж байсан. Үүнд: 1)хөвдог, 2)харгис 3)зөөлөн үхээнц, 4)чадалгүй, 5)хичээнгүй бус, 6)өвчтэй, 7)долгин хатан, 8)эрдэм дорой явдал хэмээн тодорхойлж буруушаах зэргээр тодорхой хэлэлцэж, дэвшүүлж, буруулах асуудлыг шийдэж байсан байна. Тухайлбал, Эрдэм дорой долгин хатныг нь зэрэг буурруулж улиран хэрэглэх эсвэс буурруулсан зэрэгтэй өөр тушаалд халж тавина. Зөөлөн үхээнц чадалгүй хичээнгүйг түшмэлийн пүнлүүг зогсоож дахин шалгах жил хүрүүлэн дараа удаа эс орвоос түшмэл эвдэнэ. Нас хөгшин, өвчтэйг нь түшмэл сүүлгахгүй гэрт илгээнэ гэх мэтээр зохицуулсан байна[14].

Яамдын дэс түшмэлээс доошхи түшмэдийг хууль ёсоор 3 жилд 1 удаа байцаан шалгаж дэвшүүлэх, буурруулах, тушаалд нь хэвээр байлгах зэргийг шалгаж тогтоохоор заажээ.

Монголын хаант улсын хуулиар түшмэлийн дагаж мөрдөх зүйл зөрчвөл авах арга хэмжээг нарийвчлан заасан. Жишээ нь: албаны хэргийн учир ял халдвал засгийн пүнлүү хасах, засгаас еөрчлөгдвөл пүнлүүний мөнгийг жил хувааж үл суут-гуулах, хулгай хийсэн тайж нарын харьяалах засгийн ялган салгаж пүнлүү хасах, аливаа ард хулган хийвэл тэднийг захирах тайж, сумын занги, отгийн даргыг ялган салгаж ес торгох, ес торгох малын тогтоосон тоо, ялд авсан малыг албанд хадгалж шагнахад бэлтгэх, жүжиг тавихыг цаазлах, нийслэл хүрээнд ирж харилцан заалдахыг хууль ёсоор хүндрүүлж ял торгох олон хэм хэмжээ тогтоожээ. (Түшмэлийн засаг, дөрөвдүгээр хэмээх хуульд үзнэ үү). Эдгээрээс заримыг сийрүүлбэл: Нэгэн зүйл, Аливаа харц, албат хуяг ардууд хулгайн хэрэг халдвал харьяат захирах тайж сумын занги отгийн даргыг хууль ёсоор ялган салгаж ес торго. Хэрэв тогтоосон малыг үнэхээр бүрэн тушаах хөрөнгө чинээгүй бол ес торгох тогтоосон хугацааны хууль ёсоор шийтгэхтүн гэжээ.

Энэ хууль нь Монголын автономийг устгаснаар үйлчилж чадаагүй

[13] *Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/* V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан нар. УБ., 2010 он. 64-65.

[14] Дээрх номын 64-65 дахь талаас дэлгэрүүлэн үзнэ үү.

юм[15].

1.2. 1921-1960 оны үеийн төрийн албаны хөгжлийн тойм

1921 оны Монголын үндэсний ардчилсан хувьсгалын дараахан үеэс тухайн цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн Ардын Засгийн газраас төв, орон нутагт төрийн аппаратын үндэс болох Ардын Хурлуудыг байгуулах арга хэмжээ авч энэ талаар Засгийн газрын төлөөлөгчдийн дүрэм[16], Улсын түр цагийн дүрэм, Ардын Засгийн газар ба Богд хоёрын хооронд байгуулсан Тангарагийн гэрээ, хууль цааз зохиох тухай тогтоол, Монгол Улсын Нутгийн захиргааны дүрэм, засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм[17] зэргийг баталж тэдгээрээр ардын хурлуудыг байгуулах ардчилсан журам, зохион байгуулалт үйл ажиллагааны зарчим, үүрэг зорилтыг тогтоож өгчээ.

1921 оны 7 дугаар сарын 23-нд Ардын Засгийн газраас гаргасан тогтоолд хааны эрхийг хязгаарлаж, эрх мэдлийг өөртөө төвлөрүүлсэн билээ.

Тангарагийн гэрээгээр "Богд хаан Жибзумдамба хутагт шарын шашны Богд ээзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдолгүй, шашны бүх хэргийг хязгааргүй эрхэлбэл зохино. Хууль дүрмийг Ардын Засгийн газраас үүсгэн зарлахад Богд хаанд сонсгон айлтгаж ёсоор явуулах тул энэ мэт хууль дүрмийг Богд хаантан үл зөвшөөрөх ба эвдэж үл болно"[18] хэмээн Ардын Засгийн газар, Богд хаан хоёрын харилцан үүрэг, хэм хэмжээг тогтоосон байна.

Үндсэн хууль батлахын өмнө Монгол Улс нь 1921-1924 онд "Монгол Ардын Түр Засгийн газрын дүрэм" (1921.04.23); "Засгийн хэргийг бүгд түр захиран шийтгэх газраас Монгол газраа суулгах төлөөний түшмэдийн дагаж явах дүрэм хэмжээ" (1921.04.28); "Монгол олон газар суулгах төлөөний түшмэдийн дагаж явах дүрэм буюу засгийн газрын төлөөлөгчийн дүрэм" (1921.06.03); "Засгийн газрын 11-р хурлын дүрэм"[19] (1921.07.11); "Улсын түр цагийн хурлын дүрэм" (1921.09.20); "Тангаргийн гэрээ дүрэм" (1921.11.01); "Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм" (1921.03.05); "Монголын засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм" (1922.03.22); "Засгийн

---

[15] И.Майский. Совеременная Монголия Иркутск. 1921 г. С.331.

[16] Засгийн газрын төлөөлөгч гэдэг нь Ардын Засгийн газраас тус засгийн гол бодлогыг олон харьяат газар оронд нэвтрүүлэн хэгжүүлэх ба дэлгэрүүлэн удирдах явдлыг чухал болгохын тулд тусгай төлөөлөгчдийг зохих газруудад хуваан суулгана. Төлөөлөгч суулгах газрыг тухай бүр засгийн газар хянан тогтооно.

[17] Арван гэрээс дээш баг, сум, хошуу, аймаг, улсын засгийн газар хүртэл тус тусын ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулан, элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхийн саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн хүндэтгэвэл зохино.

[18] БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхтгэл. Уб., 1972 он. Ардын Засгийн газар ба Богд хоерын хооронд байгуулсан Тангарагийн гэрээ. Дөрөвдүгээр зүйл.

[19] Энэхүү хурлын бичиг нь олон яамны албан хаагчдын цалин лангийн хэмжээг тогтоожээ.

газрын төлөөлөгчийн дүрэм[20]" (1922.09.20); "Монгол Улсын Нутгийн захиргааны дүрэм[21] (1923.03.22)"; "Аймгийн захиргааны дүрэм (1923.06.29)"; "Бүгд Найрамдах засаг тогтоон явуулах тухай Ардын Засгийн газрын тогтоол" (1924.06.13); "Монгол Улсын IIх Хурлын дүрэм" (1924.09.19) гэх зэрэг[22] Үндсэн хуулийн шинжтэй цөөнгүй дүрэм, тогтоол гарган төр улсаа төвхнүүлж анхны Үндсэн хуулиар Бүгд Найрамдах засгийг бэхжүүлэх хууль зүйн нөхцөл бүрдүүлсэн байдаг. Энэ бүхэн нийгэмд Үндсэн хуулийн шинэ ухамсар бүрэлдэхэд бодитой нөлөөлсөн нь мадаггүй билээ.

Ардын Засгийн газар хууль тогтоох, гүйцэтгэх засаглал тодийгүй, шүүн таслах эрхийг эдэлж байсан. Мөн Ардын Засгийн газар болон түүний анхны 5 яамыг байгуулснаар төрийн захиргааны төв байгууллагын тогтолцооны баттай эх суурь тавигдсан. Үүнд: Шүүх яам орон тоо 58, (ерөнхий, ял шийтгэх 2 хэлтэс); Дотоод явдлын яам орон тоо 40 (сургуулийн хэлтэс); Сангийн яам орон тоо 79 (цахилгаан гэрлийн хороо, гар тариаг, сангийн тариаг); Цэргийн яам орон тоо 116 (их буу засах газар, булигаарын завод); Гадаад яам орон тоо 35 (шуудан бичиг-цахилгаан, мэдээний ерөнхий хороо) газруудыг хариуцуулж, дээрх тоогоор ажиллуулахаар тогтжээ. Мөн яам, газрын албан хаагчдын цалин хэрэглэлийн дүрмийн ёсоор яамдын тэргүүн сайдад сар бүр 80 лан, эрхэлсэн түшмэдэд 65 лан, бичээчид 40 лан, зарлагад 30 лан зэргээр ажлын ачаалал, хүлээх хариуцлагыг харгалзан цалин тогтоосон байна.

Батлан хамгаалах, зэвсэгт хүчний байнгын Монгол Ардын хувьсгалт цэргийг байгуулсан. Мөн Дотоодыг хамгаалах газар,

---

[20] БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхтгэл. Уб., 1972 он. 60-62 дахь тал. Дүрмийн 1, 3 дугаар зүйлд зааснаар "Монгол Ардын Засгийн Газраас тус засгийн гол бодлогыг олон харьяат газар оронд нэвтрүүлэн нэгтгэх ба дэлгэрүүлэн удирдах явдлыг чухал болгохын тулд тусгай төлөөлөгчдийг зохих газруудад хуваан суулгана. Төлөөлөгчийг сонгон томилоход засгийн бодлогыг гүйцдээр ухуулан нэвтрүүлж чадах, уул газар орны хэв суртлыг боловсон мэдэх, олны санаанд үнэнээр нийлүүлэн чадах, эрдэм үзэл тэнцэх хүнийг эрхлэх газрын хуралд хэлэлцэн сонгон томилно" гэжээ. 4-14 дүгээр зүйлд эрх хэмжээг заажээ.

[21] БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхтгэл. Уб., 1972 он. 65-75 дахь тал. Нэгдүгээр дүгээр зүйлд: Бидний Монгол Улс нэгэнт ардын эрхт хэмжээт цаазат улсын засгийг байгуулсны тулд 10 гэрэгс дээш баг, сум, хошуу, аймаг, улсын засгийн газар хүртэл тус тусын ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулан, элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхийн саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн хүндэтгэвэл зохино. Гуравдугаар зүйл: Улсын ба аймаг, ... 10 гэрийн даргад хүртэл аливаа албан тушаалтан буюу тус бүрийн хурлын төлөөлөгчдийг сонгоход цөм эрх биш ард олны зовлон зүдгүүр нэвтэрхий мэдэх, олны тусыг бодох цэвэр шударга, бичиг үсэгт боловсролтой, өөр өөрийн оролдсон зүйлийг магадаар бүтээн чадах хүнийг сонговол зохино. 10 гэрийн дарга бичиг үсэгт боловсроогүй ч шударга хүн байх бол сонгож болно". Дөрөвдүгээр зүйлд: "Дээрх тушаалтан ба төлөөлөгчийг сонгоход харьяат хүрлын гишүүд дэмий ноед, ураг төрлийн нүүрчлэх ба ээлхэг харгисын сүрээс айх ба эд ашигт шунах зэргээр зусарч бялдуу, ховдог авлигач, хааш яйш хүнийг сонговол сонгосон сонгогдсон 2 этгээдийг хууль ёсоор хүндэд ялган уул тушаалын орыг өөр сонгуулна" гэжээ. Нэгэн тус бүрийн дүрмийг тусгажээ.

[22] Төрийн албаны харилцаанд холбогдох түүхэн эрх зүйн актыг Хавсралтаас үзнэ үү.

Сэргийлэх цэрэг нэртэйгээр шинэ төрийн цагдаагийн байгууллагын эх үндсийг тавьсан.

Монголын ард түмэн 1924 онд Улсын анхдугаар Их Хурал БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийг санал нэгтэй баталж **"Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс гэж Улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн улсын аливаа хэргийг Улсын Их Хурал ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино"**[23] гэж тунхагласан нь **Монголын шинэ эрх зүйн суурь, анхны гол хууль болсон юм.**

Энэхүү хуулиар:

- Шашин төрийг хослон барьсан хэмжээгүй эрхэт хаант засгаас ардын эрхэт хэмжээт цаазат хаант засаг, түүнээс Бүгд Найрамдах засагт дэвшин орсон нь төрийн байгууллын хувьд яах аргагүй нэн чухал дэвшил болсон;
- Монголын төрийн байгууллагуудын (Их, бага хурал, түүний Тэргүүлэгчид, Засгийн газар, яамд гэсэн) шинэ тогтолцоог бэхжүүлсэн;
- Монгол оронд анх удаа парламентат ёсыг хэрэгжүүлж УИХ, УБХ-ыг байгуулсан билээ[24]. Тус хуульд "БНМАУ-ын дээд эрхийг УИХ хадгалах бөгөөд, мөн хурлын чөлөөт цагт Улсын Бага Хуралд хадгалуулах, бас хурлын чөлөөт цагт Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино"[25] хэмээн төрийн эрх мэдлийг хуваарилсан байна.
- Монгол Улсын Засгийн газар нь бол гус улсын ерөнхийлөн захирах газар мөн бөгөөд гишүүд нь Ерөнхий сайд, жинхэнэ, орлогч

[23] *Монгол Улсын Үндсэн хууль. Баримт бичиг.* (2004) Эмхтгэх тайлбар бичсэн Амарсанаа Ж Батсайхан О., ред. Чимид Б. Төмөр С. УБ, 42.

[24] Болдбаатар Ж. Лундэжанцан (1998) Д. *Монголын төр, эрх зүйн түүхэн упамжлал* УБ., 229.

[25] *Монгол Улсын Үндсэн хууль* (2004) ЭмхтгэсэнАмарсанаа Ж нар. УБ., 44.

сайд, бүх цэргийн ба эдийн засгийн зөвлөлийн тэргүүлэгчид, бүх цэргийн жанжин, Улсын хянан байцаагч, Дотоод, гадаад, санхүү, аж үйлдвэр, шүүх, ардыг гэгээрүүлэх яамны сайдууд болно. Засгийн газар нь тус газрын эрхлэн шийтгэх зүйлүүдийн дүрэмд дурдсан аливаа хэргийг гүйцэтгэн явуулбал зохино[26].

• **Төрийн байгууламжийн нэгдмэл хэлбэрийг тогтоож, нутгийн захиргааны 5 шатат тогтолцооны (10 гэр, баг, сум, хошуу, аймгийн) үндсийг бэхжүүлсэн.**

Анхдугаар Үндсэн хуулийг залгамжилсан Үндсэн хуулийг 1940 оны 6 дугаар сарын 30-нд БНМАУ-ын Улсын ҮНС Их Хурал батлсан.

1940 оны Үндсэн хуульд оруулсан хамгийн том өмнөлт өөрчлөлт бол нийтийн биш, тэгш бус, олон шатат ил сонгуулийг нийт, шууд, тэгш эрхийн үндэслэл дээр саналаа нуугаар гаргах сонгуулийн шинэ зарчмыг тунхаглаж төрийн төв, орон нутгийн байгууллагын тогтолцоог дорвитой өөрчилсөн заалт юм. Үндсэн хуульд Улсын IX Их Хурлаас оруулсан өнөхүү нэмэлт, өөрчлөлтөөр анх 95 зүйлтэй Үндсэн хууль 108 зүйлтэй болж томорсон бөгөөд хэдийгээр нэг намын залуураар хэлбэрдэлд орсон ч гэсэн сонгуулийн ардчилсан зарчмын үзэл санааг Монголд нэвтрүүлсэн ач холбогдолтойг тэмдэглэх нь зүйтэй болов уу[27].

1940 оны Үндсэн хуулийн зорилго, төр-нийгмийн байгууллын үндсэн зарчмын хувьд социалист маягийн хууль мөн. Үүнийг дараахь нийтлэг шинж буюу шалгуураар нотлон харуулж болно.

Нэгдүгээрт: Үндсэн хуулиар тогтоосон үндсэн зарчим:

1) Нийгэм журам байгуулах, социализмын бүрэн ялалтыг хангах гэсэн агуулгатай);

2) засаг төрийн нийгэмшлийн үндэс нь малчин, ажилчин, оюутан (сэхээтэн);

5) "улс нийгмийн бүх байгууллагыг удирдах гол хүч нь МАХН мөн";

6) төрийн эрх барих ба захиргааны байгууллага нь дээрээс доош төвлөн захирч, доороос дээш ажлаа хариуцан тайлагнадаг бөгөөд бүхэлдээ нам, АИХ-д хянагдах 4-5 дэд тогтолцооноос бүрдсэн;

7) орон нутаг нь мөн дан ганц төрийн удирдлагатай;

8) Үндсэн хууль болон нийтийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагаа шүүхийн хяналтаас гадуур үлдсэн зэргийг дурдаж болно.

1949 он хүртэл бүгд 9 удаа хуралдсан Улсын Их Хурал; түүнийг чөлөөт цагт Улсын Бага Хурал; түүний чөлөөт цагт Бага Хурлын тэргүүлэгчид; 1949 (51). 1932-1956–Ардын Сайд нарын Зөвлөл; 1956-1990 онд –Сайд нарын Зөвлөл (СнЗ) хэмээн нэршиж байв.

[26] *Монгол Улсын үндсэн хууль.* (2004) Эмхтгэсэн Амарсанаа Ж нар. Уб., 46.

[27] Монгол Улсын Үндсэн хууль (2004) (баримт бичгийн эмхтгэл. Ж.Амарсанаа, О.Батсайхан) Уб., 16.

1940 оны 6 дугаар сарын 30-нд шинэчлэн баталсан БНМАУ-ын Үндсэн хуулийн 95 дугаар зүйлд **МАХН-ыг «...Улс нийгмийн бүх байгууллагыг удирдах гол хүчин болох»**-ыг бататган заажээ. Энэ нь Монгол Улсад нэг намын (монополь) онц эрхийг хуульчлан тогтоосон хэрэг байв[28].

1949 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тогтоосон социалист маягийн сонгуулийн тогтолцооны ёсоор Ардын Их Хурлын ээлжит сонгуулийг 1951-1986 онд нийтдээ 11 удаа явуулжээ. Энд «Эрх баригч» нам ба нам бусчуудын эвслээс нэг тойрогт зөвхөн нэг хүний нэр дэвшүүлж (өрсөлдөгчгүй) сонгох журамтай байв.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал болон 1921 оны хувьсгалын өмнөх Монголд гүйцэтгэх засгаас тусдаа шүүх үндсэндээ байгаагүй. 1921-1926 онд Ардын засгийн шүүх явдлын яам, 1923 оноос хошуудын Тамгын газрын зарга шийтгэх хэлтэс шүүн таслах ажил эрхэлж байв. Иймд анхны Үндсэн хуульд шүүхийн тухай заалт байхгүй. Шүүх анх Улсын II Их Хурлаас 1925 онд баталсан тогтоол дүрмийн дагуу 1926-1927 оны заагаар байгуулагдаж эхэлсэн. Тэр үеэс л нам, засгийн хяналтад, Шүүх явдлын (одоогийн хууль зүйн) яамны удирдлагад ажиллаж эхэлсэн. 1930-аад онд УДШ, УПГ хоёр шүүх яамны хоёр газрын статустай байв[29].

1940 оны Үндсэн хуульд БНМАУ-д шүүн таслах ажлыг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж заасан боловч их хэлмэгдүүлэлтийн үед Онц бүрэн эрхт комисс зэрэг шүүхийн бус байгууллага уг үүргийг гүйцэтгэж байсан үе бий. Ардчилалд шилжихийн өмнөх үеэс өгүүлбэл 1960 оны Үндсэн хуульд зааснаар шүүхүүд бүх үйл ажиллагаандаа өнгөндөө ардчилсан зарчмууд баримталж байсан мэт боловч захиргаадлын зэвсэг болж байсан ба шүүхүүд сонгуулиар зохих хурал ба иргэдээс байгуулагдах зарчимтай[30] байв.

Өмнөх тогтолцооны үед Улсын дээд, түгэй, аймаг, хотын болон хэсгийн (дүүргийн) шүүх гэсэн нэгдмэл "босоо" тогтолцоо, бүхэлдээ намын хяналт, Ардын Их Хурал, Засгийн газрын нөлөөнд оршин ажиллаж байв.[31]

Прокурорын газрууд анх зохих шүүхийн дэргэд, Шүүх яамны харъяанд 1930 онд үүсээд 1940 оноос бие дааж, нам, төрийн өмнөөс бүх байгууллага, албан тушаалтан, нийт иргэний үйл ажиллагаанд хяналт тавьдаг болсон. Хожим шүүхийг хүртэл хянаж, хэрэг зөрчилтэй тэмцэх талаар зохицуулдаг, төрийн байгууллагын бие даасан тогтолцоо болсон байна.

---

[28] БНМАУ-ын Үндсэн хууль. 1940 он, 95 дугаар зүйл.

[29] Чимид Б. нар. (2010) *Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн тойм* УБ., 40.

[30] БНМАУ-ын Үндсэн хууль. 66, 67, 68 дугаар зүйл. 1960 он. Ж.Амарсанаа, О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль. Баримт бичиг. УБ., 259..

[31] Чимид Б. (2004) *Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл (хоёрдугаар дэвтэр).* УБ, 118-123.

Төрийн эрх мэдлийг 3 салаанд хуваарилах шинэ тогтолцоонд шилжсэн хийгээд иргэдээ эх адаггүй хянах захиргаадлын дэглэмийг халсантай уялдуулан прокурорын хяналтын хүрээг ихэд хязгаарлаж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох болгон шинэчилсэн юм.

1940 оны Үндсэн хуульд "Бүх аамд ба төв, орон нутгийн албан байгууллагууд хийгээд тэдгээрийн харьяа газрууд, мөн албан тушаалын хүмүүс ба ард нийтээс хууль цаазыг нарийвчлан биелүүлж байгаа явдлыг байцаан хянах үүргийг Улсын прокурор (хууль сахиулагч) гүйцэтгэнэ" гэж заасан байв. Тэр үеэс өмнөх тогтолцооны турш (1990-ээд он хүртэл) прокурор одоогийн Үндсэн хуульд заасантай төстэй үүргээс гадна бусад дээр дурдсан "Ерөнхий хяналт" нэрийн дор төр, олон нийт, хоршоолол, аж ахуйн бүх байгууллага, албан газар, тэдгээрийн албан тушаалтан төдийгүй, нийт иргэний үйл ажиллагаанд хууль ёсыг хэрхэн биелүүлж буйг хянах бүхнийг хамарсан чиг үүргийг хэрэгжүүлэх болжээ[12].

1.3. 1960-1992 оны шилжилтийн үе дэх төрийн албаны хөгжлийн тойм

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо:

БНМАУ-ын Үндсэн хуулиар хуульчлан бэхжүүлсэн ёсоор энэхүү систем нь

а) төрийн захиргааны дээд байгууллага;

б) төрийн захиргааны төв байгууллага;

в) төрийн захиргааны орон нутгийн байгууллагууд гэсэн гурван хэсгээс бүрэлдэнэ.

Төрийн захиргааны дээд байгууллага нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл байсан бөгөөд СнЗ-ийн шууд удирдлаганд улс орны хэмжээнд төрийн удирдлагын зохих салбар хүрээнд гүйцэтгэн захирамжлах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байгууллагуудыг төрийн захиргааны төв байгууллага гэдэг байв. Төрийн захиргааны төв байгууллагын тогтолцоонд БНМАУ-ын яам, улсын хороод, СнЗ-ийн дэргэдэх тусгай газрууд орж байв. 1960 оны Үндсэн хуулиар "Улсын яам, хороо, тусгай газрууд бол БНМАУ-ын төрийн захиргааны төв байгууллага мөн" гэж заажээ. Эдгээр байгууллага нь СнЗ-ийн удирдлаган дор тус тусын эрх хэмжээний дагуу улсын хэмжээнд гүйцэтгэн захирамжлах ажиллагааг хэрэгжүүлдэгээрээ төв байгууллагын нийтлэг шинжийг агуулах боловч эрх зүйн салбарын хувьд зохих ялгаа онцлогтой байна.

Тэдгээрийг ажиллах салбар, хүрээ, эдлэх эрх хэмжээ, үйл ажиллагааны онцлогоор нь:

а) яам;

б) Улсын хороо;

[12] Чимид Б нар (2010) *Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн тойм* Уб., 41.

в) Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх тусгай газар гэсэн 3 төрөл хуваагдаж байв.

БНМАУ-ын төрийн захиргааны дээд, төв байгууллага:

БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн гуравдугаар бүлэг "Төрийн эрхийг барих дээд байгууллагууд" гэсэн бүлэгт А.БНМАУ-ын Ардын Их Хурал. Арван наймдугаар зүйлд "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал мөн". БНМАУ-ын Ардын Их Хурлын Байнгын комисс, Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөл, БНМАУ-ын дээд шүүх, Ардын Их Хурлын депутатууд нь хуулийн төсөл санаачлах эрх хэмжээтэй байжээ. Мөн хуулийн гучин долдугаар зүйлд зааснаар: БНМАУ-ын төрийн гүйцэтгэн захирах дээд байгууллага бол БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл мөн хэмээн тодорхойлон зааж өгчээ.

Сайд нарын Зөвлөл нь дагаж шийдвэрлэж байгаа хуулиудыг үндэслэж, тэдгээрийг биелүүлэхийн тулд тогтоол, захирамж гаргаж гүйцэтгэлийг шалгана. (Гучин наймдугаар зүйл)

БНМАУ-ын тусгай газрын эрх баригчид төрийн захиргааны зохих салаа мөчрийн ажил төрлийг удирдаж тэдгээрийн байдал үйл ажиллагааны талаар Сайд нарын Зөвлөлийн өмнө бүрэн хариуцна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл (Засгийн газар)[13] төрийн захиргааны дээд байгууллага юм. Сайд нарын Зөвлөл гагцхүү БНМАУ-ын Ардын Их Хурал, түүний Тэргүүлэгчидэд ажлаа хариуцаж тэдгээрийн хууль, зарлигийг биелүүлэх үндсэн дээр төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагыг нэгтгэн удирдах замаар улс орныхоо хэмжээнд төрийн гүйцэтгэн захирамжлах үйл ажиллагааг эрхэлдэг байна. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд "БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл бол БНМАУ-ын төрийн гүйцэтгэн захирах дээд байгууллага мөн" гэж заажээ. 1960 оны Үндсэн хуульд заасан ёсоор Сайд нарын Зөвлөлийг БНМАУ-ын Ардын Их Хурлын ээлжит сонгууль бүрийн анхдугаар чуулганаас мөн Их Хурлын бүрэн эрхийн (5 жилийн) хугацаагаар байгуулдаг. Сайд нарын Зөвлөл нь бүрэн эрхийнхээ хугацаа дуусмагц БНМАУ-ын Ардын Их Хуралд ээлжит сонгууль бүрийн анхдугаар чуулган дээр шилжүүлж мөн хугацаанд явуулсан үйл ажиллагааг хэлэлцүүлэн дүгнүүлдэг байна.

[13] БНМАУ-ын Засгийн газар нь ардын хувьсгал ялахын өмнө бүюу 1921 оны 3 дугаар сарын 13-нд байгуулагдсан "Монголын Ардын Засгийн Хэргийг Байцаах ба Түр Ерөнхийлөн Захирах газар" буюу Монгол Ардын Түр Засгийн газраас үүссэн түүхтэй. Ардын хувьсгал ялмагц 1921 оны 7 дугаар сарын 16-нд "Түр" гэсэн үгийг хаяж "Ардын Засгийн газар" 1924 онд батлагдсан анхдугаар Үндсэн хуулиар "БНМАУ-ын Засгийн газар" гэж тус нэрлэсэн байна. 1932 оны 7 дугаар сард болсон БНМАУ-ын 17 дугаар онц Бага Хурлаас тус улсын төрийн захиргааны төв байгуулпагын системийг өөрчлөхийн хамт Засгийн газрыг Сайд нарын Зөвлөл гэж нэрлэжээ. Хожим 1992 оны шинэ Үндсэн хуулиар төрийн гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар хэрэгжүүлэхээр болсон билээ. Өөрөөр хэлбэл хуучин Сайд нарын Зөвлөлийн эрхлэх асуудал шинэ Үндсэн хуулиар Засгийн газарт шилжсэн билээ.

Сайд нарын Зөвлөл ажлынхаа тухай Ардын Их Хуралд тогтмол тайлагнахын хамт түүний чуулганы чөлөө цагт Ардын Их Хурлын Тэргүүлэгчдэд хариуцан тайлагнадаг байна. Энэхүү зохицуулалт нь өнөөгийн Үндсэн хуулийн (1992 он) 38 дугаар зүйл 38.1-д Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн, 41 дүгээр зүйл 41.2-д Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана, гэж заасантай зохицуулалтын хувьд ижил юм. Сайд нарын Зөвлөлийн ажлын албыг Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга толгойлох бөгөөд тэр нь Сайд нарын Зөвлөлийн гишүүн байна.

Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг Ардын Их Хурал, уг бүрэлдэхүүнд ордог албан тушаалтныг чөлөөлөх, нөхөн томилох асуудлыг Ардын Их Хурлын Тэргүүлэгчид дараа чуулганд оруулан батлуулахаар тус тус шийдвэрлэнэ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнд Сайд нарын Зөвлөлийн дарга, нэгдүгээр орлогч дарга, орлогч дарга, БНМАУ-ын сайд, Улсын хорооны дарга нар орно.

БНМАУ-ын яамд:

Улсын яамд, тусгай газруud бол БНМАУ-ын төрийн захиргааны төв байгууллага мөн. (Үндсэн хууль 1960 он Дөчин гуравдугаар зүйл)

1988 оны байдлаар л гэхэд 17 яам Тухайлбал: Ардын боловсролын, Батлан хамгаалах, Байгаль хамгаалах, Гадаад явдлын, Нийгмийг аюулаас хамгаалах, Нийтийн аж ахуй, үйлчилгээний, Сангийн, Соёлын, Тээврийн, Холбооны, Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн, Хөвгөн үйлдвэрийн, Худалдаа бэлтгэлийн, Шүүх, Эдийн засгийн, Гадаад харилцаа, хангамжийн, Эрүүлийг хамгаалах, Эрчим хүч, уул уурхайн үйлдвэр, геологийн яам зэрэг ажиллаж байжээ. Яамдыг Сайд нарын Зөвлөлөөс өргөн мэдүүлснээр БНМАУ-ын Ардын Их Хурал, түүний чуулганы чөлөө цагт Ардын Их Хурлын Тэргүүлэгчид байгуулж, татан буулгана. Яамны сайдыг Сайд нарын Зөвлөлийн даргын өргөн мэдүүлснээр БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчид томилж, мөн журмаар албан тушаалаас өөрчилдөг байна.

Яамны эрх зүйн байдал

БНМАУ-ын Үндсэн ба холбогдох бусад хууль, тэдгээрт нийцүүлэн Сайд нарын Зөвлөлөөс баталсан тус тусын дүрэм тухайлбал: Сангийн яам БНМАУ-ын СнЗ-ийн 1960 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 449 дүгээр тогтоолоор, 1983 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 341 дүгээр Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Гадаад явдлын яамны дүрэм, 1968 Сангийн яамны дүрмийг баталсан гэх мэт. Мөн тухайн яаманд эрх олгож үүрэг ногдуулан гарсан тогтоол, дүрэм, заавар зэрэг байна.

1960 оны Үндсэн хуульд зааснаар "БНМАУ-ын яамд, тусгай газруудын үйл ажиллагаа нь нэгдмэл захирамжийн зарчим асуудлыг хамарч хэлэлцэх зарчмыг тууштай хэрэгжүүлэх үндсэн дээр зохион байгуулагдана гэж заажээ. Энэ дагуу яамны үйл ажиллагаа нь хамтын удирдлагын зохих арга, хэлбэрийг захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр тогтоон хэрэгжүүлдэг байв. Яамны үйл ажиллагаанд нэгдмэл захирамжийг хамтын удирдлагатай хослуулах зохион байгуулалтын гол хэлбэр нь яамны коллеги юм. Түүний эрх зүйн үндэс, үйл ажиллагааны журмыг Сайд нарын Зөвлөлөөс 1962 онд баталсан БНМАУ-ын яамдын коллегийн дүрмээр тодорхойлжээ. Яамдын коллегийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор тус бүр 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Коллегийн бүрэлдэхүүнд яамны сайд (коллегийн дарга) орлогч сайд нар бусад хариуцлагатан болон харьяа газар байгууллагын эрх бүрэгчдаас оруулж, хүн бүрийг яамны сайдын танилцуулан тодорхойлсноор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл батална.[24]

Улсын хороо, түүнтэй адилсах төрийн албан газрууд

Улсын хороо бол БНМАУ-ын Ардын Их Хурлаас байгуулагдан төрийн удирдлагын тусгай асуудлаар буюу нэг төрлийн чиг үүргээр нийт салбарын үйл ажиллагааг уялдуулан холбож, хянан зохицуулдаг салбар хоорондын эрх хэмжээтэй, хамтын удирдлага бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. Харин 2004 оны Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д зааснаар Яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн" гэж заасан бөгөөд эндээс авч үзвэл төрийн захиргааны төв байгууллага гэдэгт тухайлсан асуудлаарх салбарын яамдууд орж байна. Улсын хороо хэмээх эдгээр төрийн захиргааны төв байгууллага нь эрх зүйн байдлын хувьд төрийн удирдлагын зохих хүрээнд салбар хоорондын зохицуулах чиг үүргийг эрхлэн хэрэгжүүлдэгт оршино.

Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх тусгай газрууд

Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх тусгай газар бол БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар Сайд нарын Зөвлөлөөс байгуулагдаж, түүнээс томилогдсон дарга толгойлж, улсын хэмжээнд гүйцэтгэн захирах ажиллагаа явуулдаг төрийн захиргааны төв байгууллага мөн. 1988 оны байдлаар л гэхэд ийм тусгай газарт БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Авто замын ерөнхий газар, Иргэний агаарын тээврийг удирдах ерөнхий газар, Улсын Арбитрын газар, Хэвлэл утга зохиолыг хянах ерөнхий газар, Улсын стандартын газар, Шашны хэрэг эрхлэх зөвлөл зэрэг тусгай газар

[24] БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн коллегийн дүрэм 1962 он 2 дугаар зүйл

ажиллаж байсан байна.[35]

Тусгай газрын үндсэн эрх хэмжээ нь хууль тогтоомж болон Сайд нарын Зөвлөлөөс баталсан тус тусын дүрмээр тогтоогдоно. Тусгай газар эрх хэмжээнийхээ шинжээр а) салбарыг удирдах, б) салбар хоорондын гэсэн хоёр янз байдаг. Жишээ нь: БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Авто замын ерөнхий газар нь салбарын эрх хэмжээтэй байгууллага юм.

БНМАУ-ын Шүүх

БНМАУ-ын шүүхийн байгууллага бол төрийн байгууллагын бүрэлдэхүүн хэсэг юм. Шүүх байгууллага нь БНМАУ-ын Иргэний хуулиар заасан иргэний хэрэг, БНМАУ-ын БНМАУ-ын эрүүгийн хуулиар заасан эрүүгийн холбогдолтой гэмт хэргийг хянан үзэж шийдвэрлэдэг юм.[36] БНМАУ-д шүүн таслах ажлыг БНМАУ-ын дээд шүүх, тусгай шүүх, аймаг, хотын шүүх, түүнчлэн нүүдлийн болон районы шүүх, гүйцэтгэж байв. БНМАУ-ын дээд шүүх нь: Дээд шүүхийн бүгд хурал, Дээд шүүхийн тэргүүлэгчид, Улсын дээд шүүхийн эрүүгийн хэрэг эрхэлсэн коллеги, Улсын дээд шүүхийн иргэний хэрэг эрхэлсэн коллеги зэрэг дотоод аппаратыг байгуулан ажил хэргээ явуулж байв. Улсын дээд шүүхийн бүгд хурал нь БНМАУ-ын Ардын Их Хуралд оруулахаар дээд шүүхээс санаачилсан хуулийн төсөл болон Ардын Их Хурлын Тэргүүлэгдэд оруулах саналыг нягтлан хэлэлцэнэ.[37]

Улсын дээд шүүхийн эрүү, иргэний хэрэг эрхэлсэн коллеги нь тус бүр дарга, гишүүдээс бүрдэнэ. Коллеги бүр нь БНМАУ-ын эрүүгийн болон иргэний байцаан шийтгэх хуулиар өөртөө шууд харьяалуулсан хэргийг анхан шатны журмаар таслан шийдвэрлэхээс гадна мөн аймаг, хотын ба тусгай шүүхээс таслан шийдвэрлэсэн харьяаллын хэргийн хүчин төгөлдөр болоогүй тогтоол, шийдвэр магадлалыг давж заалдсан гомдол эсэргүүцлийн үндсэн дээр II шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Түүнчлэн орон нутгийн шүүхийн шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлалд хяналтын журмаар бичигдсэн эсэргүүцлийн үндсэн дээр эрүү, иргэний хэргийг II шатны журмаар хянаж зохих шийдвэр гаргадаг байна. БНМАУ-ын дээд шүүхийн тэргүүлэгчид нь тус улсын бүх шүүхийн зохион байгуулалтын ажлыг удирдах төв байгууллага юм. Улсын дээд шүүхийн хамтын удирдлагын байгууллага болох тэргүүлэгчдийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газраас батална. Түүнчлэн улсын дээд шүүхэд шүүхийн зохион байгуулалтын өдөр тутмын ажлыг удирдах шүүхийн байгуулалтын хэлтэс ажиллана.

[35] Чимид.Б (1988) *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын захиргааны эрх зүй /ерөнхий анги/* УБ., 148.

[36] Авирмэд. Э (1969) *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрх* УБ., 290.

[37] Энэ нь өнөөгийн эрх зүйн зохицуулалтын үүднээс харвал өөр зохицууллалттай байв.

Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1962 оны 262 дугаар зарлигаар БНМАУ-ын дээд шүүхийн тэргүүлэгчдийг байгуулсан бөгөөд мөн дээд шүүхийн зохион байгуулалтын ажлыг эрхлэх шүүхийн байгууллагын хэлтсийг байгуулжээ. Тэр үеийн шүүхийн зохион байгуулалтын системийн нэг онцлог нь БНМАУ-ын бүх шатны шүүхийг сонгуулиар байгуулдаг оршиж байв. БНМАУ-ын Ардын Их Хурлаас БНМАУ-ын дээд шүүхийг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс тусгай (цэргийн) шүүхийг хуульд заасан хугацаагаар тус тус сонгоно. Аймаг, хотын шүүхийн шүүгч, ардын төлөөлөгчдийг аймаг, хотын ардын депутатуудын хурал, мөн аймгийн нүүдлийн шүүхийн шүүгчийг аймгийн ардын депутатуудын хурлын чуулганаас 3 жилийн хугацаагаар сонгодог юм. Харин районы шүүхийн шүүгчийг тухайн районы ардын депутатуудын хурлын чуулганаас 3 жилийн хугацаагаар сонгоно. Нүүдлийн болон районы шүүхийн ардын төлөөлөгчдийг тухайн нүүдлийн шүүхийн ажиллах сум ба районы хөдөлмөрчдийн хурлаас маная сонгуулийн системийн зарчмыг үндэслэн мөн 3 жилийн хугацаагаар ил сонгодог байна. Шүүгчид 23 нас хүрсэн иргэнийг сонгодог байв. Шүүгчид болон ардын төлөөлөгчид нь өөрий нь сонгосон хөдөлмөрчид ба ардын депутатуудын хуралд хийсэн ажлынхаа талаар тайлагнаж байжээ. Энэ нь өнөөгийн өнцгөөс шүүхийн бие даасан хараат бус байх зарчим хэрхэн хэрэгжиж байв гэдэг нь эргэлзээнд хүргэж байгаа.

БНМАУ-ын прокурор

1930 онд БНМАУ-ын шүүх явдлын яаманд прокурорын хяналтын ажил эрхэлсэн орлогч сайд, орон нутагт аймаг, хотын прокурорын орон тоог баталжээ. Мөн оны 7 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын 42 дугаар тогтоол, 8 дугаар сарын 14-ний өдрийн Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор "Прокурорын дүрэм"-ийг баталсан бөгөөд энэ өдрийг улсын прокурорын байгууллага байгуулагдсан өдөр гэж үздэг юм. Өнөөдөр прокурорын байгууллагын 80 жилийн ой тохиож буй юм. Төрийн байгууллалагын салшгүй нэг хэсэг бол прокурорын байгууллага юм. БНМАУ-ын Үндсэн хуульд прокурорын байгуулагын үүрэг зорилт зохион байгуулалтын зарчмыг заажээ. 1960 оны Үндсэн хуулийн 72 дугаар зүйлд БНМАУ-ын бүх яам, төв байгууллагууд, тэдгээрийн харьяа албан газар, байгууллага, орон нутгийн засаг захиргааны болон олон нийтийн хоршооллын бүх байгууллага мөн албан тушаалтан ард иргэдээс хуулийг хэрхэн нарийн чанд биелүүлж байгааг нэгэн адил хянах дээд хяналтыг улсын прокурор гүйцэтгэнэ. Төрийн байгуулалтын дотроос хамгийн нэгдмэл удирдлагатай байгууллагын нэг нь БНМАУ-ын прокурорын газар байв. Өөрөөр хэлбэл дээд шатны прокурорт доод шатны прокурор нь

шууд захирагдах хатуу төвлөрсөн нэгдмэл системтэй юм.

БНМАУ-ын прокурорыг Ардын Их Хурлаас хуульд заасан хугацаагаар томилдог. АЙмаг, хот, хэсгийн болон районы прокурорыг улсын прокуроос 3 жилийн хугацаагаар томилно. Өөрөөр хэлбэл төрийн албаны томилолтын систем шууд хэрэгждэг байгууллагын нэг нь байв. Улсын прокурор нь нэгдмэл удирдлагатайн зэрэгцээ бас хамтын удирдлагын системийг хослон хэрэглэж байв. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 144 дүгээр зарлигаар улсын прокурорын газрын дэргэдэх зөвлөх эрхтэй байгууллага коллегийг байгуулжээ. БНМАУ-ын прокурорын газрын коллегийн гишүүдийг улсын прокурорын саналаар БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдээс баталдаг байв. Мөн Улсын прокурорын төв аппаратын зохион байгуулалтыг БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдээс баталж байв. Энэ нь прокурорын байгууллагад нэгдмэл төвлөрсөн удирдалагатайн дээр хамтын удирдлага хэрэгжиж байсны жишээ юм. Тухайн үеийн прокурорын байгууллага, прокурорын эрх хэмжээний өөр нэг онцлог шинж бол БНМАУ-ын дээд шүүхийн бүгд хуралд улсын ерөнхий прокурор буюу түүний орлогчийн аль нэг нь сууж өөрийн санал дүгнэлт өгөх замаар хяналтыг явуулах, хэрэв дээд шүүхийн бүгд хурлын тогтоол хууль зөрчсөн байвал БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газарт мэдэгдэл бичих зэргээр өөрийн хяналтыг шүүх ажиллагаанд тавьж байжээ.

Төрийн албан хаагчийг сонгох, томилох, огцруулах

арга зам эрх зүйн зохицуулалт

"1960-1992 оны хоорондох төрийн алба нь үндсэндээ Марксист-ленинист онолын үндэслэлтэй зарчмуудад тулгуурлаж байдгаараа феодал, хөрөнгөтний төрийн албаны шууд эсрэг мөн чанартай юм. Гэж доктор, профессор Б.Чимид БНМАУ-ын захиргааны эрх зүй (ерөнхий анги) УБ., 1988 он. 209- дэх талд бичжээ. Энэдээс харахад эл хугцааны төрийн албаны хөгжил нь үндсэндээ социалист ёсыг эрхмэлсэн төвлөрсөн удирдлага бүхий тогтолцоонд тулгуурлан төрийн албаны хөгжил явагдаж ирсэн юм.

Албан тушаалд иргэдийг авах журмыг БНМАУ-ын Үндсэн хууль, Хөдөлмөрийн хууль, тэдгээрт үндэслэн бусад хэм хэмжээгээр тогтоосон байдаг. Төрийн албанд иргэдийг авч ажлуулах үндсэн нөхцөл нь сонгох, томилох хоёр юм.

1.Сонгох журмыг зарим удирдах албан тушаалд хүмүүсийг авч ажиллуулахад хэрэглэнэ. Албан тушаалд хүмүүсийг а)хөдөлмөрчдөөс шууд сонгох б)төлөөлөгчдийн байгууллагаас сонгох в)хамт олноос сонгох хэлбэртэй байжээ. Тухайлбал депутат болон ардын шүүгчдийг

хөдөлмөрчдөөс БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн удирдах бүрэлдэхүүн (дарга, орлогч, нарийн бичгийн дарга) АДХ-ын гүйцэтгэх захиргааны удирдах бүрэлдэхүүн, Улсын Дээд Тусгай болон аймаг, хотын шүүхийн шүүх бүрэлдэхүүнийг төрийн эрх барих зохих шатны байгууллагаас, Шинжлэх ухааны академийн удирдах бүрэлдэхүүн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга, их дээд сургуулийн факультетийн декан зэрэг албан тушаалд хүмүүсийг Академийн бүх гишүүдийн хурал, факультетийн зөвлөлийн хурлаас сонгох журам байсан.[38]

Төрийн эрх барих орон нутгийн хурлууд, Улсын Их Хурлыг 4 жил, аймаг, хотын хурлыг 3 жил, сум, баг, хороо, хорины хурлыг 3 жил, ардын хэсгийн шүүх, аймаг хотын шүүхийг 3 жил, Улсын Дээд шүүхийг 4 жилийн хугацаагаар сонгох эрх зүйн зохицулалтай байв.

2. Томилох журмаар төрийн албан тушаалд авах

Энэ үеийн улс төр, нийгмийн хөгжлийн онцлогтой уялдан төрийн алба хаагчийг томилох журмаар албан тушаалд авдаг байна. Албан тушаалд томилох нь албан томилолтоос ялгаатай юм. Албан томилолт гэж албан хаагчийг тогтмол ажилладаг газраас нь өөр газарт албан үүрэг гүйцэтгүүлэхээр үйлдвэр, албан газар, байгууллагын удирдлагын шийдвэрээр түр хугацаагаар явуулж ажлуулахыг хэлдэг. Харин томилох журам нь боловсон хүчний (хүний нөөцийн) асуудлыг шуурхай шийдэж шаардлагатай газарт хуваарилж ажлуулахад сайн талтай боловч тухайн аппратыг бүрдүүлэхэд олон нийтийн оролцооны асуудлыг үгүйсгэлэг дээрээс төлөвлөсөн шаталсан босоо удирдлагын тогтолцоог дэмждэгээрээ сул талтай юм.

Сайд нарын Зөвлөлийн тогтоол, шийдвэрээр яамдын орлогч сайд, тусгай газрын дарга, орлогч нарыг тушаалаар томилдог байв. Томилолтын эдгээр акт нь улсын байгууллага ба албан хаагчид хоёрын хоорондын эрхийн харьцаг бий болгох гол үндэс нь байв.[39]

3. Ураладант шалгалтын журам

Төрийн албанд мэргэжилтэй боловсон хүчнийг сайтар шалгаруулж авах илүү боломж олгодог бөгөөд эл журмыг 1970-аад оноос л нэвтрүүлж эхэлжээ. Тухайн албан тушаалд тавигдах үндсэн шаардлагуудыг тусгасан тодорхой болзол, журам тогтоож түүний үндсэн дээр урьдаас өргөн олон нийтэд зарлаж тухайн албан тушаалд ажиллахыг сонирхогчдоос сорилт шалгалт авч, дүнг хамтын журмаар хэлэлцэж шалгарсан хүн бүр дээр нууц санал хураалт явуулж олонхын санал авсан тухайн албан тушаалд баталж авдаг нь энэ журмын гол онцлог

[38] БНМАУ-ын Үндсэн хууль 1960.20.д. 52, 66, 68 дугаар зүйл, БНМАУ-ын Шүүхийн байгуулалмжийн хууль 78, 35 дугаар зүйл, БНМАУ-ын дээд сургуулийн дүрэм, 1974, 28 БНМАУ-ын ШУ-ны Академийн дүрэм, 1974 37-р зүйлд тус тус заасан.

[39] Баатар С. (1958-3) БНМАУ-ын төрийн алба // Төр эрхийн асуудал сэтгүүл.27.

юм. Уралдаант шалгалтаар ажилд ороход уг албан тушаалыг гүйцэтгэх бүрэн эрхийн хугацаатай байхаар зохицуулжээ. Хугацаа дуусмагч дахин болзолт шалгалт авах зохицуулалттай байв. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс баталсан дүрмийн ёсоор нам, улсын хороо, тусгай газар, аймаг, хотын гүйцэтгэх захиргаанаас баталсан жагсаалтад заасан дээд тусгай дунд боловсролтой мэргэжилтэн түүнчлэн мэргэжилгүй боловч зохих мэргэжлийн албан тушаалд ажиллаж байгаа хүмүүсийг 3-5 жилд 1 удаа аттестатчилдаг байжээ. Захиргаа, нам, олон нийтийн байгууллагын төлөөлөгчдөөс бүрдэх, аттестатчиллын комисс тухайн ажилтныг албан тушаалд үргэлжүүлэн ажиллуулах эсэхийг тогтс шийдвэрлэхгүй боловч түүний улс төр, ажил хэргийн хувийн чанар, ажил мэргэжлийн өсөлт үр дүнгээр нь зохих болзлын дагуу шалгаж а)албан тушаалд тэнцэх, б)нилэрсэн дутагдлыг арилгаад ажлаа сайжруулбал тэнцэх, в) ул тэнцэх зэргийг тодорхойлдог байна. Комисс нь өндөр амжилт гаргасан ажилтныг дэвшүүлэх, ажлаа сайжруулах зэрэг зөвлөмж гаргадаг байна. Өнөөдрийн хувьд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд энэ туахй заасан бөгөөд тухайлбал 17.1-д Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө. Өөрөөр хэлбэл одоогийн зохицуулалтын онцлог бол төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах замаар бүрдүүлдэг болсон бililээ.

4.Огцруулах журмын тухайд:

"БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат сонгогчдоосоо хүлээлгэсэн итгэмжийг хөсөрдүүлж, депутатын нэр алдарт харш явдал гаргавал түүнийг сонгосон сонгуулийн тойргийн сонгогчдын олонхийн шийдвэрээр хэзээ ч огцруулж болно." гэж БНМАУ-ын Ардын Их Хурлын Депутатыг огцруулах журмын тухай хуульд[10] заажээ. Өөрөөр хэлбэл төрд төлөөлж буй түшээгээ эгүүлэн татах эрхийг сонгогчдод олгосон заалт байжээ. Мөн орон нутгийн буюу БНМАУ-ын аймаг, хот, сум хороодын Ардын депутатуудын хурлын депутатуудыг огцруулах журмын тухай хуулийн[11] Нэгдүгээр зүйлд "Аймаг, хот, сум, хороодын ардын депутатуудын хурлын депутат, сонгогчдын итгэмжийг хөсөрдүүлж, депутатын нэр алдарт харш явдал гаргавал

[10] 1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлын 4 дэх удаагийн сонгуулийн хоёрдугаар чуулганаар баталсан.

[11] 1963 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Дугаар 10 "Орон нутгийн АДХ-ын депутатыг огцруулах журмын тухай хуулийг батлах тухай зарлиг. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын аймаг, хот, сум, хороодын ардын депутатуудын хурлын депутатыг огцруулах журмын тухай хууль 13 зүйл. БНМАУ-ын Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл УБ., 1963 он №2. 30-32 дахь талд нийтлэгдсэн.

сонгуулийн зохих тойргийн сонгогчдын олонхийн саналаар хэзээ ч огцруулж болно" гэж заажээ.

Төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагын тогтолцооны онцлог

Албан хаагчид хүлээлгэх хууль зүйн хариуцлага гэдэг бол төрийн албаны хэвийн үйл ажиллагааг зөрчсөн гэм буруутай албан хаагчид эрх бүхий байгууллагаас хэрэглэх төрийн албадлагын арга хэмжээ юм.

Тухайн үеийн БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль болон хөдөлмөрийн үлгэрчилсэн дотоод дүрэмд сахилгын хариуцлагын дараах арга хэмжээг заажээ. Үүнд:

а) сануулах;

б) донгодох;

в) хатуу донгодох;

г) ажлаас халахыг сануулан донгодох;

д) бага цалинтай буюу доод тушаалын ажилд 3 сар хүртэл хугацаагаар шилжүүлэх зэрэг сахилгын шийтгэл оногдуулдаг байжээ.[42] Мөн албан хаагчийг төрийн албаны болон хөдөлмөрийн сахилга ноцтой зөрчсөний учир ажлаас халах нь сахилгын эцсийн арга хэмжээ болж байв.

Албан үүргээ зөрчсөн албан хаагчийн хүлээх сахилгын хариуцлагын арга хэмжээнүүд үндсэндээ ижил боловч Ардын хяналт шалгалтын хууль, улсын хяналтын болон сахилгын тусгай дүрэм зэрэгт үндэслэл, журмын хувьд өвөрмөц байдлаар тусгагдаж байжээ. Эдгээр нөхцөл байдалтай уялдан төрийн албан хаагчдад сахилгын хариуцлага хүлээлгэх журам нь өөрийн онцлогтой байсан юм. Тухайлбал:

а) дотоод дүрэмд заасны дагуу;

б) захирах захирагдах журмаар;

в) сахилгын тусгай дүрэмд заасаар арга хэмжээ авах гэж ангилагдаж байна.

Эдгээрээс тухайн үеийн онцлог зохицуулалт нь захирах захирагдах журмаар сахилгын хариуцлага хүлээлгэх юм. Энэ гол төлөв удирдах албан тушаалд хамааралтай бөгөөд ажлын газрын захиргаанаас биш, харин тухайн ажилтан шууд харьяалж захирах дээд байгууллагаас нь сахилгын шийтгэл оногдуулахыг хэлнэ. Үүний жишээ нь Сайд нарын Зөвлөл яамны сайд, улсын хороо, өөртөө харьяалагдах бусад байгууллагын дарга болон тэдгээрийн орлогчдод сахилгын арга хэмжээ авч болохоор заасан зохицуулалтаас харагдах юм.[43] Харин сахилгын тусгай дүрмийн хувьд төрийн албаны зарим салбарт эрх

[42] БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль 119 дүгээр зүйл. Үйлдвэр албан газар, байгууллагын хөдөлмөрийн үлгэрчилсэн дотоод дүрэм 27-р зүйл

[43] БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тухай хуулийн 20 дугаар зүйл

бүхий байгууллагаас баталсан сахилгын тусгай дүрэм дагаж мөрдөх нь бий. Тухайлбал: "Төмөр замын ажилчин, албан хаагчдын сахилга батын дүрэм", "БНМАУ-ын зэвсэгт хүчний сахилга батын дүрэм", "БНМАУ-ын шүүгчдийн сахилга батын дүрэм" гэх мэт байжээ. Эл сахилыг тусгай дүрмийн хувьд өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар ч гэсэн бий юм. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилтны сахилгын дүрэм", "Шүүгчийн сахилгын дүрэм", "Цагдаагийн албан хаагчийн сахилгын дүрэм" гэх мэт үйлчилж буй юм.

Төрийн албан хаагчдын ангиллын хувьд

Төрийн албан хаагчдыг ажиллаж байгаа байгууллагын системээр АДХ-ын ажилтан, захиргааны байгууллагын ажилтан, шүүх, прокурорын байгууллагын ажилтан, мөн захиргааны салбар байгууллагын ажилтанг аж ахуйн удирдах байгууллагын ажилтан нийгэм, соёлын удирдах байгууллагын ажилтан, захиргаа-улс төрийн байгууллагын ажилтан гэх зэргээр ангилаж бүлгэлжээ. Харин албан хаагчдыг тухайн байгууллагад эзэлж байгаа байр суурь албан ажлын хууль зүйн шинж чанарыг харуулахын тулд эрх хэмжээгээр нь:

1) албан тушаалтан;

2) туслах буюу техникийн гүйцэтгэх ажилтан гэсэн үндсэн хоёр бүлэгт хуваагдаж байжээ.

Өөрөөр хэлбэл өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар ангилагдсан төрийн улс төрийн, захиргааны, үйлчилгээний гэх шууд ялгамжтай тодорхойлсон ангилалт байхгүй байв.

1.4. 1990-1992 оны хоорондох шилжилтийн зурвас үеийн төрийн албаны онцлог, эрх зүйн зохицуулалтын тойм

1990 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Үндсэн хуулийн нэмэлтнйн тухай хуулиар төрийн албаны бүтэц зохион байгуулалтад нэлээд өөрчлөлт орсон юм. Тухайлбал:

Хуулийн 1 дүгээр зүйлд: "БНМАУ-ын Ардын Их Хурал бол Монголын ард түмний бүрэн эрхийг илэрхийлсэн төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага мөн" гэсэн бол мөн хуулийн 6 дугаар зүйлд: "БНМАУ-ын Бага Хурал нь хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага мөн "БНМАУ-ын Бага хурал дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, 50 гишүүнээс бүрдэнэ. БНМАУ-ын Бага хурлын орлогч дарга, нарийн бичгийн даргыг БНМАУ-ын Ардын Их Хурал депутатуудын дотроос шууд сонгоно. БНМАУ-ын Бага Хурлын дарга нь БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч байна. гэж Ардын Их Хурал, Улсын Бага Хурлын эрх хэмжээний асуудлыг шинэчлэн тусгаж оруулсан бөгөөд БНМАУ-ын Бага Хурлын дарга нь тус улсын Дэд ерөнхийлөгч

байхаар зохицуулж өгсөн нь төрийн албаны шинэтгэлд шинэ алхам байлаа.

Мөн хуулиар БНМАУ-ын Бага хурлын гишүүний бүрэн эрх, түүнийг сонгох, огцруулах журмыг БНМАУ-ын хууль тогтоомжоор тодорхойлно. гэж заажээ. Түүнчлэн 13 дугаар зүйлд: БНМАУ-ын Ерөнхийлөгч бол Ардын төрийн тэргүүн, БНМАУ-ын тусгаар тогтнол, Монголын ард түмний эв нэгдлийн баталгаа мөн. БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, Монголын ард түмний аж амьдрал, ёс заншлыг сайн мэддэг, сүүлийн таваас доошгүй жил БНМАУ-д байнга оршин суусан БНМАУ-ын иргэнийг Ардын Их Хурлаас саналаа нууцаар гаргаж 5 жилийн хугацаагаар сонгоно. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаалд хоёр түүнээс дээш хүний нэрийг дэвшүүлнэ. БНМАУ-ын Ардын Их Хурлын нийт депутатын олонхийн санал авсан нэр дэвшигчийг БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцно. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.[44] гэж заажээ. Өөрөөр хэлбэл энэ хуулиар БНМАУ-ын Ерөнхийлөгч гэсэн албан тушаал анх бий болсон юм.

Мөн уг хуулиар төрийн албанд хийсэн бас нэгэн шинэчлэл бол тус хуулийн хоёрдугаар бүлэг. "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар" гэсэн бүлэг 18 дугаар зүйлд заасаар "БНМАУ-ын Засгийн газар нь төрийн гүйцэтгэн захирамжлах дээд байгууллага мөн" гэж заасаар 1960 оны Үндсэн хуулиар тодорхойлон заасан Сайд нарын Зөвлөлийн эрх хэмжээ Засгийн газарт шилжсэн юм.

Ийнхүү 1990 оны Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиар төрийн албаны хөгжил, бүтэц зохион байгуулалтын шинэ өөрчлөлтийг хийсэн байна.

ХОЁР. 1992 оны Үндсэн хуулийн дагуух төрийн албаны шинэтгэлийн үе

2.1. 1994 оны Төрийн албаны хуулийн зорилт, бүтэц, агуулгын товчоон

Урьд өмнө нь төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулдаг байсан билээ. П.Жасрай гуайн Засгийн газрын үед Төрийн албаны тухай хуулийг 1992 оноос боловсруулж, Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаар Төрийн албан хаагчдын эрх зүйн байдлын үндэс тавигдсан ба 1994 оны 12 дугаар сарын 30-нд Төрийн албаны тухай хуулийг баталж дараа жилээс нь мөрдүүлж эхэлсэн. Ингэж төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг улс төрөөс хараат бус, мэргэшсэн, тогтвортой байх зарчимд тулгуурласан бөгөөд хуулиар зохицуулагдсан нийгмийн харилцаа болгож өөрчлөн шинэчилсэн (1999-05-14; 1999-05-28; 2000-08-03; 2000-12-07; УИХ-

[44] БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль 1990.05.10 13 дугаар зүйл

аас 2002 онд баталсан уг хуулийг шинэчлэн баталсан ба энэ хуульд 2002 оны 11 дүгээр сарын 8-нд, 2003 оны 1 дүгээр сарын 2, 10, 5 дугаар сарын 30-нд, 6 дугаар сарын 20-нд, 2005 оны 05 дугаар сарын 26-нд, 2006 оны 1 дүгээр сарын 12-нд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан).

1994 оны Төрийн албаны хуулиар Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн Цэц, Засгийн газар, Шүүх, тэдгээрийн харьяа газар, албан хаагчийн эрх зүйн байдлыг нэгтгэн зохицуулжээ. Уг хууль нь 7 бүлэг, 42 зүйлээс бүрдэх бөгөөд хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн албаны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавигдах шаардлага, төрийн алба хаагчийн эрх зүйн байдал, түүнээс төрийн алба хаах болзол, журам, баталгааг тогтоон зохицуулахад оршино.

Төрийн албаны нэгдмэл тогтолцоонд төрийн жинхэнэ алба тэргүүлэх байр суурь эзэлнэ. Хууль тогтоох, шүүх эрх мэдлийн албаны үйл ажиллагаа нь нэг чиглэлийн байдаг бол төрийн захиргааны болон тусгай алба төрийн бүх эрх мэдэлд хамаарахын зэрэгцээ захиргааны байгууллагын доторхи цэргийн алба, дипломат алба, хууль зүйн, эсхүл гаалийн,татварын зэрэг тодорхой аль нэг салбар алба нийлж, төрийн албаны бүхэллэг нэгдмэл тогтолцооны цөмийг бүрдүүлнэ. Төрийн албыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад юуны өмнө ажлын аппарат, албан тушаал, албан хаагч шаардагдана.

Манай улсад нам төвтэй улс төрийн тогтолцооны үеийн "спойл" буюу төрийн албаны удирдлагын "эвдрэх" тогтолцоог өөрчлж, төрийн эрх мэдлийн гурван салаа мөчирт тогтвортой ажиллах төрийн албан хаагчаар хангах нь Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулиас хойшхи төрийн байгууллын тулгамдсан асуудлын нэг болсон юм.

"Монгол Улсын Төрийн албаны хууль"-д (1994) гадаадын олон оронд үр дүнгээ үзүүлсэн төрийн албаны удирдлагын "мерит" буюу "төрд тогтвортой үйлчлэх" тогтолцоог тусгасан билээ.

"Нийтлэг үндэслэл" гэсэн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албаны ойлголт, ангилал, зарчмын үндсийг тоймлон тодорхойлжээ.

Төрийн албыг төрийн улс төрийн, тусгай, захиргааны, үйлчилгээний гэж дөрөв ангилан төрийн захиргаанд болон тусгай албыг төрийн жинхэнэ алба хэмээн томьёолж, төрийн албаны үндсэн зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал болохыг тогтоон бэхжүүлжээ.

Үүний зэрэгцээ төрийн албанд хуульд өөрөө заагаагүй бол дараахь тусгай зарчим баримтлана. 1. Захирах, захирагдах ёс; 2. Ил тод байх; 3. Ард түмэнд үйлчлэх; 4. иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх; 5. Төрийн алба

мэргэшсэн тогтвортой байх; 6. Төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах; 7. Хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах. Иймхүү төрийн албанд удирдлага болгох үзэл баримтлал, үндэслэлийг зарчим хэмээн хуульд анх удаа тусгайлан тогтоосон билээ.

"Төрийн албан тушаал" гэсэн хоёрдугаар бүлэг, 5-10 дугаар зүйлд заасанчлан төрийн албан тушаал нь төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний гэсэн ангиллаттай, удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна. Тэрчлэн төрийн аль албан тушаалд төрийн ямар албан хаагч хамаарахыг хуулийн 6-9 дүгээр зүйлд нэгбүрчлэн заажж, төрийн албан тушаалтны зэрэг зиндаа, зэрэг дэв, зэрэглэлийн талаар тусгажээ.

Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай, мэргэжлийн бэлтгэлтэй байх явдал мөн.

"Төрийн албан хаагч" хэмээх хуулийн гуравдугаар бүлэг, 11-15 зүйлд "Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсэний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ "гэсэн тодорхойлолт өгч, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын үндсийг ялгавартайгаар тогтоожээ.

Цаашилбал, төрийн захиргааны албан хаагчийн тангараг, тэдгээрийн нийтлэг үүрэг, эрх, үйл ажиллгаанд хориглох зүйлийг ерөнхийлэн томьёолсон.

"Төрийн захиргааны албан тушаал эрхлэх болзол, журам" гэсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг, 16-26 дугаар зүйлд заасанчилан төрийн албан тушаалын болзол нь "Төрийн тухайн албан тушаалд иргэний төрийн захиргааны албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьс, өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно". Мөн төрийн захиргааны албан тушаалд авч ажиллуулахыг хориглох тохиолдлуудын тухай заалт бий.

Төрийн захиргааны албан тушаалд авах, албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх, албан тушаал хаврах, орлон гүйцэтгэх, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр томилох, албан тушаал буруулах, албанаас чөлөөлөх, халах үндэслэлийг анх удаа хуульчилсан нь энэ бүлгийн гол агуулга юм.

Бас төрийн захиргааны албан хаагчид албаны сахилгын зөрчлийн шинж байдлыг харгалзан сануулах, албан тушаалын цалингийн

хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, төрийн албанд нэг жил хүртэл хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулахаар болов.

"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа" гэсэн тавдугаар бүлэг, хуулийн 27-32 дугаар зүйл нь төрийн албан хаагчийн ажил үүргээ гүйцэтгэх баталгаа, цалин хөлс, шагнал урамшуулал, тэдгээрт олгох нөхөн төлбөр, тусламж, тэтгэвэр, тэтгэмжийн асуудалд зориулагджээ.

"Төрийн албаны удирдлага, зохион байгуулалт" гэсэн хуулийн 33-39 дүгээр зүйл зургаадугаар бүлэг нь төрийн албаны удирдлага, стандарт, санхүүжилт, төрийн албаны төв байгууллага, түүний чиг үүрэг, төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндэст хамаарагдана.

Төрийн албан хаагчийн ерөнхий удирдлагыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурор; стандартын удирдлагыг Төрийн албаны төв байгууллага; шуурхай удирдлагыг төрийн байгууллагын ажлын албаны эрх бүхий албан тушаалтан тус тус бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

Төрийн албаны 1994 оны хуулиар гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд бие даасан статустай стандартын удирдлагыг хэрэгжүүлэгч Төрийн албаны зөвлөл гэсэн шинэ байгууллага бий болов.

Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, хэрэгжүүлэх, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэгдэж, төрийн албан хаагчаас албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, санхүү, статистикийн болон төрийн албатай холбогдсон бусад мэдээ тайлан гаргах, төрийн байгууллага, албан хаагчаас албан хэрэг хөтлөх, ангилах, архивын баримт бичиг, нэгж бүрдүүлэх, хяналт шалгалт хийх, мэдээллээр хангах зэрэг бусад үйл ажиллагааны журмыг тогтооно.

"Бусад зүйл" гэсэн хуулийн 7 дугаар бүлэг, 40-42 дугаар зүйлд төрийн албан хаагчаас төрийн албаны хууль тогтоомж, стандарт зөрчих, албаны үйл ажиллагаатай холбогдсон хууль бус бусад ажиллагаа явуулахыг хориглож, Монгол Улсын төрийн албаны хуулийн холбогдох зарим заалт зөрчсөн гэм буруутай этгээд, төрийн албан хаагчид эрүүтийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх, хуулийн 17 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг зөрчсөн албан тушаалтанд захиргааны торгууль ногдуулах, уг зөрчлийг давтан үйлдэж торгуулбал түүнийг ажил албан тушаалаас халах, саналыг эрх бүхий этгээдэд тавих эрх зүйн үндсийг бүрдүүлжээ.

2.2. 2002 оны Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийн онцлог

"Төрийн албаны тухай хууль"-д удаа дараа орсон олон нэмэлт, өөрчлөлт байгаа боловч 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдөр уг хуулийг бүхэлд нь хэлэлцэж, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай нийцүүлэн хуулийг шинэчилэн найруулж, боловсронгуй болгож УИХ баталсан.

Төрийн албаны тухай 2002 оны хуулийн шинэчилсэн найруулгын талаар товчхон: Монгол Улсын Төрийн албаны тухай энэ хууль нь өмнөх хуулийн нэг адил 7 бүлэг 41 зүйлтэй, нэг зүйл хасагдсаныг эс тооцвол бүтэц бүлгийн хувьд өөрчлөгдөөгүй байна.

Төрийн албаны 2002 оны хуулийн шинэчилсэн найруулгаар сайжруулсан нэмэлт өөрчлөлтийг тоймловол:

1. "Нийтлэг зүйл " Нэгдүгээр бүлгийн хуулийн зорилтод "... **төрийн албаны чиг үүргийг**" нэмж, өөрчлөн найруулсан;

2. Хуулийн 2 дугаар бүлгийн 5.2-т **төрийн захиргааны болон** тусгай **албан тушаалыг "төрийн жинхэнэ албан тушаал гэнэ"** хэмээн шинээр нэмсэн;

3. Төрийн албан тушаалын ангилалд хамаарах зарим албан тушаалтанд өөрчлөлт хийсэн. Тухайлбал 2002 оны хуулиар төрийн улс төрийн албан тушаалд "хэвлэл мэдээллийн ажилтаны албан тушаал, Улсын Их Хурал дахь нам эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал" –ыг нэмж, "хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын тохируулагч агентлагын дарга" байсныг хассан гэх мэт;

4. Хуулийн "төрийн үйлчилгээний албан тушаал"-д **агуулгын болон зарчмын** шинжтэй зарим өөрчлөлт найруулга хийгдсэн. Заримаас нь дурдвал "боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл урлаг зэрэг төрийн байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал" гэдэгт "боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл урлаг, зэрэг төрийн үйлчилгээний төсөвт байгууллагын" гэсэн өөрчлөлт оруулсан; "Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллага болон хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал"-ыг нэмсэн; "яам, тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн өмчийн үйлдвэрийн газрын захиргааны албан тушаал"-ыг (энэ хэсгийг 2003 оны 1-р сарын 10-ны өдрийн хуулиар) хассан;

5. Хуулийн 10 дугаар зүйлийн " төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлагад... " мэдлэг"-ийг нэмж" мэргэжлийн бэлтгэл" гэснийг "мэргэшсэн байх явдал" хэмээн өөрчилсөн;

6. Хуулийн 11.2-т төрийн захиргааны болон тусгай албан тушаалын ангилалын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол

Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэнэ гэж шинээр нэмсэн. Цааш нь хуулийн 13, 14, 15 дугаар зүйл " төрийн захиргааны албан хаагчийн нийтлэг үүрэг, эрх, үйл ажиллагаанд хориглох зүйл" байсныг "төрийн жинхэнэ албан хаагч" болгон нэмэлт хийж өргөтгөсөн. Мөн хуулийн "Төрийн захиргааны албан тушаал эрхлэх болзол, журам " гэсэн 4 дүгээр бүлэгт хуулийн 20 дугаар зүйлээс бусдыг нь "төрийн жинхэнэ албан тушаал" болгон бүхэлд нь өөрчилсөн;

7. 1994 оны хуулийн "Төрийн албаны удирдлага" гэсэн 33 дугаар зүйлийн 4-т төрийн байгууллага нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангахтай холбогдсон дараахь асуудлаар: 4.1 төрийн албан хаагчийн сургалт; 4.2 ...төрийн албан хаагчийн аж байдал; 4.3 ... төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа; 4.4...төрийн албан хаагчийн эрүүл мэнд; 4.5 ...төрийн албан хаагчийн амралт, сувилал; 4.6 ...төрийн албан хаагчийн аюулгүй байдал гэж байсныг "төрийн байгууллага нь дараахь хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ: 33.4.1. Төрийн албан хаагчийн сургалт; 33.4.2 төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа" болгон өөрчлөн найруулжээ;

8. Өмнөх хуулийн 34.1-д "төрийн захиргааны албаны зөвлөл" гэж байсны "захиргааны" гэдгийг хасаж, "Төрийн албаны зөвлөл" хэмээн өөрчилж нэрэлсэн. Мөн хуулийн 35 дугаар зүйлд "Зөвлөлийн чиг үүрэг" байсан бол "Зөвлөлийн бүрэн эрх" болж агуулгын хувьд баяжин нэр томъёо өөрчлөгдсөн гэх мэт.

Шинэчилсэн найруулгын дагуух нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн дээр дурсанаар хязгаарлагдахгүй нь мэдээж.

2.3. 2002 оны "Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-д 2008 онд орсон нэмэлт, өөрчлөлтийн онцлог

Монголын өнөөгийн нийгмийн хөгжлийн явцад төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах, төрийн жинхэнэ алба хаагч төвийг сахиж, улс төржихгүй, зөвхөн төр, засагтаа үйлчилж, ард түмний түсын тулд ажиллах шаардлага хурцаар тавигдаж байна.

Гэвч төрийн албаны практикт төр, нийгмийн эрх ашгийг урьтал болгох бус, намчирхан бүлгэрхэж, аль нэг намын эрх ашгийн төлөө зүтгэх, төрийн нэгдмэл бодлого, тогтвортой чанарыг алдаж, төрийг иргэнээс холдуулан нэр хүндийг нь бууруулах тохиолдол багагүй гарч байгаас улбаалан хэд хэдэн удаагийн чуулганд зүтгүүлэн байж 2008 онд Ерөнхийлөгчийн санаачилгаар Төрийн албаны тухай хуульд төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх буюу мерит зарчмыг хэрэгжүүлэх явдлыг улам илүү баталгаажуулсан агуулга бүхий томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсныг УИХ баталсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан оруулж, Монгол Улсын Их Хурлын хэлэлцэн баталсан Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дараахь гурван үндсэн чиглэлд хуваах болох юм.

1.Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах талаар.

Ийм нэмэлт, өөрчлөлтөөс хэсэгчлэн дурдвал:

1.1. Төрийн зарим албан тушаалд тодорхойлолт өгсөн юм. Тухайлбал "Төрийн албаны тухай хууль"-ийн 7.1. төрийн захиргааны албан тушаалд "... төрийн бодлого боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах чиг үүрэг бүхий" албан тушаал хамаарна; мөн хуулийн 8.1: төрийн тусгай албан тушаалд "... үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дэдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн хэв журам хамгаалахтай холбогдсон" төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал хамаарна; мөн хуулийн 9.1: Төрийн үйлчилгээний албан тушаалд "...төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад" туслах чиг үүрэг бүхий албан тушаал хамаарна гэж шинээр нэмэлт оруулжээ;

1.2. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд: төрийн улс төрийн албан тушаалд байсан Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхэт төлөөлөгчийн газрын тэргүүнийг төрийн улс төрийн албан тушаалаас хассан, мөн баг, хорооны Засаг даргыг улс төрийн албан тушаалаас төрийн захиргааны албан тушаалд хамаарууулж албан тушаалын ангилалыг өөрчилсөн;

1.3. Төрийн албаны тухай хуулийн 7.3-д төрийн захиргааны албан тушаалыг тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах гэж анилж байсан бол төрийн жинхэнэ албан тушаалд бүхэлд нь хамруулан нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Үүний зэрэгцээ эрхэлсэн, ахлах, дэс, туслах үшмэлийн албан тушаалын ангилалтад нэмэлт хийж өөрчлөн найруулсныг мөн хуулийн 7.5-7.8-аас харьцуулан үзнэ үү:

1.4. Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлсэн арав гаруй жилийн "баг бүрдүүлэх", "бүтцийн өөрчлөлт хийх" нэрээр төрийн жинхэнэ албан хаагчдыг халах, өөрчлөх практикийг харгалзан төрийн албан тушаалд тавих ерөнхий болон тусгай шаардлага, жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, журмыг хангах иргэнийг элдэв хэлбэрээр ялгаварлахгүй байх, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур халж солихгүй, ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа улс төрийн нөлөөнөөс ангид хөдөлмөрлөх эрх зүйн зохицуулалтад энэхүү нэмэлт, өөрчлөлт хийхдээ ихээхэн анхаарал хандуулсаныг дурдах хэрэгтэй.

Жишээлбэл, "Төрийн албаны тухай хууль"-ийн 10.4-д төрийн захиргааны албан тушаалд тавих тусгай шаардлагыг шаардлагатай гэж үзвэл Засгийн газар хуульд нийцүүлэн тогтоож болохоор байсныг энэ өөрчлөлтөөр зогсоосон. Харин захиргааны албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг Засгийн газар тогтоохоор бол Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулах болов.

Төрийн албаны тогтвортой байдлыг тууштай хангах үүднээс

Төрийн албаны тухай хуулийн 10.5-ийг өөрчлөн найруулж, төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг болон "...улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахихтай холбогдсон зохицуулалтыг Төрийн албаны тев байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн гэрээ, контрактаар тодорхойлно гэх мэтээр томъёолсон;

1.5. "Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, журам" гэсэн 4 дүгээр бүлгийн 16.2.4-т хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн төрийн албаны онцлог төрөл болох энэ үүргээ биелүүлээгүй бол"., мөн зүйлийн 16.2.5-д "гадаадын иргэн, харьяалалгүй хүн"-ийг төрийн жинхэнэ албан тушаалд авч ажиллуулахыг хориглоно гэсэн нэмэлт оруулжээ;

1.6. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, жинхэнэ албан тушаалд авах талаархи "Төрийн албаны тухай хууль"-ийн 17.2-г энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий (төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, мэргэшсэн байх явдал юм) болон 33.5-д заасан тусгай (энэ шаардлагын талаар Төрийн албаны тев байгууллагын тухайн хэсэгт тусад нь авч үзнэ) шаардлага, 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхтэй гэж тодотгож өөрчлөн найруулжээ.

2. Улс төрийн намын гишүүнчлэлийн талаар. Төрийн албанд тогтвортой ажиллахад нөлөөлөх сөрөг хүчин зүйлийн нэг нь улс төрийн аль нэг намын гишүүнчлэлтэй байж, төрийн эрх ашгийн урд тухайн намын боллого, зорилтоо хэрэгжүүлэхийг хичээх явдал юм.

2.1. "Төрийн албаны тухай хууль"-ийн 10.6-д "улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч нь төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, хөдөлгөөний үйл ажиллгаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх, хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэж, төрийн тухайн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ тухайгаа байгууллагын захиргаа болон харьяалах намдаа бичгээр албан ёсоор мэдэгдэнэ" гэж томъёолжээ. Энэ нь 2009 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилж эхлэв;

2.2. Хуулийн 15.1.14-т "Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зорчулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгийг дайчлах"-ыг төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хоригложээ;

2.3. Хуулийн 23.2-т "Төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших болсон бол хуульд заасны дагуу нэр

дэвчигчээр бүртгүүлэхээр сонгуулийн хороонд холбогдох баримт бичгийг ирүүлэхээс өмнө төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн эрх бүхий албан тушаалтанд гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй" гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Эдгээр нь төрийн жинхэнэ албан хаагчийг тогтвортой үр нөлөөтэй ажиллуулах, түүнийг улс төржүүлэхгүй, улс төрийн намын нөлөөнөөс ангид байлгах чухал ач холбогдолтойг тэмдэглэж байна.

3. Төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээний талаар. Төрийн албаны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, түүний төв байгууллагын эрх хэмжээг өргөтгөх нь төрийн алба тогтвортой байх, төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн түвшинг дээшлүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ.

Төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээтэй холбоотой олон шинэ зүйл, хэсэг нэмэгдэж, нэмэлт, өөрчлөлт орсноос заримыг нь хэсэгчлэн авч үзье.

3.1. Хуулийн 33.4-т заасанчлан: "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасан төрийн албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно".

Хуулийн 33.5-д: "Энэ хуулийн 33.4-т зааснаас бусад төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг төрийн жинхэнэ албан тушаалын ангилал, зэрэглэл бүрээр Төрийн албаны төв байгууллага тогтооно" гэж шинээр тус тус нэмжээ;

3.2. Хуулийн 34.3-т "Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Тэдгээрийн хоёр нь орон тооны, 4 нь орон тооны бус байна". Хуулийн 34.4-т "Зөвлөлийн орон тооны 2 гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр нэг хүний нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн, ял шийтгэлгүй, 45 насанд хүрсэн иргэн байна".

Хуулийн 34.5-д "Зөвлөлийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, удирдах ажлын дадлага, туршлагатай, ял шийтгэлгүй, 45 нас хүрсэн иргэн байна" гэж тус тус өөрчлөн найруулжээ.

Хуулийн 34.13-т "Зөвлөл нь орон тооны болон орон тооны бус салбар зөвлөл, ажлын албатай байна. Ажлын албаны даргыг Төрийн албаны зөвлөл томилж чөлөөлнө. Орон тооны салбар зөвлөл болон ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо,

төсвийг Улсын Их Хурал батална. Төрийн албаны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгааны болон зөвлөх үйлчилгээний нэгжтэй байж болно" гэх мэтээр удирдлага зохион байгуулалтыг нь бэхжүүлэх, бүрэн эрхийг нь өргөтгөх арга хэмжээ авчээ;

3.3. "Төрийн албаны хууль"-ийн 35-39 дүгээр зүйлд шинээр нэмсэн долоон хэсэг заалт байгаа нь энэ хуулийн 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн нэгэн онцлог гэж үзэж болно.

Заримаас нь дурдвал:

Хуулийн 35.1.14. Төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, өөрчлөлтийн менежмент, төрийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтанг мэргэжил арга зүйн зөвлөлгөө, үйлчилгээгээр хангах

Хуулийн 39.5. Төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбоотой холбогдон гарсан эрх бүхий албан тушаалтаны шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол Төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй гэх мэт.

"Төрийн албаны удирдлага, зохион байгуулалт" гэсэн хуулийн 6 дугаар бүлэг, 8 зүйлд гэхэд шинээр нэмэгдсэн, өөрчлөн найруулсан 36 заалт-хэсэг байгаа нь Монгол Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт, бусад нэмэлт, өөрчлөлтийн дотор зонхилох байр суурь эзэлсэн , ялгагдах онцлогтойг харуулна.

2009 оны 5 дугаар сард баталсан хуульд Баг, хорооны Засаг даргыг төрийн захиргааны ангилалд багтаасан нь багагүй хэл ам дагуулсан. Тэднийг захиргааны ангилалд багтаасан учраас баг, хорооны Засаг дарга болох сонирхолтой хүмүүсээс төрийн албаны шалгалт авч, нөөц бүрдүүлчихээд байж байтал хуульд өөрчлөлт оруулж магадгүй гээд зогсонги байдалтай болчихоод байсан. Ингэснээр бүрэн эрх нь дуусан баг, хорооны Засаг дарга нар ажиллах болсон.

Баг, хорооны Засаг даргыг захиргааны албан тушаалтан болгосон нь Үндсэн хуультай нийцэхгүй байна гэсэн Цэцийн дүгнэлт гарсан.

ТАЗ-өөс Цэцийн шийдвэр хууль зүйн болон нийгмийн таагүй үр дагавартай гэж үзсэн. Учир нь Баг, хорооны Засаг даргыг улс төрийн ангилалд хамруулах нь улстөржих нэг урхаг болдог, харин захиргааных болгосон нь илүү үр дүнтэй гэж тухайн нутаг, орныхон үзэж байгаа. Тэднээс төрийн албан хаагчийн шалгалт авч, сонгон шалгаруулалт явуулсан нь зүйтэй ажил болсон. Засаг дарга нарын чадавхийг сайжруулах, нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэхэд ихээхэн тус нэмэртэй болсон нь тодорхой харагдаж байгаа.

Улс төрийн юм уу, намчирхах үүднээс биш, сэтгэлээрээ ажилладаг хүмүүс л Засаг дарга байх ёстой. Гэтэл улс төрчид үүнийг өөрчлөх ёстой, хуульд яаралтай өөрчлөлт оруулна гээд эхэлсэн. Ганцхан хүнийг, хэн нэгний үзэмж, тааллаар, намын бодлогоор томилдгийг олон түмэн эсэргүүцдэг юм. Ард иргэд ядаж гурван хүнээс сонголтоо хийхийг чухалчилдаг юм билээ.

ГУРАВ. Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын талаарх (1994 оноос хойшх) тусгайлсан судалгаа

Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгын гол онцлог нь нийгмийн хөгжлийн тухайн үеийн ололт, эрх зүйн практик хэрэглээ, хууль зүйн шинжлэх ухааны төлөвшлийн хүрсэн түвшинд тулгуурлан хийсэн шинэтгэлийн үр дүн байсан бол 2008 оны нэмэлт, өөрчлөлт нь төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангах; төрийн жинхэнэ алба, албан хаагчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох; төрийн жинхэнэ албан хаагч улс төржихгүй, төвийг сахиж, зөвхөн төр, засагтаа үйлчилж, ард түмний тусын тулд ажиллах; Төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээг өргөтгөх зэрэг цогц арга хэмжээг тусган хэрэгжүүлснээрээ бусад нэмэлт, өөрчлөлтүүдээс ялгагдах юм.

"Төрийн алба"-ыг Франц, ХБНГУ-д болон бусад зарим оронд нийтийн алба, нийтийн албаны эрх зүй, Их Британи, АНУ-д иргэний алба, ОХУ, Японд болон бусад оронд Төрийн алба[45] гэсэн нэр томъёогоор хууль зүйн ном зохиолд авч үзэж, зарим нь захиргааны эрх зүйн төрөл-хэсэг, голлох институтын нэг[46] эсхүл эрх зүйн дэд салбар хэмээн тайлбарласаар ирэв.

Монгол Улсын хувьд сурах бичиг, гарын авлага, сургалтын хөтөлбөртөө гол төлөв төрийн алба, судлаач Ж.Долгорсүрэнгийн хувьд сүүлийн үеэс өөрийн зарим бүтээлдээ[47] нийтийн албаны эрх зүй нь Монгол Улсын захиргааны эрх зүйн дэд салбар хэмээн бичсэн нь бий.

"Төрийн албан хаагч"-ийн тухайд бол наад зах нь гурван үзэл бодлоор авч үзэж болох юм. **Нэг дэх нь,** төр-эрх зүйн талаасаа төрийн албан хаагч-төрийн "зарц" (түүний байгууллагын), төрийн

[45] Административное право зарубежных стран. Учебник. Под ред. А.Н.Козырина и М.А.Штатиной.-М., Спарк, 2003, 91-128. 240-252, 309-311, 342-353, 375-377, 427; Старилов. Ю.Н. Публичное право.-М.: 1996 и др. "Административное право России.-3-е изд., перераб.и доп.-М: Юнити-Дана, 2008.-559.с" сурах бичигт "ОХУ-ын төрийн иргэний албаны үндэс" гэсэн бүлэг бий. 180-217 дахь тал.

[46] Нарангэрэл С. (2008) *Эрх зүйн эх толь бичиг* Нэмж засварласан 2 дахь хэвлэл.-УБ.,412..

[47] Долгорсүрэн Ж. (2008) *Монгол Улсын захиргааны эрх зүй* Ерөнхий анги. Сэдэвчилсэн гарын авлага. УБ., 150-158. Үүний урьд 2001 онд МУИС-ийн ХЗС-ийн "Эрх зүйн онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал" сэтгүүлийн №4-5-д нийнхүү бичигдсэн өгүүлэл буй.

чиг үүрэг хэрэгжүүлэгч, нийгэм, төрийн бүтээгдэхүүн мөн, **хоёр дахь нь** эрүүгийн эрх зүйн үүднээс төрийн албан хаагч бол эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх онцгой субъект, албан тушаалтан мөн; **гурав дахь нь** захиргааны эрх зүйн үзэл бодлоор төрийн албан хаагч тусгай засаглах, зохион байгуулан захирах бүрэн эрхтэй, хууль хамгаалан хэрэгжүүлэх, захиргааны эрх зүйн санкци хэрэглэх чиг үүрэгтэй засаглалын төлөөлөгч гэж үзэж байна.

3.1. Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын ойлголт, үндсэн шинж, бүтэц

Төрийн албан хаагчийг өргөн, явцуу хоёр утгаар авч үзэж болно. Өргөн утгаар нь зөвхөн төрийн эрх мэдлийн байгууллагад төдийгүй, НӨҮБ болон төрийн өмчийн үйлдвэр, албан газар, байгууллагад төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчийг хамруулан ойлгоно.

Төрийн албан хаагчийг явцуу утгаар нь төрийн албан тушаал, өөрөөр хэлбэл зөвхөн төрийн эрх мэдлийн (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн) байгууллагад албан тушаал эрхэлж байгаа этгээд гэж ойлгож болох юм.

Төрийн аль ч албан хаагчийн эрх зүйн байдлын онцлог нь төрийн албан хаагчаас төрийн зорилт, чиг үүрэг, бүрэн эрхээ биелүүлэн хэрэгжүүлэх өвөрмөц чанартай нөхцөлдөн ... жишээлбэл цэргийн ба иргэний алба, татварын алба, дипломат алба, салбарын захиргааны үйл ажиллагаа зэрэг төрийн албаны янз бүрийн төрөл-тусгай шинжээр тодорхойлогдоно.[45]

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал нь эрх, үүргийн нийлбэр цогц, хариуцлага болон бусад бүрэлдэхүүн хэсэг, шинжийг өөртөө багтаасан хэд хэдэн элементүүдийн нарийн төвөгтэй, иж бүрэн төрөл-хэсэг мөн.[47]

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал нь төрийн албан тушаал эрхэлж, албан үүрэг гүйцэтгэж, эрх эдлэхтэй холбогдон гарсан хууль тогтоомж, түүнд нийцэж гарсан эрх зүйн тодорхой актаар зохицуулагдана.

Төрийн албан хаагчийн эрх байдлыг хууль тогтоомжоор тогтоогдон баталгаажсан эрх, эрх чөлөө, үүрэг, хязгаарлалт ба хориглолт, албан хаагчийн хариуцлага зэрэг нөхцөл байдлыг өөртөө бий болгохтой холбон үзэж байна.

Өөрөөр хэлбэл, төрийн албаны харилцааг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгоно. Төрийн албаны харилцаа өөрчлөгдөх бүрт **албан**

[45] Старипов.Ю.Н. (2002) *Курс общего административного права. В 3 т.п:государственная служба. Управленческие действия. Правовые акты управления.* Административная юстиция.-М.:Издательство "Норма", С.35.

[47] Габричидзе.Б.Н., Чернявский.А.Т. *Курс админстративного права Российской Федерации.* В трех частях: Учебных

хаагчийн эрх зүйн байдал нь жишээлбэл, албанд орох, халагдах, огцрох, иргэний харьяалалаа алдах, тэтгэвэрт гарах зэрэгт **дагаад өөрчлөгдөнө.**

Монгол Улсын 1994 оны Төрийн албаны хуулиас өмнө төрийн алба, төрийн албан хаагчийн ойлголтын талаар хууль тогтоомжид ямар нэг тодорхойлолт байгаагүй. Харин 1994 оны болон 2002 оны шинэчилсэн найруулгад төрийн албан тушаалын ангилал төрийн ямар албан тушаалд аль нь хамаарахыг нэг бүрчилэн заасан нь бий.

Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хууль өөрөөр заагаагүй бол Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, Төрийн албаны хуулиар зохицуулагдаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

"Монгол Улсын төрийн албаны хууль"-ийн 11 дүгээр зүйлд "Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлснийн төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг **төрийн албан хаагч** гэнэ"[50] гэж заажээ.

Төрийн албан хаагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажиллагаа нь дараахь үндсэн шинжийг өөртөө агуулна. Үүнд:

- Төрийн удирдан зохион байгуулах үйл ажиллагааны бүрэлдхүүн хэсэг;
- Албан хаагчийн ажлын зорилго, агуулга нь төрийн зорилт, чиг үүргийг практикт биелүүлэх ажиллагаа;
- Тусгайлан бэлтгэгдсэн төрийн албан хаагч ээлжлэн мэргэжлийнхээ үндсэн дээр ажиллана;
- Төр төлөөлөн, түүний нэрийн өмнөөс албан тушаалын үүрэг гүйцэтгэж, үүнийхээ төлөө улсаас цалин хөлсөөр хангагдана;
- Төрийн албаны харилцааны ихэнх нь захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдана гэх мэт.

Бидний бодлоор бол төрийн албан хаагчийн онолын зарим тодорхойлолт, эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийн **төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын агуулгын бүтцийг бүлэглэн ангилбал:**

1. төрийн албан тушаал ба албан хаагчийн засаглан захирах

[50] "Төрийн мэдээлэл". 2002., №28-аас тодруулан үзнэ үү.

эрх мэдэл;

2. албан тушаалын үүрэг, эрх;

3.хуулиар тогтоосон хязгаарлалт, хориглолт;

4.албан хаагчийн баталгаа;

5.урамшил ба хариуцлага гэсэн өөр хоорондоо харилцан холбоотой цогцолбор шинжтэй ажиллагаа хэмээн томъёолж байна.

3.2. Төрийн албан тушаал ба албан хаагчийн засаглан захирах эрх мэдэл

Төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдал нь төрийн байгууллагын эрх хэмжээнээс үүсмэл. Хамгийн гол нь **төрийн албан тушаал** юм.

Албан тушаал нь төрийн тухайн байгууллагын зохион байгуулалтын **үндсэн нэгж**, төрийн албаны **анхны бүрдүүлбэр** хэсэг юм. Төрийн албан хаагч төрийн аль нэг байгууллагад тодорхой албан тушаал эрхлэн, албан тушаалын зорилт, чиг үүргийг бүрэн эрхийн хүрээнд өдөр тутам гүйцэтгэдэг. Тухайн албан тушаалд ажлын шаардлагаас хамааран төрийн хэчнээн албан хаагч ажиллахыг орон тоогоор тогтооно.

Төрийн албан хаагчийн албан тушаалын чиг үүргээ хэрхэн, амжилттай гүйцэтгэх нь түүний засаглан захирах эрх мэдэлтэй шууд холбоотой. Иймд албан тушаал, албан тушаалын засаглах бүрэн эрх нь өөр хоорондоо харилцан хамааралтай, албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлдог үндсэн асуудал юм.

Албан тушаал нь засаглах эрх мэдэл, албан үүрэг, эрхийн тодорхой хэмжээг тогтооно. Тэгэхлээр төрийн албан тушаал эрхэлсэн албан хаагч бүхэн засаглан захирах бүрэн эрхийг эдлэхгүй. Төрийн үйлчилгээний албан хаагч, багш, эрдэм шинжилгээний болон захиргааны туслах ажилтан гэхэд захиран засаглах бус, сургах, судалгаа хийх, хүнд үйлчлэх зэрэг үүрэг хүлээж, түүндээ зохицсон эрх эдэлнэ.

Төрийн албан хаагчийн дотор **төрийн жинхэнэ албан хаагч** илүү эрх мэдэлтэй, төрийн зорилт, чиг үүрэг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Үүнээс үүдэлтэй Төрийн албаны хуулийн 5.1-д төрийн улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний гэж ангилан, мөн зүйлийн 5.2-т төрийн захиргааны болон тусгай албан тушаалыг **төрийн жинхэнэ албан тушаал,** хуулийн 11.2-т албан тушаалын энэ ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг **мэргэжлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа** Монгол Улсын иргэнийг **төрийн жинхэнэ албан хаагч** гэж заасан билээ.

Төрийн албан тушаалын тодорхойлолт хуульд байхгүй боловч 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр зохих

тодотгол хийгдсэнийг хэлэх нь зүйтэй.

Тухайлбал, "Төрийн албаны тухай хууль"-ийн 7.1-д Төрийн захиргааны албан тушаалд "... **төрийн болгого боловсруулахад зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг ...**" бүхий албан тушаал хамаарна, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 1-д төрийн тусгай албан тушаалд "... **үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн дэг журам хамгаалахтай холбогдсон**" албан тушаал хамаарна; мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д төрийн үйлчилгээний албан тушаалд "... **төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад**" туслах чиг үүрэг бүхий албан тушаал хамаарна гэх мэтээр албан тушаалын зориулалтыг тодруулан заажээ.

3.3. Төрийн жинхэнэ албан хаагчийн үүрэг гүйцэтгэлийн тухайд

Төрийн жинхэнэ албан хаагчид **төрийн захиргааны** болон тусгай албан тушаал эрхэлсэн албан хаагч багтах бөгөөд "Төрийн албаны тухай хууль"-ийн 7.1-д заасан төрийн захиргааны зарим албан тушаалыг дурдвал:

- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх, Үндэсэн хуулийн Цэц, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Монгол Улсын яамны Төрийн нарийн бичгийн дарга, хуульд өөрөөр заагаагүй бол тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Төрийн албаны Зөвлөлийн орон тооны гишүүн; ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал гэх мэт.

Хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн тусгай албан тушаалын заримаас нэрлэвэл:

- Үндэсэн хуулийн Цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;
- Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд Ерөнхийлөгч, Үнэт цаасны хорооны дарга, Үндэсний статистикийн газрын

дарга, дэд дарга;

• Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга;

• дипломат ажилтан;

• зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гал түймэртэй тэмцэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч.

Төрийн аль ч албан хаагчид эрх зүйн байдлын үндсэн элемент нь **үүрэг хүлээх явдал**. Үүрэг нь албан тушаалын үндэс, үйл ажиллагааны агуулга. Төрийн албан хаагчийн олон янзын үүргийг: 1) албаны нийтлэг, 2) албан тушаалын, 3) мэргэжлийн, 4) хязгаарласан гэж хуваан үзэж болно.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасныг төрийн жинхэнэ албан хаагчид хамааралтай албаны нийтлэг үүрэг нь:

• Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

• эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах;

• төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

• албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр тэр, заагийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;

• албан тушаалтны хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;

• төрийн албан тушаалд томилогдмогц өөрийн өмчийн байдлын талаар мэдэгдэж, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар зохих байгууллагад мэдээ өгч байх гэх мэт.

Төрийн жинхэнэ албан хаагч дээрх нийтлэг үүргээс гадна өөрийн эрхэлж байгаа албан тушаалаас хамааран **албан тушаалын** болон **мэргэжлийн** онцлог шинжийг агуулсан үүрэг гүйцэтгэнэ. Эдгээр үүрэг нь хуулиар тогтоогдсон байх ба зарим тохиолдолд хуульд нийцүүлэн тухайн салбарын эрх бүхий албан тушаалтан нарийвчлан тогтоож болно.

Төрийн албан хаагчийн **албан тушаалын** үүрэг нь эрхэлж буй албан тушаалтайгаа холбоотой. Иймд албан тушаал бүрт янз бүр байна.

Нэг байгууллагад ижил албан тушаалд ажиллаж байгаа хүнд байгууллагын захиргаа нь албаны зарим үүргийг ажлын байрны тодорхойлолтод өөр өөрөөр тусган тогтоож болно.

Монголын гаалийн байгууллагаар төлөөлүүлэн авч үзвэл албан тушаалын, мэргэжлийн өөр өөр үүргийг гүйцэтгэнэ. Гаалийн төв байгууллага, түүний харьяа гаалийн газар, хорооны дарга, тухайн байгууллагынхаа үйл ажиллагааг бүхэлд нь удирдан зохион байгуулдаг бол гаалийн улсын байцаагч хууль тогтоомж түүнд нийцсэн эрх зүйн актын хүрээнд албаны хяналт, хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэнэ.

"Гаалийн тухай Монгол Улсын хууль"-ийн 274 дүгээр зүйлд зааснаар Гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагчийн гүйцэтгэх албан тушаалын болон мэргэжлийн зарим үүргээс дурдвал:

- гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хийхдээ төр, байгууллага, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, албан тушаалаа урвуулан ашиглахгүй, хэтрүүлэхгүй байх;
- гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн хууль бус үйлдэл (эс үйлдэхгүй)-ийн талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлэх гэх мэт.

Төрийн албан хаагчийн мэргэжлийн үүрэг нь тухайн байгууллагын тодорхой албан тушаалын үүргээс илүү өргөн утга агуулгыг илэрхийлнэ. Жишээлбэл, Цагдаагийн байгууллагын ямар ч албан тушаалын албан хаагч өөрийн хариуцдаггүй нутаг дэвсгэрт, тухайлбал нийслэлийн өөр дүүрэг, эсвэл орон нутагт гэмт хэрэг, зөлгүй тохиолдол, осол гарсантай тааралдсан бол тухайн цаг үед нь холбогдох байгууллагад мэдээлэх, эмнэлгийн өмнөх болоцоотой туслалцаа үзүүлэх, хүний амь нас аврах, уг аюулыг таслан зогсоох гэх мэт үүргийг хуулиар хүлээлгэсэн байдаг.

3.4. Төрийн жинхэнэ албан хаагчийн эдлэх эрхийн тухайд

Төрийн албан хаагчийн эрх нь хуулиар хүлээсэн үүргээ өдөр тутам биелүүлэх, түүний хэрэгжилтийг хангах нөхцөл бололцоо юм. Ийм эрхийг үүргийн нэгэн адил ерөнхийд нь албаны нийтлэг, албан тушаалын болон мэргэжлийн гэж гурав хуваан үзэж болох юм.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрхийг "Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлд дараахь байдлаар тусгажээ.

- төрийн тухайн албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтыг албан ёсоор гаргуулан авах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах;
- үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн талаар харьяалах дээд шатны удирдах

ажилтны үнэлгээг зөвшөөрөх, эс зөвшөөрөх;

• цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатныхаа албан тушаалтанд ямаар бүюу бичгээр тавих;

• хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалынхаа ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуйгаа гардан эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх эрэгээр орлого олох гэх мэт.

Гаалийн улсын байцаагчийн тухайд дээр дурдсан нийтлэг эрхээс гадна Гаалийн тухай хуулийн 274 дүгээр зүйлд зааснаар эрхэлж буй албан тушаалтайгаа холбоотой дараах эрх эдэлнэ.

• гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, бүрдүүлэлт хийх;

• гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьж биелэлтийг хангуулах;

• гаалийн бүрдүүлэлттэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагын байр, агуулахад нэвтрэн орж үзлэг тооллого хийх, тэдгээрийн данс, бүртгэлийг шалгах;

• гаалийн болон бусад татвар ногдох бараанд нуусныг гэрчлэх баримт, материалыг татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс түр хугацаагаар хураах, эсхүл хуулбарлуулан авах;

• гаалийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчилд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх гэх мэт.

3.5. Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын хязгаарлалт ба хориглолт

Хязгаарлалт гэдгийг тодорхой үйл ажиллагаа явуулах, хийхийг хориглоно гэсэн утгаар ойлгож болох юм. Энэ нь эс үйлдэлд ч нэгэн адил хамаарах ба төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа хугацаанд хууль тогтоомж дахь тухайн хэм хэмжээ үйлчилнэ.

Нийтийн албан хаагчийн гол үүрэг нь албаны үүргээ шударгаар биелүүлэх явдал юм. Энэ үүргээ хэрэгжүүлэхэд албан хаагчид хүлээлгэж болох тодорхой хязгаарлалтыг хасамгүй гэж үздэг.[51]

Хуулиар тогтоосон зарим хязгаарлалт, хориглолт нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах боогдуулсан хэрэг биш. Харин төрийн жинхэнэ албан хаагчийн ажлыг үнэнч шударгаар үр нөлөөтэй гүйцэтгэх нөхцөлийг хангах, иргэдэд түүний итгэх итгэлийг улам нэмэгдүүлэх, албан тушаалаа урвуулан ашиглах, хэтрүүлэхээс сэргийлэх чухал ач холбогдолтой.

"Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-ийн 15 дугаар зүйлд зааснаар төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглохоор тусгажээ. Үүнд:

• албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн

[51] *Административное право зарубежных стран: Учебник.* Под ред. Козырина А.Н. и Штатиной М.А.-М., Спарк, (2003) С.118.

болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох;

• ажил хаялт болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

• албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх;

• нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх;

• хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хувь нийлүүлсэн аж ахуйн нэгжийг гардан удирдах, тэдгээрийн удирдах зөвлөлийн болон захиргааны гишүүн байх;

• хувийн ашиг сонирхлын үүднээс дотоодын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө үүрэг хүлээх, санхүүгийн болон бусад туслалцаа авах.

Гаалийн улсын байцаагчийн тухайд Төрийн албаны тухай хуулийн дээр дурдсанаас гадна Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 275 дугаар зүйлд зааснаар дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

• улс төрийн намын гишүүн байх;

• өөрийн нь гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүмүүсийн гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, эсхүл уг үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх;

• энэ хуульд зааснаас бусад мэдээлэл шаардах, иргэдэд чиглэгдэл учруулах, бусдад давуу байдал олгох зэргээр ялгаварлах гэх мэт.

Жинхэнэ албан тушаал эрхлэхтэй нь холбоотой албан хаагчийн эрх зүйн байдалд иймэрхүү хязгаарлалт хийсэн, хориглосон заалт салбарын бусад хуулиудад бий. Харин төрийн албан хаагчийн эрх зүйн байдалд хийх хязгаарлалт, хориглолт нь зөвхөн тухайн албаны үүрэг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай байхаас бус, хүний түгээмэл эрхийг хязгаарласан, дордуулсан байж үл болно.

3.6. Төрийн албан хаагчийн баталгааны тухайд

Төрийн албан хаагчийн баталгаа нь төрийн албан тушаал эрхэлж буй бүх хүнд нэгэн адил хамааралтай. "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа" гэсэн нэгэн бүлэг асуудал "Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-иар баталгаажин мөрдөгдөж байна.

Төрийн албан хаагчийн нийтлэг болон нэмэгдэл батлагааг **эдийн засгийн, нийгмийн, эрх зүйн, зохион байгуулалтын** гэх мэтээр дотор

нь хуваан үзэж болох юм. "Төрийн албаны тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 1-д баталгааг зориулалт, шинж байдал, эх үүсвэр, онцлог зэргийг харгалзан цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж гэж төрөлжүүлэн тус бүрийг тусгайлан авч үзжээ.

Төрийн албаны тухай хуулийн 27.2.4, 28, 31, 38 дугаар зүйлд **төрийн албан хаагчийн эдийн засгийн баталгааны** нэг болох цалин хөлс, цол, зэрэг дэвийн нэмэгдэл, шагнал урамшил, санхүүгийн баталгаа, зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зохих хэсгийг нөхөн авах зэрэг, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааны талаар нарийвчлан тусгажээ. Жишээлбэл, үг хуулийн 27.2.4-т "төрийн байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах албан хаагчид аминдаа орон сууц барих болон орон сууц, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь зориулан байгууллагаас нь хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгөх"-өөр тусгасан. Энэ хуулийн төрийн албан хаагчийн баталгааг зохицуулсан зүйлд буюу 28.10 дахь хэсгийг 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн[52].

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд албан хаагчид урамшуулал олгох талаар заасан. Иногэхдээ бүтээгдэхүүн нийлүүлэх, өөрийн буюу удирдаж байгаа ажилтнуудынхаа ажлын үр дүнг сайжруулахад тухайн албан хаагчийн оруулсан хувь нэмэр болон байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон урсгал зардлын хэмнэлтийн хэмжээг харгалзана.

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг Төрийн албаны тухай хуулийн 27.1, 27.3, 29, 30, 32 дугаар зүйлээр зохицуулсан. Жишээлбэл, тус хуулийн 29.1-д "Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор түүний цалин хөлснөөс төлбөл зохих бүх шимтгэлийн болон эрүүл мэндийн даатгалын хураамжийн 80-аас доошгүй хувийг төрийн байгууллагын төсвөөс нөхөн төлнө" гэжээ. Мөн зүйлд албан томилолтын зардал болон төрийн албан хаагчийн тэтгэмж, тусламжийн талаар тусгажээ. Мөн шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах, ээлжийн амралт эдлэх, төрийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, зохих хувь, гэр бүлийн нь болон асрамжид байдаг хүмүүст олгох уналга, тээврийн зардал, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг авах, нийгмийн даатгалаас олгох тэтгэмжээс гадна гэр бүлийг дэмжиж хуульд заасан тусламж үзүүлэх гэх мэтийг оруулж болно.

[52] Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны цалинг төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг харгалзан Улсын Их Хурал тогтооно.

Төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбоотой харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай (1994 оны 6 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан. 1999 оны 1 дүгээр сарын 21-нд, 1999 оны 6 дугаар сарын 10-нд, 2000 оны 4 дүгээр сарын 20-нд, 2002 оны 4 дүгээр сарын 19-нд, 6 дугаар сарын 20-нд, 2003 оны 6 дугаар сарын 12-нд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан) болон Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай (1999 оны 6 дугаар сарын 10-ны өдөр) хуулиар, төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн эрхийн харилцааг Хөдөлмөрийн тухай (1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан. 2001 оны 11 дүгээр сарын 30-нд, 12 дугаар сарын 27-нд, 2002 оны 7 дугаар сарын 10-нд, 2003 оны 1 дүгээр сарын 2-нд, 2003 оны 5 дугаар сарын 22-нд, 2006 оны 1 дүгээр сарын 12-нд нэмэлт, өөрчлөлт орсон) хуулиар зохицуулж байна.

Эрх зүйн гэдэгт дээр дурдсан баталгаа хууль зүйн утгаараа хамаарахын зэрэгцээ төрийн албан хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд болон албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх зэрэг хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас түүний ажиллаж байгаа төрийн байгууллага нь хамгаалах үүрэг хуулиар хүлээдэг. Энэ нь эрх зүйн баталгааны тод жишээ юм.

Төрийн албан хаагчийн эрх зүйн баталгааг Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, 25 дугаар зүйл, 27.2.1, 27.2.2, 27.2.3 дугаар зүйлээр зохицуулсан. Жишээлбэл, Төрийн албаны тухай хуулийн 4.2.7-д "хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах"-аар тусгасан. Мөн Иргэний хуулийн 498.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл (эс үйлдэхгүй)-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана". 498.4-т "Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана" гэж заасан.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль 2002 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан бөгөөд энэ хуульд 2003 оны 1 дүгээр сарын 2-ны, 6 дугаар сарын 20-ны, 2005 оны 1 дүгээр сарын 27-ны, 2005 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Хуулийн 14.1.8-д "ажилтныг үндэслэлгүйгээр ажлаас халах, энэ хуулийн 5.1.3-т заасан[53] зарчмыг зөрчих"-ийг

[53] Албан хаагчийг зөвхөн мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадварын

улсын төсвийн байгууллагад хоригложээ.

Эдгээр хуулиудаас гадна төрийн тусгай албан хаагчийн хувьд салбар байгууллагын тухай хуулиар давхар эдийн засаг, хууль зүйн баталгаат заажээ. Тухайлбал, Шүүхийн тухай хуулийн 76-87 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 33-38 дугаар зүйл, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 37-38 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137 дугаар зүйлд нийгэм, эдийн засаг, эрх зүйн нөмөгдөл баталгааг заажээ.

Төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд "Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-ийн 27.2; 30.2-т заасан дараах нөмөгдөл баталгаагаар хангагдана. Үүнд:

• Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйл, 26.1.3-т заасаас бусад тохиолдолд төрийн албанаас халагдахгүй байх;

• Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;

• төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн болович төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр) -ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан нь шалгаруулж авах;

• төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг тухайн байгууллагаас олгоно;

• Төрийн албанаас чөлөөлөгдсөн тохиолдолд 6 сарын албан

үндсэн дээр нээлттэй өрсөлдөөний зарчмаар томилох, ажлын үр дүнг нь бодитойгоор үнэлэх;

тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж, үүргээ гүйцэтгэхтэй холбогдон амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь 3 жилийн албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тусламж олгох гэх мэт.

Эцэст нь тэмдэглэхэд дээрх баталгаа нь төрийн албан хаагчийн хуульд заасан үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, нийгэм ахуй, эдийн засаг, эрх зүй, сэтгэл зүйн бүрэн бодит хамгаалалтыг бүрдүүлсэн байдгаараа чухал ач холбогдолтой.

3.7. Төрийн жинхэнэ албан хаагчийн урамшуулал, хариуцлага

Хариуцлага нь өндөр шаардлага, зохион байгуулалттай ажиллах, албаа сахилгатай гүйцэтгэх харилцан уялдаатай нөхцөлийг бүрдүүлэгч төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдлын бүтцэд хамгийн нолөөтэй, нэг салшгүй хэсэг, хууль ёс, сахилгыг бэхжүүлэх чухал хэрэглүүр юм.

Одоогоор хариуцлага хүлээлгэдэг гол үндэс нь Төрийн албаны тухай хууль болно. Тухайлбал, Хуульд ооröор заагаагүй бол удаа дараа (2 ба түүнээс дээш) албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон, Монгол Улсын харьяатаас гарсан зэрэг нөхцөлд ажлаас хална[54].

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3-д "Төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Төрийн аудитын байгууллага болон төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалт (цаашид "мэргэжлийн хяналт" гэх), Үндсэн хуулийн Цэц, шүүх, прокурорын хяналт, нутгийн ооröö удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалтаас бүрдэнэ" гэж заасан нь хуулийн биелэлтийг хянах эрх зүйн үндсийг тодорлосон хуулийн хэмжээнд тодорхойлсон байна. Иймд төрийн болон нэгжийн өөröö удирдах байгууллагаас хуулийн биелэлтийг хянан шалгана. Энэ талын харилцааг УИХ-ын тухай, Ерөнхийлөгчийн тухай, ҮХ-ийн Цэцийн тухай гэх зэргийн төрөлжсөн хуулиар нарийсган зохицуулсан байдаг.

Мөн төрийн жинхэнэ албанд хоригдох зүйлийг зөрчсөн болон албан үүргээ биелүүлэгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд ооröор заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчид сануулах, албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна, төрийн албанд 1 жилийн хугацаанд

[54] Төрийн албаны тухай хууль. 25 дугаар зүйл.

эргэж орох эрхгүйгээр халах[55].

2002 онд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг тус тус батлан гаргасан нь Захиргааны байгууллага, албан тушаалтны хийсэн үйлдэл тус бүрийг болон хийгээгүй үйлдлийг нь хүртэл хууль ёсонд хэрхэн нийцэж байгаа талаар хянах шүүхийн тогтолцоог үүсгэн бий болгосон байна.

Авилгын эсрэг хуулийн шинээр үйлчилж байгаа нь төрийн байгууллага хууль ёсыг сахих бас нэгэн баталгаа болсон байна. Энэхүү хуулиар авилгалаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хуулийн үйлчлэлд хамрагддаг[56] этгээдэд хориглох зүйлийг тогтоож, албан үүргээ гүйцэтгэж явахдаа авилгалын талаар мэдээлэл олсон төрийн байгууллага, албан тушаалтан мэдээллийг Авилгатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй болохыг, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах, бүртгэх, хадгалах харилцааг зохицуулсан байна.

Төрийн захиран засаглах бүрэн эрхээ хэтрүүлэх, эсхүл албаны үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй тохиолдолд эрх зүйн зөрчилд үзэн, хууль зүйн хариуцлага хүлээлгэнэ.

Төрийн жинхэнэ албан хаагчид хүлээлгэх хууль зүйн хариуцлагын гол төрөл нь **сахилгын шийтгэл** юм. Сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл нь сахилгын зөрчил гаргаж албаны үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн гэм буруутай төрийн жинхэнэ албан хаагчид тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд өөрөөр заагаагүй бол "Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-ийн. 26 дугаар зүйлд заасан сахилгын дараахь шийтгэлийн аль нэгийг эрх бүхий албан тушаалтан шууд удирдах албан тушаалтан, түүнийг томилсон дарга ногдуулна.

- сануулах;
- албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

Сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй бөгөөд харин сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

---

[55] Төрийн албаны тухай хууль. 26 дугаар зүйл.

[56] Төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл тур хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч. төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн эгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан, ОНРТ-ийн үндэсний зөвлөлийн дарга, ерөнхий захирал, төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу тур буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан, МУ-ын ерөнхийлөгч, УИХ, бүх шатны ИТХ-ын сонгуулд нэр дэшигчид энэ хуульд хамрагдана.

учраас албан тушаалд томилохдоо Линкольн мэдлэг чадвар гэхээсээ илүү эв нэгдлийг хангах зорилгыг эрхэмлэж байлаа. Ерөнхийлөгчийн мэдлийн нийт 1639 албан тушаалтнаас 1457-г Линкольн халж өөрчилжээ. Дээд шатны албан хаагчдыг мөн энэ харьцаатай өөрчилж байв. Линкольний засаг захиргааны үед танил талын харилцаа маш их дэлгэрсэн бөгөөд бүр хошин шог ярианы сэдэв ч болж XIX-р зууны сүүлийн хагаст албан тушаалд танил талаа томилох асуудлаар улс төрийн ширүүн тулалдаан ч өрнөж байв.

Линкольний дараа гарч ирсэн Ерөнхийлөгч Жонсоны үед энэ нь улам ширүүссэн байна. Иргэний дайны дараах бүтээн байгуулах зорилтуудыг Засгийн газар олигтой шийдвэрлэж чадахгүй байсан АНУ-ын түүхэн дэх нэн гунигтай цаг үед энэ үйл явц өрнөж байлаа.

АНУ-ын эдийн засаг бүхэлдээ технологийн шинэ зорилтын өмнө зогсож байсан бөгөөд түүний хил хязгаар Номхон далайн бүс нутаг хүртэл тэлэх учиртай байлаа. Гэтэл Засгийн газар нь хэрүүл, маргаан, албан тушаалаа урвуулан ашиглах зэрэг сөрөг нөлөөнд идэгдэж, үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрч байжээ. Улс орны нөөц хүч хувийн ашиг хонжоо хөөсөн албан тушаалтнуудын ажил явуулгаас болж суларч мөхөсдсөн байлаа. Чухамхүү энэ үед шинэтгэлийн төлөө бүлгийг АНУ-ын нэрт зүтгэлтнүүд удирдаж байсан бөгөөд тэд улс төрийн аль нэг хүчний ивээлээр албан тушаал хуваарилах тогтолцоог хурцаар шүүмжилж, түүнийг хувь хүний эрх чөлөөг хязгаарласан хэмээн үзэж, халахыг хурцаар шаардаж байсан байна.

Шинэтгэлийн төлөө иргэний хэд хэдэн нийгэмлэг байгуулагдаж, улмаар 1881 онд шинэтгэлийн төлөө үндэсний Лига нэртэй нэг байгууллагад нэгджээ. Энэ байгууллагын оролцоотойгоор ардчилсан намаас нэр дэвшсэн сенатор Жорж Пендлтон намуудад албан тушаал хуваарилах тогтолцоог эцэс болгох тухай хуулийн төсөл боловсруулж эхэлжээ.

Бүгд Найрамдах намаас албан тушаалд томилогдсон зүтгэлтнүүд намуудад албан тушаал хуваарилах системийн хор уршгийг ухамсарлаж чадаагүй учраас 1882 онд болсон Конгрессын сонгуульд ялагджээ. Үүнээс авсан сургамж нь 1883 онд Конгрессын гишүүд бараг санал нэгтэйгээр Пендлтоны хуулийг батлсан явдал бөгөөд энэ мөчөөс эхлэн АНУ-д төрийн удирдлагын "Мерит" (төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх) тогтолцоо бүрдэж эхэлсэн бөгөөд түүнээс хойшхи АНУ-ын үе үеийн Ерөнхийлөгч энэ тогтолцоог улам боловсронгуй болгон хөгжүүлж ирсэн байна. Үүний үр дүнд АНУ улс төрийн бодлого нь залгамж чанартай, эдийн засаг, нийгэм нь тогтвортой хөгжсөн, ард иргэдийнх нь амьдралын чанар хэлбэрэлтгүй дээшилсэн дэлхийд тэргүүлэх ардчилсан улс орны үлгэр загвар болж чадсан юм.

Сахилгын нэг төрлийн шийтгэлийг давхцуулан ногдуулахгүй ба төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээлгэхгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хуулиар хориглосон заалтыг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болно.

Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч удаа дараа (2 ба түүнээс дээш) албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон, Монгол Улсын харьяатаас гарсан бол түүнийг төрийн жинхэнэ албанаас хална.

Төрийн жинхэнэ албан хаагч "Монгол Улсын Эрүүгийн хууль"-ийн тусгай ангид заасан албаны үүрэгтэйгээ холбоотой, эсхүл бусад гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх нь цөөнгүй бий.

Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийг зөрчиж, захиргааны зөрчил гаргасан, гэм буруутай, хугацаат цэргээс бусад төрийн жинхэнэ албан хаагчид тухайн хуульд заасаар эрх бүхий албан тушаалтан захиргааны шийтгэл ногдуулна.

Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай Монгол Улсын хууль" (2002 он)[57]-д заасаар албан үүргээ гүйцэтгэж байх үедээ цэргийн эд хөрөнгөд хохирол учруулсан гэм буруутай цэргийн албан хаагч учруулсан бодит хохиролын хэмжээгээр нь эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

ДӨРӨВ. Гадаадын зарим орны зохицуулалт

АНУ-ын төрийн албаны тухай[58]

АНУ-ын профессор Дрисенг Деннисийн туурвисан **"Төрийн бодлого ба төрийн хүний нөөцийн менежмент"** (Улаанбаатар, 1998 он) гэсэн бүтээлээс үзэхэд Жорж Вашингтон (1789 оноос) Ерөнхийлөгчийн алба хашиж байхдаа урьд өмнө нь Британийн ноёрхлын эсрэг тэмцэлд хамтран зүтгэж явсан нөхдөө ихэд анхаарч албан тушаалд томилдог байжээ. Ерөнхийлөгч Андрю Жексон (1829 он)-ыг АНУ-д намууд албан тушаалыг хуваарилах системийг тогтоосон гэж үздэг.

Төр, засгийн албан тушаалыг намуудад хуваарилах явдал мэдэгдэхүйц өргөжсөн үе гэвэл Ерөнхийлөгч Авраам Линкольний үе байв. Иргэний дайн заналхийлж байсан тэр үед Ерөнхийлөгчид тушиг тулгуур болох улс төрийн шинэ нам хэрэгтэй байсан нь тодорхой. Тийм

[57] "Төрийн мэдээлэл".2002 он. №
[58] Civil service of USA-Wikipedia, the free encyclopedia

учраас албан тушаалд томилохдоо Линкольн мэдлэг чадвар гэхээсээ илүү эв нэгдлийг хангах зорилгыг эрхэмлэж байлаа. Ерөнхийлөгчийн мэдлийн нийт 1639 албан тушаалтнаас 1457-г Линкольн халж өөрчилжээ. Дээд шатны албан хаагчдыг мөн энэ харьцаатай өөрчилж байв. Линкольний засаг захиргааны үед танил талын харилцаа маш их дэлгэрсэн бөгөөд бүр хошин шог ярианы сэдэв ч болж XIX-р зууны сүүлийн хагаст албан тушаалд танил талаа томилох асуудлаар улс төрийн ширүүн тулалдаан ч өрнөж байв.

Линкольний дараа гарч ирсэн Ерөнхийлөгч Жонсоны үед энэ нь улам ширүүссэн байна. Иргэний дайны дараах бүтээн байгуулах зорилтуудыг Засгийн газар олигтой шийдвэрлэж чадахгүй байсан АНУ-ын түүхэн дэх нэн гунигтай цаг үед энэ үйл явц өрнөж байлаа.

АНУ-ын эдийн засаг бүхэлдээ технологийн шинэ зорилтын өмнө зогсож байсан бөгөөд түүний хил хязгаар Номхон далайн бүс нутаг хүртэл тэлэх учиртай байлаа. Гэтэл Засгийн газар нь хэрүүл, маргаан, албан тушаалаа урвуулан ашиглах зэрэг сөрөг нөлөөнд идэгдэж, үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрч байжээ. Улс орны нөөц хүч хувийн ашиг хонжоо хөөсөн албан тушаалтнуудын ажил явуулгаас болж суларч мөхөсдсөн байлаа. Чухамхүү энэ үед шинэтгэлийн төлөө бүлгийг АНУ-ын нэрт зүтгэлтнүүд удирдаж байсан бөгөөд тэд улс төрийн аль нэг хүчний ивээлээр албан тушаал хуваарилах тогтолцоог хурцаар шүүмжилж, түүнийг хувь хүний эрх чөлөөг хязгаарласан хэмээн үзэж, халахыг хурцаар шаардаж байсан байна.

Шинэтгэлийн төлөө иргэний хэд хэдэн нийгэмлэг байгуулагдаж, улмаар 1881 онд шинэтгэлийн төлөө үндэсний Лига нэртэй нэг байгууллагад нэгджээ. Энэ байгууллагын оролцоотойгоор ардчилсан намаас нэр дэвшсэн сенатор Жорж Пендлтон намуудад албан тушаал хуваарилах тогтолцоог эцэс болгох тухай хуулийн төсөл боловсруулж эхэлжээ.

Бүгд Найрамдах намаас албан тушаалд томилогдсон зүтгэлтнүүд намуудад албан тушаал хуваарилах системийн хор уршгийг ухамсарлаж чадаагүй учраас 1882 онд болсон Конгрессын сонгуульд ялагджээ. Үүнээс авсан сургамж нь 1883 онд Конгрессын гишүүд бараг санал нэгтэйгээр Пендлтоны хуулийг батлсан явдал бөгөөд энэ мөчөөс эхлэн АНУ-д төрийн удирдлагын "Мерит" (төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх) тогтолцоо бүрдэж эхэлсэн бөгөөд түүнээс хойшхи АНУ-ын үе үеийн Ерөнхийлөгч энэ тогтолцоог улам боловсронгуй болгон хөгжүүлж ирсэн байна. Үүний үр дүнд АНУ улс төрийн бодлого нь залгамж чанартай, эдийн засаг, нийгэм нь тогтвортой хөгжсөн, ард иргэдийнх нь амьдралын чанар хэлбэрэлтгүй дээшилсэн дэлхийд тэргүүлэх ардчилсан улс орны үлгэр загвар болж чадсан юм.

АНУ-ын судлаач Ван Райл бичихдээ: "Бүгд Найрамдах Улсыг үүсгэн байгуулагчид улс төрийн бодитой хандлага баримталж, улс төрийн үзэл бодлын эрх ашгийг захиргааны ажлын мэдлэг, туршлага, боловсрол, мөн түүнчлэн улс орныхоо өмнө өндөр хариуцлага хүлээх шаардлагатай хослуулж чадсан нь аз завшаантай хэрэг болсон юм. Үүний ачаар шинээр төлөвшин тогтсон улс үндэстэн улс төрийн тогтвортой үндэс суурьиа боловсруулж чадсан төдийгүй төрийн албыг өндөр мэдлэг чадварын үндсэн дээр нэгдмэл байдлаар зохион байгуулсан нь өнөөдөр ч ач холбогдолтой хэвээр байна" гэж онцлон тэмдэглэсэн байна.

Пендлтоны хууль бол АНУ-д төдийгүй дэлхийн улс орнуудын төрийн хүний нөөцийн хөгжилд шинэ үеийг нээсэн юм. Үүнийг колончлолын бодлого задран унасны дараа тусгаар тогтносон зарим улс орон (тухайлбал, Энэтхэг), дэлхийн II дайны дараа Пендлтоны хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлсэн олон улс (Тухайлбал Япон, Өмнөд Солонгос зэрэг) асар богино хугацаанд буюу 30-40-хөн жилийн дотор өндөр хөгжилтэй буюу Азийн барууд болж хөгжсөн амжилтаа тухайн үед төдийлөн таашаан хүлээж авдаггүй байсан Пендлтоны хуулийн дагуу төрийн албандаа мэргэшсэн, тогтвортой (Мерит) болгосонтой холбоотой гэж өнөөдөр нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч байгаагаас харж болох юм. Тухайлбал Англи 300-400 жил, Япон 150 жил, АНУ 100 гаруй жилийн хугацааг зарцуулан байж 1990-ээд оны хөгжлийнхөө түвшинд хүрч байсан бол Өмнөд Солонгос гучхан жилийн хугацаанд өнөөгийн хөгжлийн түвшиндээ хүрч чадсаныхаа нэг "нууц"-ыг Пендлтоны хуулийн үзэл баримтлалын дагуу мэргэшсэн, тогтвортой төрийн албаныг төлөвшүүлсэн явдал мөн гэж бахархан ярьж байгааг үгүйсгэх аргагүй юм.

АНУ-ын төрийн алба 1872 онд байгуулагдсан. Холбооны төрийн алба нь дүрэмт хувцастай үйлчилгээний албан тушаалтнаас бусад нэгдсэн улсын хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбарт томилогдсон бүх албан тушаалаар тодорхойлогдоно (АНУ-ын хуулийн 5 дугаар бүлэг 2101 зүйл). Спойл тогтолцоо гэсэн утга нь улс төрийн намуудаар дэмжигдэж хэрэглэдэг ажил, албан тушаалыг хэлнэ. Энэ нь дараагийн нэмэлт хууль болон 1883 оны Пендлтонын Төрийн албаны шинэчлэлийн актаар удаан хугацаанд үе шаттайгаар өөрчлөгдсөн. 1909 оноор бараг АНУ-ын холбооны ажиллах хүчний 2/3 нь мэрит тогтолцоон дээр үндэслэж томилогддог, мэргэшлийг нь тест, шалгалтаар хэмждэг болсон. Төрийн албаны тодорхой дээд албан тушаалыг үүн дотроо дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, гүйцэтгэх агентлагууд улс төрийн томилгоогоор томилогддог. 1939 оны Хатч актын дагуу төрийн албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэж байхдаа улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хориглосон.

Мэрит тогтолцоо:

Мэрит тогтолцоо гэдэг нь төрийн албан хаагчдыг улс төрийн хэлхээ холбоон дээр үндэслэж бус тэдний ажил гүйцэтгэх ур чадвар дээр үндэслэж ажилд авах болон албан тушаал дэвшүүлэхийг хэлдэг. Мэрит тогтолцоо нь спойл тогтолцооны эсрэг нь юм.

АНУ-ын төрийн алба нь өрсөлдөөний алба (competitive service), өрсөлдөөнөөс гаднах алба (excepted service) гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Нэгдсэн улсын ихэнх төрийн албаны томилгоо нь сонгон шалгаруулалтын дагуу томилогдог боловч тодорхой төрлүүд болох дипломат алба, FBI, бусад үндэсний аюулгүй байдлын албан тушаалууд өрсөлдөөнөөс гадна албаны дагуу томилдог.

Өрсөлдөөний төрийн алба (Competitive civil service)

Нэгдсэн улсын холбооны засгийн газрын төрийн албаны нэг хэсэг нь өрсөлдөөний (сонгон шалгаруулалт) алба юм. Ажил горилогч нь сонгон шалгаруулалтын журмаар төрийн албанд орох гэж байгаа бол нээлттэйгээр бусад төрийн албанд орохыг хүсэгчидтэй мэрит тогтолцооны дагуу буюу мэдлэг чадвараараа өрсөлдөнө. энэхүү сонгон шалгаруулалтыг Өрсөлдөөний төрийн албаны Боловсон хүчний удирдлагын газар удирдан зохион байгуулна.

Нэгдсэн улсын хуулийн гарчиг 5§2102-р зүйлийн дагуу Өрсөлдөөнийн төрийн алба нь дараах зүйлээс бүрдэнэ.

1. Гүйцэтгэх засаглал дахь төрийн албаны бүх албан тушаал, гэвч дараахь албан тушаал хамаарахгүй. Үүнд:

a) Өрсөлдөөний төрийн албанаас тодорхой шалтгааны улмаас хасагдсан эсвэл хууль тогтоомжийн дагуу хасагдсан албан тушаал;

b) албан тушаалын томилгоо нь нэр дэвшүүлээд Нэгдсэн Улсын Сенатаар баталгаажуулдаг, Сенат шууд томилохоос бусад тохиолдолд;

c) Өндөр дээд хэмжээний гүйцэтгэх албаны албан тушаал.

Ялангуяа, Өрсөлдөөний төрийн албаны гишүүдийг албан тушаал бууруулах болон ажлаас халах процедур нь маш чухал учир нь ажиллагсдын эрхийг хамгаалах зорилгоор Нэгдсэн улсын засгийн газар буюу ажил олгогч нь шударга болон өсөн нэмэгдүүлэх аргыг хэрэглэж эхлэж байна. Ажилтан нь давж заалдах эрх, халах болсон шалтгааны мэдэгдэл, 30 хоногийн өмнөх мэдэгдэл зэргээр хангагдах ёстой.

Өрсөлдөөнөөс гаднах төрийн алба (Excepted civil service)

Нэгдсэн улсын холбооны засгийн газрын ихэнх албан тушаал нь

өрсөлдөөний (сонгон шалгаруулалтын) албаны хэсэг байдаг энэ нь Боловсон хүчний удирдлагын газрын удирдлагаар мэрит тогтолцооны үндсэн дээр ажил горилогчид нь бусад ажил горилогчидтой нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр өрсөлдөнө. Гэсэн хэдий ч зарим агентлагууд (бусад агентлагууд дахь зарим албан тушаал) энэ хэсгээс хасагдсан. Гэвч голдуу өрсөлдөөнөөс гаднах төрийн алба нь мэрит тогтолцооны үндсэн дээр ажилладаг түүнээс гадна энэ албаныханд өөрийн гэсэн ажиллуулах системтэй мөн үнэлгээний шалгууртай. Эдгээр агентлагуудыг өрсөлдөөнөөс гаднах төрийн алба гэж нэрлэдэг бөгөөд эдгээр агентлагуудын албан тушаалууд нь өрсөлдөөнөөс гаднах төрийн албаны нэг хэсэг. Эдгээр агентлагийн ерөнхий хуваарь болон албан тушаалууд нь үндэсний аюулгүй байдал, оюуны өмчийн үйл ажиллагааны чиглэлийн жишээ нь Оюуны өмчийн төв агентлаг, Төрийн Департмент, Үндэсний аюулгүй байдлын агентлаг, Холбооны мөрдөн байцаах байгууллага, Ерөнхийлөгчийн Удирдлагын Хэсэг, Гадаад албаны албан тушаалууд зэрэг болно.

Багш нар, нэгдсэн улс болон хилийн чанд дахь батлан хамгаалах яамны сургуулийн удирдлагууд, мөн патентын байцаагчид гэх мэт албан тушаалууд Өрсөлдөөнөөс гаднах төрийн албанд хамаардаггүй.

Өрсөлдөөнөөс гаднах төрийн албаны нэг анхаарал татсан зүйл нь ажлаас халах эсвэл сахилгын шийтгэл хүлээлгэх явдалд ажиллагсдын давж заалдах эрх нь (өрсөлдөөний албанд ажиллаж байгаа албан тушаалтантай харьцуулахад) харьцангуй бага байдаг.

Өрсөлдөөнөөс гаднах төрийн албаны хуулийн тодорхойлолт:

АНУ-ын хуулийн 5 дугаар бүлэг 2103 зүйлээс:

а) Өндөр дээд хэмжээний гүйцэтгэх алба эсвэл өрсөлдөөний албанд хамаарахгүй төрийн албаны албан тушаалыг өрсөлдөөнөөс гаднах төрийн алба буюу excepted service гэнэ.

б) Нэгдсэн улсын конгрессын хууль тогтоомжид " ангилагдаагүй төрийн алба", "ангилагдаагүй алба" гэдэг нь өрсөлдөөнөөс гаднах төрийн алба гэсэн утгатай.

Герман Улсын Төрийн албаны тухай (Нийтийн албаны эрх зүй)[59]

Нийтийн албаны эрх зүй нь нийтийн эрх зүйн корпораци, нэгдэл, Холбооны нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд алба хаах гэсэн шинжийг илтгэнэ.

Нийтийн албаны субъект нь ажилтан, албан хаагч, түшмэлээс бүрдэнэ. Ажилтан, албан хаагч нь хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээний дагуу байгуулсан гэрээний үндсэн дээр ажиллах бол түшмэлийн хувьд түүний эрх зүйн байдлыг нийтийн эрх зүйн зарим нэг нэмэлт хэм хэмжээ тогтоосон хуулиар тодорхойлно.

[59] *Административное право зарубежных стран. Учебник* /Под ред. Козырина А.Н. и Штатиной М.А.-М.:Спарк, (2003) С.309-311

Ажилтан болон түшмэлийн хооронд гэрээний харилцаа үйлчлэхгүй бөгөөд тэр харилцаа нь захиргааны актаар тогтоосон захирах захирагдах харилцаанд тулгуурлана. Түшмэл нь өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ урт хугацааны туршид бүрэн эрх хэрэгжүүлэх бөгөөд өөрийн ажил олгогчид үнэнчээр зүтгэх нийтийн албаны харилцааны нөхцөлд захирагддаг учраас нийтийн эрх зүйн корпорацийн ажилтан болно.

Мэргэжлийн түшмэлийн харилцааг зохицуулсан гол эрх зүйн акт нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 ба 5 дахь хэсэг байна: түшмэл нь хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ (бүрэн эрх нь үндсэн эрхийг хязгаарлана), хууль тогтоогч түшмэлийн мэргэжлийн үйл ажиллагааны зарчмыг уламжлалт харилцааг тооцсоны үндсэн дээр эрх зүйн зохицуулалтыг нь тодорхойлно. Үүнийг Холбооны эрх зүйн болон мужийн хууль тогтоомжид тусгасан байдаг.

Түшмэлийн эрх зүйн байдлыг тодорхойлсон холбооны хэм хэмжээний гол актад дараахь актууд хамаарч байна:

- Холбооны түшмэлийн гол харилцааг зохицуулсан Түшмэлийн тухай холбооны хууль;
- Түшмэлийн болон төрийн албан хаагчийн баталгааны тухай холбооны хууль;
- Түшмэлийн нийгмийн хамгааллын харилцааг зохицуулсан (золгүй тохиолдол бий болоход нөхөн төлөх төлбөр, тэтгэвэр, тэтгэмж) түшмэдийн хангамжийн тухай хууль;
- Түшмэлийг төрийн албанд ажиллуулах тухай Холбооны тогтоол;
- Холбооны, мужийн, орон нутгийн түшмэлийн харилцаан дахь түшмэлийн эрх зүйн байдлыг тогтоосон актууд. Энэ төрлийн актын гол зорилго нь мөнгөн тэтгэмжийг жигдрүүлэх, албанд авах журмыг тогтоох, нийгмийн хангамжийг хангах харилцааг зохицуулахад чиглэнэ.

Эдгээр актаас гадна түшмэлийн нийгмийн асуудлыг зохицуулсан бусад хууль үйлчилж байна. Үүнд дараах актуудыг нэрлэж болно:

- Амралтын олговрын тухай хууль;
- Томилолтын зардлын тухай холбооны хууль;
- Сахилгын зөрчил гаргасан түшмэлд сахилгын хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулсан сахилгын хууль.

Үндсэн хуульд заасан түшмэлийн мэргэжлийн үйл ажиллагааны ердийн зарчим нь түшмэлийн тухай салбар хуульд хэсэгчлэн агуулагдаж байна. Зарим нэг зарчмыг нарийвчлан зохицуулаагүй боловч бодит байдал дээр хэрэгжилт нь сайн байна. Түшмэлийн мэргэжлийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг тэмдэглэх хэрэгтэй.

Ажил олгогч болон албандаа үнэнчээр ажиллах нийтийн эрх зүйн харилцааны "албаны харилцаа" гэдэг бол түшмэл ажил олгогчтой

хувийн эрх зүйн гэрээний харилцаатай байх бус харин түүний эрх зүйн байдлыг нийтийн эрх зүйгээр тогтоодогт оршино. Түшмэлийн үйл ажиллагаа, түүний цалин хангамж зэргийг хуулиар тогтооно. Цалин хангамжийн харилцааг зохицуулсан хуулиас үзвэл түшмэл нь албан үүргээ гүйцэтгэхдээ ажил хаялт зохион байгуулахыг хориглоно. Ажил хаялт нь хууль тогтоогчоос түшмэлд хориглосон нөлөөлөл болно. Албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх гэдэг нь түшмэл ямар ч үед Үндсэн хуульт журамд болон төрд хэлбэрэлтгүй зүтгэнэ гэсэн утгатай. Үүнтэй холбоотойгоор нийтийн албанд тэнцэх хатуу шаардлагыг тодорхойлдог. Нөгөө талаас үнэнчээр ажиллана гэдэг нь түшмэл албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бус шүүмжлэлээс хамгаалуулах эрхтэй байна.

Бүх насаараа нийтийн албанд ажиллах: түшмэлийг зөвхөн ноцтой зөрчил гаргасан, эсхүл шүүхийн таслан шийтгэх тогтоолоор эрхийг нь 1-ээс дээш жилээр хасаж, хорих ял шийтгүүлсэн тохиолдолд албанаас чөлөөлнө (түшмэлийнд Холбооны хуулийн 48). Нийтийн алба хаах насны дээд хэмжээнд хүрсэн (дээд хязгаарт) тохиолдолд түшмэл тэтгэврийн насанд хүрсэн ч үргэлжлүүлэн ажиллаж болно. Боловсролын салбарын түшмэлд ийм шаардлага тавигдахгүй.

Хангамж, баталгаатай байх зарчим: хуулиар тогтоосон мөнгөн тусламж болон нийгмийн халамж нь албан үүргээ гүйцэтгэсний төлөө олгож буй урамшуулал биш, харин түшмэлийн баталгаат хангамж гэж ойлгогдоно. Энэ нь эрх зүй, эдийн засгийн харилцаанд хараат бус байж өөрийн чиг үүргээ биелүүлэх боломж олгоно.

Үр дүнгийн зарчим: энэ зарчим түшмэлийг албан тушаалд томилох, дэвшихэд онцгой үүрэгтэй. Ажил олгогч түшмэл болон ажлын байранд өрсөлдөгчийг зөвхөн ажлын үр дүнгээр үнэлнэ. Арьс өнгө, хүйс, гарал үүсэл, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол энд ямарч үүрэг гүйцэтгэхгүй.

Түшмэл улс төрийн намын өмнө бус, "бүх нийгмийн" өмнө харуцлага хүлээнэ. Эндээс албан үүргээ нам бусаар гүйцэтгэх буюу ажил олгогчийн зүгээс улс төрийн нөлөө үзүүлэхийг хориглох үүрэг гарч ирдэг.

Улс төрийн итгэл үнэмшил болон нийгэмлэгт гишүүн байх эрх чөлөө гэдэг нь түшмэлд тодорхой улс төрийн итгэл үнэмшил буюу нийгмлэгт гишүүн байхыг тулгах, эсхүл хориглож болохгүй гэсэн агуулгыг илэрхийлнэ. Энэ эрх чөлөө нь Үндсэн хуулийн журмын харилцааны хувьд түшмэл зүй ёсыг баримтлах үүргээр хязгаарлагдана.

ОХУ[60] Төрийн албаны дагнасан 2 хуультай

1. ОХУ-ын Төрийн албаны үндсийн тухай холбооны хууль. 1995 он. 6 бүлэг, 30 зүйлтэй;

[60] www.allpravo.ru

2. ОХУ-ын Төрийн албаны тогтолцооны тухай Оросын холбооны хууль. 2003 он. 4 бүлэг. 18 зүйлтэй. III бүлэг нь Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын үндсийг тухайлан авч үзэж, 9-16 дугаар зүйлд төрийн албан хаагчийн эрх зүйн үндсийг, төрийн албан хаагчийн эрх, үүрэг, төрийн албанд холбогдох хязгаарлалт, хариуцлага, баталгаа, төрийн байгууллага, өөрчлөгдөх, татан буугдах үеийн төрийн албан хаагчийн эрх зүйн байдал гэсэн 8 хэсэгт хуваан авч үзжээ.

Төрийн албан тушаал нь Холбооны Улсын хувьд "А", "Б", "В" гэсэн ангилалтай, тус бүрдээ өөр өөр зэрэглэлтэй нь манай улстай харьцуулбал эрх зүйн байдлын талаар харилцан адилгүй юм байна.

Японы[61] Үндсэн хуулийн 73 дугаар зүйлд төрийн албыг тодорхойлсоноор 2006 оны 50 дугаараар үндэсний төрийн албаны актыг батлсан.

Үндэсний төрийн албаны албан тушаалыг ердийн болон тусгай алба гэж хоёр хуваадаг Ердийн алба нь тусгай албанд хамаардагаас бусад бүх үндэсний төрийн албанаас бүрдэнэ. Тусгай алба нь дараахь албан тушаалтангаас бүрдэнэ. Ерөнхий сайд, Төрийн сайдууд, Үндэсний боловсон хүчний комиссарууд, Аудитын зөвлөлийн аудиторууд, Хууль тогтоох байгууллагын кабинетын ерөнхий захирал, Кабинетын орлогч дарга, Кабинетын эрсдлийн удирдлагын орлогч дарга, Ерөнхий сайдын тусгай зөвлөгч, Ахлах дэд сайд болон, агентлагуудын дэд сайд, Ерөнхий сайдын гүйцэтгэх нарийн бичгийн дарга гэх мэт маш олон албан тушаал үүнд хамаарна.

Японы төрийн алба нь нэг сая гаруй албан хаагчтай, шуудангийн салбар нь хамгийн тос салбар бөгөөд 400000 ажилчид ажилладаг. Дайны дараах үед энэ тоо хэмжээ улам өндөр байсан ч гэсэн 1980 оноос хойш төрийн өмчит компаниуд хувийн өмчлөлд шилжсэн ч гэсэн Японы үндэсний төмөр зам болон NTT ажилчдын тоо эрс буурсан. Засгийн газрын төрийн албан хаагчдыг тусгай болон ердийн төрөл гэж хоёр хуваадаг. Тусгай төрөлд хамаардаг төрийн албан хаагчдын томилгоо нь улс төрийн шийдвэрээр эсвэл бусад хүчин зүйлээр нөлөөлж томилогддог өрсөлдөөнт шалгаруулалтад орлогүй. Эдгээр төрөлд кабинетын сайдууд, бие даасан агентлагын дарга нар, зэвсэгт хүчин болон батлан хамгаалах салбарын гишүүд, элчин сайд хамаарна. Төрийн албаны үндсэн хэсэг нь ердийн албанаас бүрддэг бөгөөд энэ албанд ажилд орох гэж байгаа хүмүүс өрсөлдөөнт шалгаруулалтын дагуу ажилд ордог. Ердийн алба нь бага/доод албан тушаал/алба, мэргэжлийн дээд түвшин гэж хуваагдаг байгаа сүүлийн үед сайн тодорхойлсон төрийн албаны хэлбэр нь элит юм.

Элит систем

[61] Civil service of Japan-Wikipedia, the free encyclopedia

хувийн эрх зүйн гэрээний харилцаатай байх бус харин түүний эрх зүйн байдлыг нийтийн эрх зүйгээр тогтоодогт оршино. Түшмэлийн үйл ажиллагаа, түүний цалин хангамж зэргийг хуулиар тогтооно. Цалин хангамжийн харилцааг зохицуулсан хуулиас үзвэл түшмэл нь албан үүргээ гүйцэтгэхдээ ажил хаялт зохион байгуулахыг хориглоно. Ажил хаялт нь хууль тогтоогчоос түшмэлд хориглосон нөлөөлөл болно. Албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх гэдэг нь түшмэл ямар ч үед Үндсэн хуульт журамд болон төрд хэлбэрэлтгүй зүтгэнэ гэсэн утгатай. Үүнтэй холбоотойгоор нийтийн албанд тэнцэх хатуу шаардлагыг тодорхойлдог. Нөгөө талаас үнэнчээр ажиллана гэдэг нь түшмэл албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бус шүүмжлэлээс хамгаалуулах эрхтэй байна.

Бүх насаараа нийтийн албанд ажиллах: түшмэлийг зөвхөн ноцтой зөрчил гаргасан, эсхүл шүүхийн таслан шийтгэх тогтоолоор эрхийг нь 1-ээс дээш жилээр хасаж, хорих ял шийтгүүлсэн тохиолдолд албанаас чөлөөлнө (түшмэлийнд Холбооны хуулийн 48). Нийтийн алба хаах насны дээд хэмжээнд хүрсэн (дээд хязгаарт) тохиолдолд түшмэл тэтгэврийн насанд хүрсэн ч үргэлжлүүлэн ажиллаж болно. Боловсролын салбарын түшмэлд ийм шаардлага тавигдахгүй.

Хангамж, баталгаатай байх зарчим: хуулиар тогтоосон мөнгөн тусламж болон нийгмийн халамж нь албан үүргээ гүйцэтгэсний төлөө олгож буй урамшуулал биш, харин түшмэлийн баталгаат хангамж гэж ойлгогдоно. Энэ нь эрх зүй, эдийн засгийн харилцаанд хараат бус байж өөрийн чиг үүргээ биелүүлэх боломж олгоно.

Үр дүнгийн зарчим: энэ зарчим түшмэлийг албан тушаалд томилох, дэвшихэд онцгой үүрэгтэй. Ажил олгогч түшмэл болон ажлын байранд өрсөлдөгчийг зөвхөн ажлын үр дүнгээр үнэлнэ. Арьс өнгө, хүйс, гарал үүсэл, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол энд ямарч үүрэг гүйцэтгэхгүй.

Түшмэл улс төрийн намын өмнө бус, "бүх нийгмийн" өмнө харуцлага хүлээнэ. Эндээс албан үүргээ нам бусаар гүйцэтгэх буюу ажил олгогчийн зүгээс улс төрийн нөлөө үзүүлэхийг хориглох үүрэг гарч ирдэг.

Улс төрийн итгэл үнэмшил болон нийгэмлэгт гишүүн байх эрх чөлөө гэдэг нь түшмэлд тодорхой улс төрийн итгэл үнэмшил буюу нийгмлэгт гишүүн байхыг тулгах, эсхүл хориглож болохгүй гэсэн агуулгыг илэрхийлнэ. Энэ эрх чөлөө нь Үндсэн хуулийн журмын харилцааны хувьд түшмэл зүй ёсыг баримтлах үүргээр хязгаарлагдана.

ОХУ[60] Төрийн албаны дагнасан 2 хуультай

1. ОХУ-ын Төрийн албаны үндсийн тухай холбооны хууль. 1995 он. 6 бүлэг, 30 зүйлтэй;

[60] www.allpravo.ru

2. ОХУ-ын Төрийн албаны тогтолцооны тухай Оросын холбооны хууль. 2003 он. 4 бүлэг. 18 зүйлтэй. III бүлэг нь Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын үндсийг тухайлан авч үзэж, 9-16 дугаар зүйлд төрийн албан хаагчийн эрх зүйн үндсийг, төрийн албан хаагчийн эрх, үүрэг, төрийн албанд холбогдох хязгаарлалт, хариуцлага, баталгаа, төрийн байгууллага, өөрчлөгдөх, татан буугдах үеийн төрийн албан хаагчийн эрх зүйн байдал гэсэн 8 хэсэгт хуваан авч үзжээ.

Төрийн албан тушаал нь Холбооны Улсын хувьд "А", "Б", "В" гэсэн ангилалтай, тус бүрдээ өөр өөр зэрэглэлтэй нь манай улстай харьцуулбал эрх зүйн байдлын талаар харилцан адилгүй юм байна.

Японы[61] **Үндэсэн хуулийн 73 дугаар зүйлд төрийн албыг тодорхойлсоноор 2006 оны 50 дугаараар үндэсний төрийн албаны актыг баталсан.**

Үндэсний төрийн албаны албан тушаалыг ердийн болон тусгай алба гэж хоёр хуваадаг Ердийн алба нь тусгай албанд хамаардагаас бусад бүх үндэсний төрийн албанаас бүрдэнэ. Тусгай алба нь дараахь албан тушаалтангаас бүрдэнэ. Ерөнхий сайд, Төрийн сайдууд, Үндэсний боловсон хүчний комиссарууд, Аудитын зөвлөлийн аудиторууд, Хууль тогтоох байгууллагын кабинетын ерөнхий захирал, Кабинетын орлогч дарга, Кабинетын эрсдлийн удирдлагын орлогч дарга, Ерөнхий сайдын тусгай зөвлөгч, Ахлах дэд сайд болон, агентлагуудын дэд сайд, Ерөнхий сайдын гүйцэтгэх нарийн бичгийн дарга гэх мэт маш олон албан тушаал үүнд хамаарна.

Японы төрийн алба нь нэг сая гаруй албан хаагчтай, шуудангийн салбар нь хамгийн тоо салбар бөгөөд 400000 ажилчид ажилладаг. Дайны дараах үед энэ тоо хэмжээ улам өндөр байсан ч гэсэн 1980 оноос хойш төрийн өмчит компаниуд хувийн өмчлөлд шилжсэн ч гэсэн Японы үндэсний төмөр зам болон NTT ажилчдын тоо эрс буурсан. Засгийн газрын төрийн албан хаагчдыг тусгай болон ердийн төрөл гэж хоёр хуваадаг. Тусгай төрөлд хамаардаг төрийн албан хаагчдын томилгоо нь улс төрийн шийдвэрээр эсвэл бусад хүчин зүйлээр нөлөөлж томилогддог өрсөлдөөнт шалгаруулалтад ордоггүй. Эдгээр төрөлд кабинетын сайдууд, бие даасан агентлагын дарга нар, зөвсөгт хүчин болон батлан хамгаалах салбарын гишүүд, элчин сайд хамаарна. Төрийн албаны үндсэн хэсэг нь ердийн албанаас бүрддэг бөгөөд энэ албанд ажилд орох гэж байгаа хүмүүс өрсөлдөөнт шалгаруулалтын дагуу ажилд ордог. Ердийн алба нь бага/доод албан тушаал/алба, мэргэжлийн дээд түвшин гэж хувааж байгаа сүүлийн үед сайн тодорхойлсон төрийн албаны хэлбэр нь элит юм.

Элит систем

[61] Civil service of Japan-Wikipedia, the free encyclopedia

"Энд хэн удирдаж байна вэ" гэдгийг илрүүлэхийг оролдож японы олон судлаачид элит системд хамаарч байгаа хүмүүс тухайн орны маш өчүүхэн хувь болох 1 сая гаруй үндэсний засгийн газрын ажилчидаас бүрдэж байгаа хэдий ч яг үнэндээ японы засгийг удирдаж байна гэдгийг тэмдэглэсэн. Хэдэн зуун элитүүд үндэсний яам болон агентлагуудад алба хашиж байна. Элит систем рүү элсэж орох нээлттэй шалгаруулалтын үндсэн дээр ордог бөгөөд их сургууль, коллежийн зэрэг шаардлагагүй байдаг.

Дүгнэлт

1. Манай улсын хувьд төрийн алба нь эртнээсээ хаант засагтай байсан учир эзний алба болж үүссэн түүхтэй. Өөрөөр хэлбэл эзэн хаан хийгээд түүний шадруудын төлөө, түүний бие төлөөлөгч болох аймаг, хошуудын засаг ноёдын төлөө байжээ. Өнгөрсөн зууны 20-иод оны дунд үеэс буюу Анхдугаар Үндсэн хууль батлагдсанаас хойш нийтийн алба гэсэн чиглэлээр хөгжиж эхэлсэн. Энэ үеэс 1990 он хүртэл манай улс социалист чиг баримжаагаар замнасан учир төрийн алба маань захиргаадалтын дэглэмдээ зохицоод нэг намын төлөө алба болж хувиран гажсан. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчдыг сонгож авах, үнэлж дүгнэх, сайшааж шагнах, буруутгаж шийтгэх гол шалгуур нь тухайн хүний улс төрийн үзэл баримтлал буюу намд үнэнч эсэхийн үнэлэмж болсон байна. Төрийн албанд хүмүүсийг ажилд шалгаруулж авах дөрвөн зарчим гэж байсны хамгийн эхэнд улс төрийн шинж байдал буюу намын бодлого, шийдвэрт үнэнч эсэхийг нь гол болгож байлаа. Ингээд нэг хүний албанаас нийтийн алба руу шилжиж байсан нь гуйваад нийтийн албанаас нэг намын төлөө алба болон хувирчээ.

"Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг" нь юуны өмнө тусгаар тогтносон улсын агуулгыг илэрхийлж, түүний төр засгийн бүтэц, засаг захиргааны хуваарийг нарийвчлан тогтоосны зэрэгцээ уламжлалд тулгуурлан төрийн түшмэлийн албаны эрх, үүргийг нарийвчлан зааж зохицуулсан эрх зүйн цогцолбор шинжтэй баримт бичиг байв.

1924, 1940 оны Үндсэн хуулиар хэдийгээр төрийн захиргааны өмнөхөөс илүү, орчин цагийн БНУ-ын хэлбэрийг сонгосон хэдий ч түүнийг хэрэгжүүлдэг засаг төрийн байгууллагын төвлөрсөн тогтолцоог бэхжүүлсэн байв. Үүнийг цаг үеийн шаардлага мэтээр тайлж болох талтай боловч тэр нь залгамжлагдан чангарснаараа гажуудалд хүргэсэн байна.

2.1960 оны Үндсэн хуулийн оршилд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зорилго бол социализмыг төгөлдөр байгуулж цаашдаа

коммунист нийгэм байгуулах явдал мөн гэсэн эл үзэл баримтлалын дагуу төрийн албаны хөгжил нь явж ирсэн бөгөөд мөн хуулийн 5 дугаар зүйлд: "Төрийн бүх байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим бол төвлөн удирдах ардчилсан ёс мөн" гэж заасан байна. Энэ дагуу төвлөн удирдах системтэй төрийн захиргааны дээд төв удирдах байгууллагын захиргааны удирдлагын системтэйгээр үйл ажиллагаа явуулж иржээ. Өөрөөр хэлбэл Ардын Их Хурал түүний чөлөө цагт Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөл, Улсын тусгай хороод, орон нутгийн АДХ тэдгээрийн тэргүүлэгчид Шүүх, Прокурор хууль хяналтын байгууллага зэрэг нь төрийн байгууллагуудын үндсэн цөм нь болж байв. Түүнчлэн БНМАУ-ын Ардын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага байсан бөгөөд шүүх, прокурорын байгууллагын системд хүртэл оролцож тодорхой эрх эдэлдэг байв.

Төрийн албан хаагчдын эрх зүйн зохицуулалтын хувьд үндсэндээ төрийн албан хаагчдыг томилох журмаар ажиллуулдаг төвлөрсөн систем бүхий тодорхой улс төрийн алба болон шүүхийн системд сонгох зарчмаар ажилуулдаг байв.

Хэдийгээр 1970-аад оноос уралдаант шалгаруулалтын үндсэн дээр төрийн албанд иргэдийг авч ажиллуулж байсан боловч энэ нь өнөөгийн Төрийн албаны хуулийн төрийн жинхэнэ албан хаагчдыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр мэргэшлийн шалгалт авч шалгаруулдаг тогтолцооноос зарчмын хувьд өөр байлаа. Өөрөөр хэлбэл "томилох" систем түлхүү байсан нь тухайн үеийн эрх зүйн зохицуулалтаас харагдаж байна.

Харин "сонгох" системийн хувьд БНМАУ-ын бүх шатны шүүхийг сонгуулиар байгуулдагт оршиж байв. БНМАУ-ын Ардын Их Хурлаас БНМАУ-ын дээд шүүхийг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс тусгай (цэргийн) шүүхийг хуульд заасан хугацаагаар тус тус сонгоно. Аймаг, хотын шүүхийн шүүгч, ардын төлөөлөгчдийг аймаг, хотын ардын депутатуудын хурал, мөн аймгийн нүүдлийн шүүхийн шүүгчийг аймгийн ардын депутатуудын хурлын чуулганаас 3 жилийн хугацаагаар сонгодог байжээ. Харин районы шүүхийн шүүгчийг тухайн районы ардын депутатуудын хурлын чуулганаас 3 жилийн хугацаагаар сонгоно. Нүүдлийн болон районы шүүхийн ардын төлөөлөгчдийг тухайн нүүдлийн шүүхийн ажиллах сум ба районы хөдөлмөрчдийн хурлаас сонгуулийн системийн зарчмыг үндэслэн мөн 3 жилийн хугацаагаар ил сонгодог байсан нь тэр үеийн шүүхийн зохион байгуулалтын системийн нэг онцлог байв.

Прокурорын байгууллагын хувьд эрх хэмжээ чиг үүргийн хувьд одоогийнхоос ялгаатай зохицуулалттай зүйл нэлээд байсан байна.

Эдгээрээс заримыг тодруулбал прокурор Улсын Дээд шүүхийн

бүгд хурлын зарим шийдвэрт хориг тавих АИХ-д энэ талаар мэдэгдэл бичих эрх хэмжээтэй байсан, босоо төвлөрсөн удирдлагын системээс гадна хамтын удирдлагын систем хэрэгжиж байсан зэргийг дурдаж болно.

Төрийн албанд олон ургалж үзэл төдий л хөгжиж эхлээгүй, төрийн албанд улс төрийн тэр тусмаа нэг намын бодлого шийдвэр үйл ажиллагаа нь төрийн аппаратын тусламжтайгаар хэрэгждэг улс төрийн нөлөөлөл бол төрийн албыг бүрэлдүүлэх, үйл ажиллагааг зохицуулах үндсэн тулгуур зохицуулалт нь болж өгч байжээ гэхэд хэлсдэхгүй болов уу.

Харин 1990 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлтийн хууль батлагдсан бөгөөд энэ хуулиар төрийн албаны бүтэц зохион байгуулалтанд тодорхой өөрчлөлт орж 1960 оны Үндсэн хуулийн 3, 4 дүгээр бүлэг хүчингүй болсон юм. Тухайлбал уг хууль батлагдсанаар Ардын Их Хурал, Улсын Бага Хурал шинэчлэн зохион байгуулагдаж эрх хэмжээ нь өөрчлөгдсөн. Тухайлбал БНМАУ-ын дэд Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн албан тушаал шинээр бий болжээ. 1960 оны Үндсэн хууль холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байсан Сайд нарын Зөвлөлийн эрх хэмжээг Засгийн газарт шилжүүлж эрх, үүргийг уг хуулиар зааж өгсөн нь төрийн албаны хөгжил, бүтэц зохион байгуулалтын шинэ үеийн эхлэл байлаа.

3. Монгол Улсын Төрийн албаны 1994 оны хууль нь манай шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан, өмнөх төрийн албаны зохих уламжлалд суурилсан төрийн албаны дагнасан анхны хууль юм.

4. Монгол Улсын Төрийн албаны тухай анхны хуульд "төрийн захиргааны албан хаагч"-ийн талаар илүү анхаарал хандуулсан бол **2002 оны Монгол Улсын Төрийн албаны хуулийн шинэчлэсэн найруулга төрийн захиргааны болон тусгай албан тушаалын ангиллын хүрээнд "төрийн жинхэнэ албан хаагч" болгон нэр томьёоны төдийгүй үзэл баримтлал, зарчмын шинжтэй агуулгын шинэчлэл, баяжилт хийсэн нь эрх зүйн шинэтгэлийн нэгэн үр дүн** юм.

Мөн онол, арга зүйн хөгжил, практикийн ололтод түшиглэсэн тухайн үеийн эрх зүйн шинэтгэлийн үр дүн, хууль тогтоогчийн өмнөх нэмэлт, өөрчлөлтийн үргэлжлэл, сайжран боловсруулагдсан оюуны үнэлэмж хэмээн үзэж болно.

5. 2008 онд Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр улс төрөөс бусад төрийн албан хаагчийг улс төрийн намаас тусгаарлаж, захиргаа, тусгай, үйлчилгээний албан хаагч

сонгуулийн аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглосон.

Төрийн албаны зөвлөл төрийн албан тушаалд нэг л хүнийг нэр дэвшүүлэх, эрх бүхий этгээд түүнийг нэг л удаа буцаах бололцоо нээгдсэн. Өмнө нь 3-5 хүний нэр дэвшүүлдэг байхад тэднээс ур чадвартайг нь бус өөрийн үзэмжээр дээд албан тушаалтан нь томилох хандлагатай байв.

Төрийн албан тушаалд томилох эрх бүхий этгээдийн гаргасан хүний нөөцийн менежменттэй холбоотой хууль бус шийдвэрийг Төрийн албаны зөвлөл хүчингүй болгох эрх ч бас үүссэн. Энэ нь улс төрөөс хамааралгүй, мэргэшсэн, тогтвортой, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах төрийн албаны шинэтгэлийн шинэ үеийн зааг дээр ирснийг харуулж байгаа юм.

6. Төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдал нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, эдгээрт нийцэж гарсан хууль тогтоомжийн бусад актаар нарийвчлагдан тодорхойлогдох ойлголт болох нь харагдаж байна.

Төрийн албан тушаал, албан хаагчийн засаглан захирах эрх мэдэл, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, эрх зүйн байдлын хязгаарлалт ба хориглолт, ажиллах нөхцөл, баталгаа, хүлээх хууль зүйн хариуцлага зэрэг ухагдахуун нь тус бүрдээ онолын үндэс, хууль тогтоомжийн хэрэглээнд зохих судалгаа, нотолгоо хийхийг шаардсан, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тогтоох үндсэн элемент хэмээн үзэж болно.

Төрийн албан тушаалын болон албан хаагчийн ангиллын дотор төрийн жинхэнэ албан тушаал, албан хаагч нь засаглан захирах талаар илүү эрх мэдэлтэй, тэр нь хууль зүйн зохицуулалтаас илэрхий харагдаж байгааг тухайлан тэмдэглэе.

Гэхдээ төрийн улс төрийн болон үйлчилгээний албан хаагчийн эрх зүйн зарим байдлыг орхигдуулаагүй, нэгэн адил авч үзсэн болно. Нөгөө талаар байгууллага, ажилтнаа засаглах талаасаа бус, удирдан захирах, зохион байгуулах үүрэг гүйцэтгэдгийг бас үгүйсгээгүй.

Төрийн албаны эрх зүйн зохицуулалтад төрийн жинхэнэ албан хаагчийн эзлэх байр, гүйцэтгэх үүрэг, захиргааны эрх зүйн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж гүнзгийрүүлэн судлах зайлшгүй шаардлага хэвээр хадгалагдаж буй нь эргэлзээгүй.

ХОРИХ АНГИЙН ТӨРӨЛ, ДЭГЛЭМИЙГ НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хууль зүйн ухааны хүрээлэнгийн судалгааны тайлан[*]

Удиртгал

Эрх зүйн шинэтгэл хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Их Хурал 2002 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн батлсан. Эдгээр хуулийг хэрэгжүүлсээр 10 гаруй жил өнгөрч байгаа бөгөөд энэ хугацаанд зохицуулж байсан нийгмийн харилцаанд ихээхэн өөрчлөлт гарснаар хөгжлийн шаардлагад нийцүүлэн дээрх хуулиудад зарим өөрчлөлт хийх шаардлагатай болсон.

Энэ үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.11-т "Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, ялтныг хуульд заасан шаардлага, олон улсын жишигт нийцсэн нөхцөлд ял эдлүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлэх онол, практикийн асуудлыг судалсан.

Хорих ялын онцлог

Хорих ял нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд заасан хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлан, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг төрийн албадлагын хатуу цээрлэл агуулсан арга хэмжээ юм.[1]

Хорих ялыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд гэхчлэн нас, хүйсийн байдлыг харгалзан тус тусад нь эдлүүлэхээс гадна ялтанд үзүүлэх эрхийн хязгаарлалтын хэр хэмжээгээр өөр хоорондоо ялгарах дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлдэг. Энэ нь хүнд, онц хүнд гэмт хэрэгтнээс хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг, онц аюултай болон рецедив гэмт хэрэгтнүүдээс анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг тусгаарлан ялыг эдлүүлэх зорилготой байдаг.[2]

[*] Судалгааг удирдсан ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрхлэгч Ж.Энхнасан, хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд.

[1] УДШ, Ханс Зайделийн Сан. (2010) *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*. Зохиогчдын хамтлаг.-162-163.

[2] Мөн тэнд

Эрх зүйн орчин

Монгол Улсад гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон хүнд хорих ял эдлүүлэхдээ Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.4-т "Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлнэ.", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйл "Баривчлах байр, жирийн дэлгэмтэй хорих анги", 108 дугаар зүйл "Чанга, онцгой дэглэмтэй хорих анги", 109 дүгээр зүйл "Гяндан" гэсэн зүйл, хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу хорих ялыг эдлүүлж байна.

Монгол Улсад хорих ял эдлүүлж буй байдал

Сүүлийн 3 жилийн дунджийг авч үзвэл жилд 5835 хүн хорих ял эдэлдэг байна. Прокурорын байгууллагын ажилтны хийсэн судалгааны дүнгээс[4] үзэхэд жилдээ хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 12000, харин хорих байгууллагын албаны хүний дүнгэлтээс үзэхэд жилд дунджаар 6000 орчим хүн хорих ял эдэлдэг .[4]

"Хорих ялын өртөг" сэдэвт судалгаанаас үзвэл хорих ял эдэлж буй ялтанд (хорих байгууллагын захиргааны зардлыг оруулан тооцвол) нэг жилд дунджаар 812,000 төгрөг зарцуулдаг бөгөөд үүний 67 хувийг ялтанд өөрт нь зарцуулдаг.[5] Жилд дунджаар 5835 хоригдол ял эдэлж байна хэмээн үзэх юм бол зөвхөн хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд 4 тэрбум 760 537265 төгрөг төсвөөс жил тутам зарцуулж байна.

Баривчлах ял

Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд баривчлах ялыг "гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгах замаар сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлэх" хэлбэрээр эдлүүлэхээр заажээ. Гэвч баривчлах ял шийтгүүлсэн этгээдийг жирийн дэглэмтэй хорих ангид олноор нь хорих, эсхүл бусад хоригдлын нэгэн адил ажил хөдөлмөр эрхлүүлэх зэргээр хуульд заасан ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчиж, хүний эрхийг хохироох явдал маш түгээмэл байна. Ийнхүү хорих, баривчлах ялыг ялгамжгүйгээр эдлүүлснээр Эрүүгийн хуульд заасан ялын зорилго биелэгдэхгүйд хүрч байна.

Баривчлах ялыг хуульд заасан зорилго, шаардлагын дагуу эдлүүлэх

[3] Мөнхбат Ц. (2006-2) *"Хорих ялын хэрэгжилт өнөөгийн байдал"* // Хууль дэздлэх ёс сэтгүүл, 73.

[4] Дамдинцэрэн Д. (2008) *Шүүхийн шийдвэр, түүний хэрэгжилт илтгэл. Эрх зүйт төр-хууль ёсны хэрэгжилт* /Үндэсний зөвлөгөөний илтгэлүүд/ . 162...

[5] Монгол Улсын хорих байгууллагын төрөл дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх зарим асуудал" хэлэлцүүлэг., (2010) 32.

нөхцол, боломжийг төр бий болгох, ийнхүү бий болгож чадахгүй гэж үзвэл түүнийг ял шийтгэлийн төрлөөс бүрмөсөн хасахаас өөр аргагүй юм. Энэ нь хууль тогтоогчийн хувьд хамгийн хялбар мэт боловч хамгийн муу хувилбар мөн.

Баривчлах ялыг "ганцаарчлан" эдлүүлэх нөхцөл, шаардлагыг бий болгож чадвал уг ял нь хорих ялын альтернативд нэлээд үр нөлөөтэй байх боломжтой.

Насанд хүрэгчийн хүн нь Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан "Хорих ангийн дотоод журам"-д заасан эрх зүйн орчинд насанд хүрэгчидтэй нэгэн адил нөхцөлд цагдан хоригдож, хорих ял эдэлж байна. [6] Цаашид насанд хүрэгчий (хүүхдэд) хүмүүсийн хорих ангийн дотоод журмыг тусгайлан гаргаж, мөрдөн ажиллах хэрэгтэй.

Монгол Улсын хорих ангийн дэглэмийн талаарх тайлбарыг[7] үзвэл:

Жирийн дэглэмтэй хорих анги: low (minimium)-regime prison-хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц аюултай хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэн, онц аюултай гэмт хэрэгт тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг эдлүүлнэ.

Чанга дэглэмтэй хорих анги: medium-regime prison-хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсвэл урьд хорих ял эдэлж байсан эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтан хорих ялыг эдлүүлнэ.

Онцгой дэглэмтэй хорих анги: Special regime prison-онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг эдлүүлнэ.

Хорих ангийн нээлттэй, хаалттай төрөл дэглэмийн хэлбэрийг зөвхөн нэр томъёонд шилжүүлэн, орчуулсан байдлыг үзэхэд Монгол Улс нь олон улсын стандартад нэлээд дөхөж очсон, 3 төрлийн дэглэм бүхий хорих ангид ял эдлүүлж байгаа мэт харагдахаар байна. Бусад орны туршлагыг судалж, хорих ялын тогтолцооны талаар орчуулгын шинэ нэр томъёо хэрэглэснээр байдал өөрчлөгдөхгүй нь ойлгомжтой тул гадны сайн туршлага буюу олон улсын стандарт жишигт хорих ял эдлүүлэх нөхцөл, журмыг хэрхэн нийцүүлсэн байдлаар дүгнэх нь зүйтэй юм.

Тайлбар: Хорих ангийн төрөл, дэглэмийг "imprisonment type" эсхүл "prison security levels" гэх зэргээр ялгаатай нэрлэсэн байгааг анхаарах. Тухайлбал хорих ангийн нээлттэй хэлбэрийг "opening prison" гэж ХБНГУ ангилсан байхад Чех[8] улсад prisoners in minimium

[6] "Насанд хүрэгчий хүмүүсийн цагдан хорих байр, хорих ангийн дотоод журам боловсруулах" судалгааны ажлын тайлан, (2009). ХЗҮХ, ЭЭЗКС..

[7] Нарангэрэл С. (2008) *Эрх зүйн эх толь бичиг /Dictionary of law/* 498.

[8] http://legislationline.org/documents/action/popup/id/5779

security" хэмээн ангилжээ.

Гадаадын зарим орны хорих ангийн нээлттэй төрөл, дэглэм

Гадаадын эрдэмтэн, судлаачдын бичсэнийг" үзвэл зарим орны хорих ангийн төрөл, дэглэм нь пенологийн[10] хөгжлийн үе шатуудад тухай бүр зохицсон байдлаар хөгжиж, төлөвшиж ирсэн байна. Хуучин ЗСБНХУ задран бутрах үед "ГУЛАГ"[11]-ийн тогтолцоог хуулбарлан хэрэглэж байсан "посткоммунист" гэсэн тодотголтой Эстони, Латви, Польш, Чех, Унгар гэх мэт орон Европын холбоонд нэгдэн орохын тулд эрүүгийн болон шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн системээ цоо шинэ өөрчлөлт хийж, хүний эрхийг баталгаажуулсан стандартыг хүлээн зөвшөөрч, тодорхой үр дүнд хүрч байна.

Монгол Улс нийгэм эдийн засгийн салбарт хийж буй зарим шинэчлэл, өөрчлөлтийг Евростандартад нийцүүлэх зорилтын хүрээнд эдгээр улсын сайн туршлагыг зээлдэн авах, өөрийн хөрсөнд буулгах зэргээр бодитой ажлыг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Судалж үзсэн гадаадын улсуудад:

- Эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх;
- Хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх;
- Тусгайлсан хууль гаргах (Prison Act);
- Эрүүгийн хууль тогтоомжийн хорих ялын хэсэгт нэмэлт, өөрчлөлт хийж хоригдлыг нээлттэй, хаалттай дэглэмд ял эдлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай бодлогын баримт бичиг гаргах
- Хүний нөөцийг шинэ нөхцөлд ажиллах бэлтгэлийг хангах зэрэг цогц арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

ХБНГУ

ХБНГУ-ын эрүүгийн хууль тогтоомж нь олон хууль (Эрүүгийн хууль, Ялын тухай хууль, Шоронгийн тухай хууль зэрэг)-иас бүрддэг. Ялтныг нийгмийн өмнө хариуцлага хүлээхүйц, нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх, түүнийг нээлттэй хаалттай төрөл дэглэмд ялгамжтай эдлүүлэх зорилгыг Ялын тухай хууль (1975 он) агуулсан байдаг. 1977 онд батлагдсан "Шоронгийн тухай" (Prison Act) хууль тус тус хамаарна. ХБНГУ-ын Шоронгийн тухай хуулийн зорилго нь хорих ялын нээлттэй хэлбэр ялтныг хэвийн амьдралд эргүүлэн

[9] Dirk Van Zyl Smit, Frieder Dünkel, / 2011/ "Imprisonment today and tomorrow: international perspectives on prisoners' rights and prison conditions

[10] Penology: deterrence, prison, prison reform, prisoner abuse, prisoners' rights, rehabilitation, recidivism, retribution

[11] "GULAG" нь хорих ангийн төрөл, дэглэмийн социалист системийн үеийн нэн түгээмэл хэлбэр бөгөөд хүний эрхийг ихэд дордуулсан, бусад байдлаар нэр төрийг нь гутаан доромжилж эрүүдэн шүүж харьцдаг байсан систем. Одоогийн зарим постсоциалсит орнууд ЗСБНХУ-ын хорих ангийн төрөл дэглэмийг хуулбарлан хэрэглэж байв.

оруулах, хуульд захирагдах, өөрийн үйлдлийн аливаа хариуцлагыг хүлээх, хэвийн ажиллаж амьдрахыг хангаж хариуцахад сургадаг. Энэ зорилгын үндсэн ачааллыг хорих байгууллагын нийгмийн алба үүрдэг.

Тус улсад харьцангуй хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, цөөн жилийн хорих ялтай ялтнуудыг нийгэмд дасгах, хөндийрүүлэхгүй байх зорилгоор суллагдахаас нь өмнө "нээлттэй" ангид байлгадаг.

Хорих ангийн нээлттэй хэлбэр нь:

- гэрээ харихад бэлтгэх (furlough and Hafturlaub) ;
- богино хугацааны хорих хэлбэр (Ausgang);
- ажил хөдөлмөр эрхлэх дэглэм (Freigang) гэсэн гурван ялгаатай дэлгэмтэй. Гэртээ харихад бэлтгэх дэглэм нь хуанлийн 21 өдрийн өмнөөс, богино хугацааны хорих хэлбэр нь хорих байгууллагаас гадуур өдөрт хэдэн цаг ажил эрхлэх боломж олгодог, харин ажил хөдөлмөр эрхлэх дэглэм нь хорих ангийн хяналтаас гадуур хөдөлмөр эрхлүүлдэг (сард 500 дойч марк). Энэ хэлбэр нэлээд түгээмэл бөгөөд Германы нийт хорих ангийн 60 хувь нь ийм нөхцөлтэй байна.

1980-аад онд Германы Хууль зүйн яамны дэргэд "Нийгмийн туслалцааны хүрээлэн" байгуулагдсан ба тэнд хөдөлмөрийн зах зээлийг судалж, гол компани, бусад аж ахуйн нэгж болон шаардлагатай бусад байгууллагатай холбоотой ажиллаж, суллагдаж буй хүмүүст гэр бүлийн болон санхүүгийн бэрхшээлээ гэтлэхэд нь туслахуйц зөвлөгөө өгдөг байна.

Хорих байгууллагын захиргаа, нийгмийн ажилтнууд хөдөлмөрийн биржтэй нягт харилцан ажиллаж, аж ахуйн аль чиглэлийн байгууллага өргөжин тэлж байгааг харгалзан тэнд ажиллах мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр сургалтын материаллаг баазыг бүрдүүлж байдаг.

Ялтны хорих ял эдлүүлэх ажиллагааг хэд хэдэн үе шатанд хуваадаг:

- Хорих байгууллагын нөхцөлд дасах үе;
- Засран хүмүүжих үе
- Суллагдахад бэлтгэх үе.

Хорих ял эдлэх бүхий л үе шатанд нийгмийн ажилтан тэднийг судалж, хувийн хэрэгт нь төлөвлөгөөний дагуу дүгнэлт бичдэг. Энэхүү төлөвлөгөөнд:

1. Хаалттай болон нээлттэй хорихын аль нөхцөлд байх;
2. Ижил харьцаа бүхий хэсэгт бусадтай хамт байж болох эсэх;
3. Ажил хийх, мэргэжил эзэмших, мэргэших болон давтан сургалтад хамруулах;
4. Мэдлэгээ дээшлүүлэх;
5. Тусгайлсан тусламж үзүүлэх;
6. Ял эдлэх нөхцөлийг хөнгөрүүлэх;

7. Суллагдахын өмнө ажил гүйцэтгэх гэсэн хэлбэртэй байна.

Чөлөөт амьдралд оруулахын тулд хорих ялын дэглэмийг бууруулж болох ба суллагдахаас 3 сарын өмнө 7 хоногийн чөлөө олгох, мөн хорих байгууллагаас гадуур чөлөөтэй явах эрхтэй ялтанд сар бүр 6 хоногийн чөлөө олгодог. Энэ нь дээр дурдсан 3 төрөл, дэглэмийн онцлогт тохирсон байна.

ХБНГУ-ын хорих ангийн нөхцөлтэй төрөл, дэглэмийг үзвэл тус улсын Эрүүгийн хуулиас гадна "Ял шийтгэлийн тухай хууль" (Penal Code), "Шоронгийн тухай хууль" (Prison Act) гэх мэт салбар хуулиуд үйлчилдэг. хорих нөхцөлтэй хэлбэрүүд болох Гэрт нь харихад бэлтгэх хэлбэр (furlough-Haftурlaub), богино хугацааны хорих хэлбэр (Ausgang) зэрэг нь Монгол Улсын Эрүүгийн баривчлах, албадан ажил хийлгэх ялтай хуульчилсан хэлбэрийн хувьд тестэй мэт боловч тухайн улсын ялын тогтолцооны онцлогтой бүрэн нийцсэн, зарчим, зорилгын хувьд эрс ялгаатай байна.

Эстони Улс[12]

Постсоциалист орон гэгдэх энэ улс Европын холбоонд амжилттай нэгдэн орохын тулд 1994 онд Эрүүгийн хууль (Criminal code) болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх (Code of Enforcement procedure) тухай хуульдаа зарчмын шинжтэй өөрчлөлт хийжээ. Ингэснээр өмнө байсан "ГУЛАГ"-ийн хорих лагераас бүрэн татгалзаж хорих ялын төрөл, дэглэмийг:

- Closed prison;
- Semi- closed prison;
- Open prison гэж ангилсан байна.

Тус улс хорих ангийн нөхцөлтэй хэлбэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 98, 119-124 дүгээр зүйлд заахдаа ажил хөдөлмөр эрхлэх боломжтой байх, гэр бүлийнхэнтэйгээ уулзаж, өөрт тохирсон хөдөлмөр эрхлэх талаар оруулсан байна. Тус улс 1996-1997 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон хорих байгууллагадаа томоохон өөрчлөлт, шинэчлэл хийж улмаар 2000 онд Шоронгийн тухай хууль (Prison Code) -ийг батлан гаргажээ. Энэ хуулийг батлан гаргахдаа Герман, Франц улсын холбогдох хуулиудын зарим хэсгийг судалж үзсэний үндсэн дээр "зөөлдэн" авч хэрэглэсэн байна.

Финланд Улс[13]

Финландын хорих байгууллага онцгой, жирийн, нөхцөлтэй гэсэн

[12] http://legislationline.org/documents/action/popup/id/5715 /холбогдох хуулийг хавсаргав/

[13] Penal code of Finland буюу Финландын ялын тухай хуулийг хавсаргав.

гурван төрлийн дэглэмд хуваагддаг. Онцгой дэглэмд ял эдэлж байгаа ялтныг нийгмээс тусгаарлаж манай улсын чанга дэглэмтэй төстэй нөхцөлд байлгадаг байна. Жирийн дэглэмд ял эдэлж байгаа хоригдлууд хоорондоо уулзаж болох ба хянагчийн харгалзаатайгаар гадуур явж болдог.

Нээлттэй хорих ангид оргох зуртахаас сэргийлсэн хашаа, тор байхгүй бөгөөд ялтан өрөөнийхөө түлхүүрийг эзэмшиж дотор нь чөлөөтэй явах, мөн энгийн хувцас өмсдөг. Зарим тохиолдолд хорих ялыг 8 сар хүртэл албадан ажил хийлгэхээр сольж болдог. 20-200 цагийн албадан ажил хийхдээ 7 хоногт 2 удаа 3-4 цаг ажилладаг. Энэ ялаар сольсон нөхцөлд ажил сургуулиасаа хөндийрөлгүй, гэр бүлийнхэнтэйгээ амьдарч гүйцэтгэдэг байна.

Финландын Ялын тухай (Penal Code) хуулиар ялтныг аль болох ердийн аж амьдарлын нөхцөлд ойр байлгах, "хоригдоно" гэдэг нь мөн чанартаа хүнд шийтгэл тул түүнийг яаз бүрийн нэмэлт арга, хэрэгслээр хүндрүүлэхгүй байх, улмаар ямар нэг анкет, баримт бичигт ял эдэлж байсныг дурдахгүй байхаар тус тус заасан байдаг.

Их Британи[12]

Хорих байгууллага нь Их Британийн Дотоод хэргийн яаманд байх бөгөөд дараах хэлбэртэй байна.

- 3-аас дээш жилтэй ялтнуудын нэгдсэн хорих анги;
- 12 сараас дээш ял эдлэх анх удаа ял шийтгүүлсэн ялтнуудын хорих анги;
- 21 -ээс дээш насны гэмт хэрэг үйлдсэн эгтгээдүүдийн хорих анги;
- Анх удаа гэмт хэрэг үйлдсэн ялтнуудын хорих анги;
- 21 хүртэл насны хүмүүст зориулагдсан хорих анги;
- Насанд хүрээгүйчүүдийн богино хугацаагаар засан хүмүүжүүлэх төвүүд байдаг.

Ялтны ял эдлэх хугацааг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. Туршилтын хугацаа (ганцааранг нь байлгах);
2. Засан хүмүүжүүлэх үе (хамтаар байлгаж, хөдөлмөрт татан оролцуулах);
3. Хугацаанаас өмнө тэнсэн суллах (ялын 4/3-ийг эдэлсэний дараа).

Засан хүмүүжүүлэх болон суллахын өмнө байршлын завсар шилжилтийн үе гэж болох "хагас чөлөөтэй үе" байдаг бөгөөд энэ үед хянагчгүйгээр ажилд гарч, гадна орчинтой чөлөөтэй харьцдаг энэ хэлбэр өөр олон улсад түгээмээл тархсан байдаг нь нийгмийн амьдралд амжилттай дасахад чухал ач холбогдолтой.

[12] http://legislationline.org/documents/action/popup/id/7236

АНУ

АНУ-ын шийдвэр гүйцэтгэх байгууллага нэг талаас Хууль зүйн яам, нөгөө талаас оршин байгаа нутаг дэвсгэрийн засаг захиргаанд давхар харьяалагддаг. Хорих ялыг :

- Холбооны;
- Мужийн;
- Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад эдлүүлдэг байна.

Орчин цагийн АНУ-ын ял эдлүүлэх байгуулагын бүтцэд "Оборн систем"[15]голлох байр суурь эзэлдэг ажээ. АНУ-ын хорих ангиудад хатуу тогтоосон болон уян хатан тогтоосон дэглэм журам аль аль нь үйлчилдэг байна.

АНУ-д хорих ангийг дараах гурван төрөлд ангилдаг:

1. Дээд зэргийн хяналтын түвшинтэй хаалттай хорих;
2. Хамгаалалтын дунд түвшний хорих, энэ нь ялтан нөмын санд очих, салхинд гарах боломжтой;
3. Хялбаршуулсан түвшний хорих буюу "нээлттэй хорих".

Нээлттэй хорих анги нь зэвсэглэсэн хамгаалалтгүй, хөнгөн дэглэмтэй, хоригдогсод нь гадны байгууллагад хөдөлмөр эрхлэх эрх эдэлдэг байна. Нээлттэй дэглэмд хорих ял эдлэгсдийн эрхэлдэг хөдөлмөрийн гол чиглэл нь барилга байгууламж барих, зам засах, хедеө аж ахуйн болон бусад ажил байдаг.

Түүнчлэн насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг, дэглэм, харуул хамгаалалтын нөхцөл насанд хүрэгчдийнхтэй жишихэд харьцангуй зөөлөн байдаг. Насанд хүрээгүй хоригдлууд өдөрт нь хорих ангийн байрлалд байрлан ажиллаж, сурах бөгөөд шөнө нь гэртээ очиж хонож болдог. Энэ нь хоригдлуудын хүмүүжилд нааштай нөлөө үзүүлдэг ажээ.

АНУ-д сүүлийн үед эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарлах, тухайлбал, хорих байгууллагаас гадуур байж сурч, ажиллахаа хэвийн үргэлжлүүлэх шийтгэлийн хэлбэр нэлээд түгээмэл болж байна.

Япон Улс[16]

Япон Улс нь "Суллагдагсадад тусламж үзүүлэх тухай", "Насанд хүрээгүй ялтны ялыг эдлүүлэх байгууллагын тухай", "Шоронгийн тухай хууль" болон бусад эрх зүйн актаар энэхүү хариицааг зохицуулдаг байна.

Япон Улсын эрүүгийн ял нь:

1. Бага хэмжээний торгууль;

[15] АНУ-ын ял эдлүүлэх тогтолцоо нь муж улс бүхэнд өөр байдаг бөгөөд Оборн нэртэй хорих ял эдлүүлэх хэлбэр түгээмэл байдаг.

[16] http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf

2. Торгууль;
3. Баривчлах;
4. Албадан болон албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр хорих;
5. Цаазаар авах гэсэн төрлүүдтэй.

Ял эдлүүлэх байгууллагын бүтцэд урьдчилан хорих байр, насанд хүрэгчдийн болон насанд хүрээгүйчүүдийн хорих байгууллага багтана. Японы ял эдлүүлэх байгууллага нь нэлээд төвлөрсөн боловч нарийвчилсан ангилалтай байдаг

Хорих ял шийтгэгдсэн ялтныг:

- Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн ;
- Гадаадын иргэн;
- 8 аас дээш жилийн хорих ялтай;
- 20 хүртэлх насны залуучууд;
- Эрүүл мэндийн байдал сул, өвчтэй хүмүүс гэдгээр тус тус ангилдаг.

Хорих ангийн нээлттэй системийг бага хэмжээгээр хэрэгжүүлж эхэлж байгаа боловч хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг. Хоригдлууд нь өдөрт 8. долоо хоногт 44 цаг ажилладаг байна.

ОХУ

1996 онд батлагдан гарсан Эрүүгийн ял эдлүүлэх хууль нь 24 бүлэг, 190 зүйлээс бүрдэнэ. ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хууль нь Монгол Улсын ШШГТХ-тай зарчмын хувьд олон зүйлээр ялгаатай.

- Хоригдлын ялыг нийгмээс тусгаарлахгүйгээр эдлүүлэх байдал;
- Баривчлах ял эдлүүлэх;
- Хорих ял эдлүүлэх;

Хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн хэрэгсэлд:

- Ял эдлүүлэхэд мөрдөх тогтоосон дэглэм, журам;
- Нийгмийн ашиг тустай хөдөлмөр;
- Ерөнхий боловсорлын болон мэргэжил эзэмшүүлэх сургалт, олон нийтийн нөлөөлөл.

Судалгааны дүгнэлт

Нэг. ХБНГУ, ЭСТОНИ, ФИНЛАНД, ИХ БРИТАНИ, ОХУ, ЯПОН, АНУ гэсэн 7 орны хорих ангийн нээлттэй хаалттай дэглэм, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлав. Тухайн улсууд нь эрх зүйн тогтолцооны онцлогоос шалтгаалаад хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэхдээ дараах байдлаар шийдвэрлэжээ. Үүнд:

	Хэрэгжүүлсэн арга зам	Орнууд
1.	*Эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх*	· *Япон*
2.	*Хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх*	· *Финланд*
3.	*Тусгайлсан хууль гаргах (Prison Act or Penal Code)*	· *Эстони ХБНГУ АНУ Их Британи*
4.	*Эрүүгийн хууль тогтоомжийн хорих ялын хэлбэр нэмэлт, өөрчлөлт хийж хоригдлыг нөөлөлтэй, хаалттай дэглэмд ял эдлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай бодлогын баримт бичиг гаргах*	· *ОХУ*

Хоёр. Судалсан орнуудад хорих ял эдлүүлэх хорих ангийн нөөлөлтэй, хаалттай төрөл, дэглэмийг хуульчлахдаа дараах хууль тогтоомжийг батлан гаргах, эсвэл өөрчлөх, шинэчлэх байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Эрүүгийн хууль (Criminal code);
2. Хорих байгууллагын (шүүхийн шийдвэр биелүүлэх) тухай хууль;
3. Ялын тухай хууль (Penal code);
4. Шоронгийн тухай хууль (Prison Code, Imprisonment code, Prison Act).

Эрх зүйн тогтолцооны онцлогоос шалтгаалан хорих ялыг эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт адилгүй боловч бүхэлдээ хорих ялыг эдлүүлэхдээ хорих байгууллагад ажиллах хүний нөөц, боловсон хүчний чадавхижуулалт, ялтныг нийгэмшүүлэх тодорхой төрлийн ажлууд, эргэлт уулзалт, хөдөлмөр эрхлэх боломж, хоригдлын ял эдлэх орчин зэргээрээ ялгагдаж байна. Тухайлбал, ХБНГУ-д хэрэглэж байгаа хорих ангийн нөөлөлтэй хэлбэрийн зарим нь баривчлах ялтай төстэй боловч түүнийг хэрэгжүүлэх алба нэгж, хэлтсийн зохион байгуулалт тус тусдаа байдаг.

Гурав. Хорих ангийн нөөлөлтэй төрөл, дэглэмтэй дээрхи орнуудын хувьд ялтныг хөдөлмөр эрхлүүлэх эрх зүйн зохицуулалтыг дэлгэрэнгүй бөгөөд тодорхой зааж өгсөн байна. Энэ нь :

· Хорих байгууллагаас гадуур хөдөлмөр эрхлэх, (Эстони);

· Хорих байгууллага дотор буюу сулагдахаас өмнө хөдөлмөр эрхлэх (ХБНГУ) ;

· Гэрээгээр хөдөлмөр эрхлэх, (АНУ, ОХУ, Япон) ;

· Шүүхээс ногдуулсан хорих ялыг хөдөлмөр эрхлэх хэлбэрээр солих (Финланд) гэх мэтчилэн ялгавартай тусгаж өгсөн ч хорих

ангийн хаалттай дэглэмээс ялгагдах гол шинж нь ажил хийлгэх, хөдөлмөр эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэнд байна.

Дурдсан орнуудад ялтны хөдөлмөр эрхлэлтийг явуулахдаа энэ талаар бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, журам, заавар гаргахдаа юуны өмнө хорих ангид хөдөлмөр эрхлэх сургалт, дадлагажуулалтын асуудлыг шийдвэрлэсний дараагаар эрхлэх хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгажээ. Зарим оронд тухайлбал, Эстони улсын Хорих ял эдлүүлэх тухай хуулийн зүйл, хэсгийг үзэхэд хорих ангийн гадна хөдөлмөр эрхлэх хугацаа, хорих ангид байх хугацаа, ажлын хөлс, сургалт, хөдөлмөр эрхэлж болохгүй байдал, насны хязгаар гэсэн байдлаар нэгбүрчлэн тодорхой хуульчилжээ.

Судалгааны хүрээнд гаргах санал, зөвлөмж

Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэхэд анхаарах дараах бүлэг асуудлыг анхаарах. Үүнд:

Нэг. Эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө зардлыг төсөвт хүрэлцээтэй суулгаж өгөх. Баривчлах ял зэрэг хорих ялын альтернативыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу эдлүүлэх шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, хорих ангийн нээлттэй байх хувилбарыг хэрэгжүүлэхдээ иргэнд дөхөмтэй хувилбарыг сонгож авах. Тухайлахад, хорих ялын нээлттэй, хаалттай дэглэмийг тусгахлаа Эрүүгийн хуулийн Есдүгээр бүлэг. Эрүүгийн хариуцлагын зорилго, төрөл, Аравдугаар бүлэг. Ял ногдуулах гэсэн бүлгүүд. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулснаар шийднэ гэж үзэх нь учир дутагдалтай юм. Үүн дээр нэмж баривчлах ялын эрх зүйн зохицуулалт, эдлүүлэх хэлбэрийг илүү тодорхой болгож, ялтныг нийгэмшүүлэх талаар хуулийн заалтыг тодотгох хэрэгтэй.

Одоо нээлттэй дэглэмийг туршилтаар хэрэгжүүлж байгаа Дархан-Уул аймаг дахь хорих ангиас гадна жирийн дэглэмтэй хорих анги болон эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангийг нээлттэй дэглэмд шилжүүлэхдээ "Хорих ангийн дотоод журам", "Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр"-ын уялдааг хангах.

Хоёр. Гадаадын зарим орны сайн хувилбарыг өөрийн хөрсөнд буулгаж "нутагшуулах"-даа зөвхөн нээлттэй гэсэн нэр томъёонд анхаарахаас илүүтэй ялтныг хөдөлмөрлөх, нийгэмд ажиллаж, гэр бүлийнхэнтэйгээ холбоотой байх боломж олгосон, олон улсын стандартад нийцсэн байх шинжийг энэ тэргүүнд харгалзах. Монгол Улсад ялтан ял эдэлж байх хугацаандаа хөдөлмөр эрхэлж хохирлоо

барагдуулах талаар ямар нэгэн санаачилгагүй, хорих ангийн зүгээс хөдөлмөр эрхлүүлдэг болович хөдөлмөрийн хөлс нь ялтны өдөр тутмын хэрэгцээ бусад зүйлд зориулагддаг, хөдөлмөрийн хөлсний үнэлгээ (ШШГЕГын даргын 1 53 тоот тушаалаар батлагдсан) бага, эрэгтэй ялтнууд болон насанд хүрээгүй ялтнууд хөдөлмөр эрхлэх боломж багатай, энэ талын мэдлэггүй байдаг. Эстони Улсын Хорих ял эдлүүлэх тухай хуульд тусгасан хөдөлмөр эрхлүүлэх нөхцөл, хязгаар, хорих ангийн дотор болон гадна хөдөлмөр эрхлэх зэрэг боломжийг тусгах.

Хоригдлын хөдөлмөрлөж хохирлоо нөхөн төлөх бололцоог хангах ажлыг зохион байгуулж, үүнд аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийг урамшуулах санхүүгийн болон бусад арга хэшүүргийг олох. Тухайлбал, Финланд Улс хорих ангид нээлттэй хөдөлмөр эрхлүүлэхдээ хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажилладаг туршлагыг харгалзах.

Анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгүүлсэн ялтнуудын хорих ял эдлэх хугацаандаа эрхэлсэн ажил хөдөлмөрийг ажилласан жилд оруулан тооцох асуудлыг судлах. Тухайлбал, 1996 онд батлагдсан ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд хоригдлын засан хүмүүжүүлэх колонийн үйлдвэрлэлд ажилласан хугацааг улсад ажилласан хугацаанд оруулан тооцох, хөдөлмөрт хамрагдаж байгаа хоригдолд жилд эжлын 12-18 хоногийн амралт олгох, 30 хүртэл насны хоригдол ерөнхий боловсролын сургалтад заавал хамруулж байхаар хуульчилсан байна. (ОХУ-ын туршлага).

ТӨРИЙН АЛБА ДАХЬ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХИЙН ТУЛД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хууль зүйн доктор, профессор Л.Батжав

Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль боловсруулахтай холбогдуулж зайлшгүй анхаарвал зохих хэд хэдэн асуудал байна. ***Нэгдүгээрт,*** ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг гадаад орнуудад ямар хууль тогтоомжоор зохицуулж байгааг олон талаас нь ул суурьтай судлаад өөрийн орны онцлог нөхцөл байдалд нийцүүлэх замаар монгол хөрсөнд монгол аргаар суулгах хэрэгтэй. ***Хоёрдугаарт,*** ашиг сонирхлын зөрчлийн зэрэглэл, хэлбэрийг зөв ангилж, ямар эрх зүйн актаар зохицуулах ёстойг нарийн тогтоож, тэр дагуу хуулиа боловсруулах, боловсронгуй болгох нь зүйтэй. ***Гуравдугаарт,*** ашиг сонирхлын зөрчилд өртөгчдийн хүрээг зөв тодорхойлж, хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээг оновчтой хуульчилж өгөх шаардлагатай байна.

Ихэнх улс орон ашиг сонирхлын зөрчлийг гурван үндсэн хэлбэрээр зохицуулдаг юм байна. ***Нэгдүгээрт,*** Казах, Эстон зэрэг орон Авлигын эсрэг ерөнхий хуулиар, ***хоёрдугаарт,*** Латви, Литва, Канад, Серби зэрэг орон бие даасан тусгай хуулиар, ***гуравдугаарт,*** Австрали, Болгар, Мексик, Румын, Словак, Шинэ Зеланд зэрэг орон Ёс зүйн дүрмээр тус тус зохицуулдаг ажээ. Иймээс эдгээр орны хууль тогтоомжийг сайтар судалж чухам юуг нь Авлигын эсрэг хуулийг боловсронгуй болгоход, юуг нь Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль боловсруулахад, юуг нь Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэхэд авч ашиглавал зохистойг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн хэмжээнд шийдэх хэрэгтэй. Тэгээд дараа нь өөрийн орны онцлогт нийцүүлэн чамбай боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Ашиг сонирхлын зөрчлийн зэрэглэл, хэлбэрийг зөв тогтоох нь хууль боловсруулах, боловсронгуй болгох, хариуцлага хүлээлгэх дараа дараагийн үе шатны ажилд илүү дөхөмтэй байх болно.

Олон улсын энэ чиглэлийн хууль тогтоомж, судалгааны материалаас үзэж байхад ашиг сонирхлын зөрчлийг зэрэглэл, хэлбэрээр нь тус тус гурав ангилж болохоор байгаа юм. Тухайлбал, хөнгөн зэрэглэлийн, дунд зэрэглэлийн, хүнд зэрэглэлийн ашиг сонирхлын зөрчил гэж

зэрэглэлийн хувьд; ёс зүйн хэлбэрээр илрэх зөрчил, ашиг сонирхлын хэлбэрээр илрэх зөрчил, авлигын хэлбэрээр илрэх зөрчил гэж хэлбэрийн хувьд тус тус ангилж, улмаар хууль тогтоомжоо энэ дагуу боловсронгуй болгох, шинээр боловсруулах нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

Зөрэглэл, хэлбэрээ дагаад хариуцлагын асуудал хөндөгдөнө. Тухайлбал: хөнгөн зөрэглэлийн ашиг сонирхлын зөрчлөөс хүндэвтэр зөрэглэлийн, хүндэвтрээс хүнд зөрэглэлийн ашиг сонирхлын зөрчилд шилжихийн хэрээр ашиг сонирхлын зөрчил нь ёс зүйн хэлбэрээс ашиг сонирхлын хэлбэртэй, ашиг сонирхлын хэлбэрээс авлигын хэлбэртэй ашиг сонирхлын зөрчилд шилжин өөрчлөгддөг гэсэн үг. Үүнээс улбаалан ёс зүйн зөрчлийн хэлбэрээр илэрдэг хөнгөн зөрэглэлийн ашиг сонирхлын зөрчлийг Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм (шинэчлэн боловсронгуй болгох)–ээр, ашиг сонирхлын хэлбэрээр илэрдэг хүндэвтэр зөрэглэлийн ашиг сонирхлын зөрчлийг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинээр боловсруулж УИХ-д өргөн барих)-иар, авлигын хэлбэрээр илэрдэг хүнд зөрэглэлийн ашиг сонирхлын зөрчлийг Авлигын эсрэг хууль (нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн боловсронгуй болгох)-иар тус тус зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хариуцлагын тогтолцоо байхгүйтэй адил болсон манай улсын хувьд хуулиудад байгаа болон байх ёстой энэ чиглэлийн хэм хэмжээ тогтоосон зааалтуудыг боловсронгуй болгох, нэмж оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. УИХ-аас 2006 онд баталж мөрдүүлсэн Авлигын эсрэг хуулийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан боловсронгуй болгох хэрэгтэйг хэлүүлэх юун. Ялангуяа тус хуулийн "Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах" гэсэн гуравдугаар бүлэгт тодруулах, нэмэх, хасах гээд хэнд ч ойлгогдохоор, хоёрдмол санаа, ойлголт өгөхөөргүй боловсронгуй болгох зүйл, заалт багагүй байна.

Түүнчлэн хөрөнгө, орлогын мэдүүлгийг ч улам тодорхой болгох хэрэгтэй байна. Энэ мэтээр хууль зөрчсөн албан тушаалтан, төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгосон нэмэлт, өөрчлөлтийг Авлигын эсрэг хуульд яаралтай оруулж батлуулах нь зүйтэй. Үүнтэй холбогдуулж Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль шинээр боловсруулж, гаргах шаардлага ч нийгмийн зүгээс тавигдаж байна. Түүнээс гадна Засгийн газрын 1999 оны "Дүрэм батлах тухай" 58 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээний тухай" дүрмийг шинэчлэх хэрэгтэй байна. Гадаад, дотоод хүчин зүйл хурдан өөрчлөгдөж, цаг үе маань үнэнч шударга, хариуцлага сахилгатай байхыг шаардаж байгаа өнөөгийн нөхцөлд бид хууль тогтоомжоо улам боловсронгуй болгох нь зүйд нийцэж,

олон түмэн хүндэтгэлтэй, итгэлтэй дэмжих болно.

Дээрх гурван төрлийн эрх зүйн актаар зохицуулагдах ашиг сонирхлын зөрчлийн хүрээ, заагийг зөв, оновчтой тогтоох нь нэн хариуцлагатай бөгөөд чухал асуудал билээ. Тухайлбал, Авлигын эсрэг хууль, Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмээр зохицуулах гурван төрлийн харилцааны хүрээ, заагийг давхардал, хийдэл гаргахгүйгээр тодорхойлж, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөл боловсруулахдаа оновчтой тусгах хэрэгтэй. Энэ хоёр хуулийг УИХ баталж мөрдүүлсний дараа Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсронгуй болгох нь зүйтэй гэж бодно.

Төрийн албан хаагч Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжид заасан эрх, үүргээ үнэнч шударгаар, бүрэн дүүрэн хэрэгжүүлэх шаардлагын үүднээс түүний үйл ажиллагаанд тулгэлзүүлэх, хориглох зүйлийг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд улам нарийн, улам тодорхой тусгах хэрэгтэй. Ингэсэн тохиолдолд хууль хэрэгжүүлэгч, хуульд хяналт тавигч аль аль талын хийх ажил, хүлээх хариуцлага эмх цэгцтэй байх нөхцөл бүрдэнэ.

Төрийн албан хаагч дор дурдсан үйл ажиллагаа явуулахаас тулгэлзэхийг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд тусгах нь зүйтэй гэж үзэж байна. ***Нэгдүгээрт***, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох шийдвэр бэлтгэх, хэлэлцэх буюу батлахад оролцох, түүнчлэн тийм шийдвэр гаргахад ямар нэгэн байдлаар хөндлөнгөөс нөлөөлөхөөс, ***хоёрдугаарт***, хууль, хяналт, шалгалтын байгууллага болон ажлын хэсэг буюу тэдгээртэй адилтгах ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах нь ашиг сонирхлын зөрчил үүсгэхээр бол тухайн ажлын хэсэг болон байгууллагатай хамтран ажиллахаас тус тус тулгэлзэнэ. ***Гуравдугаарт***, төрийн албан хаагч шийдвэр бэлтгэх, хэлэлцэх буюу батлах ажиллагаанд оролцох нь ашиг сонирхлын зөрчил үүсгэнэ гэж үзэх хангалттай үндэслэл байна гэж үзвэл байгууллагын удирдлага уг албан хаагчийг тухайн үйл ажиллагаанд оролцохоос тулгэлэүүлж болно. Энэ шийдвэрийг иргэд болон бусад байгууллага, албан тушаалтнаас бичгээр ирүүлсэн мэдээллийн дагуу тухайн төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үндэслэж гаргана. ***Дөрөвдүгээрт***, төрийн албан хаагч өөрийн ашиг сонирхлын зөрчлийн талаар өөрийн шууд удирдлага болон тухайн шийдвэр бэлтгэх, хэлэлцэх

буюу батлах ажиллагаанд оролцож байгаа бусад этгээдэд уг ажиллагаа эхлэхээс өмнө буюу түүний явцад бичгээр түдгэлзэх тухай мэдэгдэнэ. Харин нӨм мэдээлэл болон мэдэгдэл авсан байгууллагын удирдлага тэдгээрийг хүлээн авснаас хойш тодорхой богино хугацааны дотор төрийн албан хаагчийг тухайн үйл ажиллагаанд цаашид оролцуулах эсэх талаар бичгээр шийдвэр гаргаж, түүнийг төрийн албан хаагч биелүүлэх үүрэгтэйг хуульчилж өгвөл зохино.

Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд дор дурьдсан дөрвөн нийтлэг үндэслэлээр Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд хориг тавих нь зүйтэй. ***Нэгдүгээрт***, албан тушаалын байдлаа зүй бусаар ашиглах талаар хориглох зүйл, ***хоёрдугаарт***, бусдыг төлөөлөхөд хориглох зүйл, ***гуравдугаарт***, бэлэг буюу үйлчилгээ хүлээн авахад хориглох зүйл, ***дөрөвдүгээрт***, хандив хүлээн авахад хориглох зүйл гэж нарийвчлан тогтоож өгөх хэрэгтэй.

Албан тушаалын байдлаа зүй бусаар ашиглах талаар дараах хориг тавих ёстой. Тухайлбал, төрийн албан хаагч ***нэгд***, өөрийн бүрэн эрх, эрх хэмжээ болон нэрийг бусад этгээдийн шийдвэрт нөлөөлөх зорилгод ашиглаж шууд ба шууд бусаар ашиг сонирхлын зөрчил үүсгэхийг, ***хоёрт***, албан үүргээ гүйцэтгэж байхдаа олж авсан мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд өөрийн болон гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, өөрийн харилцагч нарын хувийн ашиг сонирхолд ашиглахыг, ***гуравт***, өөрийн албаны нэр болон албан тушаалын байдлаа албан үүрэгт хамаарахаас бусад тохиолдолд бизнесийн шинжтэй зар сурталчилгаанд ашиглахыг тус тус хориглоно. Түүнээс гадна төрийн албан хаагч албаны нэр болон албан тушаалын байдлыг өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, харилцагч этгээд хувийн ашиг сонирхолдоо ашиглахыг хэрхэвч зөвшөөрөх ёсгүйг шинээр боловсруулж батлуулах дээрх хуульд тусгавал зохино.

Бусдыг төлөөлөхөд төрийн албан хаагчид дор дурдсан зүйлийг хориглох ёстой гэж үзэж байна. Тухайлбал, төрийн албан хаагчийн үйл ажиллагаа нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж байгаа бол; өөрөө буюу түүний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсвэл түүний харилцагч этгээд аливаа орлого хүлээж авдаг хувь хүн юм уу хуулийн этгээдтэй харилцаж ажил хэрэг явуулж байгаа бол; үндсэн хөрөнгө буюу хувьцааны 10 хувиас дээш хэсгийг уг албан хаагч өөрөө буюу түүний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл түүний харилцагч этгээд өмчилж байгаа бүх төрлийн аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой бол; төрийн албан хаагч өөрөө буюу түүний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл түүний харилцагч этгээд нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, хяналтын болон гүйцэтгэх албаны гишүүн бол, тухайн аж ахуйн нэгж, байгууллатай

холбоотой бол тус тус төр буюу нутгийн удирдлага, эсхүл төрийн буюу нутгийн удирдлагын байгууллагыг төлөөлж болохгүй гэсэн хоригийг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд тусгах нь зүйтэй юм.

Бэлэг буюу үйлчилгээ хүлээн авахтай холбогдуулж ямар хориг байвал зохистойг мөн хуульд тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Төрийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэхтэй шууд буюу шууд бусаар холбоотойгоор бэлэг болон үйлчилгээ шууд буюу шууд бусаар авахыг хориглох шаардлагатай. Бэлэг болон үйлчилгээ гэдэгт тухайн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэхтэй шууд буюу шууд бусаар холбоотойгоор өөрт нь, эсхүл гүүний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүнд үнэ төлбөргүйгээр буюу хөнгөлөлттэй үнээр шилжүүлсэн эд хөрөнгө буюу үзүүлсэн үйлчилгээг хамруулан ойлговол зохино. Гэхдээ төрийн албан хаагч, гүүний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүний бусад этгээдээс хүлээн авах бэлэг буюу үйлчилгээний үнийн дүнгийн дээд хэмжээг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд тодорхой зааж өгөх шаардлагатай. Харин бэлэг буюу үйлчилгээний үнэ нь тэрхүү хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд төрийн албан хаагч энэ тухай байгууллагын удирдлага буюу ерөнхий менежерт бичгээр мэдэгдэнэ. Ийм нөхцөлд тухайн бэлгийг улсын орлого болгох, эсхүл үнийн зөрүүг төлөөд бэлгээ эзэн нь авах эсэхийг хуулийн төсөлд тодорхой тусгавал зохино.

Энэхүү заалтыг Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд илүү тодорхой, уян хатан суулгаж өгсөн тохиолдолд төрийн албанд одоо ажиллаж байгаа болон төрийн албанаас албан ёсоор гарсан хүний цаашдын үйл ажиллагаа, ажлын байдал, амьдрал ахуйд нь баримтлах үндсэн чиглэл болохын зэрэгцээ хуулийн биелэлтэд хяналт тавихад хялбар дөт байх болно.

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА БИЙ

ХЗУХ-ийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Мэнджаргал

Эвлэрүүлэн зуучлах нь шүүхэд хэрэг маргаан шийдэх арга мөн.

Дэлхийн олон оронд маргалдагч талуудыг шүүхээс өмнөх шатанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг өргөн хэрэглэдэг бөгөөд энэ нь цаг зардал хэмнэсэн оновчтой ажиллагаа юм. Тэр дундаа Япон улсын зуучлах ажиллагааны талаар сүүлийн үед манай улсад ихээхэн ач холбогдолтой байдлаар судлаж байна.

ЖАЙКА-ийн эрх зүйн шинэтгэл, туслалцаа төслийн дэмжлэгээр 2006 онд Монголын өмгөөлөгчдын холбооны дэргэд "Эвлэрүүлэн зуучлах төв"-ийг байгуулж үйл ажиллагаа явуулсаар ирсэн бөгөөд 2010 оны 1 дүгээр сараас эхлэн 2012 оны 6 дугаар сарыг дуустал иргэний болон гэр бүлийн хэрэгт "Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах" төсөл нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2011 оны 5 дугаар сарын 1-нд түшиц шүүхээр сонгогдсон Дархан-Уул аймаг дахь Сум дундын шүүх болон Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхэд нээлтээ хийж туршилтын хугацааанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж байгаа бөгөөд төслийн үйл ажиллагаа ихээхэн урагштай явж байна.

Маргааныг эвлэрүүлэн зуучлах гэдэг нь манай улсын хувьд анх удаагаа шинээр үүсч буй харилцаа юм. Шинэ харилцаа, ойлголт хэдий ч бусад орны хууль зүйн практикт нэгэнт хэвшиж, өргөн хэлбэрээр явагддаг. Энэ нь эрх зүйн соёл, ухамсарыг төлөвшүүлэх, шүүхийн бус арга замаар иргэний хэрэг, маргааныг зуучлан шийдвэрлэнэ гэсэн ойлголт юм.[1]

Эвлэрүүлэл ба зуучлал. Энэ ухагдахуун нь Монгол Улсад цоо шинэ ойлголт биш бөгөөд ИХШХШТХ-ийн 74.6-д Эвлэрлийн талаар тусгасан байдаг.

Мөн Монгол Улсын иргэний хуулийн гучин есдүгээр бүлэгт "зуучлал" гэсэн заалт байдаг. Зуучлалын ухагдахууныг тайлбарлахдаа "Зуучлагч, зуучлуулагч, гуравдагч этгээд хоорондын харилцааг зохицуулдаг, иргэний эрх зүй дэх бусдад туслалцаа үзүүлэхтэй

[1] http://www.medee.mn/content/2417.shtml

"Зуучлагч, зуучлуулагч, гуравдагч этгээд хоорондын харилцааг зохицуулдаг, иргэний эрх зүй дэх бусдад туслалцаа үзүүлэхтэй холбогдож үүссэн үүргийн нэгэн төрөл болно" гэж тайлбарласан байна.

Маргааныг шүүхийн бус замаар эвлэрүүлэн зуучлах гэх ойлголтыг дэлхий нийтэд англи хэлний (Alternative Dispute Resolution) буюу ADR буюу маргааныг хянан шийдвэрлэх сонгох аргууд хэмээн томъёолж ирсэн.

"Маргаан шийдвэрлэх сонголтот арга" буюу ихэнх тохиолдолд ADR гэж нэрлэгдэх энэхүү ойлголт нь маргаан шийдвэрлэх өргөн цар хүрээтэй механизмыг илэрхийлж байдаг. Уг механизм нь шүүхийн процессыг бодвол сонголттой, хугацааны хувьд хэмнэлттэй байдаг. Хөгжиж байгаа, эсвэл шилжилтийн эдийн засагтай улс орнуудад маргаан шийдвэрлэх сонголтод аргуудын программ, шүүх тогтолцоонд итгэх иргэдийн итгэл алдагдсан улс орнуудад хамгийн үр дүнтэй, хамгийн үр ашигтай хэрэгжиж чаддаг.

Аливаа эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд маргаантай харилцааны оролцогчдын өөрсдийн идэвхтэй, ухамсартай оролцоог бий болгох, эрх зүйн харилцааг өөрсдөө зохицуулах чадвартай болгох, тэдний эд хөрөнгө, цаг завыг хэмнэх, эрх зүйн ухамсарыг нь дээшлүүлэх, төрийн оролцоо, албадлагагүйгээр сайн дураар гаргасан шийдвэрээ биелүүлэх зан байдлыг төлөвшүүлэх нэг арга зам бол маргааныг эвлэрүүлэн зуучлах замаар хянан шийдвэрлэх ажиллагаа юм.

Эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэх ажиллагаа нь манай улсад хэрэгжих боломж нөхцөл байна.

Хэрэв маргааныг зохистой байдлаар зөв голдролд нь оруулж чадвал шүүхийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд маш чухал үр дүндэй асуудал болох нь тодорхой юм. **Шүүхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа гэж** маргаантай асуудалд голч шударга байр сууринаас хандах эрх зүйн мэдлэгтэй эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр маргалдагч талууд хоорондоо харилцан ярилцаж хэлэлцсэний дүнд, маргаанаа шийдэхийг хэлнэ.

Маргааныг шүүхийн бус журмаар шийдэх гэсэн аттлаа яагаад энэ үйл ажиллагааг шүүхэд нэвтрүүлэхээр төсөл хүртэл хэрэгжиж байгаа вэ гэсэн асуулт гарч ирнэ?

Талуудын хооронд нэгэнт үүссэн маргааныг эв зүйгээр зохицуулах боломжийг тэдэнд олгож, энэ талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх нь шүүхийн ажиллагаанд шууд нөлөөлөх учиртай шүүхээр хэрэг хянан шийдэх ажиллагаа өөрөө нарийн шат дараалалтай байдаг.

Маргаж байгаа талууд хоорондоо эв зүйгээр ярилцан маргааныа өөрсдөө шийдүүлж чадвал түүнийг нь шүүхийн зүгээс баталгаажуулж талуудын эвлэрэл шүүхийн шийдвэр адил хүчинтэй байх нь чухал ач холбогдолтой юм.[2] Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудыг эвлэрүүлэх талаар хуульд зааснаас илүү байдлаар идэвхитэй ажиллагаа явуулах нь талуудад хандлага төрүүлэх, шүүхийн хөндлөнгийн байр суурийг алдагдуулах магадлалтай байдаг тул энэ ажиллагаанд өмгөөлөгч оролцох нь зохимжтой.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (ИХШХШХ) 74 дүгээр зүйлд Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Гэр бүлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудад Шүүхэд эвлэрүүлэн зуучлах тогтолцоог бүрдүүлэхэд үндэслэл болохуйц хуулийн заалууд тусгагдсан байх бөгөөд энэ талаар нарийвчлан зохицуулсан хууль хэрэгжихээр яригдаж байна.

Монгол Улсын Дээд шүүхийн Судалгааны төвийн сүүлийн 3 жилийн статистик мэдээнээс харахад:

- 2008 онд улсын хэмжээнд нийт иргэний маргаан 38120 хүлээж авсанаас, шийдсэн хэрэг 28480, үүнээс 1721 хялбаршуулсан журмаар шийдсэн бөгөөд нийт шийдсэн хэргийн 6 хувьтай тэнцэж байна;
- 2009 онд улсын хэмжээнд нийт иргэний маргаан 48204 хүлээж авсанаас, шийдсэн хэрэг 35822 үүнээс 3603 хялбаршуулсан журмаар шийдсэн бөгөөд нийт шийдсэн хэргийн 10 хувьтай тэнцэж байна;
- 2010 онд улсын хэмжээнд нийт иргэний маргаан 48170 хүлээж авсанаас, шийдсэн хэрэг 35787 үүнээс 4892 хялбаршуулсан журмаар шийдсэн бөгөөд нийт хэргийн 13 хувьтай тэнцэж байна.

Энэ нь нийт шүүн таслах ажиллагааны 30-40 хувь юм.

Хялбаршуулсан журмаар шийдсэн хэргүүд хянан шийдвэрлэх ажиллагааг бодвол харьцангуй хялбар, цаг зав, хөрөнгө мөнгө хэмнэж явагдах нь ойлгомжтой. Дээрх судалгаанаас харахад сүүлийн жилүүдэд хялбаршуулсан журмаар шийдэгдсэн хэрэг маргаан өсөх хандлага анзаарагдаж байгаа хэдий ч дээрх маргаанууд шүүхэд хандахаас өмнө эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсан бол шүүхийн ачаалал дор хаяж 30 хувь буурах нь харагдаж байна.

Эвлэрүүлэн зуучлал ба шүүхийн ялгаа: Шүүхэд шүүгч нь хуульд захирагдан шийдвэр гаргана. Шүүхийн шийдвэрийн агуулга нь талуудын хүсэл зоригоос зөрөх тохиолдол ч байдаг. Харин эвлэрүүлэн зуучлалд бол зуучлагч нь шийдвэр гаргах бус талууд харилцан

[2] Өдрийн сонин

ярилцаж, бие биедээ тодорхой хэмжээгээр буулт хийн санал нэгдэнэ. Ингэснээр хуулийн дагуу хатуу, чанга бус уян хатан шийдвэр гаргаж чаддаг байна.

Мөн эвлэрүүлэн зуучлалаар маргаан шийдвэрлэхийн тулд талуудын бодол санаа маш чухал юм. Талуудын байр суурь зөрчилдөж, харилцан буулт хийх бодолгүй байгаа тохиолдолд шүүхэд хандахаас өөр замгүй. Шүүхэд талуудын бодол санаанаас хамааралгүйгээр шийдвэр гаргадаг тул өөрийн буруугаа хүлээхгүй байгаа хариуцагчаас мөнгө гаргуулж авах эсхүл нэхэмжлэл нь үндэслэлгүй бол хүлээн авахаас татгалзах боломжтой бөгөөд тухай шүүхийн шийдвэр нь төрийн эрх мэдлээр албадан биелүүлэх боломжтой ба шүүхийн шийдвэр нь заавал дагаж мөрдөх хүчин чадалтай тул шийдвэр гүйцэтгэх элбаар дамжуулан гүйцэтгүүлэх боломжтой. Шүүхийн хувьд 3 шатны тогтолцоотой тул шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол дээд шатанд хандаж болох боловч тэр хэмжээгээр хугацаа алдана.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	*Шүүхийн ажиллагаа*
Дүрмээ маргалдагч талууд тогтоох боломжтой харилцан ярилцах үндсэн дүрмээ дагаж мөрдөж байвал, бусдаар чөлөөтэй; Цаг хугацаа, заваа чөлөөтэй сонгох боломжтой; • Ашиг сонирхлын холбогдолтой этгээдүүдийн оролцоо чөлөөтэй; Шийдвэрлэх асуудал, явц дундаа ямарч асуудлаар зохицуулах боломжтой; • Тохиролцоонд хүрснээр ажиллагаа дуусна.	• Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шаардлагаа тайлбарлах, нэхэмжлэл, мэдүүлэг, баримт нотлох; Бичмэл нотлох баримт, харилцан асуулт тавих; Шүүхээс тогтоосон өдөр, зохигчдын төлөөлөгчийн зав чөлөө. Зөвхөн шүүхэд явагдана; Оролцогч нь зохигч эс бол түүний төлөөлөгч; Нэхэмжлэлд бичигдсэн шаардлагын талаар л зөвхөн хэлэлцэнэ; Нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх; • Давж заалдах шат.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь иргэний болон гэр бүлийн хэрэгт дараах маргааныг эвлэрлээр батална.

- Гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан;
- Ажилтан, ажил олгогчдын хооронд үүссэн маргаан;
- Хөршүүдийн харилцаанаас үүссэн маргаан;
- Иргэд хоорондын зээлийн харилцаанаас үүссэн маргаан;
- Хугацаандаа гүйцэтгээгүй аливаа төлбөрийн маргаан;
- Орон сууцны түрээсийн маргаан зэрэг маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдана.

Хот суурин газар дахь хүн ам нягтарших, шилжилт хөдөлгөөн

ихсэх хандлага нь шүүхийн ажлын ачааллыг нэмэгдүүлэн хүндрүүлж, улмаар шүүхээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг багасгах, чирэгдэл, цаг хугацааны алдагдал болон үргүй зардлыг ихэсгэж байгааг дан ганц шүүхийн орон тоо, хүний нөөцийн хангамжаар шийдвэрлэх боломжгүй тул эрх зүйн маргааныг шийдвэрлэх дараах хэлбэрийн ажиллагааг нэвтрүүлэн, холбогдох хууль тогтоомжид тусгах хэрэгцээ, шардлага байна. Иймд шүүхийн болон шүүхийн бус журмаар эрх зүйн маргааныг эвлэрүүлэн, хялбаршуулсан журмаар түлхүү хэрэглэх нь ихээхэн ач холбогдолтой ажил болох юм.[3]

Аливаа эрх зүйн маргаан шийдвэрлэхэд маргаантай харилцааны оролцогчдын өөрсдийн идэвхтэй, ухамсартай оролцоог бий болгох, эрх зүйн харилцааг өөрсдөө зохицуулах чадвартай болгох, тэдний эд хөрөнгө, цаг завыг хэмнэх, эрх зүйн ухамсарыг нь дээшлүүлэх, төрийн оролцоо албадлагагүйгээр сайн дураар гаргасан шийдвэрээ биелүүлэх зан байдлыг төлөвшүүлэх нэг арга зам бол маргааныг эвлэрүүлэн зуучлах замаар хянан шийдвэрлэх ажиллагаа юм.

Иймд аргаар маргааныг шийдвэрлэх нь маш үр дүнтэй болохыг олон орон хүлээн зөвшөөрч, өөр өөрийн арга барилаар хэрэгжүүлж байна. Японд эвлэрүүлэн зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэсэн хэрэг маргааны тоо жил бүр өссөөр байдаг юм билээ. Маргаж буй талууд маргаанаа эцэслэхийн тулд шүүхэд хандлаг, нэхэмжлэл, өргөдөл гаргахаар ирж буй хүмүүст эвлэрүүлэн зуучлагчийн туслалцааг авах талаар санал болгож танилцуулснаар шүүхийн бус журмаар маргаанаа шийдвэрлэх боломжийг нь нээх анхны алхам хийгдэнэ. Хэрвээ эвлэрүүлэн зуучлах ажиллагаа үр дүнд хүрээгүй бол талууд шүүхэд хандах эрх нь нээлттэй юм.

[3] Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс үндэсний чуулганаас гарсан зөвлөмж.

УРАНЫ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО

ХЗУХ-ийн Олонулсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Халиунаа

Аливаа орд газрыг ашиг олохын тулд гаргаж авсан эрдэс баялгаа улс орноо хөгжүүлэхийн тулд эрж, хайж, олборлодог.

Монголын эдийн засгийг хөгжүүлэх гол хөдөлгүүр нь өнөөгийн нөхцөлд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх жингээрээ ч, нэгдсэн төсвийн орлогыг бүрдүүлэхэд эн тэргүүнд бичигдэж байгаа салбар бол ашигт малтмалын салбар юм.

Тус нийтлэлдээ ашигт малтмал тэр дундаа манай улсын хувьд шинэхэн бөгөөд нэлээд үр өгөөж өгөх боломжтой ураны салбарын талаар, ураны салбар дахь төрийн оролцоо ямар байгаа, цаашид ямар арга хэмжээ авч болох, энэхүү салбартаа дэлхийн хэмжээнд тэргүүлж буй гадаадын зарим орны төрийн оролцооны талаар өгүүлэх болно.

Монгол орны ураны судалгаа 1948 оноос эхэлсэн гэж үздэг. ЗХУ-ын геологчид Монгол орны ураны нийт бодит болон боломжит нөөц баялгийн хэмжээг 80.0 мянган тонн гэж тооцоолсон ба үүнээс 59.0 мянган тонн нь үйлдвэрлэлийн зэргээр бэлтгэгдсэн гэж үздэг байна[1].

Нэгэнтээ энэ салбрын төрийн оролцооны талаар ярих гэж байгаа тул түүний эрх зүйн орчны зохицуулалтуудыг авч үзье.

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн[2] гэж заасан нь ашигт малтмалын салбарын удирдлагад хууль голлох үүрэгтэйг харуулж байгаа явдал юм. Учир нь газрын хэвлий түүний баялаг төрийн өмч байх тул. түүнийг захиран зарцуулах, эзэмших, ашиглах нь зөвхөн хуулиар зохицуулагдах ёстой. Мөн энэ талаар Цөмийн энергийн тухай хуулийн 5.1-д " Монгол Улсын газрын хэвлийд оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмал төрийн өмч мөн" хэмээн зохицуулсан байна.

Манай улсын хувьд ураны салбарын эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Аюултай хог, хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль, Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулдаг.

Урантай холбоотой харилцааг зохицуулагч гол хууль болох Цөмийн

[1] *"Монгол орны ураны нөөц баялаг ба төрийн авч хэрэгжүүлэх бодлогын тухайд"* //2009 Сэрсэн говь III улирал

[2] Үндсэн хууль-6

энергийн тухай хуулийг 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр батлан гаргасан бөгөөд ашигт малтмалын ордын ашиглах, уул уурхайн эмх замбраагүй, байгальд халтай үйл ажиллагааг таслан зогсоох, системчлэх үүднээс мөн ондоо "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого"[3]-ыг батлан гаргасан.

Хэдийгээр тухайн харилцааг зохицуулах хууль тогтоомжуудыг батлан гаргаад байгаа ч эдгээр нь хоорондоо зөрчилдөх, уялдаа, холбоогүй байх тохиолдол гардаг. Тухайлбал:

- Ашигт малтмалын тухай хуульд төр өөрийнхөө зардлаар хайгуул хийсэн бол 51-ээс доошгүй, харин хайгуулаа өөрөө хийгээгүй бол 34-өөс доошгүй хувийг эзэмшинэ, Цөмийн энергийн тухай хуулийн[4] 5.2, 5.3-т дээрх хуулийн адил заалт орсон байдаг. Гэтэл Үнэт цаасны тухай хуульд "Хувьцаа бол тухайн компанийн өмч мөн" гэсэн заалттай. Тодорхой хэмжээний хөрөнгө, хувьцаа гаргачихсан компанийн 34-өөс доошгүй хувийг төр эзэмшинэ гэдэг нь Үнэт цаасны тухай хуультай зөрчилдөж, хуулийн хоорондын уялдаа алдагдаж байна[5];
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.1, 6.2-т зааснаар тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно, мөн анх олгосон хугацаанаасаа доошгүй хугацаагаар сунгаж болно гэж заасан байдаг бол Цөмийн энергийн тухай хуулийн 21.1-т цацраг идэвхт ашигт малтмалыг эрэх, хайх, цацраг идэвхт ашигт малтмалыг импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх тусгай зөвшөөрлийг 3 жил хүртэл хугацаагаар олгоно гэж заасан байдаг нь дээрх Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн заалттай зөрчилдөж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, нэг хуульд нь тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгож байхад нөгөө хуульд нь 3 жил хүртэл хугацаагаар олгоно гэсэн байгаа юм. Мөн Цөмийн энергийн тухай хуулийн 21.2-т цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах тусгай зөвшөөрлийг техник, эдийн засгийн үндэслэл, хяналт шалгалтын үр дүнг харгалзан 20 жил хүртэл хугацаагаар олгоно гэж заасан байна.

Дээрх заалтаас үзэхэд манай улсын хэмжээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг үндсэнд нь хоёр ангилж

---

[3] УИХ-ын "*Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай*" 45 дугаар тогтоол

[4] Цөмийн энергийн тухай хууль 5.2."Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компаний хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ". 5.3. "Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ".

[5] П.Алтангэрэлтэг "*Уул уурхайн мэдээ*"< www.vip76.mn> сурв. Б. Уянга (сүүлд 2009.11.10)

болохоор байна".

- Хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх эрх олж авсан хайгуулын үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд,
- Хуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олж авсан хайгуулын үйл ажиллагаа нь дуусаж цаашид олборлолтын үйл ажиллагаанд ороход бэлэн болсон хуулийн этгээд.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн[7] 18.1.1-т "цацраг идэвхт ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар сэргээх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хураах, гэм буруутай иргэнийг 20000-50000, хуулийн этгээдийг 100000–250000 төгрөгөөр торгоно" гэж заасан бол Цөмийн энергийн тухай хуулийн[8] 50.1.3-т "тусгай зөвшөөрөлгүйгээр буюу тусгай зөвшөөрөл заасныг зөрчиж үйл ажиллагаа явуулсан, энэхүү үйл ажиллагаанаас учирсан хохирлыг арилгах арга хэмжээ аваагүй, цацрагийн осол, зөрчлийн тохиолдлыг төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллагад зохих журмын дагуу мэдэгдээгүй бол хууль бусаар олсон орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хураах, зөрчил гаргасан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-15, компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан нь хүлээлгэх хариуцлагын хувьд мөн зөрүүтэй заалт агуулагдаж байна. Өөрөөр хэлбэл, нэг хуулийн санкц нь торгуулийн менгөн дүнг шууд тусгасан байхад нөгөө хуулийн санкц нь торгуулийн мөнгөн дүнг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэд дахин нэмэгдүүлсэнээр тооцохоор заасан байгаа юм.

Салбар дахь хуулийн зарим зохицуулалтад зөрчилдөөнтэй тал харагдаж байгаа хэдий ч энэ салбар дахь бусад орны жишигт нийцсэн зохицуулалт мөн байна.

Монгол Улсын хувьд цацраг идэвхт ашигт малтмалын салбарын хөрөнгө оруулагчдад тавих нөхцөл, шаардлагыг Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогод ерөнхий дөрвөн хэсэгт хуваан дэлгэрэнгүй тусгаж өгсөн нь улс орнуудын хэмжээнд дагаж мөрдөж байгаа ерөнхий нөхцөл, шаардлагад нийцэж байна. Үүнд:

- Өөрийн орны стратегийн ач холбогдлыг нэмэгдүүлэхээр нөлөө бүхий улс оронтой харилцах, Монгол Улсын нутаг дэвсгэрт олборлосон цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор, дэлхийн зах зээлийн үнэд хүргэж борлуулах чадвартай, санхүүгийн хувьд бүрэн бие даасан байх, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолт, нөхөн сэргээлтийг хийх санхүүгийн чадавхтай байх, цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалт, борлуулалтаар дэлхийн зах зээлд тогтвортой, тэргүүлэх байр

[6] Ц.Ундрах (2009)"*Ашигт малтмалын лиценз эзэмшигчийн эрх зүйн байдлыг харьцуулсан судалгаа*"//Хууль дэдлэх ёс, 4

[7] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-18

[8] Цөмийн энергийн тухай хууль-50

суурь эзэлсэн байх, үйл ажиллагаа нь ил, тод байх;

• Технік технологийн хувьд цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай байх, цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой байх, цөмийн технологи нэвтрүүлэх чадвартай байх, цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулахдаа эдийн засгийн илүү ур ашиктай, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи ашигладаг байх;

• Байгаль орчин, аюулгүй ажиллагааны хувьд уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг байх, цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд явуулж, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай хийдэг байх;

• Нийгмийн асуудлаар бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд сонгочлагатай оролцдог байх, ажиллагсдын сургалт, дадлагын асуудлыг шийдэж ирсэн туршлагатай байх, компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаарх дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх зэрэг шаардлагыг бүрэн хангасан байх ёстой гэж тусгасан байна.[9]

Манай улсын хувьд цацраг идэвхт ашигт малтмалын асуудлыг Цөмийн энергийн газар[10] хариуцан гүйцэтгэж байна. Энэхүү байгууллага нь цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн судалгааг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, мэргэжлийн хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Цөмийн энергийн газрын өнөөдрийн бүтэц нь Олон улсын цөмийн энергийн агентлагийн аюулгүй ажиллагааны шаардлагуудад нийцэхгүй байна. Олон улсын цөмийн энергийн агентлагаас гаргасан стандартад "Хяналт нь хөндлөнгийн байна" гэж заасан байдаг. Гэтэл Цөмийн энергийн газар нь өөрөө лиценз, зөвшөөрлөө олгодог, үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг, цөмийн болон цацрагийн хяналтын газар нь бүтэц дотроо байгаа нь хяналтын байгууллага хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтыг алдагдуулсан байна[11].

Олон улсын жишгээс үзэхэд ураны ашигт малтмалтай холбогдсон

---

[9] УИХ-ын 1996 оны дугаар 43 тогтоолын хавсралт *"Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого" 3.3.2*

[10] "Төрийн захиргааны байгуулгын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоол. "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Цөмийн энергийн газар байгуулагдсан.

[11] УИХ-ын тамгын газар судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төв.\2009\" *Бодлогын судалгаа шинжилгээ " Уб*

үйл ажиллагааг төрийн өмчит компани эрхэлж явуулдаг туршлага байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн[12] 2.2.4-д "Ураны судалгаа, хайгуул, олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлж, баталгаажсан нөөцийг нэмэгдүүлэн, олборлолтод хөрөнгө оруулах сонирхол бүхий стратегийн хөрөнгө оруулагчтай хамтран Мардай зэрэг ураны ордыг ашиглаж эхэлнэ" гэж заасан. Дээрх заалтыг хэрэгжүүлэхийн тулд ураны үйл ажиллагааг эрхлэн явуулах төрийн өмчит компани байгуулах зайлшгүй шаардлагатай болж Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 45 тоот тогтоолоор уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх үүрэг бүхий "Мон-Атом" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулахаар баталсан[13].

"Мон-Атом" Төрийн өмчит ХХК-ийн дүрэмд заасны дагуу:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт уран болон бусад цацраг идэвхт ашигт малтмалын геологийн судалгаа, хайгуул хийх,
- Цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг тогтоож, түүнийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулах,
- Цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, түүнийг барьж байгуулах, үйл ажиллагааг удирдах,
- Ураны хүдрийг олборлох, боловсруулах, баяжуулах үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх,
- Монгол Улсын болон олон улсын гэрээнд нийцүүлэн энхийн зориулалтаар ураны бүтээгдэхүүнийг экспортлох зэрэг үндсэн үйл ажиллагаа явуулахаар заажээ.

Бүс нутгийн хэмжээнд ураны эрэл хайгуул, олборлолтоо эрс нэмэгдүүлж энэ салбар дахь төрийн хяналт, шалгалтын олон улсын стандартад нийцсэн бодлого явуулж байгаа Казахстан Улсын жишээнээс товч дурдахад тус улс нь уран төдийгүй цөмийн эрчим хүчтэй холбоотой харилцаанд сүүлийн 10 жил эрчимтэй оролцож байгаа бөгөөд энэ салбар дахь олон улсын хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж, олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэж орсон харьцангуй туршлагатай орон гэж хэлж болно. Энэ ч үүднээс энэ салбар дахь эрх зүйн зохицуулалтдаа нэлээдгүй анхаарч хэд хэдэн хууль, эрх зүйн актыг баталсан байна[14].

Тус улсын энэ салбар дахь томоохон эрх зүйн актуудыг дурдвал[15]:

- Атомын энергийг ашиглах тухай хууль (1997.04.15 №93);
- Хүн амыг цацрагийн аюулаас хамгаалах тухай хууль (1998.04.23 №219);
- Хүрээлэн байгаа орчныг хамгаалах тухай хууль (1997.07.15

[12] Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.2.4

[13] http://nea.gov.mn *"Монгол Улсын ураны судалгаа, үйлдвэрлэлийн стратеги" 2009.12.4*

[14] Концепция проекта Закона Республики Казахстан Об использовании атомной энергии.

[15] *"Бодлогын судалгаа, шинжилгээ"* судалгааны эмхтгэл. УБ 2009 он. 277 дахь тал.

№160-1);

- Тусгай зөвшөөрлийн тухай хууль (2007.01.11 №214).

Энэ салбар дахь үйл ажиллагаа эрхэлж буй гол төрлийн байгууллага бол Казахстан Улсын Аж үйлдвэр болон шинэ технологийн яамны дэргэд үйл ажиллагаагаа эрхэлж буй Атомын эрчим хүчний хороо. Тус байгууллага нь энэ салбар дахь аюулгүй байдал, хамгаалал, хяналтын үүргийг гүйцэтгэдэг. Хяналт хэрэгжүүлэх нэгэн гол хэрэгсэл бол тусгай зөвшөөрөл олголт, олголтын үйл явц, тусгай зөвшөөрөлтэй нэгжүүдийн үйл ажиллагааг хянах явдал юм. Тусгай зөвшөөрлийг тус улсын Эрчим хүч, эрдэс баялгийн яамнаас олгож харин Хорооны хувьд тус үйл ажиллагааг үнэн шударга, авилгагүй, дүрэм журмын дагуу явуулахад хяналт тавьж, тодорхой журам, хөтөлбөрүүдийг боловсруулдаг байна[16].

Казахстан Улсын хувьд манай адил харьцангуй шинэ зах зээл бөгөөд ОХУ-тай түүхэн харилцаатай, маркетинг, стратегийн зөв боллогын ачаар хэд хэдэн түнштэй нэгэн зэрэг ашигтай хэлбэрээр ажиллаж, зах зээл дэх нөлөөгөө хүчтэй нэмэгдүүлж чадсан байна[17].

Дээрх жишээнээс харахад цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой харилцааг маш нарийн чанд хууль дүрэм боловруулж зохицуулах шаардлагатай байгаа юм. Учир нь энэхүү ашигт малтмал нь бусад төрлийн ашигт малтмалыг бодвол хайгуул хийх, олборлох, тээвэрлэх зэрэг бүхий л асуудал нь стандартын дагуу явагдахгүй бол энэхүү стандартаа ялимгүй зөрчихөд нийгэмд учруулах хор хөнөөл нь өндөр эрсдэл дагуулж байдаг байна. Үүний нэг тод жишээ бол саяхан болж өнгөрсөн Япон Улсын Атомын цахилгаан станц дэлбэрсэн явдал.

Дээр дурдсан ашигт малтмалыг эрэх, хайх, олборлох гээд тусгай зөвшөөрлийн хугацааг нарийн тодорхой зааж өгөхгүй бол бидний сайн мэдэх "Бороо Гоулд" шиг хэдхэн жилийн дотор хамаг баялгийг минь олборлож авчхаад үлдэж буй газар нутгийн асуудлыг тэр чигт нь орхигдуулах асуудал тулгархыг ч үгүйсгэх аргагүй юм. Ялангуяа хяналтын асуудалд олон улсын стандартыг дагаж мөрдөх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, олон улсын стандартад зааны дагуу хяналтын систем нь хараат бус байх ёстой учраас манай улс энэхүү асуудлыг сайтар нягталж үзэх шаардлагатай байна. Яг энэ цаг мөчид яригдаж байгаа цөмийн хаягдлыг булшлах асуудлыг ч гэсэн яаралтай нягтлан үзэх нь зүйтэй. Учир нь энэ асуудалд ч гэсэн эрх зүйн орчны хувьд зөрүүтэй зүйлүүд гарч ирж байгаа юм.

Эцэст нь тэмдэглэхэд аливаа улс орны төрийн аль ч салбартаа нөлөөлөх нөлөөллийн хэрэгсэл нь тухайн салбарын эрх зүйн орчин учраас манай улс энэхүү хэрэгслээ зөв зүйтэй зохион байгуулж, аль болох дэлхийн өндөр хөгжилтэй улс орны жишээнээс харж, судалж, олон улсын стандартад нийцсэн, өөрийн оронд илүү тохирохуйц үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлогыг баримталж эрх зүйн орчноо боловсронгуй болгох шаардлагатай юм.

---

[16] "О комитете" http://www.kaec.kz/rus/o_kompanii /сүүлд үзсэн 2011.08.11-ний өдөр/

[17] "*Бодлогын судалгаа, шинжилгээ*" судалгааны эмхтгэл, УБ 2009 он, 279 дэх тал.

КАНАД, КИПР УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

Нэг. Канад Улсын мэдээллийн агентлагийн тухай

ХЗҮХ-ийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Л.Амаржаргал

Канадад "Канадын пресс" болон Радио, телевизийн корпораци (CBC/Radio-Canada) гэсэн хоёр мэдээллийн агентлаг байсан. "Канадын пресс" нь 2010 онд татан буугдаж хувийн компанийн өмчлөлд шилжсэн. Одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа нь Канадын Радио, телевизийн корпораци (CBC/Radio-Canada) юм.

1920 оноос АНУ-ын нөлөө их байсан учир Канадын соёл, ёс заншлыг хадгалж үлдэхийн тулд Канадын үндэсний радио телевизийн компани байгуулах зайлшгүй шаардлага гарчээ. Энэхүү Радио, телевизийн корпораци нь бусдаас ялгарах үндэсний онцлогийг харуулсан мэдээ, мэдээлэл тарааж үндэсний хэмжээний том байгууллага болж чадсан байна.[1]

Канадын Радио, телевизийн корпораци (CBC/Radio-Canada) нь цэвэр мэдээллийн байгууллага биш атлаа интернетээр мэдээ, сурвалжлагаа тараадаг болсноор МОНЦАМЭ, ИТАР-ТАСС зэрэг байгууллагуудтай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг болсон бөгөөд канадын үндэсний мэдээллийн агентлаг юм.

2010 оны 6 дугаар сарын сүүлээр Радио, телевизийн корпораци нь ойролцоогоор 9432 ажилтантай, орон нутгийн 27 салбартай байв. Төв байр нь Оттавад байрладаг. Радио телевизийн корпораци нь 14 улсад салбартай бөгөөд Канадын хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүх мэдээг хамарсан өргөн хүрээний мэдээг олон улсад түгээдэг.

Канадын Радио, телевизийн корпораци нь төсвөөс тодорхой хувиар санхүүждэг бөгөөд үлдсэн хэсгээ өөрсдийнхөө үйл ажиллагаанаас санхүүжүүлнэ. Тус корпорацийн удирдлагыг ерөнхий удирдагч томилж, чөлөөлдөг. Корпорацийн удирлага гэдэг нь 12 захирлаас

[1] http://www.cbc.radio-canada.ca/history/ /сүүлд үзсэн 2011.04.15/

бүрдсэн захирлуудын зөвлөл байна. Захирлуудын зөвлөлийн дарга нь зөвлөлийг тэргүүлэн, бодлого, чиглэлийг тодорхойлж, гүйцэтгэх захирлын ажилд хяналт тавьж, үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэгтэй өргөн эрх мэдэл, үүрэг хариуцлагыг хүлээдэг. Корпорацийн өдөр тутмын үйл ажиллагааг ерөнхийлөгч буюу гүйцэтгэх захирал удирдан чиглүүлдэг.

Радио телевизийн корпораци нь Засгийн газраас хараат бусаар ажилладаг. Гэхдээ парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Тайлангаа Соёлын яамаар дамжуулж парламентад тавина. Жилийн тайлан болон корпорацийн төлөвлөгөөний хураангуйг парламентад жил бүр танилцуулна. Мөн түүнчлэн үйл ажиллагааны тайлангаа Канадын Радио, телевиз болон харилцаа холбооны комисст тайлагнаж, санхүүгийн тайлангаа танилцуулдаг.

Эрх зүйн зохицуулалтын хувьд хуульдаа ерөнхий зохицуулалтыг тусгаад дүрмээр тухайн байгууллагын эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулдаг нь харагдаж байна.

Канадын Радио, телевиз болон харилцаа холбооны хороо (комисс) нь радио телевизийн корпорацийн үйл ажиллагаанд чиглэл өгч, удирдан чиглүүлж хяналт тавьдаг байгууллага юм.

Хоёр. Кипр Улсын мэдээллийн агентлагийн тухай

Кипр Улсын мэдээллийн агентлаг нь өөрийн гэсэн бие даасан хуультай. Тус хуулиар мэдээллийн агентлагийн бүтэц тогтолцоо, бүрэлдэхүүн, удирдлагын эрх хэмжээ, санхүүгийн нөхцөл зэрэг шаардлагатай зохицуулалтыг тус хуульд тусгажээ. Агентлагийн даргыг захирлын зөвлөлийн саналыг үндэслэн Сайд нарын зөвлөлөөс томилно. Агентлагийн даргыг оролцуулаад нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй захирлын зөвлөл ажиллана. Кипр Улсын хувьд захирлын зөвлөлд орох гишүүдэд тавигдах шаардлага, мэдээллийн агентлагийн баримтлах зарчмыг зааж өгсөн нь давуу талтай.

Кипр Улсын агентлаг нь төрөөс санхүүждэг. Агентлагийн захирлын зөвлөлөөс бэлтгэсэн төсвийг Сайд нарын зөвлөл болон Төлөөлөгчдийн танхим баталдаг. Сангийн сайд нь ямар төсөвтэй байх вэ, мөнгийг юунд зарцуулах вэ, орлого, зарлага нь ямар байх вэ гэдгийг тодорхойлдог. Агентлаг нь олон нийтийн болон арилжааны үйл ажиллагаа явуулахдаа тусдаа данс нээж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хөтлөн явуулна. Санхүүгийн зарцуулалтад ерөнхий аудитор хяналт тавьж шалгалтын тайланг захирлын зөвлөлд танилцуулна. Дараа нь аудитын тайланг Сайд нарын зөвлөл болон Төлөөлөгчдийн танхимд хүргүүлнэ. Мөн түүнчлэн агентлаг нь тусдаа сантай байж болно гэж заасан.

Агентлаг нь ажлаа Сайд нарын зөвлөл болон төлөөлөгчдийн

танхимд тайлагнана. Кипр Улсын мэдээллийн агентлагийн санхүүгийн хяналт хатуу, харин ажилтанг ажилд авахдаа ажлын байранд тавигдсан шаардлага хангаж байвал заавал Кипр Улсын иргэн байх албагүй гэсэн хүний нөөцийн чөлөөт бодлого баримталдаг байна.

Дүгнэлт

Улс болгоны улс төр, эрх зүйн системээс хамаарч агентлагийн бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчин, хариуцлага тооцох механизм, санхүүжилт зэрэг нь харилцан адилгүй өөр өөр байна. Гэхдээ дараах нийтлэг зүйл ажиглагдлаа. Үүнд:

- Ихэнх улсуудын мэдээллийн агентлаг нь захирлын зөвлөл буюу удирдах зөвлөлтэй байдаг юм байна. Захирлын зөвлөлийн дарга гол үүрэг гүйцэтгэж, агентлагийг удирдан чиглүүлдэг. Удирдлагын баг буюу гүйцэтгэх захирлаар удирдуулсан баг агентлагийн өдөр тутмын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг;
- Эрх зүйн зохицуулалтын хувьд хуулиар өөрөхий зохицуулалт хийж дүрмээр агентлагийн нарийвчилсан зохицуулалт хийдэг;
- Санхүүжилтийн хувьд бүгд төрөөс бүрэн буюу төрийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Зарим агентлагийн хувьд санхүүжилтэд хяналт тавих нь сул, зарим нь хатуу байдаг. Энэ нь улс орны онцлогоос хамаарч байна. Ихэнх орны хувьд төсвөөс санхүүжихээс гадна өөрсдийн үйл ажиллагаанаас орлого олох боломж нь нээлттэй байдаг;
- Агентлагийн дарга нь нэг бол удирдах зөвлөлийг томилсон байгууллагын өмнө эсвэл санхүүжилт өгч байгаа байгууллагын өмнө ажлаа хариуцан тайлагнадаг.

Судалсан улсуудын ихэнх нь хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулдаг байна. Кипр Улсын мэдээллийн агентлагийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6"-д агентлагийн баримтлах зарчмыг тодорхойлсон байна. Үүнд: "агентлаг нь ямарч нөхцөлд аливаа улс төрийн болон намын бүлэг, эдийн засгийн болон бусад бүлгийн эрхшээлд орох, эсвэл тэднийг дэмжих, эрх ашигт нь үйлчилж үл болно" гэж заасныг харахад эрх зүйн хувьд хараат бус үйл ажиллагаа явуулдаг гэж дүгнэх үндэслэлтэй байна.

Канад Улсын зохицуулалтаас харахад улсын төсвөөс санхүүждэг хэдий ч өөрсдийн үйл ажиллагаанаас орлого олох боломжтой, нээлттэй үйл ажиллагаа явуулдаг. Санхүүгийн хувьд харьцангуй хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг нь санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлангаас харагдсан. Канад Улсын хувьд мэдээ, мэдээллийг дамжуулахад аль нэг улс төрийн хүчин, нам, бүлэглэлээс хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломж нээлттэй байна.

Ихэнх улсын мэдээллийн агентлаг нь захирлын зөвлөл буюу удирдах зөвлөлтэй байдаг. Захирлын зөвлөлийн дарга нь гол үүрэг гүйцэтгэж, агентлагийг удирдан чиглүүлдэг. Удирдлагын баг буюу гүйцэтгэх захирлаар удирдуулсан баг агентлагийн өдөр тутмын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг. Канад Улсын ерөнхийлөгч (гүйцэтгэх захирал)-өөр ахлуулсан алба, хэлтийн дарга нар удирдлагын багт багтдаг. Удирдлагын баг буюу гүйцэтгэх захирал нь захирлын зөвлөлд ажлаа хариуцан тайлагнадаг. Захирлын зөвлөлөөр мэдээллийн агентлагийн стратеги болон бизнес төлөвлөгөө, дүрэм, журам, бодлогын баримт бичгүүд батлагддаг. Кипр Улсын хувьд Мэдээллийн агентлагийн тухай хуульдаа захирлын зөвлөлийн гишүүд ямар байгууллагаас хэдэн хүн байх, ямар мэргэжилтэй байх зэрэг захирлын зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхой заасан байна.

Кипр Улс Мэдээллийн агентлагийн эрх зүйн байдлыг тодорхойлсон бие даасан хуультай байна. Бусад улсын хувьд мэдээллийн агентлагийн удирдлагын нийтлэг зохицуулалтыг ерөнхий хуулиар, харин захирлын зөвлөл, түүний гишүүдийн, эрх, үүрэг, хүлээх хариуцлага, дотоод зохион байгуулалт зэрэг мэдээллийн агентлагийн дотоод асуудлыг дүрмээр зохицуулдаг юм байна.

Кипр Улсын мэдээллийн агентлагийн тухай хуульд заасан шиг захирлын зөвлөлийн гишүүд ямар байгууллагаас хэдэн хүн байх вэ, ямар мэргэжилтэй байх, ямар шаардлага хангасан байх ёстой зэргийг зааснаар удирдлагын төлөөллийг тэгш хангасан.

Канад, Кипр Улсуудын мэдээллийн агентлаг нь төрөөс бүрэн буюу тодорхой хувиар санхүүжилтавч, төрийн дэмжлэгтэйгээр үйлажиллагаа явуулдаг. Канад Улсын хувьд парламентаас санхүүжилт авч мөн ажлаа парламентад тайлагнадаг. Кипр Улсын хувьд улсын төсвөөс санхүүжиж Сайд нарын зөвлөл, Төлөөлөгчдийн танхимд ажлаа тайлагнадаг. Захирлын зөвлөл буюу удирдах зөвлөлийг томилсон байгууллагын өмнө аль эсвэл санхүүжилт өгч байгаа байгууллагын өмнө ажлаа хариуцан тайлагнадаг нь судалсан улсуудын жишгээс харагдаж байна.

Олноо өргөгдсөн Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын талаар товч өгүүлэх нь

Чин гүрэн XX зууны эхээр син чжэн буюу шинэ засгийн бодлого хэмээх арга хэмжээ хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү бодлогыг хүлээн авах эсэх талаар 1911 оны 6 дугаар сарын 21-ний өдөр халх дөрвөн аймгийн хан, чуулган дарга, шанзудба зэрэг ноёд нууцаар зөвлөлдсон байна. Энэхүү зөвлөгөөнөөс Хаант Орос улсаас тусламж авч Чин улсаас салж, тусгаар улс байгуулж, Богдыг улсын эзэн хаанаар өргөмжлөх тухай тус тус санал нэгдэж хэд хэдэн хүнийг Орос улсад төлөөлөгчөөр томилон илгээжээ.

Энэхүү үйл явдлын дараа 1911 оны 11 дүгээр сарын 28-нд Жабзундамба хутагт "Одоо монгол овогтон бүгдээр нийлж, өөртөө улс болон тогтнож, шашнаа мандуулан, бусдын эрх мэдэлд дарлагдах зовлон зүдгүүрийг үзэхгүй болох цаг болсон" гэсэн лүндэн буулгаж, үүний дараагаар цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн еснөө буюу Европын тооллын 1911 оны 12 дугаар сарын 29-ны өдөр Жабзундамба хутагтыг Монгол Улсын хаан ширээнд залах ёслол болон, оны цолыг "олноо өргөгдсөн" хэмээн нэрлэж, Олноо Өргөгдсөн Монгол Улсыг албан ёсоор тунхаглан зарлаж, төрийн таван яамыг байгуулсан билээ.

1911 онд Монгол Улсыг тунхагласан нь монголчуудын төр, хууль зүйн сэтгэлгээ сэргэн мандахад нэн таатай нөлөө үзүүлсэн юм. Шинэ тунхагласан улс орны улс төр, нийгэм, эдийн засгийн харилцааг зохицуулахад сайтар боловсруулсан хууль цааз нэн шаардлагатай байдаг.

Энэ ч жаягийн дагуу Олноо Өргөгдсөн Монгол Улсын үеийн эрх зүйн түүхэнд холбогдох "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг" хэмээх хууль цаазын эх сурвалжийг эл үеийн хамгийн гол эх сурвалж гэж судлаачид үзсээр иржээ. Энэхүү хууль цаазын бичгийг зохиолгохоор 1915 онд Богд хааны зарлигаар комисс байгуулж, Манж Чин Улсын үеийн "ерөнхий хууль 100 дэвтэр, тусгай хууль 180 дэвтэр, цэргийн дүрэм 69 дэвтэр, эрүү шүүлтийн хууль 47 дэвтрийг орчуулан ашиглаж, мөн монголын эртний хууль зүйг баримтлан" 1918 онд уг хуулийг зохиож, хэлэлцэн батлах үе үндсэндээ дуусаж, хэвлэх ажиллагаа эхэлжээ.

Энэхүү "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг"-ийн 51 дэвтэр нь "Манжийн хуучин хуулийн зааалтыг Монголын төрийн уламжлалын дагуу өөрчлөн найруулсан" гэж судлаачид бичсэн байдаг ч монголын уламжлалт хууль цаазад анх удаа төрийн байгууллагуудын бүтэц, эрх хэмжээ, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн

нэгж түүний удирдлага, түшмэлийн зэрэг дэв, цалин пүнлүү, татвар зэрэг нэлээдгүй асуудлыг нарийвчлан зохицуулсан байдаг.

Үүнээс тус хуулийн тэргүүн дэвтэрт Олноо өргөгдсөн Монгол Улсын засаг захиргааны бүтэц, нэгжийн талаар хэрхэн өгүүлснийг дор дурдсуу.

Манай улс өгүүлэн буй үед үндсэн 4 аймагтай байжээ. Тэдгээр нь бүгд нутгийн хойноос урагш сунасан байдалтайгаар оршиж байв. Олноо Өргөгдсөн Монгол Улс нь Богд Жабзундамба хутагтын шавь Баруун Хүрээний, Эрдэнэ номунханы, Мэргэний, Эрхийн гэх мэт отгууд 30 их отог, улсын Эх дагины 1 отог, тамга бүхий хутагтуудын харъяат 5 отог, цорж, ван, улсад туслагч гүн, бэйсүүдийн харъяат 10 отог, Богдхан хайрхан уулын чуулганы Түшээт хан аймгийн 21 хошуу, Хан Хэнтий уулын чуулганы Сэцэн хан аймгийн 25 хошуу, 2 отог шавь (эдгээр нь Эрдэнэ ялгуусан хутагт, Егүзээр ачит зан бадарсан эрдэнэ мэргэн хамба хутагт 2-ын шавь отог болой), Хантайширр уулын чуулганы Засагт хан аймгийн 20 хошуу, 3 отог (эдгээр нь самадн багш Номунхан хутагт, нэвтэрхий сайн самадн багш ялгуусан хутагт, Номунханы шавь гэсэн 3 отог билээ), Цэцэрлэгийн уулын чуулганы Сайн ноён хан аймгийн 25 хошуу, 8 отог (Зая бандид, Эрдэнэ бандид, Чин сүжигт, Эрдэнэ мэргэн ноён, Нар ванчин, Наран хутагт, Хамба хутагт Номунхан, Шива ширээт хутагтын гэх отгууд), Дөрвөд 2 аймгийн 27 засаг хошуу буюу нийт их, бага 59 отог, 118 хошуудаас бүрэлдэж байжээ.

Эдгээр хошуу, отгуудын дийлэнх нь Манжийн үед байсан хэвээрээ байв. Дээр өгүүлсэн Сайн ноён хан аймгийн 8 отгийн тухайд нэг зүйл дурдахад, Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгээс 1995 онд эрхлэн гаргасан "XX зууны Монгол" хэмээх хамтын бүтээлийн 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлд тус аймгийг 7 отогтой байсан гэжээ. Гэтэл Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй "Зарлигаар Тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг"-ийн тэргүүн дэвтэрт 8 гээд, бүгдийнх нь нэрийг жагсаан бичсэн байна. Үүнийг түрүүнд дурдсан хамтын бүтээл дэх отгуудын нэртэй тулган үзэхэд Эрдэнэ бандидын шавь отгийг орхигдуулсан явдал нь ямар нэгэн учир шалтгааны улмаас хэмээн санахад бэрхтэй юм. Үүнийг тодруулан судлах шаардлагатай болов уу.

Мөн түүнчлэн цагаагчин гахай жилийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний ололтыг бэхжүүлэх, өөрөөр хэлбэл, тусгаар улс болсноо бататган, харийн түрэмгийллээс хамгаалах шаардлага урган гарч, үүнээс үүдэн 1912 оны туршид Өвөр Монгол, Цайдам, Алшаа, Хөхнуур, Хөлөнбуйрын хошууд Монголын төрд дагаар орон, нэгэн туурганд нэгдэх хүсэлтээ илэрхийлэн, зарим нь дагаар орж байв.

Эдгээрийн нэг нь Монголын төрөөс Манлайбаатар цол авсан баргын Дамдинсүрэн юм. Түүнд Дорнод аймагт тусгайлан хошуу байгуулж өгч байсан нь өдгөө сурвалжид бичигдэн үлджээ. Энэ мэтчилэн дагаар орж буй аймаг, хошуудад тусгайлан засаг захиргааны нэгж байгуулах явдал нэлээдгүй байсан юм.

Өнөөгийн улс төрчдийн зарим нь хуучин 4 аймаг байсан засаг захиргааны зохион байгуулалтад шилжих нь зүйтэй гэж үзэж байдаг. Энэ нь зүйн хэрэг мэт боловч тухайн нутаг орны газарзүйн байрлал, угсаатны бүтэц, хэл соёл, түүхэн уламжлал, хуучин газар усны нэршил зэрэг олон зүйлсийг баримталж байж гэмээ нь сая нэг хэрэгжүүлж болох асуудал юм. Өдгөө Монгол Улс 21 аймаг, 330 сумтай байгаа нь засаг захиргааны зохион байгуулалтын хувьд нүсэр бөгөөд үрэлгэн зардалтай, тархай бутархай байдалтай байгааг харуулж байна.

Энэ үеийн засаг захиргааны бүтэц, зохион байгуулалтын талаар эрдэмтэн, судлаачдын дунд "Цагаан ном" хэмээх нэршлийг хүртэн, олдоц муутай, ховор бүтээлийн тоонд зүй ёсоор багтаж явдаг нэгэн ном буй. Тэр бол түүхч, архивч Ц.Сономдагва агсаны "Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт" хэмээх бүтээл билээ. Эл ном нь өдгөө Манжийн ноёрхолын үеэс одоог хүртэлх (1691-1997 оныг хүртэлх үеийг хамардаг) монголын засаг захиргааны зохион байгуулалтын талаарх түүх судлаач хэн бүхний эн тэргүүнд нээж үздэг гол гарын авлага нь болсоор байна.

Олноо өргөгдсөн Монгол Улсын үеийн засаг захиргааны зохион байгуулалтын талаар цухас дурдахад ийм буюу.

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР,
АРДЫН БАГШ, ГАВЬЯАТ ХУУЛЬЧ Б.ЧИМИДИЙН НЭРЭМЖИТ

шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтан, сургалт, шинжилгээний байгууллагын багш, судлаач, оюутны

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН

Илтгэлийн уралдаан нь Үндэсний хуулийн эрх зүйн салбар дахь судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих; хууль зүйн эрдэм шинжилгээний ажлыг урамшуулж, тэдний бүтээлч эзэлхүүнийг, шинжлэх ухааны хандлагыг нэмэгдүүлэх; хууль зүйн шинжлэх ухааны болон бодлогын тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилготой.

Зохион байгуулагч байгууллага:

Хууль зүйн үндэсний хүрээлэн
МУИС-ийн Хууль зүйн сургууль
Удирдлагын Академи
Нээлттэй Академи
ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн.

Уралдаанд ирүүлэх илтгэлийн сэдэв: "Үндэсэн хуулийн эрх зүйн" хүрээнд байна.

ШАГНАЛЫН САН:

Шалгарсан илтгэлд:

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтан, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаачын шагнал:

- **I байр, Өргөмжлөл, 500.000 ТӨГРӨГ**
- **II байр, Өргөмжлөл, 300.000 төгрөг**
- **III байр, Өргөмжлөл, 200.000 төгрөг**

Оюутны шагнал:

- **I байр, Өргөмжлөл, ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕР**
- **II байр, Өргөмжлөл, 300.000 төгрөг**
- **III байр, Өргөмжлөл, 200.000 төгрөг**

Хугацаа:

- Илтгэлийг **2011 оны 12 дугаар сарын 26**-ны өдрийн 18.00 цаг Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүлээн авна.

ы шалгаруулалтын дүн 2012 оны 1 дүгээр сарын 5-нд

ы шалгаруулалт 2012 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр

эллийг **88024884, 99036187** утаснаас лавлана уу.

80025 75540

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nji.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Өндөр хурдны интернет бүхий компьютерийн лаборатори иргэдэд үйлчилж байна.
1 цаг интернет ашиглахад 400 төгрөг.

Мөн та манай танхимыг түрээслэн сургалт, уулзалт зохион байгуулах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл 315735 дугаарын утсаар лавлана уу.

Хаяг: Улаанбаатар 210646, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай 7, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 205 тоот танхим